

# **Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага**

**СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**2013 он**

**УДИРТГАЛ**

**I. ТӨРИЙН ЭРҮҮГИЙН БОДЛОГО /CRIMINAL POLICY/**

- 1.1. Эрх зүйн бодлого
- 1.2. Төрийн эрүүгийн бодлогын эрх зүйн үндэс
- 1.3. Төрийн эрүүгийн бодлогын ойлголт, зарчим, хэрэгжүүлэх субъект, тэдний чиг үүрэг
- 1.4. Эрүүжүүлэх /гэмт хэрэгт тооцох, эс тооцох/
- 1.5. Орчин үеийн эрүүгийн бодлогын үндсэн чиглэл
- 1.6. Эрх зүй
- 1.7. Уламжлал түүх

**II. МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ЯВДЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА**

**III. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНД ХИЙГДЭХ ӨӨРЧЛӨЛТ**

- 3.1. Эрүүгийн хуультай холбоотой судалгааны тайлангуудаас гарсан санал, дүгнэлт
- 3.2. Шүүхээс оногдуулсан ял шийтгэлийн байдал
- 3.3. Эрүүгийн хуулийг шинэтгэх шаардлага

**IV. ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГАА**

- 4.1. Мөрдөн байцаах албаны талаар
- 4.2. Хэрэг бүртгэх албаны талаар
- 4.3. Гүйцэтгэх ажлын талаар
- 4.4. Шүүхийн шинжилгээний албаны талаар
- 4.5. Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт
- 4.6. ЭБША-ны шинэтгэлийн үзэл баримтлал

**V. ХУУЛЬ ЗҮЙН САЛБАРЫН ХУУЛЬ САХИУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЭТГЭЛ**

- 5.1. Хууль зүйн салбарын хууль сахиулах үйл ажиллагааны шинэтгэл
- 5.2. Хууль сахиулах байгууллагуудын дэд бүтэц, шинэтгэлийн үндсэн чиглэл

**VI. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

- 6.1. Ялын хэрэгжилт
- 6.2. Хорихоос өөр төрлийн ялын үр нөлөөг дээшлүүлэх
- 6.3. Баривчлах ялын үр нөлөөг дээшлүүлэх талаар
- 6.4. Хорих ялын үр нөлөөг дээшлүүлэх талаар
- 6.5. Хорихоос суллагдсан хүмүүст чиглэсэн бодлого, нөхцөл байдал

**VII. ХОХИРОГЧ, ГЭРЧИЙН ЭРХИЙН ХАМГААЛАЛ**

**ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

## УДИРТГАЛ

Энэхүү судалгааны ажлыг өнгөрсөн он буюу 2012 онд Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэн, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн сектортой хамтран гүйцэтгэхээр судалгааны ажлын удирдамжийг байгууллагын тухайн үеийн удирдлагууд баталсан боловч Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дотоод бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор хамтран гүйцэтгэх боломжгүй болсон. Иймээс ДХИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэн өөрчлөгдөн байгуулагдсан Хууль сахиулахын их сургуулийн Шинжлэх ухаан, технологийн газрын Цагдаа судлалын төвийн эрдэмтэн, судлаачид 2012-2013 онд хийж гүйцэтгэв.

ХЗЯ-ны Хууль сахиулах үйл ажиллагааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга, докторант Г.Оюунболд, ХСИС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, цагдаагийн хурандаа Ж.Болдбаатар, Цагдаа судлалын төвийн дарга бөгөөд Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор С.Жанцан, эрдэм шинжилгээний ахлах ажилтан, докторант, цагдаагийн ахмад Б.Мөнхдорж, эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн магистр, цагдаагийн дэслэгч Б.Мөнхсэргэлэн, Д.Сумъяацэрэннар энэхүү судалгааны тайланг бэлтгэв.

### **Судалгааны ажлын зорилго, зорилт**

Гэмт явдалтай тэмцэх Монгол Улсын төрийн бодлого боловсруулах ажиллагааны хүрээнд гэмт хэрэгт тооцох, эс тооцох тухай асуудал, Монгол Улсын Эрүүгийн хууль дахь гэмт хэргийн ангилал, ялын тогтолцоо, харилцан уялдаа, үр нөлөөг судлах, орчин үеийн төрийн бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлох, санал зөвлөмж боловсруулах нь уг судалгааны ажлын зорилго юм.

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж ажиллав. Үүнд:

- Төрийн эрүүгийн бодлоготой холбоотой эрх зүйн зохицуулалт тэр дундаа 2002 оны Эрүүгийн хууль батлагдсанаас хойш орсон нэмэлт өөрчлөлт, УИХ, Засгийн газраас гаргасан эрх зүйн баримт бичгийг судлах;
- Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлого боловсруулахад үүсч байгаа хүндрэл бэрхшээлийг тодорхойлох;
- Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын чиг хандлагыг тодорхойлох;
- Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын онол, практикт тулгамдаж буй асуудлуудыг судлах;
- Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогоор тодорхой үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, эс тооцох асуудлын үндэслэлийг тодорхойлох;
- Гадаадын зарим улсуудын төрийн эрүүгийн бодлогын талаар эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах.

### **Судалгааны арга, хэлбэр:**

Судалгааны сэдвийн хүрээнд хууль зүйн эх сурвалж болох баримт бичгийн задлан шинжилгээ, харьцуулалт, онолын судалгаа, практикийн өнгөрсөн болон өнөөгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, задлан шинжлэж, нэгтгэн дүгнэх зэрэг аргаар судалгааг явуулав.

### **Судалгааны ажлын үр дүн:**

Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын онол, манай улс дахь гэмт явдлын төлөв, байдал, чиг хандлагын талаар, мөн хууль зүйн салбарын шинэтгэлтэй уялдуулан хууль сахиулах байгууллагын дэд бүтцийн талаар судалж дүгнэлт хийж, судалгааны ажилд үндэслэн зөвлөмж гаргасан болно.

Аливаа бодлого боловсруулах үйл явцад **ОНОЛЫН** академик судалгаанаас гадна “бодлогын судалгаа” чухал юм. Төрийн эрүүгийн бодлогыг тодорхойлоход чухамдаа одоо тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлж, бодлогын шийдлийг судалгааны үндэслэлтэй санал болгох нь зүйтэй гэж үзлээ.

### 1.1. Эрх зүйн бодлого

#### Бодлого гэж юу вэ?<sup>1</sup>

Төрийн эрүүгийн бодлого нь Засгийн газраас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хууль сахиулах замаар нийгэмд иргэдийн аюулгүй амьдрах эрхийг хуульчлан баталгаажуулахад чиглэсэн гүйцэтгэх үйл ажиллагаа юм. Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын асуудал нь эрх зүйн нэгдсэн бодлогоос урган гардаг учраас эрх зүйн бодлогын асуудлыг авч үзэх шаардлагатай.

Төрөөс эрх зүйн үр ашигтай бодлогыг боловсруулах, улс орны алсын болон ойрын ирээдүйн эрх зүйн хөгжлийн үзэл баримтлалыг үндэслэх явдал хууль зүйн шинжлэх ухааны тулгамдсан зорилтуудын нэг юм. Эрх зүйн бодлого нь төрөөс улс орондоо эрх зүйн ардчилсан шинэчлэл хийх үндсэн үзэл баримтлалын нэгдэл бөгөөд эрх зүйн хэм хэмжээнд тусгагдан хэрэгждэг.

Орчин үеийн Монголын өөрчлөн байгуулалтын бодлого нь бүхэлдээ эрх зүйн шинжтэй, хуулийн үйлчлэлийн нөлөөн дор хэрэгжиж байгаа нь нэг онцлог юм. Төрийн гадаад болон дотоод бодлого юуны өмнө Үндсэн хууль, Олон улсын эрх зүйн хэм хэмжээ, бусад салбар хуулиудын тусламжтайгаар хэрэгжинэ.

**Эрх зүйн бодлого нь** эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох, хууль ёс, эрх зүйн дэг журмыг бэхжүүлэх, гэмт явдалтай тэмцэх, эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг дээшлүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах, тэдгээрийн баталгааг нь хүчтэй болгох нийгэм эрх зүйн ухамсар, соёлыг бүрдүүлэх, иргэдийг хууль ёсыг ягштал биелүүлдэг болгон төлөвшүүлэх зэрэг тодорхой зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн субъектүүдийн үйл ажиллагаа юм. Эдгээр нь бүхэлдээ эрх зүйт төрийг төлөвшүүлэх зорилтыг хангахад чиглэгдэнэ.

Эрх зүйн бодлого нь төрийн бодлогын илрэх онцгой хэлбэр болохын хувьд хуулийн үйлчлэлээр түүнийг амьдралд бүтээлчээр хэрэгжүүлэх хамгийн үр дүнтэй хүчтэй хэрэгсэл юм. Учир нь төрийн бодлого бүхэлдээ эхлээд үндсэн хууль, нэгдэж орсон олон улсын гэрээ, конвенциуд, салбар хуулиуд, эрх зүйн бусад актуудад тусгагдан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн харилцааг төгөлдөржүүлэн хөгжүүлэхэд үйлчилж байдаг.

Эрх зүйн бодлого нь зорилт агуулгаараа нийгмийг өөрчлөн байгуулах хүчтэй хэрэгсэл юм.

#### Эрх зүйн бодлого нь:

**1-д,** эрх зүйд үндэслэгддэг, эрх зүйтэй шууд холбоотой;

**2-т,** эрх зүйн арга, хэрэгслээр эрх зүйн зохицуулалтын үр дүнд хэрэгждэг;

**3-т,** эрх зүйн хүрээний үйл ажиллагааг бүхэлд нь хамаардаг;

**4-т,** шаардлага гарсан үед албадлагад тулгуурладаг;

**5-д,** нийтэд хамааралтай, албан ёсны шаардлагыг илэрхийлдэг. Бүх тохиолдолд эрх зүй нь энэ төрлийн бодлогын үндэс суурь нь болдог. Эрх зүйн бодлого нь аль ч нийгэмд, ялангуяа эрх зүйт төрийг төлөвшүүлэх, хуулийн засаглалыг хэрэгжүүлэх үйл явцад нийгмийг удирдан чиглүүлэх зорилтыг амжилттай шийдвэрлэх илүү үр дүнтэй, ухаалаг хэлбэр юм.

Монголын эрх зүйн бодлогыг УИХ, Ерөнхийлөгч, Засгийн Газар зэрэг хууль санаачлах эрх бүхий субъектүүд гардан боловсруулдаг бөгөөд энэ үйл ажиллагаанд шинжлэх ухааны болон олон нийтийн үүсгэл санаачлагын байгууллагууд, иргэд өргөнөөр оролцох бүрэн боломжтой. Эрх зүйн бодлогыг төлөвшүүлэх, амьдралд бүтээлчээр хэрэгжүүлэхэд хууль сахиулах, хамгаалах, хэрэглэх талаар баялаг туршлага хуримтлуулсан хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх, прокурорын байгууллага, үндсэн хуулийн цэц шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Гэхдээ эрх зүйн бодлогыг хэрэгжүүлэгч, зохион байгуулагч, зохицуулагч нь удирдлага-албадлагын хүчтэй аппараттай, захиран тушаах чиг үүргийг хуулиар хүлээсэн төр өөрөө юм.

#### **Төрийн эрх зүйн бодлого нь:**

- Үндэслэгээ сайтай байх;

- Нийгмийн хувьд бүрэн нөхцөлдсөн байх;
- Шинжлэх ухааны үндэслэлтэй байх;
- Бодитой байх;
- Тогтвортой, чиглэсэн зорилготой байх;
- Ардчилсан шударга байх;
- Ил тод байх;
- Хувь хүн ба төрийн сонирхлыг оновчтой хослуулсан байх;
- Хүний эрхийн давуу байдлыг эрхэмлэх
- Олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцсэн байх;
- Хоорондоо харилцан шүтэлцээ бүхий зэрэг тулгуур зарчмуудад үндэслэгдсэн байх ёстой.

Төрийн эрх зүйн бодлогыг амьдралд хэрэгжүүлэх гол хоёр арга бол итгүүлэх болон албадах явдал юм. Эдгээр хоёр арга нь хүмүүсийн ухамсар, зан үйлд нөлөөлөхүйц хориглох, албадах, цээрлүүлэх, хүмүүжүүлэх, ухамсарлуулах агуулга, зорилго бүхий хуулиар зөвшөөрөгдсөн олон хэрэгслүүдийг өөртөө багтааж байдаг.

Улс оронд эрчимтэй өрнөж буй эрх зүйн шинэтгэл, ардчилсан өөрчлөлтүүдийг гагцхүү эрх зүйн цэгцтэй, оновчтой бодлогын тусламжтайгаар хэрэгжүүлэх боломжтой гэдэг нь улам тодорхой мэдрэгдэж байна.

Эрх зүйн бодлого онолын хувьд:

а) Хууль тогтоох, хэрэглэх, хэрэгжүүлэх, үйл ажиллагааны хэтийн төлөв;

б) Эрх зохицуулалтын зарчмууд;

в) Үндсэн хуулийн байгууламж;

г) Шүүхийн болон эрх зүйн шинэтгэл;

д) Хүний эрхийн хамгаалалт;

е) Төрт ёс, хууль ёс, эрх зүйн дэг журам, сахилга, хариуцлагын хэрэгжилт гэсэн тулгуур асуудлыг өөртөө багтаадаг өргөн хүрээтэй ойлголт юм.

Орчин үед Монголын төрийн эрх зүйн бодлогын нийтлэг үзэл баримтлалыг эрх зүйт төрийг төлөвшүүлэх, хүний эрх эрх чөлөөг дээдлэн хамгаалах, ардчиллыг нийгмийн амьдралын бүх салбарт гүнзгийрүүлэх зорилтын хүрээнд тодорхойлох зайлшгүй шаардлагатай болж байна.

Монголын төрийн эрх зүйн бодлого нь түүний зориулалт, мөн чанар, зарчим, цаашдын хөгжлийн чиг хандлагыг илэрхийлсэн дараах асуудлуудыг өөртөө багтаасан үзэл баримтлалыг иш үндэс болгох юм. Үүнд:

1. Шинжлэх ухааны орчин үеийн ололт, хууль хэрэглэх, сахиулах ажиллагааны практикт үндэслэн эрх зүйн бодлогын онол-арга зүйн үндсийг боловсруулах;

2. Эрх зүйн бодлого нь улс оронд нэгэнт бүрэлдсэн улс төр, нийгэм-эдийн засаг, соёл, ёс зүй, хүн ам зүйн болон бусад бодит хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн байх;

3. Нийгмийн харилцааны хууль зүйн хэлбэрүүдийг боловсронгуй болгох;

4. Эрх зүйн бодлогын үндсэн агуулга, түүний хөгжлийн давамгайлах чиглэл, хандлагыг тодорхойлох, энэ бодлыг амьдралд хэрэгжүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэх, хойшлуулшгүй нэн тэргүүний зорилтууд, тэдгээрийг шийдвэрлэх субъектүүд, арга замуудыг үндэслэл бүхий прогноз, урьдчилан таамаглалд тулгуурлан тодорхойлох;

5. Улс оронд өрнөж буй ардчилсан өөрчлөн байгуулалтын эрх зүйн үндсийг бүрдүүлэх, хүний эрхийн баталгааг хангах, хууль бүтээх үйл ажиллагааг эрчимжүүлж, түүний чанар, шинжлэх ухааны үндэслэлийг дээшлүүлэх;

6. Эрх зүйн бодлогыг хэрэгжүүлэх арга замыг боловсронгуй болгох, итгүүлэх болон албадах аргуудыг зөв хослуулах, үр дүнг дээшлүүлэх талаар санал боловсруулах;

7. Нийгмийн амьдралын улс төр-эрх зүйн хүрээг тууштай ардчилах, нийгэмд үүсэж болох зөрчилдөөн, засаглалын салаа мөчрүүдийн хоорондох санал зөрөлдөөнийг хүч хэрэглэх аргаар бус, хэлцэл зөвшилцөөгөөр шийдвэрлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэг юм.

Эрх зүйн бодлогын стратеги болон тактик нь иргэний нийгэм, эрх зүйт төрийг цогцлон байгуулах, иргэдийг хууль ёсыг ёсчлон биелүүлдэг болгох, тэдний эрх зүйн соёл, ухамсрыг дээшлүүлэх, эрх зүйн гутрангуй үзлийг гэтлэн давах, урьдчилсан сэргийлэхэд чиглэгдэх учиртай юм. Төрийн эрх зүйн бодлогод үндэслэн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын асуудлыг дараагийн зүйлд авч үзье.

## 1.2. Төрийн эрүүгийн бодлогын эрх зүйн үндэс

Гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлого нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудаас шууд урган гарч байна. Тухайлбал, Үндсэн хуулийн 11-р зүйлд “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”, 3-р зүйлд “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно”, 4-р зүйлд “Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил хязгаар халдашгүй дархан байна”, 5-р зүйлд “Төр нь нийгмийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, 6-р зүйлд “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл төрийн хамгаалалтанд байна”, 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан оюуны өв, төрийн хамгаалалд байна”, 16-р зүйлд “Монгол Улсын иргэн үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ” гэжтус тус заасан нь Эрүүгийн бодлогын агуулга, чиглэл болох ёстой.

Үндсэн хуулийн 19-р зүйлийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”<sup>2</sup> гэсэн тулгуур хэм хэмжээ нь төрийн эрүүгийн бодлогын үндсэн агуулга болох юм.

УИХ-ын 2008 оны 12-р тогтоолоор батлагдсан “**Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого**”-д “Төрийн үйлчилгээг хүртээмжтэй ил тод болгох, хүний эрхийг баталгаатай хангах нийгэм дэх аюулгүй орчинг бий болгох, эрх зүйн зохицуулалтыг тус тус боловсронгуй болгоно”, мөн түүнчлэн 2012 оны 37-р тогтоолоор баталсан “**Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр**”-т “ардчилсан нийгмийн үнэт зүйл, зарчим, улс орны хөгжлийн шаардлагад нийцсэн, авилга, албан тушаалын болон шинэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох чадавхитай эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоог бүрдүүлж, ялын бодлогыг оновчтой, үр нөлөөтэй, олон сонголттой болгох”<sup>3</sup> гэж тус тус заасан нь өнөө үеийн гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогын зорилт болж байна.

Төрийн эрүүгийн бодлогын олон тулгуурт зорилт, агуулгыг бүрэн илэрхийлсэн бичиг баримт бол УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “**Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал**” юм.

- Үзэл баримтлалын 1.1.2-т “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана” гэж заасан. Монголчууд бидний дээр дурдсан амин чухал эрх ашиг, сонирхол эрүүгийн хуулийн хамгаалалтанд байсаар ирсэн.

- Үзэл баримтлалын 3.1.3-д “цус ойртолтыг багасгах, архидан согтууралт, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх...(3.1.3.4), 3.2-т “Эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгох нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл мөн”.

- “Дотоод аюулгүй байдал” хэмээх 3.3-д “Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж... нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн”, 3.4-д “Монгол хүний эрүүл аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн” гэж тус тус баталгаажуулсан нь гэмт хэрэгтэй тэмцэхэд төрөөс баримтлах бодлогын үндэс юм.

Гэмт хэрэгтэй тэмцэх төрийн эрүүгийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны эрх зүйн орчинг 1997 оны 12-р сарын 5-ны өдөр батлагдан мөрдөгдсөн “**Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль**” бүрдүүлж байдаг. Энэ хуулиар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, үндсэн чиглэл, төрөл, арга хэлбэр, энэ талаар төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон боловч хэрэгжилт, үр дүн нь төдийлөн сайнгүй байлаа.

### 1.3. Төрийн эрүүгийн бодлогын ойлголт, зарчим, хэрэгжүүлэх субъект, тэдний чиг үүрэг

Гэмт хэрэгтэй тэмцэх нь аливаа улс орны дотоод бодлогын нэг чиглэл байдаг учраас эрүүгийн эрх зүйн онолчид, судлаачид судалгааны объект болгож өөрсдийн номлолыг боловсруулжээ.

ОХУ-ын эрдэмтэн Л.Д.Гаухман, Ю.И.Ляпунов нар “Эрүүгийн бодлого гэдэг нь түүхэн тодорхой цаг үе дэх нийгмийн хөгжлийн объектив зүй тогтлыг танин мэдэх үйл ажиллагаанд суурилсан нийгмийн харилцааг гэмт халдлагаас хамгаалах үйл ажиллагааны үндсэн чиглэл, зарчмууд, иргэдийн чиг хандлагыг илэрхийлсэн төрийн дотоод бодлогын нэг салбар юм”<sup>4</sup> гэж тодорхойлсон бол Японы эрүүгийн эрх зүйн эрдэмтэн Иго Макото “Аливаа төр иргэндээ гэмт халдлагаас хамгаалах, аюулгүй амьдрах нөхцөлийг хангахад чиглэгдсэн цогц бодлого боловсруулж үе шаттай хэрэгжүүлж байгаа нь агуулгаараа төрийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлого юм”<sup>5</sup> гэжээ.

Францын эрүүгийн эрх зүй судлаач М.Л.Рассат “Иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалахын тулд аливаа улсын төр гэмт явдлын шинж, төрөл, гаралт, хөдөлгөөн, хандлагыг судласаны үндсэн дээр боловсруулсан төрийн бодлоготой байх ёстой”<sup>6</sup> гэжээ.

АНУ-ын эрдэмтэн Брикс Жексон “Аливаа муж улсын Эрүүгийн хууль нь төрийн эрүүгийн бодлогын эрх зүйн үндэс болохоор шудрага, алагчлахгүй байх, тэгш эрхийг болон энэрэнгүй ёсны зарчмуудаар дамжин хэрэгжих учиртай”<sup>7</sup> гэж эрүүгийн бодлогын асуудлыг тусгайлан авч үзжээ.

ХБНГУ-ын шинэ үеийн Эрүүгийн хууль тогтоомжид “Нэг үйлдлийх нь төлөө хэнийг ч олон удаа шийтгэж болохгүй, хуульгүйгээр ял гэж үгүй, гэм буруутай бол яллах үндэслэл болно, оногдуулж буй ял нь үйлдсэн хэрэг, субъектын хувийн байдалд тохирсон байх гэх мэт чухал зарчмуудаар дамжин эрүүгийн бодлого хэрэгжинэ”<sup>8</sup>.

Академич С.Нарангэрэл “Эрүүгийн бодлогыг гэмт халдлагаас нийгэм ба тодорхой иргэнийг хамгаалах талаар төрөөс авч явуулах бүх арга хэмжээний нийлбэр цогц” гэж тодорхойлоод гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ба түүнтэй тэмцэхэд чиглэгдэнэ. Эрүүгийн бодлогын стратеги нь нийгмийн аюулгүй байдлыг хангах бодлогын ерөнхий асуудлын зэрэгцээ эрүүгийн эрх зүйн шинэчлэлт байна<sup>9</sup> гэж, профессор Г.Совд “Эрүүгийн бодлого нь гэмт явдалтай тэмцэх үндсэн шаардлагуудыг агуулж байдаг төрийн дутуу бодлогын нэг чиглэл” гэж тодорхойлоод төрийн эрүүгийн бодлогын үндсэн чиглэл бол нэг талаас онц ноцтой гэмт хэрэг үйлдэгч этгээдүүдэд хатуу ял оногдуулж тэдэнтэй эвлэршгүй тэмцэх, нөгөө талаас үйлдсэн хэргийн шинж байдал, хувийн чанараар аюултай биш этгээдүүдийг олон нийтийн байгууллагуудын /сургууль, хамт олон, нөхөрлөл/ нөлөөгөөр хүмүүжүүлэх зорилтыг шийдвэрлэх явдал мөн”<sup>10</sup> хэмээн тодорхойлсон.

Гэмт явдалтай тэмцэхэд төрөөс баримтлах үйл ажиллагааны чиглэл гэдэг агуулгаар эрүүгийн бодлогыг **эрүүгийн бодлого/criminal politik/** гэдэг нэр томъёогоор анх Германы гүн ухаантан Людвиг Фейербахын эцэг, хуульч Ансельм Фейербах илэрхийлсэн гэж үзэж ирсэн.

Төрийн эрх зүйн бодлого, тэр тусмаа эрүүгийн бодлогын асуудал манай улсад төдийлөн судлагдаагүй, эрдэмтдийн анхаарлын гадна үлдсэн гэж үзэх бүрэн үндэстэй юм. Тийм учраас Эрүүгийн бодлого нь эрүүгийн эрх зүйн онолд зохих байраа эзлэх ёстой асуудал юм. Эрүүгийн бодлогыг зөвхөн төрийн дотоод бодлогын нэг хэсэг гэж үзэх нь учир дутагдалтай юм. Учир нь Монгол Улсын олон улсын гэрээнүүдийн /конвенцүүд/ үзэл санаанд нийцүүлэх үүднээс Эрүүгийн хуулиар хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг чиглэсэн үйлдэл, эс үйлдэхүйнүүдийг /218-304-р зүйлүүд/ гэмт хэрэгт тооцсон нь улс хоорондын харилцааны асуудлыг шууд хөндөж байгаа утгаараа Эрүүгийн бодлого нь гадаад бодлогын нэг салшгүй хэсэг болж байна.

Эрх зүйн бодлогын тогтолцоонд үндсэн хуулийн эрх зүйн бодлого, өргөн утгаар авч үзвэл, төр эрх зүйн бодлого шийдвэрлэх үүрэгтэй. Энэ бодлоготой эрүүгийн эрх зүйн бодлого шууд харилцан шүтэлцээнд оршиж байдаг.

**Эрүүгийн бодлого** гэдэг нь хүн, төр, нийгэм, байгууллага, аж ахуйн нэгжийн хууль ёсны эрх, эрх ашиг, сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор нийгэмд аюултай ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, тэдгээрт оногдуулах эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээ, тэдгээрийг хэрэглэх, эсхүл чөлөөлөх үндэслэл, журмыг тогтоох, түүнчлэн гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг судалж тогтоох, энэ үндсэн дээр урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үр өгөөжтэй арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг төгөлдөржүүлэх талаар төрөөс баримталж буй чиглэл, удирдамж юм.

Эрүүгийн бодлого нь төрийн бодлогод эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, нийгмийн үйл явцад нөлөөлөх аргаараа бусад салбарын бодлогоос өвөрмөц онцлогтой, өөртөө *эрүүгийн эрх зүйн, эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн, шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүйн, криминологийн гэсэн* хэд хэдэн бие даасан чиглэлийн тусгай бодлогыг багтааж байдаг.

Эрүүгийн бодлого нь иргэн нийгэм, төр, байгууллага, аж ахуйн нэгжийн эрх, ашиг сонирхолд хохирол учруулдаг нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт явдалтай хийх тэмцэл, нийгмийн дэг журмыг сахиулах үйл ажиллагааны үндсэн чиглэл, арга замыг тодорхойлдог.

Эрүүгийн бодлого нь Үндсэн хуулиас гадна салбар хуулиуд УИХ-ын тогтоол, төр, засгийн бусад шийдвэр, эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт тусгагдан хэрэгжиж эхэлдэг. Эдгээр нь эрүүгийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны эрх зүйн үндэс болдог.

Эрүүгийн бодлого нь төрийн дотоод бодлогын нэг чухал чиглэл болохын хувьд нийгэм эдийн засаг, улс төр, үзэл суртлын талаархи төрийн бодлого үр дүнтэй хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж байдаг.

**Эрүүгийн бодлого нь нэгд:** төрийн хууль, тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлигт тусгалаа олж байдаг гэмт явдалтай тэмцэх төрийн бодлого /номлол/, **хоёрт:** улс төр, социологи, эрх зүйн мэдлэгийн нэгдэл буюу шинжлэх ухааны онол, **гуравт:** гэмт явдал болон эрх зүйн буюу зөрчилтэй тэмцэх талаарх нийгмийн үйл ажиллагааны онцлог төрөл юм.

Эрүүгийн хуулийн 1-р зүйлд “Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам, энх тайван, хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхийн тулд хүн, төр, нийгэмд аюултай ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, түүнийг үйлдсэн гэм буруутай нь шүүхээс тогтоогдсон этгээдэд хүлээлгэх Эрүүгийн хариуцлагын төрөл хэмжээг тогтооно” гэж заасан.

Төрийн эрүүгийн бодлого нь хууль ёс, шударга ёс, энэрэнгүй ёс, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх, гэмт хэрэг үйлдсэн этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх, Эрүүгийн хариуцлагын гарцаагүй байх зэрэг зарчмуудаар дамжин хэрэгжих боллоо. Тухайлбал, өмнөх төрийн эрүүгийн бодлогод гарч байсан алдаа завхралаас сэргийлэх ач холбогдолтой, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэж дээдэлсэн агуулга, зорилт бүхий “Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй байх”, “Хүний үзэл бодол, итгэл, үнэмшлийн төлөө хариуцлага хүлээлгэхгүй байх”, “Гэм буруугүйгээр энэ хуульд заасан хор уршгийг учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх”, “Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тухайн гэмт хэрэгт нь зөвхөн нэг удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэх” зэрэг орчин үеийн эрүүгийн эрх зүйн онолын тэргүүний үзэл баримтлалуудыг 2002 оны Эрүүгийн хуульд хуульчилсан нь эрүүгийн бодлогын онцлог юм.<sup>11</sup>

Эрүүгийн хуульд илрэлээ олон хэрэгжиж эхлээд байгаа эрүүгийн бодлого нь энэ хуулийг боловсруулахад иш үндэс болгосон дор дурдсан үзэл баримтлалаас /тулгуур үзэл санаа/ үүдэлтэй юм. Тухайлбал:

1. Нийгэм эдийн засгийн цоо шинэ нөхцөл байдал, гэмт хэрэгтэй хийх тэмцлийг практикаар нөхцөлдсөн, иргэн, төр, байгууллага, аж ахуйн нэгжийн эрх ашиг, сонирхлыг эрүүгийн хуулийн хамгаалалтад оруулах;

Д.Зүмбэрэлхам. Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчлэлийн үндсэн үзэл баримтлал. Монголын эрх зүйн шинэтгэл. 1995-2003. УБ., 490 дэх тал



2. Эрүүгийн хууль тогтоомжийн хууль ёс, ардчилсан болон энэрэнгүй ёсны зарчмуудыг улам төгөлдөржүүлэх;

3. Нийгэмд аюултай тодорхой үйлдэл, эс үйлдэхүйг эрүүжүүлэх, нийгэмд аюулгүй зарим үйлдэл эс үйлдэхүйг эрүүгүйжүүлэх замаар одоогийн хуулийн хийдэл, хоцрогдлыг засаж залруулах нөхцөл бүрдүүлэх;

4. Эрүүгийн хуульд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, тулгуур зарчмуудыг шинээр хуульчлан тогтоох, урьд байсан зарчмуудын агуулгыг улам боловсронгуй болгох;

5. Гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдэх үеийн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдлыг иж бүрэн харгалзах замаар эрүүгийн хариуцлага ялгавартай байх нөхцөл бүрдүүлэх;

6. Эдийн засаг, банк, санхүү, аж ахуйн хүрээнд гардаг нийгэмд онц аюултай үйлдэл, эс үйлдэхүй, тухайлбал, мөнгө угаах, санхүүгийн луйвар хийх, зохион байгуулалттай гэмт хэрэг, коррупци, экологийн болон компьютерийн болон хар тамхи мансууруулах бодистой холбоотой шинэ төрлийн гэмт хэрэгтэй хийх тэмцлийн чиг хандлагыг тодорхойлох, орчин үеийн эрүүгийн нөхцөл байдалтай Эрүүгийн хуулийн хэр хэмжээг чанд нийцүүлэх;

7. Хүний эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг Эрүүгийн хуулийн хэм хэмжээгээр хамгаалах явдлыг улам хүчтэй болгох;

8. Хүнд, онц хүнд гэмт хэргийг удаа дараа үйлддэг, ялын цээрлэлийг амссан хэр нь засрахгүй архагшсан гэмт хэрэгтнүүдэд хүлээлгэх хариуцлагыг чангаруулах, анх удаа, хөнгөн, хүндэвтэр, болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн, насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдсэн хүмүүст аль болох хорихоос өөр төрлийн ял оногдуулах, тэднийг Эрүүгийн хуулийн энэрэнгүй хэм хэмжээнд өргөн хамруулах чиглэл, хандлагыг Эрүүгийн хууль боловсруулахдаа харгалзан үзэх;

9. Эрүүгийн хуулийн хэм хэмжээг Үндсэн хууль, Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээ, пактуудын агуулга, үзэл санаа хүн төрөлхтний нийтээр хүлээн зөвшөөрсөн үнэт зүйлд бүрэн нийцүүлэх;

10. Эрүүгийн хуулийг боловсруулахдаа дэлхий нийтийн хууль тогтоох туршлага, эрүүгийн эрх зүйн онолын үндэслэл, ололт амжилтыг харгалзах зэрэг болно.

Эрүүгийн хуулийг боловсруулахад баримталсан нэг чиглэл бол нэг талаас удаа дараа, хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлж төрийн цээрлэл амссан хэр нь хашрахгүй дахин санаатай гэмт хэрэг үйлдсэн хүмүүст хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг бүх талаар чангаруулах, нөгөө талаас анх удаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэрэг болгоомжгүй болон хөнгөрүүлэх нөхцөл байдалтай үйлдсэн, бусдын дарамт шахалт, харш нөлөөлөл, хүчирхийлэлд автаж, эсхүл амьдралын аргагүй нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг үйлдсэн, насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдсэн, үйлдсэн гэмт хэрэгтээ чин санаанаасаа гэмшиж байгаа, учруулсан хохирлоо нөхөн төлсөн, учруулсан хохирол, гэм хороо сайн дураараа арилгасан тохиолдолд аль болохоор эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх явдал юм.<sup>12</sup> Энэ хоёр хандлага төрийн эрүүгийн бодлогын үндсэн агуулга болж байна.

Төрийн эрүүгийн бодлогын агуулга, орчин үеийн зорилт Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгагдан хэрэгжиж байна. Тухайлбал,

1. ЭБША-ны хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хангах механизмыг хангах;

2. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг шинэ Эрүүгийн хуультай уялдуулах;

3. ЭБШ хуулийг Олон улсын эрүүгийн эрх зүйн зохицуулалтад нийцүүлэх;

4. Нийгмийн хөгжлийн шаардлагад нийцүүлж хууль хяналтын байгууллагын оновчтой тогтолцоог бий болгох эрх зүйн үндсийг бууруулах;

5. ЭБША-ны оролцогч болох иргэний нэхэмжлэгчийн ойлголтыг нийгмийн хөгжлийн эрэлт, шаардлагад нийцүүлэн шинээр тодорхойлох;

6. ЭБША-г шуурхай болгох;

7. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчдийн хариуцлагыг дээшлүүлэх;

8. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд баримталбал зохих тодорхой зарчмуудыг шинээр хуульчилж мөрдүүлэх;

9. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдыг төрөлжүүлж, түүний эрх үүргийг нарийвчлан тодорхойлох;

---

С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн тусгай анги. /схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал/. УБ., 2003. 7 дахь тал

10. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг олон үе шат, дамжлагагүй, ямар ч нөхцөлд шуурхай явагдах эрх зүйн орчин бүрдүүлэх зэрэг үзэл баримтлалыг иш үндэс болгох явдал юм.

Гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийн гаралт, хөдөлгөөн, хандлага, тэдгээрийн шалтгаан, нөхцөлийг урьдчилан судлах замаар урьдчилан сэргийлэх нь төрийн эрүүгийн бодлогын цөм болно. Тийм ч учраас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулалт, үндсэн чиглэл, төрөл, арга хэлбэр, энэ талаар төр, иргэн аж ахуйн нэгж, байгууллага албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон тухайлсан тусгай хуулийг 1997 онд батлан гаргаж мөрдсөн нь төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлсэн чухал ач холбогдолтой үйл явдал болсон юм.

Энэ хуулийн 3-р зүйлд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх таслан зогсоох талаарх авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ мөн” гэж заалаа. Энэ хууль анх удаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зарчим, үндсэн чиглэл, төрөл, тэдгээрийг төрөөс удирдах, хэрэгжүүлэх арга зам, ялангуяа гүйцэтгэх засаглалын байгууллагуудын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргүүдийг тус бүрд хуульчлан тогтоосон нь эрүүгийн бодлого бодитой хэрэгжих эрх зүйн баталгаа болсон гэж үзэх үндэстэй юм.<sup>13</sup>

Эрүүгийн бодлогын чухал эх сурвалж болох “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуулиар эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэх үйл ажиллагааны зарчим, үндэслэл, гүйцэтгэх байгууллагуудын чиг үүргүүдийг тогтоосон нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны төгсгөлийн шатанд эрүүгийн бодлого үр дүнтэй хэрэгжих эрх зүйн үндэс бүрдэв.

Гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогын агуулгад гэмт явдлын гаралтын түвшин, нийгмийн хор аюулыг багасгах, саармагжуулах, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэдгээрийг төрүүлж буй шалтгаан, нөлөөлж буй нөхцөл болох об'ектив болон суб'ектив шинжтэй сөрөг хүчин зүйлүүдийг арилгах, түүнчлэн хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэгч суб'ектүүд болох хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгоход чиглэгдсэн зөвхөн эрх зүйн төдийгүй улс төр, нийгэм, эдийн засгийн шинжтэй цогцолбор арга хэмжээнүүд хамааран хэрэгждэг.

Эрүүгийн бодлогын үндсэн аргууд нь **эрүүжүүлэх** (гэмт хэрэгт тооцох ёс), **эрүүгүйжүүлэх** (гэмт хэргийг үгүйсгэх ёс), ялгүй болгох, эрүүгийн хариуцлагыг ялгавартай хэрэглэх явдал юм.

#### **1.4. Эрүүжүүлэх /гэмт хэрэгт тооцох, эс тооцох/**

**Эрүүжүүлэх гэдэг нь** нийгэмд аюултай тодорхой үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцож Эрүүгийн хуульд хариуцлага хүлээлгэхээр заах үйл явц юм. Бид 1926 оноос хойш батлагдан мөрдөгдөж байсан эрүүгийн хуулиуд, одоо үйлчилж буй хуулийг хооронд нь харьцуулан судлахад нийт 350 орчим үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцож байжээ. Одоогийн Эрүүгийн хуулийн тусгай ангид 451 бие даасан үйлдэл, эс үйлдэхүйг эрүүжүүлсэн байна.

Ямар үйлдэл эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох нь тухайн үеийн нийгэм, төрийн байгууламж, эдийн засгийн үндэс, төрөөс шийдвэрлэхээр дэвшүүлж байсан зорилтууд, эрхэмлэж байсан ашиг сонирхолтой шууд холбоотой байсан нь манай эрүүгийн хуулиудын зорилтуудаас тодорхой харагддаг. Эрүүжүүлэх үйл явц нь эрүүгийн хуулийн хамгаалалтад авагдах ёстой хүн, төр, нийгмийн эрх, эрх чөлөө, ашиг сонирхлын хүрээг тодорхойлж байдаг. 2002 оны Эрүүгийн хуульд 40 орчим үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцож эрүүжүүлсэн байх жишээтэй. Тодорхой үйлдэл эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцоход:

- а) Урьд нь байгаагүй, нийгэмд аюултай хүний үйл ажиллагааны төрөл олширсон /худал дампуурах, мөнгө угаах, хүн худалдаалах, нянтай программ тараах гэх мэт/
- б) Захиргааны хариуцлагын тухай хуулиар захиргааны эрх зүйн зөрчилд хамаарагдаж байсан зарим үйлдэл, эс үйлдэхүй иргэн, нийгэмд илүү их хохирол учруулах болсон (зам тээврийн осол гарсан газрыг санаатай орхих, албан тушаалын нэр барих гэх мэт)

в) Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах явдлыг хүчтэй болгох (хүний хувийн нууцыг задруулах, сэтгүүлчийн хуульд нийцсэн ажиллагаанд саад хийх, хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлэх гэх мэт)

г) Шинжлэх ухааны техникийн дэвшлийн сөрөг үр дагавар, хүмүүс ахуй амьдралдаа янз бүрийн техник хэрэгсэл ашиглах болсон нь зарим талаар аюулын эх үүсвэрийг бүрдүүлэх болсон /тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны журам зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг/ зэрэг шалтгаанууд нөлөөлсөн байна. Тодорхой үйлдэл, эс үйлдэхүйг эрүүжүүлэхдээ хууль тогтоогч:

а) Тэдгээр нь нийгмийн хор аюул ихтэй байх;

б) Тэдгээртэй ял болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэглэх замаар тэмцэх нь зайлшгүй байх;

в) Эрүүжүүлж буй үйлдэл эс үйлдэхүй нь түгээмэл байх;

г) Тэдгээртэй эрүүгийн эрх зүйн арга хэрэгслээр тэмцэх нь үр өгөөжтэй байх;

д) Нийгмийн хор аюул багатай үйлдэл, эс үйлдэхүйг эрүүгийн хуульд заахгүй байх зэрэг зарчмуудыг үйл ажиллагаандаа харгалзах учиртай. Эрүүгийн бодлогын нөгөө нэг арга бол эрүүгүйжүүлэх үйл явц юм. Энэ нь урьд нь гэмт хэрэгт тооцож байсан үйлдэл, эс үйлдэхүйг хууль тогтоогч эрүүгийн хуулиас хасч, хүчингүй болгохыг хэлнэ. Эрүүгийн шинэ хуулиар цаг үеийн нөхцөл байдал өөрчлөгдсөнөөр нийгэмд аюултай шинж чанараа алдсан, хууль зүйн бусад хариуцлага тооцох замаар тэмцэх бүрэн боломжтой, нийгмийн хор аюул багатай, төдийлөн түгээмэл биш, эдийн засгийн арга, механизмаар зохицуулах боломжтой 51 гэмт хэргийг эрүүгүйжүүлсэн байна.

**Төрийн эрүүгийн бодлогын зарчим гэдэг нь** эрүүгийн эрх зүйн арга хэрэгслийн тусламжтайгаар гэмт явдалтай хийх тэмцлийн үр дүнг хангадаг. Эрүүгийн бодлогын мөн чанар, чиглэлийн тухай төрийн байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болговол зохих үзэл санааны цогц бүрдэл юм. Энэ нь гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогын үндсийг тодорхойлж, хүн амын эрх зүйн ухамсар, төлөвших, хэрэгжих үйл явцыг удирдан чиглүүлдэг. Төрийн эрүүгийн бодлогын зарчим нь ардчилсан ёс, шударга ёс, үндэсний яв нэгдлийг хангах хууль дээдлэх явдал юм.

Эрүүгийн хуульд төрийн эрүүгийн бодлогын зарчмыг хуульчилсанаар энэ талаарх судлаачдын үзэл бодлын зөрүүтэй байдлыг шийдвэрлэх боломжгүй бөгөөд цаашид шинжлэх ухааны боловсруулалт хийгдэх нь ойлгомжтой. Учир нь Эрүүгийн хуульд явцуу утгаар нь авч үзвэл зөвхөн эрүүгийн хариуцлагын зарчмууд хуульчлагдсан.

**Эрүүгийн бодлогын зарчмуудыг:**

1-т, түүний стратеги, тактик чиг үүргийг илэрхийлсэн зарчмууд;

2-т, эрүүгийн бодлого ба эдийн засаг, нийгэм-улс төр, оюун санааны хүчин зүйл, түүнчлэн нийгмийн хөгжлийн зөрчилдөөний харилцан хамаарлыг илэрхийлж буй зарчмууд;

3-т, эрүүгийн бодлогын хууль сахиулах механизм бусад эрх зүйн үндэслэлийг илэрхийлж буй зарчим гэж ангилан судалж болох юм.

Гурав дахь бүлэгт хамаарах

а) Эрүүгийн хуульд тусгагдсан хууль ёс, хууль, шүүхийн өмнө иргэд эрх тэгш байх, шударга ёс, энэрэнгүй ёс, гэм буруу нь заавал нотлогдсон байх, эрүүгийн хариуцлага үндэслэлтэй байх зэрэг зарчмууд нь эрүүгийн бодлогын мөн чанарыг илэрхийлж байгаа юм.

Түүнчлэн б) гэмт явдлыг таслан зогсоох, гаралтыг нь бууруулах, урьдчилан сэргийлэх чиг үүргийг хангаж буй эрүүгийн болон бусад хууль тогтоомжийн харилцан үйлчлэл үр ашигтай байх,

в) эрүүгийн бодлогын хууль сахиулах механизм ба эрх зүйн орчинг боловсронгуй болгох үйл ажиллагаа тасралтгүй, харилцан үр ашиг бүхий хамааралтай байх,

г) гэмт явдалтай хийх тэмцлийн арга, хэлбэр үр ашигтай, уян хатан байх,

д) гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, аажмаар арилгах талаарх эрүүгийн бодлогыг хэрэгжүүлэгч субъектээр (*төрийн болон төрийн бус байгууллага*) үйл ажиллагаа нэгдсэн зорилготой, идэвхитэй, дайчин, давшингүй, харилцан хамааралтай, тасралтгүй явагдах,

е) гэмт явдалтай тэмцэх чиг үүрэгтэй хууль сахиулах үйл ажиллагаа хууль, чанд сахилга бат, өндөр зохион байгуулалтанд тулгуурласан байх,

ё) гэмт явдалтай тэмцэх хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд төрийн бус байгууллагуудын оролцох арга, хэлбэрийг аль болох өргөжүүлэх, эрх зүйн үндсийг бүрдүүлэх,

з) шинжлэх ухаанч байх зэрэг нь эрүүгийн бодлогын тулгуур зарчмууд болох ёстой. Дээр дурьдсан бүлэг зарчмууд нь нэгдсэн зорилт, өөрөөр хэлбэл эрүүгийн бодлогыг үр ашигтай хэрэгжүүлэхэд чиглэгдэж байгаа боловч харьцангуй биеэ даасан, өөр өөрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг, тэдгээрийн үзэл баримтлалын үндэс нь нийгэм дэх гэмт явдлын гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх замаар иргэн, нийгэм, төрийн эрх ашиг сонирхлыг хамгаалах баталгааг хангах, эрүүгийн бодлогыг үр өгөөжтэй байлгахад чиглэгдэж байна.

Эрүүгийн бодлогын мөн чанарыг нэг талаас, өөрөөр хэлбэл үйл ажиллагаа, харилцаа, үзэл номлол, онол гэсэн явцуу ойлголтуудаар илэрхийлэх боломжгүй.

**Эрүүгийн бодлогын мөн чанар нь** өргөн агуулгаар авч үзвэл улс төр-эрх зүйн харилцаа, эрх зүйн хэм хэмжээ, улс төр-эрх зүйн үзэл суртал, объект, субъект хэмээх хоорондоо харилцан шүтэлцээтэй боловч харьцангуй бие даасан элементүүдээр илэрхийлэгдэнэ. Эрүүгийн бодлого нь аливаа төрийн бодлогод хамаарах объектив болон субъектив гэсэн хоёрдмол шинжтэй.

**Объектив шинж** нь хэрэгжүүлэгч субъектын ухамсарт төдийгүй, бодит үйл ажиллагаагаар, **субъектив шинж** нь бодлогыг хэрэгжүүлэгч субъектын эрх зүйн ухамсараар дамжин тус тус илэрхийлэгддэг.

Субъектүүд нь эрүүгийн бодлогын нэгдсэн хөдөлгөгч хүч болохын хувьд түүний зорилтыг өөрсдийн нягт харилцан ажиллагаагаар хэрэгжүүлж байдаг. Улс төр-эрх зүйн харилцаа бол эрх зүйн бодлогын мөн чанарыг тодорхойлоход шийдвэрлэх үүрэгтэй. Эдгээр харилцаа нь төрийн бодлого, тэр тусмаа эрүүгийн бодлогын объектив эх сурвалж бөгөөд нийгмийн хөгжлийн түүхэн үйл явцын хөгжлийн түвшин, эдийн засгийн болон бусад хүчин зүйлүүд, зөрчлийн хэлбэрүүдээр нөхцөлдөж улмаар эрүүгийн бодлогын эрх зүйн зохицуулалтыг бодит амьдралын шаардлагад нийцүүлэн бий болгоод зогсохгүй, эрүүгийн бодлогын субъектүүд эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх суурь нөхцөл болж өгдөг.

**Хуулийн хэм хэмжээ нь** улс төр-эрх зүйн харилцааны дотоод зохион байгуулалтын гадаад илэрхийлэл шаардлагатай зохицуулалтын чухал хэлбэр юм. Хуулийн хэм хэмжээ болон улс төр-эрх зүйн харилцаа нь агуулга ба хэлбэрийн илэрхийлэл бөгөөд агуулга нь харилцаа, хэлбэр нь хуулийн хэм хэмжээ болдог.

Энд харилцаа нь эрх зүйн хэм хэмжээний агуулга, мөн чанар, бүтэц, чиг үүргийг тодорхойлдог бол **эрх зүйн хэм хэмжээ нь** харьцангуй бие даасан шинжтэй байхын зэрэгцээ улс төр-эрх зүйн харилцаанд эргэж нөлөөлөх замаар тэдгээрийг тодорхой чиглэлтэй, зохион байгуулалттай болгож байдаг онцлогтой. Түүнчлэн эрх зүйн хэм хэмжээ бол эрүүгийн бодлогын хийсвэр болон хэлбэрийн төдий элемент юм. Аливаа зан үйлийн журам заавал хэрэгжих ёстой байдаг. Ингэж бодитойгоор хэрэгжихгүй юм бол эрх зүйн хэм хэмжээ амьдралаас хөндий бэлэгдлийн шинжтэй олон хуудас цаас болж хувирна.

**Үйл ажиллагаа нь** өөртөө улс төр-эрх зүйн харилцаа, эрх зүйн хэм хэмжээ, эрх зүйн үзэл санааг багтаасан эрүүгийн бодлогын цорын ганц шийдвэрлэх шинж чанар юм.

**Эрүүгийн бодлогын хувьд үйл ажиллагаа нь дор дурдсан хэд хэдэн онцлог шинжийг агуулдаг.** Үүнд:

1. Үйл ажиллагааны мөн чанар нь хүн, иргэдийн хууль ёсны ашиг сонирхлыг хангах, гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, гаралтыг нь бууруулах, хууль ёсыг бэхжүүлэх салбар дахь нийгмийн харилцаа юм. Шинж чанар, бүтцийн хувьд эдгээр харилцаа ихэвчлэн эрх зүйн тухайлбал үндсэн хуулийн, эрүүгийн, эрүүгийн байцаан шийтгэх, ял эдлүүлэх, захиргааны эрх зүйн харилцаа байна. Эдгээр харилцаа нь холбогдох салбарын эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдана.

2. Дээр дурдсан эрх зүйн харилцааны онцлог шинжтэй холбогдуулан авч үзвэл эрүүгийн бодлогыг зөвхөн эрүүгийн хуулийн хэм хэмжээтэй холбож үзэх нь учир дутагдалтай. Тэгээд ч эрүүгийн хууль тогтоомж болон гэмт хэрэгтнүүдэд үзүүлэх эрүүгийн эрх зүйн нөлөөлөл нь гэмт явдалтай тэмцэх гол хэрэгсэл биш болохоор эрүүгийн хуулийн үйлчлэлийг дутуу үнэлэх, эсхүл хэтрүүлэн үнэлэх байдал байж болохгүй юм. Ер нь эрүүгийн хуулийн үйлчлэл /хэрэглээ / нь гэмт явдалтай хийх тэмцлийн нэг чиглэл, нэг арга хэрэгсэл юм.

3. Эрүүгийн бодлогын чухал шинж болох үйл ажиллагааны мөн чанар нь хоорондоо холбоотой хоёр чиглэлтэй. **Нэгдэх нь** үйл ажиллагаа бол хуулиар зохицуулагдсан үйлдэл, зан үйлийн материаллаг шинжтэй хэлбэрүүд юм. Зан үйлийн тийм хэлбэрүүд нь эрүүгийн бодлогын хэрэгжилтийг илэрхийлэх гэмт явдалтай тэмцэх чиглэл, арга хэлбэрүүд юм. Эрүүгийн бодлогыг хууль сахиулах үйл ажиллагаагаар хэрэгжүүлнэ. Үйл ажиллагааны чиглэл нь хууль сахиулах ажиллагааны тодорхой салбар дахь арга хэмжээгээр илэрч байдаг.

Тухайлбал: эдийн засгийн, зохион байгуулалттай, хүч хэрэглэсэн, насанд хүрээгүйчүүдийн гэмт хэрэгтэй тэмцэх хууль сахиулах ажиллагааны тодорхой төрөлүүд нь эрүүгийн бодлогын чиглэл болдог.

Гэмт явдалтай тэмцэх үйл ажиллагааны хоёр дахь чиглэл онол-үзэл номлолын шинжийг агуулж байдаг. Өөрөөр хэлбэл шинжлэх ухааны мэдлэг, үзэл баримтлал, ойлголт, ухагдахуун, үнэлэмж, тогтсон хандлагыг өөртөө багтааж байдаг эрүүгийн бодлогын онол юм. Эрүүгийн бодлогын шинжлэх ухаан-онол болон практик ажиллагаа ямагт харилцан хамаарал шүтэлцээнд оршиж байдаг бөгөөд тэдгээрийн нэгдмэл шинж нь эрүүгийн бодлогын объект, субъектэд илэрч байх жишээтэй.

4. Гэмт явдалтай тэмцэх үйл ажиллагаа нь зүгээр нэг эрүүгийн бодлогын чиглэл, төрөл гэж үзэж болохгүй бөгөөд энэ нь төрийн нэрийн өмнөөс хуулиар тогтоосон арга, хэлбэрээр хэрэгжүүлдэг төрийн үйл ажиллагааны онцгой төрөл юм. Гэмт явдалтай тэмцэх үйл ажиллагаа нь өөрийн зорилго, мөн чанараараа иргэн, нийгэм, байгууллага, аж ахуйн нэгжийн ашиг сонирхолд бүрэн нийцсэн, шаардлагатай тохиолдолд субъектүүд өөрсдийн амь насанд аюул учруулахуйц өндөр эрсдэл бүхий нөхцөлд үүрэг гүйцэтгэхэд хүргэдэг онцлогтой. Эрүүгийн бодлогыг амьдралд хэрэгжүүлэгч үндсэн субъект нь төр өөрөө юм. Учир нь:

- 1-д, эрүүгийн бодлого нь төрийн бодлогын нэг хэсэг. Бодлого бүр төрийн үйл ажиллагаанаас ангид байдаггүй.
- 2-т: бодлогыг төр өөрөө биш түүний хууль тогтоох болон засаглан захирах бүтэц боловсруулж, хэрэгжүүлдэг,
- 3-т: эрүүгийн бодлогыг төрийн нэрийн өмнөөс төрөөс тогтоосон хуулийн хүрээнд төрийн тусгай байгууллага гардан хэрэгжүүлдэг.
- 4-т: эрүүгийн бодлогын объект /гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаа/ тодорхой тохиолдолд зөвхөн төр хуулиар эрх олгосон албадлага, хүч хэрэглэхийг шаардаж байдаг бөгөөд энэ нь хүн, нийгэм, төр, байгууллагын эрх ашиг, сонирхлыг хамгаалах зорилтын хүрээнд хийгддэг. Төрийн эрүүгийн бодлогыг хэрэгжүүлэхдээ хууль бусаар хүч хэрэглэх нь цаад зах нь гэмт хэрэг, наад зах нь захиргааны зөрчил болж хууль зүйн хариуцлага хүлээх ёстой болдог.

Эрүүгийн бодлогын субъектыг өргөн утгаар зөвхөн нийгэм өөрөө, түүний хүчний байгууллагууд гэж явцуурч хэрхэвч болохгүй. Аливаа нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт явдлын гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх туйлын сонирхолтой боловч нийгмийн анги, давхаргуудын сонирхол өөр өөр байх жишээтэй. Нэг хэсэг нь тодорхой үйлдэл, эс үйлдэхүйг нийгэмд аюултай гэмт хэрэг гэж үзэж байхад нөгөө хэсэг нь тэдгээрийг эсрэгээр нийгэмд аюулгүй, харин ч ашигтай гэж үзэх нь бий. Тухайлбал, Зарим нийгмийн давхарга болох зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд хийж буй гэмт үйлдлүүдээ нийгэмд харш гэж үздэггүй учраас төрийн зүгээс түүний эсрэг явуулж буй арга хэмжээг дайсагнан эсэргүүцдэг нь бодит үнэн юм.

Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд олон нийтийн оролцоо, дэмжлэг чухал учраас эрүүгийн бодлогын субъектын хүрээг зөвхөн хүчний болон хууль сахиулах байгууллагууд гэж туйлширч болохгүйг гэмт хэрэгтэй тэмцэх өнөөгийн практик нотолж байна. Энэ талаар Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиудад маш тодорхой заалтууд байдаг. Эдгээр хуулийн дагуу гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх төрийн үйл ажиллагаанд төрийн бус байгууллагууд болон иргэд туслах чанарын үүрэг гүйцэтгэж байна. Цаашид өргөн баригдаад байгаа шинэ хуулиудад олон нийт, иргэдийн оролцооны хэлбэр, агуулга, эдгээр субъектүүдийн эрх зүйн байдал, түүний баталгааг нарийвчлан тусгах зайлшгүй шаардлагатай.

**Эрүүгийн бодлогын субъект** гэдэг гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хуулийн дагуу тодорхой чиг үүрэг хэрэгжүүлж байгаа хууль сахиулах болон төрийн бус байгууллага, иргэд юм.

Эрүүгийн бодлогын субъектүүдийг түүнийг хэрэгжүүлэхэд гүйцэтгэж байгаа чиг үүргийн онцлогийг харгалзан:

- а/ хуулийн бус чиг үүрэг хэрэгжүүлдэг нийтлэг субъектүүд,
- б/ хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагууд,
- в/ төрийн бус байгууллага, иргэд гэж ангилж болохоор байна.

Хуулийн бус нийтлэг субъектүүдэд нийслэл болон орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, засаг даргын тамгын газар, харъяа газар, хэлтсүүд хамаарна. Эдгээр

байгууллагууд харъяа нутаг дэвсгэрийн хууль сахиулах байгууллагатай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлж байдаг.

Хууль бус чиг үүрэг хэрэгжүүлдэг нийтлэг субъектүүдэд юуны өмнө Засгийн газар, аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, бүх шатны засаг дарга хамаарна. Гэмт хэрэгтэй тэмцэх, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журмыг хамгаалах чиг үүргийн асуудлыг авч үзье.

Засгийн газар нь Засгийн газрын тухай хуулийн 7-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг хангах зорилгоор гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах асуудлаар тогтоол, захирамж гаргаж биелэлтийг хангана.

Мөн хуулийн 14-р зүйлд зааснаар а) Хүний эрх, эрх чөлөөг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон шаардлагатай бусад баталгааг бүрдүүлэх, бэхжүүлэх арга хэмжээ авах, б) хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх талаар хуульд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх, в) нийгмийн хэв журмыг сахин хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах чиг үүргийг хэрэгжүүлнэ.<sup>14</sup>

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7-р зүйлд зааснаар Засгийн газар гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар улсын хэмжээнд хэрэгжүүлэх ерөнхий ба тусгай арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө батална. Хууль зүйн сайд төрийн захиргааны төв, нутгийн захиргааны болон шүүх, прокурор, хууль сахиулах бусад байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар зохиож байгаа ажлыг зохицуулах, гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж засгийн газарт оруулах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7-р зүйлийн 7.6-д зааснаар нутгийн захиргааны бүх шатны байгууллага а) харъяа нутаг дэвсгэртээ гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах, б) гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг өөрийн төсвөөс тусгайлан төсөвлөж санхүүжүүлэх, в) хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагыг дэмжин туслах чиг үүрэгтэй.<sup>15</sup>

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.7-д зааснаар “Бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурал нь нутаг дэвсгэр дээр гарч буй гэмт хэрэг, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах талаар харъяа нутаг дэвсгэрт оршин байгаа аж ахуйн нэгж, байгууллагаас зохиож байгаа ажлыг хэлэлцэж чиглэл өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг хянан батлана.”

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29-р зүйлийн 29.1.6-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг дарга нийтлэг бүрэн эрхийн хүрээнд а) тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын хууль тогтоомжийн хүрээнд удирдах, б) тухайн нутаг дэвсгэр дэх шүүх, прокурорын байгууллагын үйл ажиллагаагаа хараат бусаар явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлснээр гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд шууд бусаар оролцож байгаа юм.

Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг гарган хэрэгжүүлдэг эрүүгийн бодлогын субъектүүдэд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагууд хамаарна. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 4-р зүйлд зааснаар шүүх нь:

а) хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох,

б) Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, Үндсэн хуульт байгууллагыг хамгаалах,

в) хууль дээдлэх, шудрага ёс, ардчилсан ёсыг бэхжүүлэх,

г) хэрэг маргааныг шийдвэрлэх замаар гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, иргэний эрх зүйн ухамсар соёлыг дээшлүүлэх зэрэг эрхэм зорилгыг хэрэгжүүлнэ.<sup>16</sup> Прокурорын байгууллага нь төрийн эрүүгийн бодлогын хэрэгжүүлэх субъект мөн.

Үндсэн хуулийн 56-р зүйлд “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж заасан. Прокурор нь Прокурорын байгууллагын тухай хуулийн 11-р зүйлд зааснаар захиргааны

зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа, 12-р зүйлд зааснаар эрүүгийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа, 13-р зүйлд зааснаар гүйцэтгэх ажилд тавих хяналт, 14-р зүйлд зааснаар ял эдлүүлэх, шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд тавих хяналт зэргийг хэрэгжүүлж байгаагаараа гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд шууд оролцогч болдог.

Прокурор нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавихдаа Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 193-р зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.<sup>17</sup> Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 190-р зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тогтоомогч хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, зохих хуулийн этгээдэд тэрхүү шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авхуулахаар мэдэгдэл бичиж хуулбарыг хэрэгт хавсаргана”, энэ зүйлийн 2 дахь хэсэгт “Хуулийн этгээд нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын мэдэгдлийг дагуу шаардлагатай арга хэмжээ авч, 1 сарын дотор тэр тухай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорт хариу мэдэгдэх үүрэгтэй” гэж заасан нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой зохицуулалт юм.

Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 10-р зүйлд зааснаар Цагдаагийн байгууллага нь:

1) Гэмт хэрэг, нийгмийн хэв журмаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн шалтгаан нөхцөлийг тогтоож арилгах ажлыг хууль тогтоомжид заасан арга хэрэгслээр хэрэгжүүлэх,

2) гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа болон үйлдэж байгаа тухай мэдээллийг авмагц таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх шуурхай арга хэмжээ авах,

3) гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц түүнийг бүрэн илрүүлэх арга хэмжээ авах,

4) хуулиар харъяалуулсан эрүүгийн хэрэгт хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа явуулах,

5) нутгийн захиргааны болон төрийн бус байгууллагаас зохион явуулж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж, давтан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хорих ял эдэлж суллагдсан хүнд захиргааны хяналт тогтоох,

6) гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн туслалцаа, тэдний хамтын ажиллагаанд түшиглэн зохион байгуулах,

7) энэ хуулийн 11-р зүйлд зааснаар гудамж, талбай, үйлчилгээний газар, нийтийн тээврийн буудал, орон сууц зэрэг олон нийтийн газар хууль тогтоомжоор болон төрийн эрх бүхий бусад байгууллагаас тогтоосон нийтээр дагаж мөрдөх журмыг сахиулж, хүн амын амгалан тайван байдлыг хамгаалах,

8) хүмүүсийг эрэн сурвалжлах (хуулийн 12-р зүйл),

9) хуулийн 13-р зүйлд хуулийн 13-р зүйлд заасан зорилгоор гүйцэтгэх ажил явуулах,

10) цагдан хорих, баривчлах, албадан саатуулах (15-р зүйл),

11) ял эдлүүлэх тогтоол биелүүлэх (16-р зүйл),

12) эрүүлжүүлэх (17-р зүйл),

13) замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах (18-р зүйл) зэрэг гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлдэг эрүүгийн бодлогын гол субъект юм.

Төрийн бус байгууллага, иргэд эрүүгийн бодлогыг хэрэгжүүлэгч субъект юм.

Аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээд нь:

а) байгууллагынхаа дотоодод болон үйл ажиллагаа явуулж байгаа хүрээндээ гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авах,

б) ажилтнууддаа гэмт хэсгээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийг сурталчлах,

в) гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах талаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын мэдэгдэл, зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, аж ахуйн нэгж түүний дагуу тодорхой арга хэмжээ авч, хариуг 1 сарын дотор өгч байх үүрэгтэй субъектүүд юм.

Иргэд эрүүгийн бодлогын хэрэгжүүлэгч субъект болохын хувьд:

а) нийгмийн хэв журам сахихыг бусдаас шаардах,

б) гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд шаардлага тавих,

в) архидан согтуурч, нийгмийн хэв журмын зөрчил гаргаж байгаа этгээдийг эрүүлжүүлэх байргүй газар амь нас, эрүүл мэндэд нь хохирол учруулахгүйгээр эрүүлжүүлэх, үйлдлийг таслан зогсоох арга хэмжээ авах,

г) гэмт халдлагаас эд хөрөнгө, өөрийн буюу бусдын амь нас, эрүүл мэндийг хуулийн хүрээнд хамгаалах,

д) нутгийн захиргааны байгууллага харъяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахдаа иргэдийг татан оролцуулсан тохиолдолд нийтийн эргүүлд гарах, хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрээр ажиллах, нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчаар ажиллах үүрэг гүйцэтгэж гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд оролцоно.

Төрийн эрүүгийн бодлогын хэрэгжилтийг гэмт явдлын хөдөлгөөн, хандлагад гарч байсан өөрчлөлт харьцангуй тогтвортой гэгдэж байсан 1989 оныг 1999 оныхтой, Эрүүгийн хууль батлагдан хэрэгжсэн 2003 оны гэмт явдлын байдлыг 2012 оныхтой тус тус харьцуулан судлах шаардлагатай бөгөөд ингэж судалснаар илүү бодитой дүр зураг гарна гэж үзлээ.

1989 онд улсын хэмжээнд нийт 7624 гэмт хэрэг бүртгэгдэж байсан бол 1999 онд 23,352 болж 3,6 хувиар эрс өссөн зураглал харагдаж байна. 1989 онд хүнийг санаатай алах гэмт хэрэг 86, дээрэмдэх гэмт хэрэг 116, хулгайлах гэмт хэрэг 2709, хүчиндэх гэмт хэрэг 374, танхайрах гэмт хэрэг 909, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 825, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 461 үйлдэгдэж байсан бол 1999 онд хүнийг санаатай алах гэмт хэрэг 156 болж 1,8 хувиар, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг 457 үйлдэгдэж 3,9 хувиар, хулгайлах гэмт хэрэг 11676 болж 4,3 хувиар, танхайрах гэмт хэрэг 2497 болж 2,7 хувиар тус тус эрс өссөн үзүүлэлт гарч байна.

Гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг авч үзвэл 1989 онд гэмт хэргийн улмаас 553 хүний амь нас хохирсон, 1801 хүний бие махбодод ямар нэгэн гэмтэл учирч байсан бол 1999 онд бүртгэгдсэн 23352 гэмт хэргийн улмаас 1281 хүний амь нас хохирч, 6238 хүн ямар нэгэн бэртэл авчээ.

Материаллаг хохирлыг авч үзвэл 1989 онд гэмт хэргийн улмаас улсад 20,2 сая төгрөгийн, иргэдэд 4,9 сая төгрөгийн нийт 25,1 сая төгрөгийн хохирол учирсан бол 1999 онд улсад 24206,9 сая, иргэдэд 7774,7 сая төгрөгийн нийт 31981,6 сая төгрөгийн хохирол учирсан байна. Сүүлийн 10 жил буюу 2003–2012 онд нийт 197959, жилд дунджаар 19796 гэмт хэрэг бүртгэгдэж, төр, засаг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад нийт 380,6 тэрбум жилд дунджаар 38,1 тэрбум төгрөгийн эд материалын хохирол учирч нийт 15746, жилд дунджаар 1575 хүн гэмт хэргийн улмаас нас барж 7457, жилд дунджаар 7452 хүн хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл авсан байна.

Гэмт хэргийн хөдөлгөөнийг авч үзвэл, 2003–2012 онд нийт 197959 гэмт хэрэг, жилд дунджаар 19796 гэмт хэрэг бүртгэгджээ. Жил тутам дунджаар 239 хэргээр буурчээ. 2006, 2007, 2012 онд гэмт хэргийн өсөлт хамгийн өндөр хувьтай байсан байна.

Гэмт хэргийн төрлийг авч үзвэл нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 34.4 хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах, 23.1 хувь нь бусдын бие махбодод хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учруулах, 8.5 хувь нь танхайрах, 7.3 хувь нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг, 3.9 хувийг бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, 3.2 хувийг бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, 3.2 хувийг бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, 1.6 хувь нь бусдын эд хөрөнгийг булаах, 1.7 хувийг хүчиндэх, 1.4 хувийг хүнийг санаатай алах, 0.9 хувь нь аж ахуйн эсрэг, 0.5 хувь нь албан тушаалын, 13.3 хувь нь бусад төрлийн гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

Гэмт хэрэг үйлдэгчдийн байдал: Сүүлийн 10 жил буюу 2003–2012 онд нийт 197959, жилд дунджаар 19796 гэмт хэрэг бүртгэгдэж, энэ гэмт хэрэгт нийт 181037, жилд нийт 18104 хүн гэмт хэрэгт холбогдон, сэжигтнээр тооцогдож шалгагдсан байна. Тэдний 19715 буюу 10.9 хувь эмэгтэйчүүд байна.

Гэмт хэрэг үйлдэгчдийн зарим онцлог байдал: 2003–2012 онд гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн 25.1 хувь нь архидан согтуурсны улмаас буюу согтуугаар, 22.1 хувь нь бүлэглэн гүйцэтгэсэн, 1.2 хувь нь урьдчилан үгсэж тохиролцж, 7.3 хувь нь урьд шүүхээр ял шийтгэгдсэн хүмүүс байжээ.

Гэмт явдлын хөдөлгөөн, хандлагыг дээр дурдсан аргачлал 10 жилийн үечлэлтэйгээр харьцуулан судлахад 1989 оны байдлаас 1999 онд гаралт эрс өссөн, хор аюул илт нэмэгдсэн, 2003 оноос 2012 он хүртэл хугацаанд энэ хандлага үргэлжилсэн нь харагдлаа. Төрийн эрүүгийн бодлого оновчтой, үр ашигтай байх гол шалгуур бол эрүүгийн хуульд заасан



ялын төрөл, хэмжээг гэмт хэргийн нийгмийн хор аюулын хэм хэмжээ, шүүгдэгчийн хувийн байдалд хэрхэн тохируулан оногдуулж байсныг шүүхийн тоо бүртгэлд тулгуурлан тодорхойлох явдал юм.

Одоогийн Эрүүгийн хууль 2002 оны 1-р сарын 3-нд батлагдаж, мөн оны 9-р сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдсөн боловч ялын судалгааг 2003 оны байдлаар, өөрөөр хэлбэл бүтэн жилээр авч үзэхэд 2003 онд Монгол Улсын шүүхүүд 10906 холбогдогчтой 6931 хэрэг хүлээн авч, 650 холбогдогчтой 400 хэргийг мөрдөн байцаалтад буцааж, 569 холбогдогчтой 267 хэргийг хэрэгсэхгүй болгож 9029 холбогдогчтой 5874 хэргийг таслан шийдвэрлэж 658 холбогдогчтой 390 хэргийн үлдэгдэлтэй байв. Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 2002 онтой харьцуулбал 36.0 хувиар, ял шийтгүүлэхэд 30.6 хувиар буурсан байгаа нь 2002 оны Эрүүгийн хуулийн эерэг зохицуулалттай холбоотой юм.<sup>18</sup>

Хүнийг санаатай алсан 175 гэмт хэрэгт 198 хүн, хүнд гэмтэл санаатай учруулсан 267 гэмт хэрэгт 286 хүн, хулгайлах 2245 гэмт хэрэгт 400 хүн, танхайрах 853 гэмт хэрэгт 1242 хүн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг 445 гэмт хэрэгт 478 хүн, албан тушаалын 19 гэмт хэрэгт 41 хүн шийтгэгдсэн байдлаас харахад хамгийн түгээмэл гардаг нь тодорхой харагдаж байна. Энэ төрлийн гэмт хэргүүд нийт шийдвэрлэсэн хэргийн 70 орчим хувийг эзэлж байна. 2003 онд 9029 хүн ял шийтгүүлснээс 6561 хүнд хорих, 2468 хүнд хорихоос өөр төрлийн ял оногдуулжээ. 6561 хүнд оногдуулсан хорих ялын 43.6 хувийг биечлэн эдлүүлсэн, 42.6 хувийг тэнссэн /хүндэвтэр гэмт хэрэг байсан/, 13.4 хувийг шийтгэх шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, 0.2 хувьд нь өршөөл үзүүлсэн байна. 2003 онд 2468 хүнд оногдуулсан хорихоос бусад төрлийн ялуудын 61.0 хувь баривчлах, 27.6 хувь нь торгох, 11.1 хувь албадан ажил хийлгэх, 0.3 хувь нь бусад ял байна.<sup>19</sup>

Шүүхээс хорих ял оногдуулах явдал буурсан нь 2002 оны хуульд баривчлах ял шинээр хуульчлагдсантай холбоотой юм. 2003 онд гэмт хэргийн улмаас 513 хүний амь нас хохирсон, 1247 хүний биед хөнгөн, 539 хүний биед хүндэвтэр, 446 хүний биед хүнд гэмтэл тус тус учирсан.

Хүний амь нас хохирсон үзүүлэлт 2002 оныхоос эрс өссөн нь 2002 оны Эрүүгийн хуулиас хүний бие махбодод хүнд гэмтэл учруулсны улмаас хохирогч нас барсан гэсэн хүндрүүлэх нөхцөл байдалыг хассантай холбоотой гэж үзэж байна. Гэмт хэргийн улмаас нийтдээ 6 тэрбум 196 сая төгрөгийн хохирол учирснаас иргэдэд 4 тэрбум 193 сая төгрөгийн, улсад 1 тэрбум 327 сая төгрөгийн, аж ахуйн нэгжид 676 сая төгрөгийн хохирол учирсан байна.

2012 онд шүүхүүд 10672 хүнд холбогдох 7065 эрүүгийн хэрэг хүлээн авч, 851 хүнд холбогдох 472 эрүүгийн хэргийг нийт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхэд буцааж, шүүгдэгч хохирогч эвлэрснээр 522 хүнд цагаатгах тогтоолоор 219 хүнд холбогдох хэрэгт хэрэгсэхгүй болгож, 8324 хүнд холбогдох 6161 хэргийг таслан шийдвэрлэж 736 холбогдогчтой 420 хэргийн үлдэгдэлтэй байгаагаас харахад 2003 оныхоос онцын ялгаа байхгүй байна. 2011 онтой харьцуулбал 2012 онд шийдвэрлэсэн хэрэг 4.8 хувиар, ял шийтгүүлэгчид 1.4 хувиар өсчээ. 2012 онд хүнийг санаатай алсан гэмт хэрэг 259 үйлдэгдэж 2003 оныхоос 61 хэргээр өсчээ. Харин бусдын бие махбодод хүнд гэмтэл учруулах гэмт хэрэг буурсан.

2003 онд хулгайлах 2245 хэрэгт 4009 хэрэг шийтгэгдэж байсан бол 2012 онд 1281 хэрэгт 2227 хэрэг шийтгэгдсэн нь эрс бууралттай байгаа нь сонирхол татаж байна. 2003 онд ял оногдуулсан байдлыг 2013 оныхтой харьцуулбал 2003 онд 9029 хүн ял шийтгүүлж байсан бол 2012 онд 8324 болж буурсан. 2003 онд 6561 хүнд хорих ял оногдуулсан бол 2012 онд энэ үзүүлэлт 6457 болж бага хэмжээгээр буурсан, 2002 онд 2468 хүнд хорихоос өөр төрлийн ял оногдуулж байсан бол энэ төрлийн ялаар шийтгүүлсэн хүн 1728 болж 740-өөр буурчээ.

2012 онд хорих ял шийтгүүлсэн 6457 хүний 2691 хүн ялыг биечлэн эдлүүлсэн 3217 хэргийн ялыг тэнссэн. 480 хүнд ял оногдуулсан шийтгэх тогтоолыг хойшлуулсан, 69 хүнд өршөөл үзүүлсэн. 2012 онд ял шийтгүүлсэн хүмүүст 77.6 хувьд нь хорих, 5.8 хувьд албадан ажил хийлгэх, 11.7 хувьд баривчлах, 3.2 хувь буюу 272 хүнийг 1 тэрбум 317 сая төгрөгөөр торгох ял оногдуулжээ. Эд хөрөнгө хураах нэмэгдэл ялыг 478 хүнд хэрэглэн 193.8 сая төгрөг

гаргуулсны дээр тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг 677 хүнд нэмэгдэл ялын чанартайгаар оногдуулжээ.

2003 онд гэмт хэргийн улмаас нийтдээ 6 тэрбум 196 сая төгрөгийн хохирол учирч байсан бол 2012 онд 21 тэрбум 982 төгрөг болж бараг 4.0 хувиар өсчээ. 2003 онд 513 хүний амь нас хохирч байсан бол 2012 онд 654 болж бага зэрэг өссөн, 2232 хүний бие махбодод хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учирч байсан бол 2963 болж өссөн зураглал харагдаж байна.<sup>20</sup>

2002 оноос 2012 оныг дуустал хугацаанд анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэрэг, шийтгэгдсэн хүмүүсийн талаархи шүүхийн тоо бүртгэлийг судалж үзэхэд 2002 онд буюу эрүүгийн хууль батлагдаж мөрдөгдсөн жилд хамгийн олон буюу 13007 хүнд холбогдох 9183 гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байна. 2003 оноос хэрэг 5874 болж 3309 хэргээр буурсан бөгөөд энэ үзүүлэлт 2004-2005 онд бага зэрэг өсөлттэй, 2005-2010 он хүртэл хугацаанд нэг түвшинд (5558-5460) байж байгаад 2012 онд 6161 болж бага зэрэг өссөн байна.

Шийтгэгдсэн хүмүүс 2002 онд 13007 байснаа дараах онуудад буюу 2003-2010 хүртэл 7000-8000-ын буурсан түвшинд байж байгаад 2011 онд 8210, 2012 онд 8324 болж өссөн үзүүлэлттэй байгаагаас дүгнэлт хийвэл шийтгэгдсэн хүмүүс, хэргийн тоо нэг түвшинд хэлбэлзэлж байна.

Энэ харьцуулсан судалгаанаас 2002 оны Эрүүгийн хуулийн бодлого чангарсан байдал харагдахгүй байна. Шүүх шүүгдэгчнэрт хорихоос өөр төрлийн ял түлхүү хэрэглэж байгаа, хорих ял оногдуулсан шийтгэх тогтоолыг хойшлуулсан, тэнссэн шийдвэр гаргаж байжээ гэсэн дүгнэлт хийж байна.

#### **1.5. Орчин үеийн эрүүгийн бодлогын үндсэн чиглэл**

1. УИХ-ын 1998 оны 18-р тогтоолоор батлагдсан “**Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр**” болон УИХ-ын тогтоолоор 2000 онд баталсан “**Монгол Улсын Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө**”-нд тусгагдсан шүүхийн салбарын шинэчлэл, үйл ажиллагааг боловсронгуй болгох заалт, 2009 онд УИХ-ын 38-р тогтоолоор баталсан “**Монгол Улсын Хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн** 91, 94, 96, 112-р заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009 оны 105-р зарлигаар батлагдсан “**Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөрбөр**”-ийг 3,1-3,3 дахь заалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд бололвсруулагдаж 2012 оны 03-р сарын 07-нд УИХ-аас баталсан

а/ Шүүхийн тухай хууль

б/ Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль

в/ Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль

г/ Эвлэрүүлэн зуучлалын тухай

д/ Шүүхийн захиргааны тухай

е/ Хуульчийн эрх зүйн байдлын тухай эдгээр багц хуулиудыг амьдралд хэрэгжүүлэх замаар явахаар шударга ёс бэхжих, хараат бус, иргэдийн эрх, эрх чөлөө, ардчиллын үнэт зүйлийг шударгаар хамгаалдаг шүүхийн тогтолцоог төлөвшүүлэх

2. Хүний аюулгүй байдал, тухайлбал амьд явах, аюулгүй амьдрах эрх болон гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах эрх зүйн найдвартай, баталгаатай орчин бүрдүүлэх,

3. Монгол Улсын амин чухал эрх ашиг болох тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, эв нэгдэл, үндсэн хуульт байгууламж, хил хязгаарын халдашгүй дархан, бүрэн байдлыг гэмт халдлагаас хамгаалах

4. Иргэдийн амьдрах орчны болон хүрээлэн байгаа байгаль орчны аюулгүй байдал, хүн амын эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах талаар эрх зүйн таатай орчин бүрдүүлэх

5. Иргэдийнхээ өмчлөх, аж ахуйг эрхлэх эрх, төрийн эдийн засгийн аюулгүй байдлыг найдвартай хангах

6. Зохион байгуулалтын төрийн эрх мэдэлтнүүд оролцсон авлига, албан тушаалын гэмт явдалтай хийх тэмцлийг эрчимжүүлэх, хүлээлгэх хариуцлагыг чангатгаж эрүүгийн хариуцлага гаргаагүй байх, шударга байх зарчмыг бодитойгоор хэрэгжүүлэх.

7. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 13.4.4-д заасан “Иргэдийг үндэстэн дамнасан гэмт халдлагаас” хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн зохион байгуулалтын болон эрх зүйн орчин бүрдүүлэх

8. Хүн хулгайлах, хүн барьцаалах, хүн худалдаалах, хүний цус эд эрхтэнг хууль бусаар авах, худалдах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдэх, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар олж авах, наймаалах, террор үйлдэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, санхүүгийн луйвар хийх зэрэг шинэ төрлийн зохион байгуулалттай гэмт хэргүүдтэй хийх тэмцлийг хүчтэй болгох.

9. Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, иргэн, төр, байгууллага аж ахуйн нэгжийн мэдээллийн бүрэн байдал, нууцлагдсан, хүртээмжтэй баталгаажуулах зорилтыг хангахын тулд юуны өмнө мэдээллийн аюулгүй байдлыг хангах суурь хуулийг баталж, одоогийн эрүүгийн хуульд байгаа кибер гэмт хэргийн төрлийг олшруулж, хүлээлгэх хариуцлагыг чангатгах

10. Эрүүгийн салбарын болон хууль сахиулахын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилтын хүрээнд гэмт хэргийн тухай, зөрчлийн тухай, гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай, цагдаагийн албаны тухай, хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай, маршалын албаны тухай, Мөрдөх албаны тухай зэрэг багц хуулийг Монгол Улсын үндсэн хууль, Монгол Улсын Олон улсын гэрээ, Конвенцийн агуулга, үзэл санаанд нийцүүлэн боловсруулж батлуулах

11. Нийгмийн аюулгүй байдал, эрх зүйн журмыг баталгаатай сахиулдаг, иргэд чанд мөрддөг үйл явдлыг хэвшүүлэх

12. Гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг шинжлэх ухааны аргаар судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг оновчтой боловсруулж хэрэгжүүлэх

13. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

14. Хууль сахиулах байгууллагуудыг боловсон хүчин, ажиллах санхүү, материал техникийн хангалтыг санхүүжүүлэхэд төрөөс онцгой анхаарах

15. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай үинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг улам хөгжүүлэх үр ашигтай хамтран ажиллах, энэ чиглэлээр олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орох

16. Хэрэг бүртгэх, мөрдөн шалгах, шүүхээр хэргийг хянан шийдвэрлэх оролцогчдын эрхтэй холбогдсон Монгол Улсын Олон улсын гэрээний холбогдох заалтуудыг бүтээлчээр хэрэглэдэг тогтолцоог бүрдүүлэх.

17. Хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис, галт зэвсэг наймаалцах, террор үйлдэх, мөнгө угаах, хүн худалдаалах, Кибер гэмт хэрэг үйлдэх, төрийн албан тушаалтны оролцоо бүхий авлига, албан тушаалын зохион байгуулалттай нийгмийн хор аюул ихтэй, далд үйлдэгддэг, илрүүлэхэд удаан хугацаа шаарддаг гэмт хэргүүдийг дагнан мөрдөх чиг үүрэг бүхий мэргэшсэн мөрдөх албыг шинээр байгуулж, олон байгууллагын дэргэдэх мөрдөн байцаах албуудыг нэгтгэн зохион байгуулах

18. Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын одоогийн бүтэц, тогтолцоог шинэчилж, үйл ажиллагааны эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох

19. Прокурорын байгууллагын ажиллах орчин нөхцөл, албан байр, унаа, холбооны хэрэгсэл, цахим сүлжээ, техник хэрэгслээр бүрэн хангах, прокурорын орон тоог цалин хангамжийг нэмэгдүүлэх, өнөөгийн дэлхийн чиг хандлагад нийцүүлэн, чиг үүргийг төгөлдөржүүлэх зорилгоор уг байгууллагын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, мөн түүнчлэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хүний эрхийг зөрчсөн зарим онцгой ажиллагаанд прокурор зөвшөөрөл өгдөг журмыг бүрмөсөн халж энэ эрхийг шүүгчдэд шилжүүлэх, прокурор зөвхөн яллах бус хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрхийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлдэг болгох.

Гэмт хэрэгтэй тэмцэх ухаалаг бодлого боловсруулах нь нийгэмд шууд нөлөө үзүүлдэг. Эрүүгийн хууль тогтоомжийн чиглэлээр бодлого боловсруулах үйл явцад хувь хүн буюу бүлэг хүмүүс нь бодлогын шийдвэрийн үр дүнг шууд буюу шууд бусаар сонирхож байдаг. Тухайлбал, сонирхогч талууд нь төрийн албад, бодлогын зөвлөхүүд, төрийн бус эсвэл нийгмийн өргөн хүрээний хувь хүн буюу хэсэг бүлэг хүмүүс, тэр байтугай гэм буртай нь шүүхээр тогтоогдож ял эдэлж байгаа хүмүүс, гэмт хэргийн хохирогчид байдаг. Энэ тохиолдолд төрийн байгууллага нь бодлогын шинжээчид эсхүл бодлогын судалгааны

байгууллагуудыг асуудлыг нарийн судалж хэрэгжүүлэх төрийн бодлогын үндэс болох бодлогын зөвлөмж гаргахыг хүлээж байдаг.

Шударга ёсыг хамгаалах тогтолцооны үндсийг бүрдүүлэхэд анхаарч, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, Хууль зүйн үндэсний хүрээлэн, МУИС-ын Хууль зүйн сургууль, Хууль сахиулахын хх сургууль зэрэг судалгаа, эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн, судлаачдын зүгээс Эрүүгийн хуулийн эерэг болон сөрөг үр нөлөө, хэрэгжилтийн талаар хийсэн 10 гаруй судалгаанд<sup>21</sup> үндэслэн гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогын үзэл баримтлал, зарчим, ерөнхий, тусгай ангийг бүхэлд нь шинэчлэх талаар байр суурь, саналыг бүхэлд нь харгалзан үзэх хэрэгтэй байна.

Доорх хүснэгтээс тухайн улс төрийн хүчний үзэл, баримтлалаас хамаарч гэмт хэрэг, ялын тухай бодлого тодорхойлогдож байгааг олж харж болно.

### Улс төр, эдийн засгийн чиглэл, ялын бодлого<sup>22</sup>

|  | Байгууллын төрөл / Régime types/  |  |   |   |
|--|---|--|---|---|
| Нийгэм эдийн засаг, эрүүгийн индекс /Socio-economic & penal indices/ | Неолиберализм /Neo-Liberalism/  | Уламжлалт үзэл /Conservative corporatism/  | Нийгмийн ардчилсан үзэл /Social democratic corporatism/   | Дорны үзэл /Oriental corporatism/   |
| Нийгэм эдийн засгийн үзэл /Economic and social policy organization/  | Чөлөөт зах зээл, нийгмийн халамжийн үзэл/Free market, minimalist or residual welfare state/             | Нийгмийн халамжийн ерөнхий үзэл/Status-related, moderately generous welfare state/   | Нийгмийн халамжийн нийтлэг үзэл/Universalistic, generous welfare state/   | Хувийн хэвшилд суурилсан нийгмийн халамжийн үзэл, хүнд суртлын болон загварчлах үзэл/Private sector based 'welfare corporatism'; bureaucratic, paternalistic/ |
| Үр дүнгийн ялгаа/Income differentials/                               | Туйлын/Extreme/   | Туйлын бус зарлан тунхагласан /Pronounced but not extreme/   | Харьцангуй хязгаарлагдмал/Relatively limited/   | Маш их хязгаарлагдмал/Very limited/   |
| Байдлын ялгаа/Status differentials/                                  | ёс төдийн тэгш байдлал/Formally egalitarian/  | Аядуу шаталсан уламжлалт албан тушаалын зэрэг дэвд үндэслэгдсэн/Moderately hierarchical, based on traditional occupational rankings/ | Өргөн тэгш байдал, зөвхөн албан тушаалын зэрэг дэвээр хязгаарлагдсан/Broadly egalitarian; only limited occupational status differentials/ | Уламжлалт зэрэг дэвд илэрхий тулгуурласан/Marke dly hierarchical, based on traditional patriarchal ranking/   |
| Иргэн-Төрийн харилцаа/Citizen-state relations/                       | Хүнчлэгдсэн, жижигрүүлсэн нийгмийн эрх хязгаарлагдсан /Individualised, atomised, limited social rights/ | Нөхцөлт болон нийгмийн дунд зэргийн эрх /Conditional & moderate social rights/   | Харьцангуй нөхцөлт бус нийгмийн ерөнхий эрх /Relatively unconditional & generous social rights/   | Феодалын шахуу үзэл, үүргийн хатуу мэдрэмж/Quasi-feudal corporatism; strong sense of duty/  |
| Улс төрийн чиг хандлага/Political orientation/                       | Барууны /Right-wing/  | Төвийн /Centrist/  | Зүүний/Left-wing/   | Төв-барууны/Centre-right/   |
| Хорих ялын   | High /Өндөр/  | Medium /Дунд/  | Low/Бага/   | Low /Бага/  |

|                             |  |                       |         |      |
|-----------------------------|--|-----------------------|---------|------|
| түвшин/Imprisonment rate/   |  |                       |         |      |
| Жишээ/Archetypal examples/  | АНУ  | Герман                | Швед    | Япон |
| Бусад жишээ/Other examples/ | Англи, Уэлс, Авсрали, Шинэ Зеланд, Өмнөд Африк | Франц, Итали, Голланд | Финлянд |      |

Манай улсад байгаа улс төрийн нам, хүчин нь өөрсдийгөө барууны, зүүний эсвэл төвийг сахисан үзэл баримтлалтай гэж зарлах боловч аль аль нь тухайн үзлийнхээ гэмт хэрэг, ялын тухай бодлогыг тодорхойлж байгаагүй юм. Тухайлбал, төрийн эрхийг барьж байгаа нам нийгмийн ардчилалд тулгуурласан үзэлтэй атал ял шийтгэлийн талаар баримталж байгаа хатуу бодлого тэдний үзлээс ангид байгааг олж харж болохоор байна. Төрийн эрх мэдлийг авахаар сонгуулиар өрсөлдөж буй нам, улс төрийн хүчин дээр дурдсан гэмт хэрэг, ял шийтгэлийн талаар баримтлах бодлого боловсруулах нь зайлшгүй агаад өөр, өөрийн онцлогтой байдаг. Ялсан нам, улс төрийн хүчин баримталж байгаа үзлээсээ хамаарч цаашид гэмт хэрэгтэй тэмцэх талаар төрийн бодлого, стратегийг тодорхойлодог.

Ардчилсан аль ч нийгэмд аливаа сонирхогч талууд сайн гэж үзсэн сонголтоо хамгаалахын тулд үр дүн өгөхүйц бүхий л аргыг хэрэглэдэг. 2012 онд сонгуулийн үр дүнгээр гарч ирсэн Засгийн газрын мөрийн хөтөлбөрт төрийн эрүүгийн бодлогын түвшинд хэд хэдэн томоохон асуудал дэвшүүлсэн .

- 1) Авлигал, хүнд сурталтай хийх тэмцэлд эрс шинэчлэл гаргана.
- 2) Шүүх, хууль хяналтын байгууллага, цагдаагийн байгууллагын тогтолцооны шинэчлэлт хийнэ.
- 3) Дотоод хэргийн яамны чиг үүргийн давамгайлсан байдлыг халах замаар Хууль зүйн яамны чиг үүрэг, зохион байгуулалтыг сайжруулж, хууль зүйн бодлогыг хүний эрх, эрх зүйт ёсны шинэтгэлд чиглүүлнэ.
- 4) Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлнэ.
- 5) Хүний эрхийн төлөөх үйл ажиллагааг хуульчдын ажил, мэргэжлийн ур чадварыг үнэлэх шалгуурын гол үзүүлэлт болгоно.
- 6) Ардчилсан нийгмийн зарчим, улс орны хөгжлийн шаардлагад нийцсэн орчин үеийн эрүүгийн хуультай болно.
- 7) Судалгаа, шинжилгээний ажлыг их, дээд сургууль болон бодлогын институт дээр төвлөрүүлж, шинжлэх ухаан, технологийг дэмжих сангийн санхүүжилтийг энэ зорилготой уялдуулна.
- 8) Шүүх үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, шийдвэр, гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг нээлттэй болгоно.
- 9) Шүүхийг тойргийн тогтолцоогоор шинэчлэн зохион байгуулж, прокурор, өмгөөлөл, мөрдөх албаны үйл ажиллагааг үүнд нийцүүлнэ.
- 10) Шүүхэд мөрдөн байцаалтын шатны шүүгчийн бүтцийг бий болгож, хүний эрхийн баталгааг дээшлүүлнэ.
- 11) Шүүхийн захиргааны болон шүүн таслах үйл ажиллагааг тусгаарлаж, Шүүхийн ерөнхий зөвлөлийг байнгын ажиллагаатай болгоно.
- 12) Шүүхэд “Маршалын алба” бий болгож, эрүүгийн хэргийн болон иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албыг ялгавартай зохион байгуулна.
- 13) Прокурорын байгууллагын хүний эрхийн болон гүйцэтгэх ажлын хяналт, процессын маргаан шийдвэрлэх чиг үүргийг шүүхэд шилжүүлнэ.
- 14) Захиргааны болон эрүүгийн зөрчлийг бүртгэх нэгдсэн сан бий болгож, эргүүлийн цагдаа, хилийн алба, татвар, бусад мэргэжлийн хяналтын үйл ажиллагаанд эрсдлийн удирдлагын менежментийг нэвтрүүлнэ.
- 15) Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, эрүүгийн цагдаагийн байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг мөрдөх алба болгон нэгтгэн зохион байгуулна.
- 16) Цагдаагийн байгууллагад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар мэргэшсэн нэгж байгуулна.
- 17) Мөрдөх албаны дэргэд шүүх шинжилгээний бүтцийг бий болгоно.
- 18) Хэв журмын цагдааг орон нутгийн мэдэлд шилжүүлж, иргэний хяналтын механизм бүрдүүлнэ.

19) Авлигатай тэмцэх асуудлыг шинэ түвшинд гаргаж авлигын индексийг эрс бууруулна.

20) Хахууль өгсөн талыг авлигын хэргээс чөлөөлөх асуудлыг хуульчилна.

Эрх зүйт төр нийгмийг цогцлоон хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгож буй хүний эрх, эрх чөлөөг ардчилсан ёс, шударга ёс, энэрэнгүй ёс нь нийгмийн эталон болж буй өнөө үед хууль хэрэглэх эрх бүхий албан тушаалтнаас хуулийг нэг мөр зөв ойлгож хэрэглэх шаардлагыг өндөр түвшинд хүргэхийг нөхцөлдүүлж байна.

### ЭРҮҮГИЙН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛИЙН БАГЦ ХУУЛЬ

/Planned legislations under Comprehensive criminal justice reform/

| №  | Боловсруулах хуулийн төслүүд                                     | Names of acts  |
|----|--|--|
| 1  | Гэмт хэргийн тухай хууль   | Criminal Code  |
| 2  | Гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай                                | Code of Criminal Procedure                           |
| 3  | Хууль сахиулах үйл ажиллагааны тухай                             | Law Enforcement Law                                  |
| 4  | Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай                        | Law on the Legal Status of Law enforcement officers  |
| 5  | Цагдаагийн албаны тухай  | Police Service Law                                   |
| 6  | Мөрдөх албаны тухай  | Law on the Investigation Service                     |
| 7  | Гэрч хохирогчийг хамгаалах тухай                                 | Law on the Protection of Crime Witnesses and Victims |
| 8  | Төлбөрийн чадваргүй яллагдагчид эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай | Legal Assistance Law                                 |
| 9  | Иргэний шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийн тухай                    | Civil Execution Law                                  |
| 10 | Ял эдлүүлэх, нийгэмшүүлэх тухай                                  | Correctional and rehabilitations act                 |
| 11 | Маршалын албаны үйл ажиллагааны тухай                            | Marshall Service Law                                 |
| 12 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай                           | Crime prevention act                                 |

Хууль Зүйн Яам “Эрх зүйн шинэтгэл” буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоог шинэчлэхэд онцгой анхаарч цагдаа, прокурор, шүүхийн байгууллага тэдгээрийн үйл ажиллагаа явуулах хууль тогтоомж, өдөр тутам хэрэглэдэг эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиудыг бүхэлд нь шинэчлэхийн хамт, түүнийг үр дүнтэй ажиллуулах хуулийн дэд бүтэц бий болгох талаар тооцоо, судалгаа гаргасныг Хууль зүйн сайд Х.Тэмүүжин танилцуулсан билээ.

| Шударга ёсыг хамгаалах тогтолцоо                                   |                             |   |  |
|--|-----------------------------|---|--|
| <b>Материаллаг хүрээ:</b> Ял шийтгэл хүлээлгэх зарчмыг тодорхойлох |                             | <b>Процессын хүрээ:</b> Зөрчил, гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулах |  |
| <b>Гэмт хэргийн тухай хууль</b>                                    | <b>Зөрчлийн тухай хууль</b> | <b>Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хууль</b>                                 | <b>Гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль</b> |
| Зөрчил, гэмт хэрэгт тооцох үндсэн зарчмыг                          |                             | Хүний эрхэнд халдах, халдашгүй эрхийг хязгаарлах                                  |  |

|  |  |  |  |
|--|--|--|--|
| тодорхойлно.   |  | үндэслэл, журмыг хуулиар тодорхойлно.  |  |
| Гэмт хэрэг, түүнд хүлээлгэх ял, ялын төрөл, хэмжээг тогтооно.                              | Зөрчил, түүнд хүлээлгэх шийтгэлийн төрөл хэмжээг тогтооно. | Хууль сахиулах, мөрдөх үйл ажиллагааны стандарт, баримтлах зарчим, үндэслэл, журам | Гэмт хэрэг шүүн таслах ажиллагаанд баримтлах зарчим, үндэслэл, журам                               |
| <b>Шүүхийг хамгаалах, шийдвэр биелүүлэх ажиллагаа</b>                                      |  |  |  |
| <b>Ял эдлүүлэх, нийгэмшүүлэх тухай хууль</b>   |  | <b>Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль</b>                               | <b>Маршалын албаны тухай хууль</b>   |
| Хорих, бусад төрлийн ял эдлүүлэх, ялтныг болон шоронгоос суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэх |  | Иргэний шүүхээс гарсан шийдвэрийг биелүүлэх  | Шүүхийн аюулгүй байдал, шүүхийн шатанд гэрч хохирогчийг хамгаалах, эрэн сурвалжлах, хуяглан хүргэх |
| <b>Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулиуд</b>                             |  |  |  |
| Цагдаагийн албаны тухай  | Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хууль            | Мөрдөх албаны тухай хууль  | <b>Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль</b>   |

### 1.6. Эрх зүй

Дэлхийн түүхээс үзвэл эрх зүйг тогтолцоонд хуваах олон янзын үзэл баримтлал байдаг боловч хамгийн түгээмэл нь түүнийг загварчлан хууль бүтээх техник, арга зүй, эрх зүйг илэрхийлэх хэлбэр болсон эрх зүйн эх сурвалжийн шинж байдлаар нь:

- 1) Ром-Германы буюу эх газрын эрх зүйн тогтолцоо
- 2) Англо-Саксоны буюу далайн эрх зүйн /хэвшүүлэн шийдэх/ тогтолцоо
- 3) Зан заншлын эрх зүйн тогтолцоо
- 4) Шашны эрх зүйн тогтолцоо хэмээх бүлгүүдэд хуваадаг.

Ром-Германы буюу эх газрын эрх зүйн тогтолцоо 12-13-р зуунд бүрэлдэн тогтсон ба түүний үүсэл хөгжилд МЭӨ 6-1-р зуунд бүрэлдсэн эртний Ромын эрх зүйн үзэл санаа нөлөөлсөн ба өнөө үед Европын болон Латин Америкийн дийлэнх орнуудад үйлчилж байна.

Энэ тогтолцооны гол онцлог нь эрх зүйн хэм хэмжээний акт, эрх зүйн зохицуулалтын үндсэн эх сурвалж нь болон ашиглагддаг ба тэдгээрийг нэлээд хийсвэр, нийтлэг шинжтэйгээр бүтээдэг тул ихэнх тохиолдолд эрх бүхий субъектүүдээс тайлбарлагдан үйлчлэлийн цар хүрээгээ тодорхойлдог байна. Манай орны эрх зүйн тогтолцоо нь агуулга, хууль зүйн техник, арга зүйн талаас нь авч үзвэл Ром-Германы эрх зүйн тогтолцоонд хамаарах ба энэ ч утгаараа нийгмийн боломжтой бүхий л харилцааг хуулийн зохицуулалтанд оруулах шаардлага тавигдаж байгаа ба энэ үйл явц үргэлжилж байгаа билээ.

- Ром-Германы эрх зүйн тогтолцоотой улс орнуудын эрх зүйн зохицуулалтын үндсэн эх сурвалж нь эрх зүйн хэм хэмжээний акт байдаг ба тэдгээр нь нэлээд хийсвэр, нийтлэг үг хэллэгээр хуульчлагддаг боловч түүгээр амьдралын тодорхой харилцаануудыг зохицуулдаг. Гэтэл амьдралын тохиолдол-туйлын олон, байнга өөрчлөгдөж, хувьсаж агуулгаа өөрчлөх боломжтой байдаг тул хүчин төгөлдөр эрх зүйн хэм хэмжээний цар, үйлчлэлийн хүрээг тогтоох объектив шаардлага үүсдэг.

Эрх зүйн хэм хэмжээг эрх зүйн акт, түүний зүйл, хэсэг, заалтад хууль зүйн техник ашиглан илэрхийлэх тул тэр нь хүн бүрт ойлгомжтой бус байдаг явдал. Учир нь хууль зүйн техник гэж эрх зүйн хэм хэмжээг боловсруулах, батлан гаргах, системчлэх үйл ажиллагаанд түүний агуулгыг тодорхой, бүрэн дүүрэн, үр ашигтай илэрхийлэх үүднээс баримтлах онолын хүрээнд боловсрогдсон, тусгай дүрэм, арга хэрэгслийн нийлбэр мөн.

- Хууль зүйн техникийн боловсронгуй бус байдал. Өөрөөр хэлбэл, хууль тогтоогчийн санаа бодол эрх зүйн актад буруу, эсхүл дутуу хуульчлагдах явдал байдаг.

- Нэг талаас эрх зүйн хэм хэмжээг батлан гаргасан, нөгөө талаас эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх нь цаг хугацааны хувьд өөр өөр орчинд явагддаг. Иймд энэ хугацаанд шинэ нөхцөл байдлууд бий болж тэдгээрийг уг хэм хэмжээний хүрээнд багтаан ойлгох уу гэдэг асуудал гардаг.

### **1.7. Уламжлал түүх**

Монгол орон хүйтэн дайны үед дэлхийн социалист системийн орнуудын бүрэлдэхүүнд багтаж олон жилийн туршид гэмт хэрэгтэй тэмцэх марксист онолыг удирдлага болгож ирсэн билээ. Тэр үед нийгмийн сэтгэлгээ бүхэлдээ коммунизмын үзэл сурталд хүчтэй автсан байсан бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд ч марксист-ленинист үзэл дангаар ноёрхож бусад үзэл урсгалуудыг үгүйсгэн хориглодог байлаа. Уг нийгэмд ёс суртахууны гажуудал, өмч хөрөнгийн шуналаас ангижирч коммунизмын үзэл сурталд бүрэн дүүрэн итгэсэн, хүмүүс амьдрах ёстой учраас гэмт хэргийн нөхцөл, шалтгаан социалист нийгэмд байхгүй гэсэн номлолыг баримталж тухайн үед үйлдэгдэж байсан гэмт хэргийн шалтгааныг өнгөрсөн нийгмээс үлдэж хоцорсон муу зуршил, капиталист системийн сөрөг нөлөөлөлтэй холбон тайлбарладаг байв.

Энэ шалтгаанууд удахгүй арилж дэлхийн бүх улс коммунизмын замд орно, өнгөрсөн нийгмийн үлдэгдлийг даван туулж түүнээс уламжлагдсан муу зуршил ой ухаанаас арилна, тэр үед хүмүүс гэмт хэрэг үйлдэхээ болино гэсэн хийсвэр хэтийн прогнозад үндэслэсэн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогыг төрөөс боловсруулж хэрэгжүүлдэг байсан юм.

Гэмт хэрэгтэй тэмцэх тэрхүү бодлогын хүрээнд хүмүүсийн хувийн өмчийн ашиг сонирхлыг дарангуйлан сааруулах, төрийн буюу социалист хэмээн нэрлэдэг байсан өмчийг өөрийн өмч гэж үзэж хандлагыг нийгмийн дэд хуулийн дарангуйлал дор албадан төлөвшүүлэхэд гол анхаарлаа хандуулдаг байсан юм. Тухайлбал, манай улсын социализмын үеийн Эрүүгийн хуульд хувийн өмчийг хулгайлах гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлага харьцангуй бага байхад социалист өмчийн эсрэг үйлдсэн онц хүнд гэмт хэрэгт цаазаар авах ял ногдуулдаг байв. Ийнхүү тухайн үеийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогод улс төр, эдийн засгийн хатуу байр суурь хүчтэй нөлөө үзүүлж байв. Энэ бол ганц манай улсын биш, хуучин социалист системийн хэмжээний гажуудал байсан юм.

Хэдийгээр манай улсад гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах судалгааны байгууллага ажиллаж байсан боловч судалгаандаа үндэслэн гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг тухайн нийгмийн гажуудал, түүний үр дагавартай холбож зориглон гаргаж тавих боломж байгаагүй. Ингэх нь коммунизмын үзэл номлолд ноцтой харшилна гэдгийг судлаачид тооцож бүтээл болон судалгааны үр дүнгийн талаарх танилцуулгадаа тухайн нийгмийг шүүмжлэхээс зайлсхийдэг байв.

Үүний уршгаар Монгол оронд Криминологийн шинжлэх ухааны хөгжил анхнаасаа л коммунизмын үзэл сурталд захирагдсан, хэт өрөөсгөл байдлаар хөгжиж ирсэн бөгөөд энэ нь гэмт явдлын мөн чанарыг бодитойгоор таньж мэдэх, түүнийг нийгмийн хүчин зүйлүүдтэй холбож судлахад саад болсон юм.

1990-ээд оноос хүйтэн дайны үе шувтарч, социалист систем задран унаж, энэ системд байсан орнуудад улс төр, эдийн засаг, нийгмийн бүх салбарт эргэлтийн чанартай өөрчлөлт гарсан ба манай оронд ч ардчилсан хөдөлгөөн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн билээ. Үүний үр дүнд Монгол Улс ардчилсан хөгжлийн замд орж сүүлийн 15 жилийн турш шилжилтийн үеийг туулж байна. Энэ хугацаанд тус оронд нийгмийн харилцаа, түүний эрх зүйн зохицуулалт, хүмүүсийн хүсэл сонирхол, өмчид хандах хандлага, чөлөөт зах зээлийн хөгжил гээд олон зүйл шинэчлэгдэн өөрчлөгдлөө. Шилжилтийн эхний жилүүдэд хүмүүс энэ олон талын өөрчлөлтөд цочирдон барьц алдах нь их байсан бол сүүлийн жилүүдэд дасан зохицох нь давамгайлах хандлагатай боллоо. Гэхдээ дасан зохицож байгаа хандлагыг криминологийн шинжлэх ухааны үүднээс авч үзвэл тэр бүр нааштай эерэг гэж хэлэхээргүй зарим дүр зураг ажиглагдаж байна.

Социализмын үед хүн бүр хувийн өмч хөрөнгөгүй, хийсэн хөдөлмөрийнхөө хөлсөөр аж амьдралаа залгуулан амьдарч байсан. Улс орон зах зээлийн эдийн засагт шилжиж, төрийн өмч хувьчлагдах үйл ажиллагаа явагдсан ба түүнийг зарим сөрөг үзэгдлүүд дагалдах болов. Махны үнэ хадсан сургаар малын хулгай ихэсдэг бол нийгмийн халамжийн 21 мянга, оюутны 70 мянга согтуугаар гэмт хэрэг үйлдэх шалтгаан болж, өршөөлийн хууль давтан гэмт хэргийн өсөлтөд шууд нөлөөлж байна.



Улсын Их Хурлаас 2007 оны 8 дугаар сарын 9-ний өдөр Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлан гаргасан ба уг хууль нь 2007 оны 9 дүгээр сарын 6-наас хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нилээд тооны нэмэлт, өөрчлөлт оруулснаас зарчмын шинжтэй томоохон өөрчлөлт нь зарим хөнгөн гэмт хэргийг хялбаршуулсан журмаар шалгаж шийдвэрлэх шинэ зохицуулалт юм.Хуулийн энэ шинэ зохицуулалтыг зөв ойлгож хэрэгжүүлэх шаардлага манай хуульчдын өмнө тулгарч байна.

## II. МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ЯВДЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хүрээнд гэмт явдлын түвшин, хөдөлгөөн, тархалтыг тодорхойлж, түүнээс учирсан хор хохирлыг илэрхийлэн гаргаж, гэмт явдлын цаашдын чиг хандлагыг нийгэм, эдийн засаг, эрүүгийн нөхцөл байдалтай уялдуулан авч үзлээ.

Сүүлийн 10 жилд<sup>23</sup> нийт **197959**(жилд дунджаар 19796) гэмт хэрэг бүртгэгдэж, төр засаг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад нийт **380.6 тэрбум**(жилд дунджаар 38.1 тэрбум) төгрөгийн эд материалын хохирол учирч, нийт **15746**(жилд дунджаар 1575) хүн нас барж, нийт **74517** (жилд дунджаар 7452) хүн хөнгөн, хүндэвтэр, хүнд хэлбэрээр гэмтсэн байна.

Монгол Улсад Эрүүгийн хариуцлага хүлээлгэх субъектийн насны доод хязгаар 16, зарим гэмт хэрэг дээр 14 байдаг учраас 16 ба түүнээс нас гэж авч үзсэн, мөн олон улсын түвшинд харьцуулах байдлаар 18-аас дээш насны хүмүүсийн тоонд харьцуулан бодож үзэв.

Албан ёсны статистикийн мэдээлэлд<sup>24</sup> үндэслэн тооцолоход жилд дунджаар 16 ба түүнээс дээш насны 10 000 хүнд 109, 100 000 хүнд 1093гэмт хэрэг, 18 ба түүнээс дээш насны 10 000 хүнд 117, 100 000 хүнд 1167гэмт хэрэг тус тус ногдож байгаа нь Монгол Улсын эрүүгийн нөхцөл байдлыг бусад улс оронтой харьцуулах үзүүлэлт юм. Үүнээс үзэхэд хүн ам багатай, гэмт хэргийн гаралтын түвшин өндөр, түүнээс үүссэн хор хохирол их байгаа нь харагдаж байна.

График-1





График-2

16 ба түүнээс насны 10 000, 100 000 хүн амд ногдох гэмт хэрэг



#### эмт хэргийн хөдөлгөөн:

Дэлхийд гэмт явдал ерөнхийдөө өсч байна. Сүүлийн 30-40 жилд гэмт явдал дунджаар 3-4 дахин өсчээ. Хуучин ОХУ-д 6-8 дахин, АНУ-д 7-8 дахин, Англи, Швецаард 6-7 дахин, Францад 5-6 дахин, Германд 3-4 дахин, Японд 1,5-2 дахин гэмт явдал өссөн байна.

Монгол Улсын 1968 оноос хойшхи 45 жилийн гэмт явдлын төлөв байдал, хандлагыг авч үзье.

#### Монгол Улсад гэмт хэрэг 1968-2013 онд 6.4 дахин<sup>25</sup> өсчээ.

**1961 оны** батлагдсан Эрүүгийн хуулийн гол үзэл баримтлал нь эхлээд төрийн, дараа нь нийгмийн, хамгийн сүүлд хүний эрх ашгийг гэмт халдлагаас хамгаалахад оршиж байсан бөгөөд ерөнхий анги 5 бүлэг, 44 зүйлтэй, тусгай анги 11 бүлэг, **221** зүйлтэйгээр батлагдсан байдаг. Гэмт хэргийн гаралт 1968 оноос 1984 он хүртэл тогтвортой байдлаар нэмэгдсэн нь тухайн үед нийгмийн байдал, хүн амын амжиргааны түвшинтэй холбоотой байсан. 1984 оноос 1988 он хүртэл буурсан нь нийгмийн өөрчлөлт явагдаж, хоршоо, нэгдэл, үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж, хүн бүр ажилтай, орлоготой жигд амьдрах боломж бүрдсэн нь гэмт хэргийн бууралтад нөлөө үзүүлсэн байх талтай.

**1987 оны** шинэчлэн найруулсан эрүүгийн хууль нь эрүүгийн хуулийг боловсронгуй болгоход чухал алхам болжээ. Эрүүгийн хуулийн тусгай ангийн гол онцлог нь хүний амь бие, эрүүл мэнд, эрх чөлөө, нэр алдрын эсрэг гэмт хэргийг социалист өмчийн эсрэг гэмт хэргийн өмнө оруулан системчилсэнд оршдог. Эрүүгийн хууль нь ерөнхий ангийг 5 бүлэг, 59 зүйлтэй, тусгай анги 13 бүлэг, **301** зүйлтэйгээр батлагдсан байна. Үүнээс үзэхэд урьд нь Эрүүгийн хуульд 221 гэмт хэрэг байдаг байсан бол 1987 онд 301 болгож тооны хувьд өссөнөөс гадна аливаа нийгмийн харилцааны өөрчлөлт, шинэчлэлтэй холбоотойгоор 1988 оноос 1997 он хүртэл гэмт хэрэг эрчимтэй өсчээ гэж болно.

Харин төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн хэлбэрт 1990 оны үед шилжиж, нийгэмд шинэ нөхцөл байдалд бүрэлдэж, төр, иргэд чөлөөт системд шилжиж, нийгмийн хяналт илт суларсан нь гэмт явдлын түвшин огцом нэмэгджээ.

**1993 оны** Эрүүгийн хууль нь шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлал, зарчим, агуулгад нийцүүлэн дагаж мөрдөж буй хуучин хууль тогтоомжид цогцолбор өөрчлөлтийг шаргуу, иж бүрэн хийх шаардлагатай болсон. Эдгээр нэмэлт өөрчлөлт нь олон хэвшилт эдийн засагтай зах зээлийн харилцаа, олон ишт үзэл бодлыг хамгаалж, олон улсын эрх зүйн хэм хэмжээг хүлээн зөвшөөрч, хүнийг дээдлэж, түүний эрх чөлөөт байдлыг эрхэмлэн хамгаалах чиглэлээр хийгдсэн чухал алхам болов. Өөрөөр эрх зүйн хэм хэмжээг хүлээн зөвшөөрч,

хүнийг дээдлэж, түүний эрх чөлөөт байдлыг эрхэмлэн хамгаалах чиглэлээр хийгдсэн чухал алхам болов. г шаргу

1993 оноос ардчилал үргэлжлэх 10 жилийн явцад гэмт хэргийн гаралт тогтвортой өндөр түвшинд байж, 2002 оноос буурсан байна. Энэ бууралт нь мөн л Эрүүгийн хууль 2002 онд шинэчлэн батлагдсантай холбоотой юм. Шинэ эрүүгийн хуулийн ерөнхий анги нь 4 хэсэг, 13 бүлэг, 78 зүйлтэйгээр, тусгай ангийг 7 хэсэг, 16 бүлэг, **225** зүйлтэйгээр батлагдсан. 2002 оноос хойш 2005 он хүртэл гэмт хэргийн гаралт тогтвортой буурсан хэдий ч түүнээс хойш жилүүдэд гэмт хэргийн гаралт өсөх хандлагатай боллоо.

2003-2012 онд нийт **197959**(жилд дунджаар **19796**) гэмт хэрэг бүртгэгджээ. Жил тутам дунджаар **239** хэргээр буурчээ. 2006, 2007, 2012 онд гэмт хэргийн өсөлт хамгийн өндөр хувьтай байсан байна.

Монгол Улс дахь гэмт хэргийн төлөв, хандлагаас үзэхэд тухайн үеийн нийгэм, эдийн засгийн шалтгаан гэж шууд хэлэхээс илүүтэй төр засгийн баримталж буй бодлого, Эрүүгийн хуультай шууд холбоотой гэсэн дүгнэлтийг ч хийж болохоор байна. Иймд тухайн нийгэм дэх сөрөг үзэгдэлтэй тэмцэхийн тулд сөрөг гэж үзэж буй нийгмийн харилцаатай тэмцэх, арилгахын тулд Эрүүгийн хуулийг оновчтой болгох нь гэмт явдлын чиг хандлагад шууд хамааралтай.

График-3

арин Монгол Улсын шүүхээр жилд дунджаар 5921 гэмт хэрэг шийдвэрлэгддэг бөгөөд бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт 2011 он хүртэл буурах хандлагатай байсан ч цаашид өсөх, мөн шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг хэлбэлзэлтэй байж ирсэнд цагдаа, прокурор, шүүхийн байгууллагын уялдаа холбоо, ажлын үр дүнд үнэлэлт дүгнэлт хийх асуудал бий гэж үзэж байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 1/3 нь шүүхээр шийдвэрлэгджээ.

График-4



Бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлт буурсан, цаашид ч мөн буурах хандлагатай байгаа нь бодит байдал дээр гэмт хэрэг үйлдэгдэх нь багассан, гэмт хэрэгтэй тэмцэж буй үйл ажиллагаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүн гэж үзэх эерэг талтай.

Нөгөө талаас гэм буруутай этгээдийн үйлдсэн гэмт үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрүүгийн эрх зүйн зохицуулалт оновчтой бус, гэмт хэргийн үйлдэгдэж буй арга, хэлбэр улам нарийсч, зохион байгуулалтын хэлбэрт шилжсэн, нууц далд хэлбэрт орсон болон гэмт хэрэгтэй тэмцэж буй байгууллагын тухайн цаг үеийн үйл ажиллагааны бодлого, зорилт, төлөвлөлт, хэрэгжүүлэх явцаас шалтгаалсан байх үндэслэлтэй юм.

Жилд 2203 гэмт хэрэг бүлгээр үйлдэгдэж байгаа нь нийт хэргийн 11.0 хувийг эзэлж байна. Гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн 20.3 хувь нь бүлэглэн үйлдсэн байгаагаас үзэхэд урьд

өмнө нь үйлдэгдэж байсан гэмт хэргийн арга нарийсч, бүлэг зохион байгуулалтын хэлбэрт шилжсэн нь харагдаж байна.


Мөн сүүлийн 4 жилийн хугацаанд 4914 хүн урьд ял шүүхээр ял шийтгэгдсэн дахин гэмт хэрэг үйлджээ. Монгол Улсын Шүүхээр 2012 онд 8324 хүнд холбогдох 6161 эрүүгийн хэрэг шийдвэрлэгдсэний 539 нь давтан, 995 нь 2 ба түүнээс дээш удаа, 22 гэмт этгээдийг онц аюултай гэмт хэрэгтнээр тооцсон байна. Түүнчлэн өнөөдөр хорих байгууллагад ял эдэлж буй 7000 орчим ялтны 49.4 хувь нь нь 2 ба түүнээс дээш ял шийтгэгдсэн, 200 орчим ялтан онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон байна.

Өөрөөр хэлбэл мэргэшсэн, эрмэшсэн гэмт этгээдүүд бий болон туршлагажиж байна. Энэ нь эрх зүйн зохицуулалт оновчтой бус, хорихоос суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэх тогтолцоо хангалтгүй, хувь хүний хүмүүжил, төлөвшил, нийгмийн ёс суртахуунтай холбоотой.

#### Гэмт хэргийн тархалт<sup>26</sup>:

Сүүлийн 10 жилд бүртгэгдсэн 20 мянган гэмт хэргийн 47.9 хувь нь орон нутагт, 52.1 хувь нь нийслэлд үйлдэгдсэн байна.

График-5



Харин гэмт хэргийн 2008 онд 52.7%, 2009 онд 55.7%, 2010 онд 54.8%, 2011 онд 56.1%, 2012 онд 58.4% нь Улаанбаатар хотод үйлдэгдэж, цаашид ч улам өсөх хандлага байна. Гэмт хэргийн гаралт төвлөрсөн суурин газруудад ихэвчлэн үйлдэгдэх боллоо. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод 2010 оны хүн амын тооллогын дүнгээр нийслэлд хүн амын 63 хувь нь оршин сууж байна гэсэн дүн мэдээ гарсан.

Дэлхийн том хотуудад гэмт явдлын түвшин 2-3 дахин их байв. Улаанбаатар хотод 1968-20011 онд гэмт хэргийн гаралт 10.2 дахин<sup>27</sup> өссөн. Өөрөөр хэлбэл Монгол Улсын хувьд “Улаанбаатар хот гэмт хэргийн үнэмлэхүй төв” болж байна. Хотжилт нь гэмт хэргийн явдлын хүчин зүйлс болж байна.

#### Гэмт хэргийн илрүүлэлт:

2007 оноос гэмт хэрэг илрүүлэлт тооцох аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэн өөрчилсөн. Өөрөөр хэлбэл “эзэн холбогдогч, сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй гэмт хэрэг”-ийн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоон, улмаар прокурорт



шилжүүлсэн тохиолдол бүрээр илрүүлэлтийг тооцдог болсон.

### Гэмт хэргийн төрөл

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 34.4 хувийг хулгайлах, 23.1 хувь нь бусдын бие махбодод хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учруулах, 8.5 хувь нь танхайрах, 7.3 хувь нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг, 3.9 хувийг залилан мэхэлж авах, 3.2 хувийг дээрэмдэх, 1.6 хувь нь булаах, 1.7 хувийг хүчиндэх, 1.4 хувийг хүнийг санаатай алах, 0.9 хувь нь аж ахуйн эсрэг, 0.5 хувь нь албан тушаалын, 13.3 хувь нь бусад төрлийн гэмт хэргүүд тус тус эзэлж байна.


График-6



### Гэмт хэргийн ангилал:

Нийт 2003-2012 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 37.2 хувь нь хөнгөн, 48.3 хувь нь хүндэвтэр, 12.4 хувь нь хүнд, 2.2 хувь нь онц хүнд ангиллын гэмт хэрэг тус тус эзэлж байна. Үүнээс үзэхэд хөнгөн, хүндэвтэр гэмт хэргийн гаралт ихэнхи хувийг эзэлж байна.


График-7



### Гэмт хэрэг үйлдэгдсэн зарим онцлог байдал:

2003-2012 онд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 2136 хувь нь архидан согтуурсны улмаас буюу согтуугаар, 12.0 хувь нь бүлэглэн гүйцэтгэсэн, 4.2 хувьд нь хүүхэд, 8.2 хувьд нь эмэгтэй хүн оролцож үйлдэгдсэн байна.

График-8




### Гэмт хэргийн улмаас учирсан хохирол:

Монгол Улсын Цагдаагийн байгууллага 2007 оноос эхлэн гэмт хэргийн улмаас хохирсон иргэн, байгууллагын мэдээллийн сан бүрдүүлж, статистик мэдээлэл гаргаж иржээ.

Улсын хэмжээнд 2007-2012 онд нийт **123456** гэмт хэрэг бүртгэгдэж, **112798** хүн холбогдон шалгагдаж, **118999** хүн эрүүл мэнд, эд хөрөнгө, сэтгэл санаагаараа, **3552** байгууллага, аж ахуйн нэгж эд хөрөнгөөрөө хохирчээ.


Гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүсийн 34.1 хувь нь эмэгтэй, 5.7 хувь нь насанд хүрээгүй, 34.0 хувь нь 18-30 насны, 14.7 хувь нь 31-35 насны, 46.1 хувь нь 36-аас дээш насны хүмүүс байжээ.

График-9



2003-2012 онд гэмт хэргийн улмаас нийт **15746**, жилд дунджаар **1575** хүн нас барж, нийт **74517**, жилд дунджаар **7452** хүн хөнгөн, хүндэвтэр, хүнд хэлбэрээр гэмтсэн байна.

График-10



2003-2012 онд гэмт хэргийн улмаас төр засаг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад нийт **380.6 тэрбум**, жилд дунджаар **38.1 тэрбум** төгрөгийн эд материалын хохирол учирч, түүнийг 107.6 тэрбум төгрөг буюу 28.3 хувийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.



График-11




Гэмт хэргийн улмаас дээрх онц их хэмжээний хохирол, аюул учрахаас өмнө **ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ** гөргөн хүрээнд, үр дүнтэй зохион байгуулах шаардлага байна.

#### Гэмт хэрэг үйлдэгчдийн криминологи шинж:

2003-2012 онд нийт **197959**, жилд дунджаар **19796** гэмт хэрэг бүртгэгдэж, энэ гэмт хэрэгт нийт **181037**, жилд дунджаар **18104** хүн гэмт хэрэгт холбогдон, сэжигтэнээр тооцогдож шалгагдсан байна.

График-12



Дээрхи гэмт хэрэг үйлдсэн нийт хүмүүсийн **19715 буюу 10.9 хувь нь эмэгтэй** хүн байна.

График-13




График-14





График-15

Ажилгүйдэл-ядуурал-архидалт уялдаатайгаар эрүүгийн нөхцөл байдалд сэргээр нөлөөлж байгаа нь тодорхой асуудал, ярьдаг нийтлэг хүчин зүйл юм.


Гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн тухайд бол 18-35 насны залуучууд, тодорхой эрхэлсэн ажилгүй, бүрэн дундаас доогуур боловсролтой, ажиллах идэвхитэй насны хүмүүс байгаа нь зарим төрлийн гэмт хэрэг дээр анхаарах асуудал мөн. Орлоготой, мөнгөтэй хүмүүс албан тушаал, эдийн засаг, хар тамхи, байгалийн баялаг ашиглахтай холбоотой гэмт хэрэгт холбогдож байна.

**Гэмт хэрэг үйлдэгчдийн зарим онцлог байдал:**

2003-2012 онд гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн 25.1 хувь нь архидан согтуурсны улмаас буюу



согтуугаар, 22.1 хувь нь бүлэглэн гүйцэтгэсэн, 1.2 хувь нь урьдчилан үгсэж тохиролцож, 7.3 хувь нь урьд нь шүүхээр ял шийтгэгдсэн хүмүүс байжээ.



### Дүгнэлт

Нийгэм дэх шударга бус явдал, хувь хүний ухамсар, зан төлөвшил, ёс зүй, хүн чанар, архидалт, ажилгүйдэл, ядуурал, хүн амын төвлөрөл, тээврийн хэрэгслийн эрчимтэй өсөлт, улс төр, эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлт зэрэг нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс нь улс орны эрүүгийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлж байгаа нь дамжиггүй юм. Эдгээртэй уялдуулан гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын хүрээнд зарим дүгнэлт, саналыг хийж байна.

1. Гэмт хэргийн гаралтын түвшин Эрүүгийн хуулийн өөрчлөлт, шинэчлэлтэй холбогдон өөрчлөгдөж хэлбэлзэж байна.

2. Гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирсон иргэн бүрт цагдаа, хууль сахиулах байгууллага хүрч ажиллах бодлого баримтлах. Иргэдээс цагдаагийн байгууллагад хандаж 2012 онд гэмт хэрэг, зөрчлийн талаарх 141276 гомдол, мэдээлэл ирүүлсэн бол өмнөх оныхоос 9.8 хувиар өсчээ. Энэ нь иргэд бухимдал, стресст орж, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирох, шударга бус үйл явдал нэлээдгүй байгаагийн илрэл. Нөгөө талаас хууль сахиулах байгууллагуудын үйлчилгээний хүртээмж нэмэгдэж байна. Гомдол, мэдээлэл өссөн ч гэмт хэргийн түвшин буурах хандлагатай байгаа нь дүгнэлт хийх асуудал мөн.

3. Хууль тогтоомжийг чанд мөрдүүлэх, иргэн бүр хуулиа мөрддөг байх эрх зүйн соёлыг төлөвшүүлэх бодлого баримтлах. Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2012 онд 795923 захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 21.8 хувиар өсөв. Насанд хүрсэн хүмүүсийн гуравны нэг нь захиргааны арга хэмжээ авагдсан нь иргэдийн хууль тогтоомж, нийтээр тогтоосон эрхийн актыг биелүүлэхгүй зөрчдөг монгол зан эндээс харагдаж байна. Нөгөө талаас цагдаагийн байгууллагаас хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж буй ажлын үр дүн юм.

4. Хор хохирол үүсэхээс нь өмнө гэмт явдлаас урьдчилан сэргийлэх бодлогыг нийгмийн бүхий л салбар, шатанд төлөвшүүлж, хэрэгжүүлэх. Монгол Улсын Төр, засгаас гэмт явдлын чиг хандлагыг урьдчилан харж, нийгэм, эдийн засгийн шинжтэй нийтлэг арга хэмжээг бүхий л салбарт авч үзэж, хөгжлийг төлөвлөх, хэрэгжүүлэх ёстой. Гэмт хэрэг илрүүлэхээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгох.

5. Архидан согтууралтай дээд, доод түвшинд эрчимтэй тэмцэх. Энэ төрлийн бизнес хийх боломжийг хаах. Согтууруулах ундааны үйлдвэрлэлийг багасгах, хэрэглээг дотоодод багасгаж чангатгах, үйлчилгээний цэгийг цөөлөх, согтууруулах ундааны үнийг нэмэгдүүлэх, гадагшаа импортыг дэмжих бодлого баримтлах.

6. Монгол Улсад гэмт хэрэг илрүүлэх, шийдвэрлэх механизмыг оновчтой болгох, шинэ арга, техник, технологи нэвтрүүлэх. Тагнуул, цагдаа, авлига, прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба зэрэг хуульд заасан харъяаллын дагуу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулдаг байгууллагын хэмжээнд өнөөгийн байдлаар 10 мянга орчим түдгэлзүүлсэн гэмт хэрэг байна. Үүний цаана олон хүн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон байгаа нь ойлгомжтой. Дээрээс нь бүрэн илрүүлж, нотлоогүйгээс шүүхээс нэмэлт мөрдөн байцаалтад хэрэг

буцах тохиолдол нэлээдгүй байна. Иймд гэмт хэрэг илрүүлэх, нотлох шинэлэг арга, техник, технологи ашиглах зайлшгүй шаардлага байна.

7. Хотжилтыг төлөвлөхөд гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлыг давхар төлөвлөх бодлого баримтлах. Гэмт хэргийн гаралт төвлөрсөн суурин газар, ялангуяа Улаанбаатар хот, Эрдэнэт, Дархан хотод гэмт хэргийн гаралт их байдаг. Хот, орон сууц хороолол, аливаа төлөвлөлтийг хийхдээ хүрээлэн буй орчинд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлогыг давхар авч үзэж байх нь зүйтэй.

8. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хөдөлгөөний оновчтой зохицуулалт үгүйлэгдэж байна. Монгол Улсын, тэр дундаа Улаанбаатар хотын тулгамдсан асуудлуудын нэг нь автомашины түгжрэл. Хүн амын хэт төвлөрөл, тээврийн хэрэгслийн эрчимтэй өсөлт, жолооч бэлтгэх, давтан сургах сургалтын үр нөлөө, замын дэд бүтэц, жолоочийн хөдөлгөөнд оролцох соёл, үүрэг хариуцлагаас шалтгаалан зам тээврийн осол, хэрэг, түүнээс учрах нийгэм, эдийн засгийн хор хохирлын хэмжээ нэмэгдэж, хүн нас барах, эрүүл мэндээрээ хохирох явдал жил дараалан нэмэгдэж байна.

9. Монгол Улсад голчлон үйлдэгддэг хулгай, бусдын бие махбодод гэмтэл учруулах, танхайрах, булаах, дээрэмдэх зэрэг гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх бодлогыг түлхүү баримтлах, тухайлбал эргүүл хяналтыг оновчтой төлөвлөх, камерын нэгдсэн системийг улсын хэмжээнд нэвтрүүлэх, нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах.

10. Шинэ төрлийн гэгдэх урьд өмнө нь төдийлөн үйлдэгдэж байгаагүй, зохион байгуулалттай, үндэстэн дамнасан, нууц далд аргаар үйлдэгддэг гэмт хэрэгтэй онцгой түвшинд тэмцэх бодлого баримтлах.

- Байгалийн баялаг, ашигт малтмал, ой мод, ус, ургамал, газар нутгийг хууль бусаар ашиглах явдал газар авлаа. Байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, эргэлтэд оруулах нь улс орны хөгжил дэвшил, ард иргэдийн амьдралтай чухал ач холбогдолтой хэдий ч байгалийн баялаг, ялангуяа ашигт малтмал-ыг хууль бусаар олборлох, хайгуул хийх, орчиндоо аюул учруулах, баялгийг сүйтгэх, гол, ус, булаг шандыг хаах, байхгүй болгох, бохирдуулах зэрэг үндэсний аюулгүй байдлын хэмжээний асуудлууд үүсч байна.

- Монгол Улсад биеэ үнэлэх, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт явдал нууц далд хэлбэрт шилжиж зохион байгуулалтад орох, насанд хүрээгүй хүнийг садар самууны сурталчилгаанд ашиглах, татан оруулах, бэлгийн мөлжлөгт ашиглах, хүн худалдаалах гэмт хэрэгт татан оруулах зэрэг хууль бус үйлдэл нэмэгдэх хандлага байна.

- Хар тамхи, мансууруулах бодисын дамжин өнгөрөгч, иргэд нь дамжуулагч, тээвэрлэгч нь болж золиослогдох явдал багагүй гарах болсон. Хар тамхитай холбоотой гэмт хэргүүдэд манай улсын иргэдэд өөрийн орондоо төдийгүй гадаад улсад ч ихээр холбогдох болсон нь сэтгэл эмзэглүүштэй асуудал болж байна.

- Хүн бүр интернэтэд холбогдсон, бүхий л үйл ажиллагааг цахимжиж байгаа энэ цаг үед компьютер, сүлжээ ашиглан гэмт хэрэг үйлдэгдэх хандлага цаашид нэмэгдэнэ.

- Банк, санхүүгийн салбарт гарсан гэмт хэргийн гаралт багагүй гарах боллоо. Сүүлийн үед үл хөдлөх хөрөнгө, санхүүгийн зах зээлийн салбарт хууль бус үйлдэл их гарах боллоо. Банк, санхүүгийн луйврын шинжтэй гэмт үйлдэл мэргэжлийн өндөр түвшинд хийгдэж байна.

- Эмийн хууль бус эргэлттэй эрчимтэй тэмцэхгүй бол болохгүй байна. Эмнэлэгийн импорт, борлуулалт, худалдаанд, бүр хэрэглээнд тавих хяналт туйлын хангалтгүй байна.

- Хил, гаалийн эргэн тойронд гэмт хэрэгтэй тэмцэх төр, засгийн бодлогыг чиглүүлэх. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 175 дугаар зүйл /Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх/, 166 дугаар зүйл /Татвар төлөхөөс зайлсхийх/, 188 дугаар зүйл /Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх/, 203 дугаар зүйл /Ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих/-д заасан гэмт хэргийг гаалийн хяналт, шалгалтын явцад илрэх боломжтой юм. Улсын хилээр эд зүйл хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг нь хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх, улсын хилийн дэглэм зөрчих, татвар төлөхөөс зайлсхийх, хээл хахууль, албан тушаалын зэрэг гэмт хэргүүдтэй уялдаатайгаар үйлдэгддэг онцлогтой юм.

Түүнчлэн, өнөөдөр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гол үүрэг гүйцэтгэж байгаа хэсгийн төлөөлөгч, байцаагч нарын ажиллах нөхцөл бололцоо муу байгаагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд нөлөөлж байна. Зөвхөн нийслэлийн хэсгийн байцаагч нарын дунд явуулсан судалгаанаас үзэхэд ажиллах нөхцөлөөр 17.7 хувь нь дунд, 37.7 хувь нь хангагдаагүйн дээр 37.7 хувь нь телефеон утасгүй байна.

Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах, хэрэг зөрчил гарч байгаа цэгт иргэдийн анхаарал, цагдаагийн хүчийг төвлөрүүлэх нь чухал байна. Өнөөдөр нийслэлийн нэг хороо гэхэд 2800-3200 шахам айл өрхтэй байхад хөдөөгийн зарим сум 600 өрхтэй байх жишээтэй. Үүнээс

шалтгаалж иргэдийнхээ шилжилт хөдөлгөөнийг ч хийж чадахаа больсон. Гадаад орноос төдийгүй төв орон нутгаас шилжиж ирсэн сэлгүүцсэн хүмүүсийн бүртгэл, судалгаа хангалтгүй, хэн гэдэг хүн хэдийд ирж, хэдэн жил амьдарч байгааг ч бүртгэж чадахгүй болсон.

Ингэж хэн дуртай нь аймаг, сум хэсэн сэлгүүцэж хүссэн цагга гэмт хэрэг үйлдэж, өөр аймаг, сум дүүрэгт шингэж алга болдог. Зөвхөн Улаанбаатар хотод сүүлийн 4 жилд бусад аймаг, хотоос ирсэн сэлгүүцэгчид 1371 гэмт хэрэг үйлдсэн байх жишээтэй.

Зарим хүн хэд хэдэн аймаг, нийслэлийн дүүргүүдийг дамжиж хэд хэдэн удаа эрүүлжүүлэгдэх, захиргааны журмаар торгуулах, баривчлагдах бүр хэд хэдэн аймагт тэнсэн харгалзах ял авах асуудал байхыг үгүйсгэхгүй. Энэ нь хуулийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу, бүртгэл, судалгаа нь компьютерийн системд бүрэн шилжээгүй байгаатай холбоотой. Энэ нь хүнийг гэмт хэрэгт дахин давтан оруулах, зарим гэмт хэрэгтнийг ял завшихад хүргэж байгаа юм.

Ялангуяа нийслэлийн хэмжээнд нэн яаралтай хорооллын системд шилжүүлэх буюу хороодын айл, хүн амын тоог тэнцүүлэн тогтоох, түүнийг дагаж хэсгийн байцаагч, цагдаагийн орон тоог яаралтай нэмж, хүн амын цэг рүү тараан төвлөрүүлж иргэдэд хүрч үйлчлэх боломжтой болгох шаардлага байна.

Нөгөө талаар аймаг, дүүрэг, сум, хороо, цагдаагийн газар, хэлтсийн ажлыг дүгнэхдээ урьдчилан сэргийлэх арга ажиллагааг гол үзүүлэлт болгон гэмт хэргийг бууруулах талаар авсан бодитой арга хэмжээ, хэргийг бууруулсан үр дүнгээр нь хэмжих цаг болжээ. Ялангуяа эрүүгийн нөхцөл байдал хүндэрсэн цэгүүдэд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг оролцуулах, нутаг орны эрүүгийн нөхцөл байдлыг эрүүлжүүлэх, хэрэг, зөрчлийг бууруулахад чиглэгдсэн удирдлага, зохицуулалтын ажил, тэдний дэмжлэг туслалцаа ихээхэн үгүйлэгдэж байна. Ер нь гэмт хэргийг гарч хохирол амссаны дараа зэнийг олох гэж хөөцөлдөх биш, гарахаас нь өмнө урьдчилан сэргийлэх л хамгийн чухал. Энэ нь дэлхийн улс орнуудын бодлого болоод байна.<sup>28</sup>

### III. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНД ХИЙГДЭХ ӨӨРЧЛӨЛТ

Эрүүгийн хууль нь хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулж, улс үндэстний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг сахин хангах чиг үүрэг бүхий суурь хууль болохын хувьд эрх зүйн шинэтгэл, олон нийтийн анхаарлын төвд байнга байдаг билээ. 2002 онд Эрүүгийн шинэ хуулийг батлан мөрдөж эхэлснээс хойш уг хуулийн хэрэгжилт, нийгмийн амьдралд үзүүлж буй нөлөөллийн талаар өргөн хүрээтэй хэлэлцүүлэг явагдаж, багагүй шүүмж, шинэчлэн өөрчлөх олон янзын санал гарч байна.

Тухайлбал, ялын бодлогыг хэт чангаруулж шоронжуулах нөхцөл бүрдүүлсэн, хохирогчийн хохирлоо нөхөн төлүүлэх боломжийг хаасан, шүүх, прокурор, цагдаагийн байгууллага хуулийг нэг мөр ойлгон хэрэглэж чадахгүй байгаа буюу хуулийн зарим зүйл заалт салаа утгатай, нэр томъёо тогтоогүй зэрэг олон дутагдал, бэрхшээлийг дурддаг. Өнгөрсөн арван жилийн хугацаанд уг хуульд олон удаа нэмэлт, өөрчлөлт орсон ба хуулийг бүхэлд нь шинэчлэн найруулах саналыг ч зарим хууль тогтоогч, хуульчид гаргажээ .

Монгол Улсын Эрүүгийн хууль нь тус улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам, энхтайван, хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах<sup>29</sup> урьдчилан сэргийлэх зорилтыг хэрэгжүүлдэг.

Эрүүгийн хууль нь энэ зорилтоо хэрэгжүүлэхдээ эрүүгийн эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалагдаж буй нийгмийн амин чухал харилцаанд халдсан хүн, төр, нийгэмд аюултай ямар хэргийг /үйлдэл, эс үйлдэхүйг/ гэмт хэрэг гэж үзэх, тэдгээрийг үйлдсэн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэлбэр, хэмжээ, тэдгээртэй холбоотой эрүүгийн эрх зүйн нийтлэг үндэслэлүүд /эрүүгийн хариуцлага, түүний үндэслэл, эрүүгийн ял оногдуулах, эрүүгийн хариуцлага болон ялаас чөлөөлөх гэх мэт/, түүнчлэн тодорхой гэмт хэргүүд, түүнийг үйлдсэн этгээдэд оногдуулах тодорхой ялын төрөл, хэмжээг тогтоодог учир гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, үндсэн чиглэл, төрөл, арга хэлбэр, энэ талаар төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”-иас илүүтэйгээр “**Эрүүгийн хууль**”-д үндэслэгддэг байна.

Монгол хэлэнд бидний хэрэглэж хэвшсэн “**гэмт хэрэг**”<sup>30</sup> гэдэг ойлголтыг барууны орнуудын эрүүгийн эрх зүйн жишгээр crime, **crimes**, **crimen**, **verbrechen**, **offences**, **delitto** гэж нэрлэгдсээр ирсэн ба нэр томъёоны зориулалт, нийтлэг хэрэглээ талаас нь авч үзвэл энэ нь ихээхэн явцуу хүрээнд ойлгогдох ажээ.

Дэлхийн улс орнуудад “**гэмтхэрэг**” гэдэгт ямар үйлдлийг тооцохыг тус тусынхаа эрүүгийн хууль тогтоомждоо тусган шууд ба шууд бусаар томъёолсон байх нь бий.

Гэмт хэргийн ойлголтыг эрүүгийн хууль тогтоомждоо тодорхойлж томъёолоогүй орнууд бий. Тухайлбал, Англи, Франц, Япон, Бразил, Албани, Венесуэл, Аргентин, АНУ-ын зарим муж, Перу, ӨАБНУ, Бахрейн зэргийг жишээлж болно. Эдгээр орнуудад онол, номлол, шинжлэх ухаан судлалын хүрээнд буюу зарим тохиолдолд шүүхийн шийдвэрт /англи/ тусган томъёолсон байдлаар тодорхойлолт өгсөн байдаг. Тэгвэл Эрүүгийн хууль болон эрүүгийн хууль тогтоомжийн актуудад “гэмт хэрэг” гэдгийг хуульчлан томъёолсон практик дийлэнх оронд бүрэлдэн тогтжээ.

Гэмт явдлыг /гэмт хэргийн/ категорчлох хандлага нь гэмт хэрэг ба адил төстэй эрх зүйн зөрчлийн давхардлыг арилгах, эрүүгийн эрх зүйн зохицуулалтанд эрүүгийн хийдэл гарах, нөхцөлийг хаах, улмаар гэмт үйлдлийн илрэх хэлбэрийг зохистойгоор үнэлэх, ялын санкцийн үр ашигтай механизмыг бий болгоход чиглэгдэж иржээ. Түүнчлэн гэмт халдлагынүр дагавар ямар хэмжээнд ямар холбогдлыг бий болгож байгаагаас хамаарч гэмт хэргийн хир хэмжээнд тааруулж тохирсон ялыг оноох нөхцөлийг бий болгоход оршино.

Сүүлийн үед баруун европт эрүүгийн болон эрүүгийн процессын эрх зүйн хамаарал улам гүнзгийрч байгааг харгалзан гэмтхэргийн ангиллыг процессын шалгуураар үзэх хандлага бий болсон. Энэхүү олон категорт ангилал бүхий систем нь нийгмийн харилцаанд тэвчишгүй ул мөр үлдээж, хуулиар хориглосон үр дагавар бий болгосон, зүй бус зан үйлийн бүх боломжийг хаах, хязгаарлах үүднээс гэмт хэргийн ойлголтыг ийнхүү өргөн хүрээнд авч

үзэж, нийгмийн ухамсарт төлөвшүүлснээс гадна эрүүгийн эрх зүйн олон талт эх сурвалжаар зэрэгцүүлэн тэнцвэртэйгээр зохицуулахад чухал үүрэг гүйцэтгэсээр байна.

Иймд үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, түүнийг үйлдсэн этгээдэд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг болон ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээнээс чөлөөлөх үндэслэл журмыг тогтоосон Эрүүгийн хууль нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрх зүйн арга хэмжээнд тавигддагхууль, тогтоол, бусад шийдвэр нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлогод тохирсон байх үндэслэлтэй байх тодорхой байх бодитой, биелэгдэх бололцоотой байх системтэй байх зорилго чиглэлтэй байх<sup>31</sup> гэсэн шаардлагуудыг хангасан тохиолдолд сая гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилтоо амжилттай хэрэгжүүлж чадах юм.

Гэвч одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн зарим хэм хэмжээ нь дээрх шаардлагыг хангахгүй байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрх зүйн арга хэмжээг хэрэгжүүлэхэд /гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Эрүүгийн хуулийн зорилтыг хангахад/ сөргөөр нөлөөлж байна.

### 3.1. Эрүүгийн хуультай холбоотой судалгааны тайлангуудаас гарсан санал, дүгнэлт

#### 1. “Гэмт хэргийн ангилал ба ялын тохироо” судалгааны тайлан. ХЗҮХ. 2005 он

Уг судалгаанд дараах зүйлийг судлан дүгнэжээ.

| Ялын төрөл   | Тухайн ялыг оногдуулахаар заасан зүйл, хэсгийн тоо |
|--|--|
| Торгох ял  | 181  |
| Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах | 24 /үндсэн ял/<br>26 /нэмэгдэл ял/                 |
| Эд хөрөнгө хураах  | 13/үндсэн ял/<br>3 /нэмэгдэл ял/                   |
| Албадан ажил хийлгэх ял  | 52   |
| Баривчлах  | 171  |
| Хорих  | 311  |
| Цаазаар авах ял  | 6  |

Эрүүгийн хуульд хорих, торгох санкцтай 33 зүйл анги, баривчлах, торгох санкцтай 77 зүйл анги байдаг .

Түүнчлэн уг судалгаанд “хөрөнгө мөнгөтэй хүн, албан тушаалтан, мөн албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ял хэт хөнгөн тусдаг гэж судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь үзсэн бол давтан гэмт хэрэг үйлдсэн хүн, хөрөнгө мөнгөгүй ядуу хүн, анх удаа гэмт хэрэг үйлдсэн хүн, насанд хүрээгүй хүн, гэмт хэрэг үйлдэхээр завдсан, мөн хамтран үйлдсэн хүнд, түүнчлэн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт ял хүнд тусдаг” гэж судалгаанд хамрагдагсдын дийлэнх хувь нь үзсэнийг анхааран дүгнэх нь зүйтэй.

Ял оногдуулахад бэрхшээл учирдаг эсэх, учирдаг бол ямар бэрхшээл учирдаг талаар санал асуулгын, ярилцлагын, ажиглалтын болон хэрэг уншин судлах аргаар судалсан болно. Уг судалгаагаар ял оногдуулахад дараах бэрхшээл учирдаг болох нь харагдсан юм. Судалгаанд оролцсон хуульчид ял оногдуулах ажиллагаа хэт автоматжлагдсан учраас шүүгч эрүүгийн шүүн таслах ажиллагааны ур чадвар гаргах шаардлагагүй болсон, төрөөс шүүгчид ял шийтгэлийг ялгамжтай оногдуулах эрх зүйн боломжийг бий болгож өгөх шаардлагатай гэсэн байр суурьтай байсан бөгөөд энэ нь ял оногдуулахад учирч буй бэрхшээлийн дотор тодорхой хувийг эзэлж байсан юм.

#### “Хорих ялын үр нөлөө”. Судалгааны тайлан. ХЗҮХ, 2007 он

- Бусдын өмчийн эсрэг гэмт хэргүүд, танхайрах зэрэг эрүүгийн хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн тохиолдолд ихэвчлэн 8 ба түүнээс дээш жилийн хорих ял онохоор заасан байгаа нь шоронд ял эдэлж байгаа ялтангуудын тоог ихэсгэх, улмаар хорих ялын үр нөлөөг багасгахад хүргэж болзошгүй байгаа юм. Иймээс эрүүгийн хуулийн ялын бодлогод зарчмын шинжтэй өөрчлөлт шаардлагатай

- эрүүгийн хуульд заасан ялын цээрлүүлэх зорилго хэт өргөн, агуулга, ач холбогдлын хувьд цаг үеийн хэрэгцээнд тохироогүй.
- Хүүхдийн хорих ял болон түүний нөхцөлийг тусгайлсан бүлгээр зохицуулах.
- Хорих ял эдлүүлэхэд наад захын стандартын шаардлага эрүүл ахуйг хангасан дэглэм эдлүүлэхээр тусгаж, нээлттэй хаалттай тогтолцоонд шилжих
- төрийн хууль цаазын бодлогын гол зорилго нь тэднийг зөвхөн цээрлүүлэхдээ бус харин хүмүүжүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхийг урьдач болгож буй тул хоригдлыг нийгэмшүүлэх, шоронгоос гараад ажил, хөдөлмөр эрхэлж, дахин гэмт хэрэг үйлдэхгүй амьдрах боломжийг олгоход илүү анхаардаг байх

**“Эрүүгийн болон Захиргааны хариуцлагын тухай хуулийн харьцуулсан судалгаа”, ХЗҮХ, 2007 он.**

- Захиргааны зөрчлийн тухай ойлголт, мөн чанар, нутаг дэвсгэрт нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон журмыг зөрчсөн, нийгэмд хор уршигтай, гэм буруутай, захиргааны шийтгэл хүлээлгэх үйлдэл, эс үйлдэхүй, ЗХТХ-иар хамгаалагдаж байгаа нийгмийн харилцаа болох хүний эрх эрх чөлөө, эрүүл мэнд, хүн амын аюулгүй байдал, , нийгмийн ёс суртахуун, байгаль орчин, түүнчлэн захиргааны журам зөрчсөн талаас нь онолын шинжтэй шинэ ойлголт өгч хуульд тусгах ЗХТХ-ийн тусгай ангид оруулж өгөх, захиргааны зөрчлүүдийг эрүүгийн хууль тогтоомжтой давхардуулахгүй байх, эрүүгийн гэмт хэргийн шинжийг ялимгүй агуулсан, нийгмийн хор аюул багатай хэргүүдийг захиргааны зөрчилд оруулж болохоор тодорхой зааж өгөх, Эрүүгийн хууль, ЗХТХ- нь харилцан бие биеэ нөхөж байхаар зохицуулалт хийх
- Гадаадын Захиргааны хариуцлагын хууль тогтоомж тэр дундаа ижил төстэй эрх зүйн тогтолцоотой ОХУ гэх мэт орнуудын хууль тогтоомжийг судалж шинэ үзэл баримтлалыг хуульд тусгах, нэвтрүүлэх
- Бага хэмжээтэй ашиглан шамшигдуулах гэдгийг эрүүгийн хуульд заасан байдлаар ойлгож, хэрэв бага хэмжээтэйгээр, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших үрэгдүүлэх, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийг үйлдсэн бол ЗХТХ-иар ашиглан шамшигдуулах гэмт хэрэгт тооцож, давтан үйлдсэн, бага хэмжээнээс дээш буюу үлэмж хэмжээтэйгээр үйлдсэн бол эрүүгийн гэмт хэрэг гэж үзэж байхаар Эрүүгийн хуульд тусгах.
- Түүнчлэн захиргааны зөрчилтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарч буй бэрхшээлийг харгалзан захиргааны зөрчилтэй хэрэг хянан шийдвэрлэх процессын хууль гаргах, эсвэл ЗХТХ-ийн хэсэгт тусгай бүлэг болгон тусгаж өгөх нь зүйтэй байна. /захиргааны процесс/
- Иймээс захиргааны шийтгэвэрээр торгууль хүлээлгэх асуудлыг нэг мөр цэгцлэх, зөрчил гаргагчид үзүүлэх эдийн засгийн нөлөөллийг дээшлүүлэх үүднээс тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний хэмжээнээс хамааралтай заалт оруулах, хуульд заасан “ удаа дараа гэдгийг 2 ба түүнээс дээш” гэж тодорхойлох
- Захиргааны зөрчилд шинэ төрлийн зөрчлүүдийг оруулж өгөх, Захиргааны зөрчилтэй холбоотой нийт 240 гаран хуулийн холбогдох хэсэгт судалгаа хийж, тэдгээрийг эмх журамд оруулж, захиргааны хариуцлагын тухай хуульд тусгах ажлын хэсэг байгуулах, давхардсан зөрчилдсөн хэм хэмжээг хүчингүй болгох, зөрчилдөөнийг арилгах зэрэг ажиллагааг хийх
- ЭХ болон ЗХТХ-иар хамгаалсан ижил төрлийн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн ялгааг гаргах, шаардлагатай бол зарим гэмт хэргийн захиргааны зөрчилд тооцох, огт арга хэмжээ авагддаггүй зөрчлийг хасах нь гэмт хэрэг эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар үр нөлөөг дээшлүүлэх нэг алхам болох болов

**“Хүүхдийн хэрэг эрхлэх хороо, түүний үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ”. 2009 он. НҮБ-ын Хүүхдийн сан, ХЗҮХ**

Эрүүгийн хуульд орох өөрчлөлтийн талаар дараах саналууд гаргажээ. Үүнд:

- Шүүхээс гэм буруутай тогтоогдсон насанд хүрээгүй хүмүүст ял ногдуулах бодлогоос аль болох татгалзаж, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ авах, сургах, хүмүүжүүлэх мэргэжлийн чиг баримжаатай болгох, нийгмээс хөндийрүүлэхгүй байх бодлого баримтлах



бөгөөд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бус журмаар шийдвэрлэхийг урьтал болгох

- Эрүүгийн хариуцлага хүлээх насны хязгаар: Гэмт хэрэг үйлдэх үедээ 18 насанд хүрсэн боловч 21 насанд хүрээгүй иргэнийг түүний сэтгэц, оюун санаа, бие бялдарын байдлыг харгалзан насанд хүрээгүй иргэнд шүүгч тооцож болноч, “Анх удаа хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүмүүсийг нийгэмшүүлэн, хүмүүжүүлэх сургалт хүмүүжлийн тусгай байгуулагад байлгах насны дээд хязгаар 21 нас хүртэл байна.” гэж оруулах.
- Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагыг ангилал
- Тодорхой нийгэм хүмүүжлийн арга хэмжээг эрүүгийн хуульд нэмж оруулах өөрөөр хэлбэл хуулиар төрлийг нь нэмэгдүүлэх
- Насанд хүрээгүй хүмүүсийг сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад явуулахгүй байх боломжтой гэж шүүх үзвэл дурдсан хүмүүжлийн арга хэмжээний төрөл болон олон нийтэд тустай хөдөлмөрийг эрхлүүлэхээр хүүхдийн эрхийг хамгаалах орон нутгийн байгууллагын саналыг үндэслэн шийдвэрлэх агуулга бүхий заалтууд байх хэрэгтэй.

## **2. Эрүүгийн хуулийг шинэтгэх төслийн санал, Т.Мэндсайхан ахлагчтай судалгааны баг, 2010 он**

Судалгааны ажлын үр дүнг харгалзан өнөөгийн Эрүүгийн хуулийг шинэтгэх дараахь үндэслэл, шаардлага байна гэж үзлээ. Үүнд:

- 1) 2002 оны Эрүүгийн хуульд эрүүгийн эрх зүйн гол зарчмуудыг хүлээн зөвшөөрч тусгасан боловч тэдгээрийн хэрэгжилтийг тусгай ангийн зүйл заалтад бүрэн бэхжүүлээгүй ба зарчмаас гажих тохиолдлыг хавтгайруулсан алдаа дутагдал байна. Түүнчлэн хүүхдийн эрх ашгийг онцгой анхаарах, гэрээний үүргээ биелүүлээгүй этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх зарчмыг хуульд огт тусгаагүй орхигдуулжээ. Эрх зүйн зарчмууд нь аливаа хуулийн суурь, ноён нуруу болдог учраас энд дурдсан алдаа дутагдлыг засахгүйгээр хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан Үндсэн хуулийн зүйл заалт, Эрүүгийн хуулийн зорилго хэрэгжихгүй. Иймд хуульд тусгагдсан болон шинээр тусгах зарчмын хэрэгжилтийг бататгах үүднээс Эрүүгийн хуулийн ерөнхий ангид зүйл заалт шинээр нэмэх, улмаар тусгай ангийн олон зүйл заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай болно.
- 2) Өнөөгийн Эрүүгийн хуульд хууль зүйн техник буюу хуулийн бүрдэл хэсгийн хоорондын уялдаа холбоо, хэм хэмжээний бүтээц, хэл зүйн найруулга, холбоос үгний сонголт, нэр томъёоны оноолт тогтож хэвшээгүй, нэг мөр болоогүй учраас хуулийг иргэд төдийгүй хуульчид ойлгож хэрэглэхэд хүндрэлтэй, шүүх, прокурор, өмгөөлөгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид нэг хэргийн хувьд хуулийг олон янзаар тайлбарлаж хэрэглэх явдал түгээмэл байна. Иймд Эрүүгийн хуульд баримтлах хууль зүйн техникийн жишгийг шинээр тогтоосны үндсэн дээр хуулийн эх бичвэрийг бүхэлд нь хянаж үзэх, өөрчлөлт оруулах шаардлага зүй ёсоор тулгарч байна. Ялангуяа гэмт хэргийн ангилал, хөнгөрүүлэх ба хүндрүүлэх нөхцөл байдал, тэдгээрийг эрүүгийн хариуцлага, ялын төрөл хэмжээтэй тохируулж буй өнөөгийн арга техникийг шинэчилж, АНУ-д хэрэглэж буй хүснэгтийн аргыг ашиглах нь илүү шударга, зохимжтой болно.
- 3) Эрүүгийн хуульд хэрэглэсэн олон тооны нэр томъёо нь салаа олон утгатай, нэг мөр ойлгож хэрэглэхэд бэрхшээлтэй бөгөөд УДШ-ийн тогтоолоор энэ асуудлыг олон жил зохицуулахыг оролдож ирсэн буруу практик, өмнөх тогтолцооны үеийн энерцийг халах цаг нэгэнт болжээ. УИХ-ын хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд Эрүүгийн хуулийн нэр томъёог дахин хянаж, уг хуульд түгээмэл хэрэглэгдэж буй 300-500 нэр томъёонд зүүлт тодорхойлолт шинээр хийж хуулийн эх бичвэрт тусгавал зохино.
- 4) Хохирогчийн эрхийг хамгаалах, түүний хохирол нөхөн төлөгдөх нөхцөлийг хангах чиглэлээр ялын бодлогод зохих өөрчлөлт оруулах эрэлт шаардлага, хүлээлт иргэдийн дунд их байна \Саналын ... талыг үзэх\.
- Ялангуяа хулгайн гэмт хэрэг болон иргэдийн амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн хувьд энэ асуудлыг онцгой анхаарч оновчтой шийдэл олох хэрэгтэй болжээ.
- 5) Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн ангиллыг үзвэл нийт гэмт хэргийн 80 орчим хувийг материаллаг бүрэлдхүүнтэй гэмт хэрэг эзэлж байна. Энэ нь гэмт хэргийг материаллаг талаас нь түүнд хамаарах бүх шинжүүдээр нь хуульчлан тодорхойлж гэмт хэргийн ангилалыг хийхдээ тухайн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ,

оногдуулж болох ялын хэмжээг гол шалгуур болгосонтой<sup>32</sup> холбоотой байна. Гэтэл гэмт хэргийг ангилахдаа дээрхи үзүүлэлтээр ангилах нь алдаатай<sup>33</sup> бөгөөд түүнийг ангилах гол шалгуур болох гэм буруугийн хэлбэрийг хуульчилж өгөх нь зүйтэй юм

- 6) Эрүүгийн Хуулийн Ерөнхий ангийн 21 дүгээр зүйлд заасан ялын төрөл хэмжээ нь гэмт хэргийн ангилалыг тогтоосон 17 дугаар зүйлийн заалттай нийцэхгүй байгаагаас тухайн гэмт хэрэг нь ямар ангилалд хамаарах нь ойлгомжгүй, холимог шинжтэй болж тухайн хэрэгт шүүх ямар санкц сонгосноос хамаарч хөнгөн, хүндэвтэр, хүнд, эсвэл онц хүнд гэмт хэргийн аль алинд тооцогдож болохоор байгаа нь тусгай ангийн заалтыг ерөнхий ангийн заалттай уялдуулах, шинэчлэх шаардлагатай байгаа харуулж байна.
- 7) Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй ЭБШХ нь ЭХ-иар тогтоосон зарим харилцааг шууд зохицуулдаг. Практикт ЭХ-ийн зүйл хэсгийг хэрэглэхгүйгээр түүнтэй ижил харилцааг зохицуулсан процессын хуулийг илүү хэрэглэж байна. Тухайлбал, ЭХ-ийн 4 дүгээр зүйлд заасан Гэм буруугүйн зарчмыг ЭШБХ-ийн 13 дугаар зүйлд мөн тусгасан байх бөгөөд шүүн таслах ажиллагааны явцад ЭБШХ-ийн заалтыг л үндэслэл болгон дурддаг. Түүнчлэн Хөөн хэлэлцэх хугацаа, ял шийтгэлгүйд тооцогдох хугацаа, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэх, цагдан хоригдсон хугацааг тоолох, эмнэлэгийн чанартай албадлыгн арга хэмжээ хэрэглэх, насанд хүрээгүй этгээдэд ногдуулсан ялыг хойшлуулах гэх мэт нэр томъёоны хувьд ижил төдийгүй хоорондоо шууд уялдаа холбоо бүхий заалтууд байгааг анхаарах хэрэгтэй байна. Тодорхой гэмт хэргийг шийдвэрлэхэд процессын хуулийн агуулгад нөлөөлөхгүйгээр материаллаг хууль болох Эрүүгийн хуулийн хэм хэмжээний хэрэгжилтэд нөлөөлдөг байдлыг орхигдуулахгүй байх хэрэгтэй.

#### Эрүүгийн гэмт хэргийг захиргааны зөрчлөөс ялгах шалгуурууд:<sup>34</sup>

а) Эрүүгийн гэмт хэргийг захиргааны зөрчлөөс ялгаж зааглахад германд, ялангуяа Холбооны Үндсэн Хуулийн шүүхийн шүүн таслах ажиллагаанд нийцдэг, тоо- чанарын гэгдэх холимог аргачлалыг голчлон хэрэглэдэг. Захиргааны зөрчил гэдэг нь ерөнхийдөө захиргааны дүрэм журмыг зөвхөн сахин биелүүлээгүй асуудал байдаг бол эрүүгийн ял шийтгэл (үүнтэй уялдаад эрүүгийн гэмт хэргийн)-ийн үндсэн тодорхойлолт нь нийгмийн ёс зүйн буруутай үйлдлийг яллах цээрлүүлэх явдал байдаг. Тэрчлэн (захиргааны зөрчилд мөнгөн торгууль оногдуулдаг- орч.) мөнгөн торгууль оногдуулахад төрийн ял шийтгэлийн чанд байх шинж чанар дутагдалтай байдаг, мөнгөн торгууль нь зөвхөн үүргээ биелүүлэхийг сануулж байдаг. Энэ мэтээр эрүүгийн гэмт хэргийг үндсэн гол цөмийн хувьд захиргааны зөрчлөөс чанараар нь ялгаж болох боловч чухам ямар гэмт үйлдэлд эрүүгийн хариуцлага болон захиргааны шийтгэл ногдуулах вэ гэдгийг зааглах, хязгаар тогтоох нь хууль тогтоогчийн үзэмжээрээ шийдвэрлэх асуудал юм. Өөрөөр хэлбэл зөвхөн жолооны үнэмлэхгүй машин жолоодож явсан үйлдлийг эрүүгийн гэмт хэрэг эсхүл захиргааны зөрчил гэж үзэх эсэхийг хууль тогтоогч л шийднэ.

Үүний зэрэгцээ хувь хүний эсхүл олон нийтийн эрх зүйн үнэт зүйлсэд ноцтойгоор халдсан байвал мэдээж эрүүгийн гэмт хэрэг гэж үзнэ. Харин үүнээс эсрэгээрээ захиргааны зүгээс тавих хяналтыг хүндрүүлсэн үйлдэл бол захиргааны зөрчил болох юм. Мөн захиргааны байгууллагад тайлагнах ёстой тодорхой тайлбар мэдүүлгийг өгөөгүй үйлдэл нь захиргааны зөрчил болно. Харин захиргааны байгууллагыг төөрөгдүүлснээр төр авах ёстой татвараа авч чадаагүй бол үүнийг залилантай адилтгана гэж үзэх бөгөөд татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг үйлдсэн гэж үзэж болно.

Харин гэмт этгээд тодорхой нэг эрх зүйн үнэт зүйлд ноцтой аюул учруулах бус, түүний тухайн үйлдэл нь туршлагаас харахад олонх тохиолдолд хожим нь ийм аюулыг учруулж болохоор байдаг хийсвэр (абстракт) буюу бодит бус хохирол учруулах гэмт хэргүүд дээр ялгах зааглах асуудал хүндрэлтэй байдаг. Үүний жишээ гэвэл дээр дурдсан зохих зөвшөөрөлгүй автомашин жолоодох явдал юм. Ихэнх тохиолдолд жолоочийн дадлага туршлагагүй байдлаас болоод замын хөдөлгөөнд аюул учирдаг.

Эрүүгийн гэмт хэрэг эсхүл захиргааны зөрчил гэж үзэх үү гэдэг нь хууль тогтоогчийн үзэмжээр шийдвэрлэх эрх хэмжээнд хамаардаг бөгөөд дээрх томъёолол нь мэдээж хууль тогтоогчдийн хувьд баримтлах чиг шугам болно гэж үзэж болохгүй, учир нь хууль тогтоогчид үзэмжээр шийдвэрлэх эрх хэмжээгээ хэрэгжүүлэх тодорхой нэг шалгуур гэж байх ёстой.

Энэ хүндрэлтэй байдлаас гарах гарц нь гурван давхар стратеги байж болох юм. Юуны түрүүнд торгох ял болон мөнгөн торгууль (германд нэр томъёогоор ялгадаг: Geldstrafe-эрүүгийн эрх зүйн санкци болох "торгох ял"; Geldbusse- захиргааны хариуцлагад оноодог "мөнгөн торгууль" орч.) хоёрыг ялгах материаллаг ялгаа гэж байх ёстой. Ингэж ялгахдаа хэрэв гэмт этгээд торгох ял буюу мөнгөн шийтгэлийг (Geldstrafe) төлөх чадваргүй бол түүнийг эрх чөлөөг хязгаарлах ялаар орлуулж болдог бөгөөд энэ нь нэлээд шүүмжлэлд өртдөг, харин захиргааны зөрчилд оногдуулсан мөнгөн торгуулийн хувьд ийм боломжгүй байдаг.

Гэхдээ торгох ял оноох гэмт хэрэг нь төлбөрийн чадваргүй буюу ядуу этгээдийн хувьд түүнийг төлөх чадваргүй бол оронд нь эрх чөлөөг хязгаарлах ял оноож болох тийм хүнд хэрэг байх ёстой. Нөгөө талаас гэмт этгээдийн эрх чөлөөг удаан хугацаагаар хасах нь түүний нийгмийн оршихуйг үгүй хийж болох шийтгэлийн өвөрмөц онцлогоос үүдээд ял шийтгэлийг зөвхөн маш нарийн хатуу чанд зохицуулалт бүхий, яллагдагчийн хувьд олон тооны баталгааг хангаж өгсөн эрүүгийн процессоор оноох ёстой гэдэг нь харагдаж байна.

Харин захиргааны зөрчилд мөнгөн торгууль оногдуулахад түргэвчилсэн процесс явуулах нь харьцангуй эргэлзээ бага төрүүлнэ. Үүнээс үндэслэн олон тоогоор үйлдэгддэг үйлдлийг захиргааны зөрчил гэж үзэх нь төрийн ашиг сонирхолд илүү нийцдэг гэж дүгнэж болохоор байна: Хэрэв ийм үйлдлүүдийг эрүүгийн гэмт хэрэг гэж үзэх юм бол өртөг зардал их өндөртэй болох бөгөөд ийм олон тооны эрүүгийн процесс төрийн, шүүх эрх мэдлийн хүчин чадалд дарамт учруулна.

Эргэлзээтэй тохиолдолд аль болох эрүүгийн хууль тогтоомжийг хэрэглэнэ гэсэн чиг хандлага сүүлийн жилүүдэд германы хууль тогтоогчдийн дунд давамгайлах болсон бөгөөд энэ нь ноцтой алдаа юм. Үнэхээр ухаалаг хууль тогтоогч бол эрүүгийн хэргийн шүүхийн шүүн таслах ажиллагаа явуулах хязгаарлагдмал хүчин чадлыг харгалзан түгээмэл гэмт үйлдлүүдийг аль болох захиргааны зөрчил гэсэн ангилалд хамааруулдаг. Хэрэв эрүүгийн хэргийн шүүхийн ачаалал хэтэрвэл хэт олон шүүн таслах ажиллагааг явуулж чадахгүйд хүрнэ, улмаар үнэхээр зөв ял оноож чадахгүйд хүрснээр хууль тогтоогчийн хүссэнээс эсрэг үр дагаварт хүрч болно.

Энэ бүхнээс үндэслэн хууль тогтоогчид дараах чиглэлийг өгч болох юм. Үүнд: Хэрэв хувь хүн эсхүл олон нийтийн эрх зүйн тун чухал үнэт зүйлд тодорхой аюул, хохирол учруулбал түүнийг эрүүгийн гэмт хэрэг гэж үзэж болно. Хэрэв хуулиар хориглосон үйлдэл нь бодит бус (хийсвэр) аюул учруулж байвал захиргааны зөрчил гэж үзнэ гэж болох юм. Эрх зүйн үнэхээр тун чухал үнэт зүйлийн тухайд, түүнчлэн хэрэв тухайн гэмт үйлдэл нь зөвхөн бодит бус буюу хийсвэр аюул учруулах төдийгүй гэмтээхэд чиглэгдсэн байвал тусгайлан авч үзэж болно. Өөрөөр хэлбэл зөвхөн санамсаргүй тохиолдолд суурилсан үйлдлүүд эрх зүйн үнэт зүйлд тодорхой аюул эсхүл хохирол учруулаагүй байлаа ч тухайн үнэт зүйл нь тун чухал бол эрүүгийн гэмт хэрэг гэж үзэж болно. Авто машин барих ямар ч туршлага дадлагагүй этгээд машин барьж замын хөдөлгөөнд оролцлоо гэвэл үүнээс болоод юу ч болоогүй байсан ч (энэ нь ямагт санамсаргүй үйлдэл байдаг- машин жолоодоход зайлшгүй шаардлагатай ур чадвар, туршлагагүй атлаа зөвшөөрөлгүй машин жолоодох үйлдлийг) үүнийг эрүүгийн хэрэг гэж үзэж болно. Харин машин жолоодох дадлага туршлагатай этгээдийн (замын хөдөлгөөнд оролцохдоо янз янзын зөрчил гаргасны улмаас) тодорхой хугацаагаар машин барих эрхийг нь хассан байтал машин жолоодсон бол машин жолоодох хоригийг үл тоомсорлосон гэж үзэн тухайн үйлдлийг нь захиргааны зөрчил гэж мөнгөн торгууль ногдуулж болно.

Бланкетный эрх зүй буюу иш татсан хэм хэмжээг эрүүгийн хуульд хэрэглэх нь

а) Хууль тогтоогчоос тогтоож өгсөн бол бланкетный эрх зүй буюу иш татсан хэм хэмжээг эрүүгийн хуульд хэрэглэх асуудал нь тийм ч эргэлзээ төрүүлэхүйц зүйл биш. Энэ тохиолдолд зөвхөн техникийн асуудал л гарна. Эрүүгийн хууль болон бусад хуулийг нэг дор хэвлүүлж болно, тэгвэл тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүнийг нэг дороос олоод үзчих боломжтой болно.

б) Эрүүгийн хуулийн зохицуулалт яамны шийдвэрээр зохицуулахаар шилжүүлэн заасан бол харин түвэгтэй. Ийм тохиолдолд эрх мэдлийн хуваарилалтыг чанд мөрддөг эрх зүйт төрд тухайн сайд нь хууль тогтоох эрхтэй байхыг зөвшөөрсөн тухай асуудал гарч болох юм. Нөгөөтэйгүүр богино хугацаанд өөрчлөгдөж буй нөхцөл байдалд парламент нь тухай бүр бүх зохицуулалтыг хийж, мөн шаардлагатай үед нэмэлт өөрчлөлтүүдийг мөн гардан хийх болбол түүний ажлын ачаалал нь хэрээс хэтэрсэн байх болно. Иймд ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүх энэ талаар зарчмын шийдвэр гаргасан байдаг. Үүнд: оногдуулах шийтгэлийг ямарч тохиолдолд хууль тогтоогч өөрөө тогтоох ёстой ба энэ нь шийтгэлийн хэмжээг тэрээр

зааж өгнө гэсэн үг юм. Цаашилбал, хууль тогтоогч нь буруутай үйлдлийн гол цөм буюу хамгаалагдах эрх зүйн үнэт зүйлийг тодорхойлох ёстой. Техникийн шинж чанартай тодруулга хийх ба өөрчлөгдсөн нөхцөл байдалд тохируулах явдлыг яамны тушаал, шийдвэрээр зохицуулна.

Жишээлбэл, эрх бүхий яамнаас ойг хамгаалах зорилгоор гаргасан шийдвэрийг зөрчсөнөөс үүдэн гарах эрүүгийнхэргийн бүрэлдэхүүн байж болох юм. Энэхүү тохиолдолд чухамхүү ямар тодорхой үйлдлийг ой хамгаалах хэм хэмжээг зөрчсөн үйлдэл гэх вэ гэдгийг тогтоох боломжтой болно. Чингэхдээ ганц нэг тохиолдолд ойд тодорхой хор уршиг хүргэхгүй боловч олон удаа (их хэмжээгээр)-гийн үйлдлээр буюу их хэмжээгээр үйлдсэн тохиолдолд хохирол учруулж болохуйц үйлдлийг хамааруулж болох ёстой юм.

Германд ийм гэмт хэргийг нийлмэл гэмт хэрэгт ял шийтгэх (кумулятив) хэрэг хэмээдэг: тухайлбал ганцхан ширхэг боргоцой унагасны улмаас хушан ойд аюул учрахгүй. Тэгсэн хэдий боловч зөвхөн энэ этгээд энэхүү тодорхой үйлдлийг хийгээд төгсгөл болохгүй, харин түүний энэ муу жишээг бусад хүмүүс дагана хэмээн ойлгох ёстой. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал нь гагцхүү хушны боргоцой (самрыг)-г түүсэн нөхцөлд эрүүгийн хариуцлагад татахаар заасан бол хууль тогтоогч өөрийнхөө гаргасан эрүүгийн хуулиар чухам ямар үнэт зүйлийг хамгаалах зорилго тавьсны хүрээнд л ой хамгаалахад шаардлага бүхий техникийн асуудлыг тухайн тушаалд тусгана. Иймд гэмт хэргийн бүрэлдэхүүнийг нэмж тодруулсан сайдын тушаал нь эрх зүйт төрийн зарчимд харшлахгүй хэмээн үзэж болох талтай.

в) Гурав дахь тохиолдолд хуулийн заалт нь захиргааны байгууллагын захиргааны актыг хэрэглэхээр заасан байж болох юм. Ийм жишээ ялангуяа байгаль орчинг хамгаалах эрүүгийн эрх зүйд олонтаа гардаг ба энэ нь хууль тогтоох техник үйл ажиллагаатай ямар ч холбогдолгүй юм. Аливаа үйлдвэр байгаль хамгаалах байгууллагаас зөвшөөрсөн хэмжээнээс давсан бохирдолтой усыг гол мөрөнд асгасан бол олон орнуудад ийм үйлдэлд эрүүгийн хариуцлага ногдуулдаг.

Германд бол ямар ч тохиолдолд гол мөрний усыг бохирдуулбал эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг боловч түүний зэрэгцээ гагцхүү хууль бусаар үйлдвэл эрүүгийн хариуцлага ногдуулахыг мөн хүлээн зөвшөөрдөг. Энэхүү зохицуулалт нь эрх бүхий байгууллагаас усны бохирдолтын зөвшөөрсөн хэмжээг тогтоосон нөхцөлд голын усыг бохирдуулсан үйлдвэр энэхүү журмыг зөрчөөгүй бол хариуцлагын асуудал яригдахгүй гэсэн утгатай юм. Ийм зохицуулалт нь байгаль орчинг хамгаалахад ч ач тустай байдаг.

Учир нь нөгөө талаас бохирдсон усыг гол мөрөнд асгах (цутгах) тохиолдол бүрийг хориглох боломжгүй ингэснээр эдийн засгийн үйл ажиллагаа (үйлдвэрлэл) бүр зогсонги байдалд орж болох юм. Нөгөөтэйгүүр зөвшөөрөгдсөн хэмжээг гагцхүү холбогдох (эрх бүхий) байгууллага л тогтоож чадна. Ийм тодорхой асуудлыг эрүүгийн хуулиар шийдвэрлэх боломжгүй.

Тийм учраас эрүүгийн хуульд ийм тохиолдолд эрх бүхий захиргааны байгууллагаас тогтоосон журмыг баримтлана гэсэн ерөнхий заалтыг эрүүгийн хуульд оруулж болох юм. Чингэхдээ захиргааны байгууллагаас тогтоосон норм (хэм хэмжээ)-г зөрчих нь эрх зүйн үнэт зүйлийг зөрчсөн зөрчил (энэ тохиолдолд усыг хууль бусаар бохирдуулах) мөн гэдгийг тов тодорхой зааж өгөх нь зүйтэй. Иймд тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар тодорхойлж болох юм.

Үүнд: “Эрх бүхий захиргааны байгууллагаас тогтоосон дээд хязгаарыг зөрчин үйлдвэрлэлийн бохир усыг гол мөрөн (цэвэр усанд) цутгасан (асгасан) тохиолдолд буруутай этгээдэд ...шийтгэл ногдуулна”. Хэрэв эрх бүхий байгууллагаас тогтоосон журмын дагуу бохирдлыг хэмжих төхөөрөмжийг байрлуулах тухай журмыг дагаж мөрдөөгүй бол энэ нь эрүүгийн хэрэг биш харин захиргааны зөрчил болж таарна.

### **Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага ногдуулах асуудал**

а) Англи-америкийн эрх зүйгээс улбаалан хуулийн этгээдэд хувь хүний адил эрүүгийн хариуцлага ногдуулах нь зөв зүйтэй гэсэн хандлага олон улсын хэмжээнд бий болж байна. Үнэн хэрэг дээрээ асуудалд ийнхүү хандах онолын үндэслэл байхгүй байдгийн хамгийн гол нь түүнээс эрүүгийн ба улс төрийн нааштай үр дүн гарахгүй байгаа явдал юм.

Тийм учраас “Сарбани-Окслийнх” хэмээсэн хууль гарснаас хойш АНУ-д хувь хүнд (хувь этгээдэд) эрүүгийн хариуцлага ногдуулах явдалд хуучны адил илүүтэй анхаардаг болоод байна. Үүнээс гадна хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага ногдуулахаас илүү үр

нөлөөтэй арга зам байдаг бөгөөд тэр нь хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг байгууллага (нэгж) ажиллуулах явдал юм. Энэ нэгж нь хуулийн этгээдийн үйл ажиллагааны улмаас эрх зүйн үнэт зүйлийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх үүрэгтэй юм.

б) Бидний дээр хэлсэнчлэн хуулийн шинэтгэлийн гол асуудлууд нь маш өргөн хүрээтэй ба түвэгтэй байдаг учир түүнд тодорхой ганц хариулт өгөх боломжгүй байдгийн сонгодог жишээ нь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага ногдуулах тухай асуудал мөн юм. Үүнийг харгалзан бид дараах дүгнэлтийг хийх боломжтой хэмээн үзэж байна. Үүнд:

в) Хуулийн этгээд нь хувь хүнтэй харьцуулахад үйлдлийн болоод гэм буруугаа хүлээх чадамжгүй байдаг учраас хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай асуудал байдаггүй юм.

г) Аж ахуйн нэгжүүдийн (компаниудын) олон ажиллагсад компанийнхаа үйл ажиллагааны хүрээнд эрх зүйн зөрчил үйлдэх нь хувь хүний хувьд үйлдэхээс илүүтэй, тэдний хувьд илүү хялбар байдаг нь бодит үнэн юм. Учир нь нэгэн компаний бүрэлдэхүүнд орсноор тухайн хувь хүн уул компаний ёс зүйг хүлээн зөвшөөрөх болно. Хэрэв энэхүү компани нь эрх зүйн тодорхой зөрчил үйлдэх нь компанийн үйл ажиллагаанд гардаг ердийн зүйл хэмээн үздэг бол ийм тохиолдолд “гэмт бүлэглэл”-ийн асуудал тавигдаж болох ба тухайн компанийн нэг ажилтны үйлдэл ч эрх зүйн үнэт зүйлийн зөрчил үйлдэх аюул бий болгоно.

д) Тэгсэн хэдий боловч өнөөгийн байдалд хуулийн этгээдэд ногдуулах хариуцлагад үндэслэн компанид мөнгөн торгууль ногдуулах нь утгагүй юм. Учир нь мөнгөн торгуулийг ажил хариуцсан менежер биш харин эцсийн эцэст тухайн компаний хувьцаа эзэмшигчид төлж таарч байгаа юм. Яагаад гэвэл мөнгөн торгууль төлснөөр тухайн компаний ашгийг багасгах ба энэ нь эцсийн эцэст хувьцаа эзэмшигчийн дивидендийн (ногдол ашиг) хэмжээг мөн бууруулахад хүргэнэ. Хувьцаа эзэмшигчдээс гадна компанид их хэмжээний мөнгөн торгууль ногдуулах нь компаний ажилтнуудад муу үр дагавар авчирч болзошгүй, Яагаад гэвэл компанид торгууль ногдуулсны улмаас компани ажилтнуудын цалингаас хасах эсхүл орон тоогоо цөөлөх (ажилтнуудаа ажлаас нь халах) шаардлага гарч болох юм. Эцсийн бүлэгт менежментийн буруу үйлдлээс болж гэм буруугүй хүмүүст шийтгэл ногдуулахад хүрч болзошгүй ба тэгсэн нөхцөлд энэ нь эрүүгийн эрх зүйн ёс зүйн (ёс суртахууны) үндсэн зарчмыг зөрчихөд хүргэнэ.

е) Тийм учраас гэмт бүлэглэлийн шинж чанартай үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн эсрэг чиглэсэн шийтгэлийн цогц зохицуулалт бий болгох нь онолын талаас илүү зохимжтойгоос гадна практикийн хувьд бас илүү үр нөлөөтэй байх болно. Олон улсын хэмжээнд өргөнөөр хэрэглэж буй нэг арга бол авилгын хэрэгт холбогдсон аж ахуйн нэгжийн тендерт оролцох эрхийг нь тодорхой хугацаагаар хязгаарлах явдал юм.

Үүний зэрэгцээ тухайн аж ахуйн нэгжээс хууль бус үйлдэл хийх явдлыг таслан зогсоох зорилгоор хуулийн байгууллагын даалгавраар хяналтын нэгж ажиллуулах боломж байдаг (куратор). Ихэнх тохиолдолд хууль бус үйлдлийг тухайн аж ахуйн нэгжийн удирдлага хийдэг учир түүнийг хянах нэгж байгуулснаар цаашид ийм хэрэг үйлдсэн менежерүүдийг олж тогтооход хялбар болно. Энэ байдал нь менежерүүд үйл ажиллагаандаа хууль журмыг мөрддөг болоход тус дөхөм болно.

ё) Дээрх шийтгэлийн цогц зохицуулалтын оронд практикт өргөн хэрэглэгддэг аж ахуйн нэгжид мөн мөнгөн торгууль ногдуулах шийтгэл нь бас өөр нэг сөрөг талтай. Ийм тохиолдолд менежерүүд хариуцлага хүлээхгүй, торгууль төлсөн ч бага хэмжээний торгууль төлнө гэсэн ойлголтод хүрдэг.

Тухайлбал ийм явдал Германы “Сийменс” концерн дээр саявтар гарсан юм. Мюнхен хотын прокурорын газрын шаардсанаар энэ компанид олон зуун сая еврогийн торгууль ногдуулж, торгуулийн төлбөрийн мөнгийг Бавари муж улсын төсөвт оруулсан юм. Харин хууль бус үйлдлийг гардан үйлдсэн төлөөлөн удирдах зөвлөл нь маш бага хэмжээний торгууль төлсөн юм. Иймд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага ногдуулах нь эрүүгийн эрх зүй болон улс төрийн талаас авч үзэхэд нааштай гэхээсээ илүү сөрөг үр дагавартай гэдэг нь үүнээс харагдаж байна.

#### 1. Хэрэг бүртгэх ба мөрдөн байцаах байгууллагуудын хүчийг нэгтгэх

а) Европт 200-аад жилийн өмнөөс мөрдөн шалгах (байцаах) үйл ажиллагааг зөв зохион байгуулах талаар янз бүрийн арга хэлбэрийг хэрэглэж мөн энэ сэдвээр мэтгэлцэж ирсэн юм. Тухайлбал, одоогоор Монголд мөрдөж байгаа ЭБШХ-ийн зохицуулалттай адил хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагуудыг ажиллуулж байв. Түүнчлэн зөвхөн шүүхийн харьяалалд байдаг цагдаагийн байгууллага ажиллуулах, эсхүл мөрдөн байцаах ажиллагааг

бүхэлд нь цагдаагийн байгууллагад хариуцуулж, прокурорын газар нь гагцхүү ялын дүгнэлт гаргадаг байх зэрэг хэлбэрээр энэ ажлыг зохион байгуулж байв.

Хамгийн оновчтой арга хэлбэрийг сонгон хэрэглэх асуудлын хүндрэл нь (түвэгтэй тал нь), нэг талаас байцаан шийтгэх процессыг явуулахдаа эрх зүйт төрийн иргэний эрхийг хамгаалсан хяналтын зарчмыг чанд баримтлах, нөгөөтэйгүүр үйлдвэржсэн нийгэмд хөдөө аж ахуйн нийгэмтэй харьцуулахад гэмт хэрэг зүйрлэшгүй их гардаг учир түүнийг олж илрүүлж тогтоох, эрүүгийн зохих шийтгэлийг оногдуулах боломжийг хангахуйц, практик амьдралд нийцсэн, хурдан шуурхай ажиллагаа байх шаардлагатай юм.

Одоогоор бол Германд эрүүгийн цагдаа нь нэг цогцолбор байгууллага болж мөрдөн байцаах ажиллагаагаа прокурорын газрын хяналт, удирдлагын дор явуулдаг нь зохион байгуулалтын хамгийн оновчтой хэлбэр хэмээн үздэг юм. Прокурорын байгууллага нь мөрдөн байцаах ажиллагааг хэдийд ч өөрсдөө явуулахаар шийдвэрлэж, тухайлбал чухал ач холбогдол бүхий гэрчүүдийн байцаалтыг өөрсдөө явуулах эрхтэй байдаг юм.

Яг тодорхой практик дээр бол цагдаа ба прокурорын байгууллагын ажлын хуваарь (хуваарилалт)-ийн асуудал нь мөрдөн байцаалтыг явуулж буй прокурорын мэдэлд байдаг юм. Тодорхой салбарын асуудлуудыг шийдвэрлэхэд тусгай эрхээр хангагдах шаардлага гарвал үүнийг тухайн байгууллагын дотор (хүрээнд) тухайн асуудлыг хариуцсан нэгж (хэлтэс, газар) байгуулах хэлбэрээр зохион байгуулна.

Жишээлбэл тухайн прокурорын байгууллагад эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх төв газрууд байдаг ба тэдгээр нь мөн авилгатай тэмцэх асуудлыг хариуцдаг юм.

б) Ажпыг аль болох өндөр үр дүнтэй гүйцэтгэхийн тулд энэхүү зохион байгуулалтын хэлбэр нь хамгийн их тохирсон байдаг. Учир нь авилгын хэрэг үйлдсэн гэсэн сэжгийг мөрдөн шалгах ажиллагаанд мөн өөр өөр гэмт үйлдлийг шалгах шаардлага гардаг тул ийм нөхцөлд байгууллага хооронд ажлын хуваарийг нарийвчлан тогтоох нь (ялгаж салгах нь) зохимжтой бус юм.

Нөгөөтэйгүүр захиргааны байгууллагуудын эрх мэдлийг ийм хүчтэй нягтруулан төвлөрүүлэх нь (практик дээр бол цагдаагийн байгууллага ба түүнийг удирдах прокурорын газар) тэдгээрийн эрх мэдлийг маш их хэмжээгээр өсгөж байгаа учир үүнд эрх зүйт төрийн хяналт зайлшгүй шаардлагатай байдаг.

Энэхүү хяналт нь авилгатай тэмцэх асуудал дээр хоёр чиглэлд хэрэгжих ёстой: нэг талаасаа иргэдийг хамгаалах чиглэлд, нөгөө талаас авилгатай тэмцэх үүрэг бүхий цагдаагийн ажилтан ба прокурорууд өөрсдөө авилгад өртөх явдлаас урьдчилан сэргийлэхэд чиглэгдэх ёстой.

в) Прокурорын үйл ажиллагаагаар иргэдийн эрхэнд халдах явдлыг хянах зорилгоор мөрдөн байцаалтын үед байцаан шийтгэх албадлагын арга хэмжээ (урьдчилан хорих, баривчлах, нэгжлэг хийх, банкны дансны гүйлгээг хаах г. м.) авсан тохиолдолд иргэдэд аль ч үед анхан шатны, зарим тодорхой нөхцөлд давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах боломж олгодог.

Яллагдагчийн буюу гуравдагч этгээдийн үндсэн эрхэнд ноцтойгоор халдах жишээлбэл урьдчилан хорих, нэгжлэг хийх, эд хөрөнгийг нь хураах гэх мэтийн арга хэмжээг гагцхүү прокурорын хүсэлтэд үндэслэсэн шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд авдаг. Амьдрал дээр энэхүү хяналтад нэлээд зөөлөн ханддаг учир нь анхан шатны шүүгч нь мөрдөн байцаалтын бүхий л үйл ажиллагаатай гүн гүнзгий танилцана гэвэл түүний ажлын ачаалал нь хэрээс хэтрэх билээ. Үүний сацуу мөрдөн байцаалтын арга хэмжээ (жишээлбэл нэгжлэг хийх)-г үл зөвшөөрсний уршгаар мөрдөн байцаалтын бүх ажиллагаа нурах эрсдэлээс шүүгч зайлсхийхийг хичээдэг.

г) Энэхүү хяналтыг эрчимжүүлэх талаар хоёр боломж (альтернатив) яригдаж байгаа: Германд шүүгч, прокурорын мэргэжлийн чиглэл (албан тушаалын карьер) хоорондоо маш их уялдаа холбоотой, мөн энэ хоёр мэргэжлээр солбиулан ажиллах тохиолдол олонтаа гардаг учир шүүх нь прокурорын ашиг сонирхолд хэтэрхий их ойртсоноос болж хяналтыг сулруулах аюул байнга оршиж байдаг юм.

Монгол Улсад шүүгч ба прокурорын ажил (карьер) хэр их ойр байдаг, энэ ойр орон зай нь бие биенээ дэмжих байдал бий болох эрсдэл байгаа эсэхийг зориуд авч үзэх нь зөв болов уу. Ямар ч атугай эдгээр хоёр мэргэжлийн хооронд сайтар зааглаж өгснөөр шүүхээс прокурорт тавих хяналтыг сулруулах явдлыг ямар нэг хэмжээгээр хязгаарлах боломжтой гэж үздэг. Өөр нэг боломж нь гэвэл мөрдөн байцаалтыг нууц байдалд явуулж яллагдагчийн

эрхэнд гэнэт ноцтойгоор халдаж хүндрэлтэй байдалд оруулсан тохиолдолд яллагдагчийн эрх ашгийг хамгаалдаг тусгай алба байгуулах явдал юм.

Хэрэв Монголд эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх явцад энэ асуудлыг гүнзгийрүүлэн судлах сонирхол байвал мөрдөн байцаалтын үед хэрэгжүүлэх хяналтыг илүү хүчтэй болгох асуудлыг нухацтай хэлэлцэж болох юм.

Цагдаагийн байгууллага нь хэдийгээр мөрдөн байцаах үйл ажиллагааг прокурорын удирдлагын дор явуулдаг боловч энэ нь эрх мэдлийн маш их хүчтэй төвлөрөл үүсгэдэг учир үүнд тохирсон хяналтыг хэрэгжүүлэхгүй бол ийм байдлыг зөвтгөх нь эргэлзээ төрүүлнэ: нөгөөтэйгүүр эрх мэдлийн энэхүү төвлөрөл нь мөрдөн байцаалтын үр дүнг дээшлүүлэхэд нэн чухал ач холбогдолтой юм.

д) Нэн ялангуяа авилгатай тэмцэхэд түүний эсрэг тэмцэж буй байгууллага өөрөө авилгад өртөх магадлал өндөр байдаг тул цагдаагийн байгууллагыг авилгатай тэмцэх ажилд прокурорын удирдлага, хяналтын дор төвлөрүүлэх явдал нь хамгийн зөв зүйтэй шийдэл юм. Бусад орны олон жишээнээс үзэхэд авилгатай тэмцэх бие даасан байгууллага нь авилгад их хэмжээгээр өртдөг байна.

Үүний оронд авилгатай тэмцэх үүрэг бүхий цагдаагийн ажилтан болон прокурор нь гурван давхар тайлагналын буюу хяналтын журмаар ажиллах нь зохимжтой: нэгдүгээрт, өөрийнхөө шууд удирдах албан тушаалтан, өөрөөр хэлбэл тухайн байгууллагын удирдлагад; хоёрдугаарт цагдаагийн байгууллага хяналтын прокурорт; гуравдугаарт, өөрөө мөрдөн байцаах ажиллагаа явуулдаггүй боловч мөрдөн байцаалтанд хяналт тавьдаг бие даасан авилгатай тэмцэх ажилд хяналт тавьдаг тусгай алба байгуулж болох юм.

е) Эцэст нь хэлэхэд тагнуулын байгууллагад онцгой үүрэг оногддог. Тагнуулын байгууллага нь зарчмын хувьд мөрдөн байцаах (шалгах) эрх мэдлийг эдэлдэггүй ба эдлэх ч ёсгүй. Учир нь энэ үүргийг хуулийн байгууллагууд гүйцэтгэх ёстой бөгөөд шүүх эрх мэдэл үүнд хяналт тавьдаг. Нөгөөтэйгүүр тагнуулын байгууллагын олж авсан мэдээлэл нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд тустай байж болох юм. Иймд чухам ямар тохиолдолд цагдаагийн болон прокурорын байгууллага тагнуулын (нууц) ажиллагааны үр дүнг ашиглаж болох тухай асуудлыг эрүүгийн байцаан шийтгэх хуулиар зохицуулах нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл тагнуулын аргаар олж авсан нотлох баримтыг ЭБШ ажиллагаанд хэрэглэх асуудал гэсэн үг юм.

Чингэхдээ үүнд хоёр шатлал байх ёстой. Үүнд: арай зөөлөн хэлбэр нь бол тагнуулын ажиллагааны үр дүнг мөрдөн шалгах ажиллагааг гүнзгийрүүлэн явуулахад ашиглах ба ЭБШ ажиллагаанд гагцхүү энэхүү нэмэлт ажиллагааны үр дүнд олж илрүүлсэн нотлох баримтыг ашиглах явдал юм. Тагнуулын ажиллагааны үр дүнг ашиглах хамгийн дээд хэлбэр нь тагнуулын ажиллагааны үр дүнд олж авсан нотлох баримтыг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд шууд хэрэглэх явдал юм.

Жишээлбэл (Германд ийм тохиолдол нэг бус удаа гарч байсан ) тагнуулын байгууллагын ажилтан нэгэн гэмт этгээдээс дансанд бичигдсэн хадгаламжийн хүүг төлөөгүй, өөрөөр хэлбэл татвараас зайлсхийсэн этгээдүүдийн тухай мэдээлэл бүхий компакт диск (СР)-ийг худалдаж авсан ба түүнийг ЭБШ ажиллагаанд нотлох баримт болгон ашиглаж байсан юм.

Энэхүү асуудлын зохицуулалт Германы ЭБШХ-д зарим талаар хуулийн цоорхойтой байхад зарим заалтыг хэрэгжүүлэхэд маш их бэрхшээлтэй тулгардаг. Энэ асуудлыг хэрхэх талаар шийдвэрлэхдээ гипотезийн (байх боломжийн) халдлагын зарчмыг баримтлана. Жишээлбэл тагнуулын шугмаар бусдын телефоны яриаг нууцаар сонссоны үр дүнд олж авсан баримтыг гагцхүү эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрэглэх нь зөвшөөрөгдсөн тохиолдолд ашиглаж болно (жишээлбэл тодорхой гэмт хэргийг илрүүлэн тогтооход телефоны яриаг сонсох явдлыг ЭБШХ-иар зөвшөөрсөн бол).

в) АНУ-ын эрх зүйд **“discovery”** гэж нэрлэдэг, өөрөөр хэлбэл прокурорын эсрэг хандсан өмгөөлөгчийн эрх гэж байдаг ба энэ нь функцийнхээ (зорилгынхоо) хувьд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрэгжүүлдэг хэргийн материалтай танилцах эрхээс эсрэг зорилготой бөгөөд өмгөөлөгчийн энэхүү эрхийг зарим талаар хязгаарлах боломжтой байдаг.

Энэхүү хязгаарлалтын үндэс суурь нь прокурор, өмгөөлөгч хоёр нь бие биенийхээ эсрэг тэмцэлдэх ёстой гэсэн мэтгэлцээний зарчимд оршдог ба бүтээлч талаас нь авч үзэхэд утгагүй ойлголтоос үүдэлтэй ба энэ үүднээс прокурор нь хэргийн материалтай танилцах өмгөөлөгчийн эрхийг нэлээд хэмжээгээр хязгаарлах боломжтой байдаг юм.

Прокурор ба өмгөөлөгчийн эдлэх эрх нь ийм их ялгаатай байгаа нөхцөлд прокурор нь нотлох баримтуудаа шүүх хуралдаан болтол нууцлах эрхтэй байна гэсэн үзэл санаа нь 150-иад жилийн тэртээ Хойд Америкийн Өрнөд хэсэг (“Зэрлэгүүдийн нутаг”)-т цагдаагийн дарга (“шериф”), дээрэмчид нарын хооронд өрнөж байсан тэмцэлдээний үлдэгдэл гэж үзэхээс өөр аргагүй. Мөн монголын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т иргэн хүн бүр хэргээ шударга шүүхээр шийдүүлэх эрхийг баталгаажуулсны дагуу прокурор нь хэргийг хангалттай мөрдөн шалгаж мөрдөн байцаалтыг дуусгах боломжтой гэж үзвэл тэрбээр цуглуулсан нотлох баримтаа яллагдагчид танилцуулах үүрэгтэй.



### 3.2. ШҮҮХЭЭС ОНОГДУУЛСАН ЯЛ ШИЙТГЭЛИЙН БАЙДАЛ /2002-2012 ОН/

| д/д | Ялын төрөл                                 | Бүтэн жилд   |             |             |              |             |             |             |             |             |             |             |
|-----|--|--------------|-------------|-------------|--------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|
|     |  | 2002 он      | 2003 он     | 2004 он     | 2005 он      | 2006 он     | 2007 он     | 2008 он     | 2009 он     | 2010 он     | 2011 он     | 2012 он     |
|     | Нийт ял шийтгүүлсэн                        | <b>13007</b> | <b>9029</b> | <b>9473</b> | <b>10153</b> | <b>7792</b> | <b>8463</b> | <b>8495</b> | <b>7513</b> | <b>7292</b> | <b>8210</b> | <b>8324</b> |
| 1.  | Хорих ялаар бүгд                           | <b>9577</b>  | <b>6561</b> | <b>6686</b> | <b>6947</b>  | <b>5454</b> | <b>5864</b> | <b>6150</b> | <b>5742</b> | <b>5537</b> | <b>6357</b> | <b>6457</b> |
|     | а/ Хорих ялыг биечлэн эдлүүлсэн            | 4552         | 2869        | 2926        | 3136         | 2660        | 2859        | 3011        | 3074        | 2543        | 2781        | 2691        |
|     | б/ Тэнссэн                                 | 4014         | 2794        | 2886        | 2915         | 1930        | 2154        | 2517        | 2013        | 2444        | 3084        | 3217        |
|     | в/ Ял эдлүүлэхийг хойшлуулсан              | 782          | 883         | 858         | 888          | 480         | 737         | 555         | 305         | 434         | 442         | 480         |
|     | Өршөөл үзүүлсэн                            | 229          | 15          | 16          | 8            | 384         | 114         | 67          | 350         | 116         | 50          | 69          |
| 2.  | Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн        | <b>3412</b>  | <b>2446</b> | <b>2661</b> | <b>3106</b>  | <b>2314</b> | <b>2573</b> | <b>2242</b> | <b>1771</b> | <b>1668</b> | <b>1770</b> | <b>1728</b> |
|     | а/ Торгох ял                               | 2946         | 675         | 672         | 745          | 609         | 589         | 419         | 260         | 281         | 271         | 272         |
|     | б/ Албадан ажил хийлгэх ял                 | 40           | 271         | 396         | 645          | 538         | 671         | 534         | 337         | 376         | 476         | 482         |
|     | в/ Баривчлах ял                            | 371          | 1492        | 1593        | 1716         | 1167        | 1313        | 1289        | 1099        | 1011        | 1023        | 974         |
| 3.  | Бусад ял                                   | -            | -           | 22          | 31           | 24          | 26          | 27          | 11          | 19          | 10          | 7           |
| 4.  | Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ | -            | 8           | 104         | 69           | -           | -           | 76          | 64          | 68          | 63          | 132         |

- **Хорих ял** - 18351 хүн буюу нийт ял шийтгэлийн 77.05 хувийг эзэлж байгаа бөгөөд дээрх 3 жилийн дунджаар 6117 хүн хорих ялаар шийтгүүлсэн байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын судалгаагаар Монгол Улсад сүүлийн 10 жилийн дунджаар жилд 7272 хүн хорих ял эдэлдэг бөгөөд практик алба хаагчдийн хийсэн судалгааны дүнгээс<sup>35</sup> үзэхэд жилдээ хорих байгууллагаар дамжиж байгаа хүмүүсийн тоо 12000 байдаг байна.<sup>36</sup> 2010 оны байдлаар шоронд байгаа хүний тоо 7265, үүнээс нийт хоригдлын дунд эмэгтэй хоригдол 6.2 хувийг, 18-аас доош насны хүүхэд 1.0 хувийг тус тус эзэлж байна. Ял эдэлж буй хоригдлын дундаж тоо 100000 хүн тутамд 269 байгаа нь уг үзүүлэлтээр дэлхийн 216 улсаас 44-р байрт жагсаж байна.

Хорих ялыг дотор нь задалж авч үзвэл:

- Хорих ялыг биечлэн эдлүүлсэн хүний тоо 8015 буюу жилд дунджаар 2671 хүнд хорих ялыг биечлэн эдлүүлсэн байгаа нь нийт хорих ял шийтгүүлсэн хүний 43.6 хувийг;
- Хорих ялыг тэнссэн хүний тоо 8745 буюу жилд дунджаар 2915 хүнийг тэнссэн байгаа нь нийт хорих ял шийтгүүлсэн хүний 47.7 хувийг;
- Хорих ялыг эдлүүлэхийг хойшлуулсан хүний тоо 1356 буюу жилд дунджаар 452 хүний ял эдлүүлэхийг хойшлуулсан байгаа нь нийт хорих ял шийтгүүлсэн хүний 7.4 хувийг;
- Хорих ялыг өршөөсөн хүний тоо 235 буюу жилд дунджаар 78 хүнд өршөөл үзүүлсэн байгаа нь нийт хорих ял шийтгүүлсэн хүний 1.3 хувийг тус тус эзэлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас сүүлийн 3 жилийн байдлаар жилд дунджаар 2245 ялтныг шүүхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллаж шийдвэрлэжээ.

- **Хорихоос өөр төрлийн ял** - 5166 хүн буюу нийт ял шийтгэлийн 21.7 хувийг эзэлж байгаа бөгөөд жилд дунджаар 1722 хүн хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн байна. Үүнийг дотор нь задалж авч үзвэл.
  - Торгох ялаар шийтгүүлсэн хүний тоо 824 буюу жилд дунджаар 275 хүн торгуулсан байгаа нь нийт хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүний 16 хувийг;
  - Албадан ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн хүний тоо 1334 буюу жилд дунджаар 445 хүн албадан ажил хийсэн байгаа нь нийт хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүний 26 хувийг;
  - Баривчлах ялаар шийтгүүлсэн хүний тоо 3008 буюу жилд дунджаар 1003 хүн баривчлах ялаар шийтгүүлсэн байгаа нь нийт хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүний 58 хувийг тус тус эзэлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас 2012 онд торгох ял шийтгүүлсэн 248 ялтанд холбогдох 1.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа явуулж, 181 ялтанд холбогдох 851.7 сая төгрөгийг бүрэн биелүүлж, 67 ялтны 455.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Мөн 2012 онд албадан ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн 445 ялтны 130457 цагийн ялыг эдлүүлэхээс 417 ялтны 124590 цагийн ялыг эдлүүлж, 28 ялтны 6897 цагийн үлдэгдэлтэй байна.

- **Бусад ял** - 36 хүн буюу нийт ял шийтгэлийн 0.15 хувийг эзэлж байгаа бөгөөд жилд дунджаар 12 хүнд бусад ял шийтгэлийг хүлээлгэсэн байна.

- **Хүмүүжлийн чанартай албадлагын арга хамжээ** - 263 хүн буюу нийт ял шийтгэлийн 1.1 хувийг эзэлж байгаа бөгөөд жилд дунджаар 87 хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг авсан байна.

### **Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэргийн байдал 2010-2012 он**

Насанд хүрээгүй хүмүүс үйлдсэн хэрэг сүүлийн гурван жилийн байдлаар 2010 онд 455 хэрэгт 907 хүүхэд, 2011 онд 590 хэрэгт 1163 хүүхэд, 2012 онд 1076 хэрэгт 673 хүүхэд тус тус бүртгэгдсэн нь нийлбэр дүнгээрээ нийт 2021 хэрэгт 2743 хүүхэд шалгагдсан байна. Дээрх гурван жилийн тоон үзүүлэлтээс харахад нэг жилд дунджаар насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн 673 хэрэгт 914 хүүхэд холбогдон шалгагдсан байна.

Эдгээр гэмт хэрэг үйлдсэн хүүхдүүдийн насны ангиллыг хувиалан авч үзвэл :

- 15 хүртэлх насны 771 хүүхэд гэмт хэрэг үйлдсэн буюу нийт гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн 28.1 хувийг;
- 16-17 насны 1972 хүүхэд гэмт хэрэг үйлдсэн буюу нийт гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн 71.9 хувийг тус тус эзэлж байна.

Сүүлийн гурван жилийн байдлаар нийт 263 хүнд буюу жилд дунджаар 87 хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг авсан байна. Эдгээр нь насанд хүрээгүй гэмт хэрэг үйлдсэн хүүхдүүд бөгөөд энэ нь нийт ял шийтгэлийн 1.1 хувийг эзэлж байна.

2010 онд 68 хүнд буюу насанд хүрээгүй гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн 7.5 хувьд, 2011 онд 63 хүнд буюу насанд хүрээгүй гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн 5.4 хувьд, 2012 онд 132 хүнд буюу насанд хүрээгүй гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн 19.6 хувьд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг тус тус авсан байна. Өөрөөр хэлбэл нэг жилд дунджаар насанд хүрээгүй гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн 10.8 хувьд буюу 87 хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг авсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын насанд хүрээгүй ялтны судалгаагаар 2010 онд 46 хүүхэд, 2011 онд 56 хүүхэд, 2012 онд 83 хүүхэд тус тус хорих 407, 411-р ангиудад ял эдэлсэн байна. Өөрөөр хэлбэл сүүлийн гурван жилд нийт 185 буюу жилд дунджаар 61 хүүхэд хорих ангид ял эдэлсэн байна. Нийт хорих ял эдэлж буй хүүхдийн 28.1 хувь буюу жилд дунджаар 17 хүүхдийг нь суллаж, 23.7 хувь буюу жилд дунджаар 14 хүүхдийг насанд хүрэгчдийн хорих ангид шилжүүлж, 48.1 хувь буюу жилд дунджаар 29 хүүхдийг хорих ангид үргэлжлүүлэн ял эдлүүлсэн байна.

### 3.3. Эрүүгийн хуулийг шинэтгэх шаардлага:

Хууль тогтоогч болон хэрэгжүүлэгч, эрдэмтэн судлаачдын зүгээс уг хуулийг шинэчлэх цаг үеийн хэрэгцээ, шаардлагыг аль аль талдаа “нэгэн дуугаар” хүлээн зөвшөөрч байна. Ингэхдээ Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хүрээнд эн тэргүүнд эрүүгийн хуулийг шинэтгэн “criminal justice system” буюу эрүүгийн хариуцлагын тогтолцооны суурь материаллаг норматив үндсийг бүрдүүлэх хэрэгцээ тулгараад буйг харгалзаж үзэх хэргтэй байна.

Уг хуульд харьцангуй урт хугацаанд тогтвортой мөрдөх зарим хэм хэмжээг нухацтай судалгаа хийсний үндсэн дээр оруулах хэрэгцээ, шаардлага байсаар байгаа юм.

Энэхүү шаардлагыг харгалзан Улсын Их Хурлын 2009 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл” - ийн 95 дугаар заалтад “Эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэргийн хохирлын хэмжээг тодорхой болгох, ойлгомжгүй буюу оновчгүй хэрэглэсэн зарим нэр томъёог залруулах, Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцид нийцүүлэх, албан тушаалын гэмт хэргийг ялын бодлогыг чангатгах”, Улсын Их Хурлын 2012 оны “Засгийн газрын үйл ажиллагааны 2012-2016 оны хөтөлбөр батлах тухай” 37 дугаар тогтоолд ардчилсан нийгмийн үнэт зүйл, зарчим, улс орны хөгжлийн шаардлагад нийцсэн, урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох чадавхтай эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоог бүрдүүлж, ялын бодлогыг оновчтой үр нөлөөтэй, олон сонголттой болгохоор заасантай нийцүүлэх, Олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх талаар судлан үзсэний үндсэн дээр хэд хэдэн субъектээс боловсруулж байсан төслүүдийг нэгтгэн Гэмт хэргийн хуулийн төслийг боловсруулж байна.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж байгаа энэ үед хууль санаачлах эрх бүхий бусад этгээдээс хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэсэн хуулийн цөөнгүй төслүүдийг санаачлан боловсруулж байгаагаас гадна эрдэмтэд, судлаачид, иргэний нийгмийн байгууллагууд ч хуулийн хэрэгжилтэд зүй ёсны шүүмжлэлтэй хандан өөрсдийн байр сууриа илэрхийлэх болсон.

## А. Гэмт хэргийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал<sup>37</sup>

### Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн хөгжлийг Ардын хувьсгал ялж, анхдугаар Үндсэн хуулийг боловсруулах ажлыг эхлүүлсэн 1921 оноос хойш тооцож үзвэл, 1926, 1929, 1934 оны “Шүүх цаазын бичиг”, 1942, 1961, 1986, 2002 оны “Эрүүгийн хууль”-иуд нь залгамж чанартай, тухайн цаг үеийн улс төр, үзэл суртлыг агуулсан шинжтэй байсан хэдий ч түүхэн үүргээ зохих ёсоор гүйцэтгэж иржээ.

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулсан 2002 оны Эрүүгийн хуулийг дагаж мөрдсөнөөс хойш цаг үеийн нөхцөл байдал, нийгмийн захиалга, шаардлагаар уг хуульд олон удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Дээрх нэмэлт, өөрчлөлтүүд нь хохирлын хэмжээ болон гэмт хэрэгт тооцох нөхцөлийг тодорхой болгох, шинэ гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хуульчлах, Монгол Улс олон улсын гэрээ, конвенцид шинээр нэгдэн орсон, соёрхон баталсан, түүнчлэн өөр бусад хууль шинээр батлагдаж, зарим хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор хийгдэж ирсэн боловч өнөөгийн нийгмийн харилцааны хөгжил, эрэлт хэрэгцээтэй холбон авч үзвэл Үндсэн хуулиар тунхагласан үнэт зүйлсийг бүрэн дүүрэн хамгаалж чадаагүй, даяарчлагдаж буй эрин үед олон улсын нийтийн эрх зүйн хөгжлөөс хоцрох хандлагатай байна.

Шударга ёсыг хамгаалах тогтолцооны үндсийг бүрдүүлэх үүднээс хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, ХЗҮХ, МУИС-ийн ХЗС, ХСИС зэрэг судалгаа, эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн, судлаачдаас Эрүүгийн хуулийн эерэг болон сөрөг үр нөлөө, хэрэгжилтийн талаар хийсэн 10 гаруй судалгаа, хуулийн төсөлд дурдсан Эрүүгийн хуулийн үзэл баримтлал, зарчим, ерөнхий анги, тусгай ангийг бүхэлд нь шинэчлэх талаарх байр суурь, санал шүүмжлэл, зөвлөмжийг харгалзан үзэж, ардчилсан нийгмийн харилцаанд тохирсон, Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний суурь эрх, халдашгүй байдлыг илүү баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцсэн урт хугацаанд тогтвортой үйлчлэх хуулийг батлан гаргах зүй ёсны шаардлага урган гарч байна.

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Ардчилсан нийгмийн үнэт зүйл, зарчим, улс орны хөгжлийн шаардлагад нийцсэн, урьдчилан сэргийлэх, хариуцлага

тооцох чадавхтай эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоог бүрдүүлж, ялын бодлогыг оновчтой үр нөлөөтэй, олон сонголттой болгох" зорилтыг дэвшүүлсэн билээ.

Түүнчлэн олон нийт, иргэний нийгмийн байгууллагаас гэмт хэрэг, зөрчлийн ялгаа, гэмт хэргийн ангилал ба ялын төрөл хэмжээ, ял шийтгэлийн бодлого, хохирлын хэмжээ, гэмт хэргийн зүйлчлэл, шинэ гэмт хэргийн бүрэлдэхүүн зэрэг асуудалд зүй ёсны шүүмжлэлтэй хандан гаргасан санал, зөвлөмжийг ажлын хэсгийн гишүүд судлан үзсэн.

Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан үнэт зүйлсийг материаллаг хуулиар хамгаалахдаа гэмт хэрэг, зөрчлийн шинжийг ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байдлаар, өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчилж, томъёолохоос гадна шинээр хамгаалах шаардлагатай харилцаа, хүний эрх, эрх чөлөө, хүний халдашгүй байдлыг хамгаалах хууль эрх зүйн баталгаатай орчныг бүрдүүлэхэд Эрүүгийн хариуцлагын тогтолцооны шинэтгэл чиглэгдэж байна.

Энэ зорилгоор хүнийг эрүүдэн шүүх, хүний орон байранд хууль бусаар халдах, хууль бусаар нэгжих, эд хөрөнгө хураан авах, битүүмжлэх, хүнийг зөвшөөрөлгүй мөрдөж мөшгих, хууль бусаар баривчлах, саатуулах, ялгаварлан гадуурхах, гэр бүл – ахуйн хүчирхийлэл зэрэг шинэ гэмт хэргийг хуулийн төсөлд тусгахаас гадна практикт хэрэглэхэд төвөгтэй, ялын бодлогын хувьд үр нөлөө багатай олон зүйл, заалтын диспозиц шинж, оногдуулах санкцийг төрийн бодлого, нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хуулийн төсөлд тусгана.

Нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг “гэмт хэрэг” ба “захиргааны зөрчил” гэж ангилж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг илрүүлж, хянан шийдвэрлэхэд анхаарч, харин захиргааны зөрчилтэй холбоотой нийгмийн харилцааг захиргааны эрх зүйд хамааруулж, Захиргааны хариуцлагын тухай хуулиар шийдвэрлэж иржээ. Иймд Эрүүгийн хариуцлагын тогтолцоог Гэмт хэргийн тухай хууль, Зөрчлийн тухай хуулиас бүрдэхээр авч үзэж, Үндсэн хуулиар хамгаалагдсан үнэт зүйлсийг давхардал, хийдэлгүйгээр, үр дүнтэй хамгаалах, гэмт явдлаас урьдчилан сэргийлэхэд чиглүүлж, гэмт хэрэг болон зөрчлийг нэг стандарт, журмын дагуу шалгаж, шийдвэрлэх зохицуулалтыг бий болгоно.

Хуулийн төсөлд гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, түүнд оногдуулах ялын төрөл, хэмжээ, хянан харгалзах арга хэмжээг тогтооно.

Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан үнэт зүйлс болох хууль ёсны ашиг сонирхлыг гэмт халдлагаас бодитой хамгаалахын тулд хувь хүнээс гадна хуулийн этгээдийг гэмт хэрэг, зөрчлийн субъектэд тооцож, хариуцлага хүлээлгэх талаар зохицуулалтыг оруулснаар олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх боломж бүрдэнэ.

## Хоёр. Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хуулийн төслийн ерөнхий бүтэц

### **1/ Гэмт хэргийн тухай хуулийн ерөнхий ангид хийх өөрчлөлтийн талаар:**

Гэмт хэргийн тухай хуулийн төслийн ерөнхий ангид оруулсан өөрчлөлтийг тоймлон дурдвал:

1. Гэмт хэргийн тухай хуулийн төслийн зорилтыг шинээр томъёолж хүний эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан нийтлэг ашиг сонирхлыг нэн тэргүүнд авч үзэж, Монгол Улсын Үндсэн хуульд байгуулал, хүн төрөлхтөний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх байдлаар эрэмбэлнэ.

2. Ерөнхий ангид нэрлэж, томъёолсон зарчмуудын агуулгыг шинээр томъёолж “Хууль ёсны зарчим”, “Гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарчим”, “Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим”, “Шударга ёсны зарчим”, “Энэрэнгүй ёсны зарчим”, “Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх зарчим”, “Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим” гэсэн 7 зарчмын агуулгыг өөрчилж боловсруулна. Ингэснээр шүүх хуульд заасан зарчмыг баримталж хэрэг шийдвэрлэх боломж бүрдэнэ гэж үзлээ.

3. Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд гэмт хэргийн талаарх ойлголтыг өргөн хүрээтэй болгох, хүн, нийгэм, төрд учруулах хор аюулын шинж чанараас хамааруулан гэмт хэргийг зөрчлөөс шинжээр нь тодорхой ялган зааглана. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хохирлын хэмжээ гэсэн шалгуур үзүүлэлт бүхий, босго тогтоосон ойлголтыг байхгүй болгосноор гэмт хэргийг зөрчлөөс материаллаг шинжээр ялган төсөөтэй байдлаар хэрэглэдэг байдлыг хална.

4. Одоо хэрэглэж байгаа баривчлах ял үр нөлөөгүй байгааг харгалзан үзэж хорих ялыг долоо хоногоос хорин жил хүртэл хугацаатай байхаар тооцож, иргэн, нийгэм, төрд шууд

хохирол учруулахад чиглэгдсэн үйлдлүүдийг хуулийн төсөлд тусгаж, “эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүйн учир нийгэмд аюулгүй үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй” гэсэн ойлголтыг халж, шинээр боловсруулагдах Зөрчлийн хуулийн төсөлтэй уялдуулна.

5. Хуулийн төсөлд гэмт хэргийн бүрэлдэхүүн гэсэн ойлголтыг гэмт хэргийн шинж гэж томъёолон хуулийг төсөөтэй хэрэглэхгүй байх, гэмт хэргийн шинжийг тодорхойлох, тайлбарлахад энэ хууль, бусад хуулиар тогтоосон нэр томъёо, зүйл, хэсэг, заалтыг хэрэглэх, шаардлагатай тохиолдолд хуулиар тусгайлан эрх олгож хэм хэмжээ тогтоосон актыг үнэлж, хэрэглэж болох талаар тусгана. Шүүхийн тухай хуульд зааснаар Улсын Дээд шүүх хуульд заасан нэр томъёо, аливаа зүйл, хэсгийг нэг мөр зөв ойлгож, нэгдсэн практик тогтоох асуудлыг зөвхөн хэрэг маргааныг шийдвэрлэх замаар тайлбарлахаар болж байгаа тул хуульд гэмт хэргийн диспозиц шинж, хууль зүйн нэр томъёог тодорхой, ойлгомжтой бичих шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

6. Хуулийн төсөлд гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдалд хамаарах “бие махбодийн буюу сэтгэл санааны албадлага”-ыг нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдал гэсэн хэсэгт оруулж, Гэмт хэргийн тухай хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд сэтгэл санааны болон бие махбодийн хянан харгалзах үр дүнд гэмт хэрэг үйлдсэн бол хариуцлага хүлээлгэхгүй байх зохицуулалтыг оруулна.

7. “Бүлэглэсэн”, “урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг” гэсэн тодорхойлолтыг өөрчилж, хамтран оролцогч, зохион байгуулагч, захиалагч, хатгагч, хамжигч, гүйцэтгэгч гэсэн томъёоллын заримыг нэгтгэх, гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн, зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн тохиолдолд хуулийн төсөлд заасан ялын төрөл хэмжээ, хязгаарын хүрээнд илүү чанга ял оногдуулдаг байх бодлого баримтална.

8. Онц аюултай гэмт хэрэгтэн, ялтай байдал, урьд ял шийтгүүлсэн, гэмт хэрэг давтан үйлдсэн гэж хүндрүүлэн үзэхээр нэрлэн заасан, хууль зүйн үр дагавар үүсгэдэг ойлголтыг өөрчилж, Тусгай ангийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон авч үзэхгүй байхаар хуулийн төсөлд тусгана. Эрүүгийн хуулийн нийт 49 зүйлд гэмт хэргийг давтан үйлдсэн, 13 зүйлд урьд ял шийтгүүлсэн бол хүндрүүлж үзэхээр заажээ. Энэ нь нэг хэрэгт нэг удаа ял шийтгэх буюу олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн “Non double jeopardy” зарчмыг гажуудуулахад хүргэж, аливаа гэмт хэрэгт ял шийтгүүлж, эдэлсний дараа түүний үр дагаврыг хүндрүүлэн хэрэглэж байгааг өөрчлөн хуулийн төслийн Ерөнхий ангид “ял хүндрүүлэх нөхцөл байдал” гэсэн хэсэгт тусгана.

Монгол Улсад сүүлийн 10 жилийн дунджаар авч үзэхэд жилд 7272 хүн хорих ял эдэлдэг бол хорих байгууллагаар дамжиж байгаа хүмүүсийн тоо 12000 байдаг байна.

Улсын хэмжээнд 2000-2010 онд нийт 40119 хүн шоронгоос суллагдаж, үүнээс 19000 хүн дахин гэмт хэрэг үйлджээ. Энэ нь сүүлийн арван жилийн дунджаар шоронгоос суллагдсан хүмүүсийн 47% нь дахин гэмт хэрэг үйлдэж хуулийн байгууллагад шалгагдсаныг харуулж байна.

9. Ял, шийтгэл нь гарцаагүй байх ёстой боловч давтан гэмт явдлын шалтгаан байх ёсгүй байдлыг харгалзан сонгон хэрэглэх боломжтой хянан харгалзах арга хэмжээ болох эмнэлгийн чанартай, хянан харгалзах, эрх хасах, хязгаарлах, хүүхдэд хүлээлгэх хариуцлагын төрлийг шинээр хуулийн төсөлд тусгана. Ингэснээр хянан харгалзах арга хэмжээ нь сонгон оногдуулах боломжтой байх ба хорих ялыг багасгаж, үр нөлөөтэй, хүний хувийн байдалд тохирсон байх шинжийг харгалзан үзэх боломжтой болно. Уламжилж ирсэн “эрүүгийн хариуцлага” гэсэн ойлголтыг “ял шийтгэл” хэмээн тодорхойлж, энэ дотроо ял, хянан харгалзах арга хэмжээ гэсэн 2 хэсгээс бүрдэхээр тусгасан. Ял үр нөлөөтэй байх зорилгыг хангах үүднээс ял эдэлж дууссаны дараа хянан харгалзах арга хэмжээг хэрэгжих байдлаар хуулийн төсөлд тусгана.

10. Хуулийн төсөлд ялын төрлийг дараах байдлаар тусгана. Үүнд:

а/ Торгох ялыг нэг зуун дөчин мянгаас ерэн сая хүртэлх төгрөгөөр оногдуулахаар зааж, уг торгох ялаас хохирогчид учирсан хохирлыг төлүүлэх, ялтан торгох ялыг сайн дураараа биелүүлээгүй тохиолдолд албадан биелүүлэх, албадан биелүүлэх ажиллагаанд саад учруулсан, оргон зайлсан тохиолдолд торгох ялыг хорих ялаар солих;  
б/ Нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт дөрвөөс дээшгүй цагаар эдлүүлэх, ялыг эдлүүлэх хугацаа нь нэг зуун хорин цагаас дөрвөн зуун наян цаг, уг ялаас зайлсхийсэн тохиолдолд хорих ялаар солих, хөдөлмөрийн чадваргүй хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, жирэмсэн, 3 хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эх, эцэг, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэйд оногдуулахгүй байх;

в/ Эрх чөлөө хязгаарлах ялыг долоо хоногоос таван жил хүртэл хугацаагаар оногдуулахаар зааж, тодорхой хүн, хэсэг бүлэг хүн, тогтоосон замаар зорчих, хууль сахиулах

байгууллагын зөвшөөрлөөр оршин суух газраа өөрчлөх зэргээр эдлүүлэх бөгөөд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, хоригийг зөрчвөл уг ялын нэг хоногийг хорих ялын нэг хоногоор дүйцүүлэх;

Энэ нь шинэ төрлийн ял бөгөөд шүүхээс хорих ялыг оногдуулах явдлыг багасгах зорилготой, цахим хяналт, электрон гав хэлбэртэй байх юм.

г/ Хорих ял нь хугацаатай ба бүх насаар нь байна. Хугацаатай хорих ял нь долоо хоногоос 20 жил хүртэл байх, бүх насаар хорих ял нь хорин жилээс дээш хугацаагаар байх бөгөөд суллагдах үндэслэл нь хорин жилээс дээш хугацаагаар хорих ялыг биечлэн эдэлсний дараа үүсэх;

Монгол Улс нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II дугаар Протоколд нэгдэж орсонтой холбогдуулан цаазаар авах ялыг бүрмөсөн хална. Харин энэ онцгой ялын оронд бүх насаар хорих ялыг хуулийн төсөлд тусгаж, 20 жилийн дараа тодорхой болзол хангаж байвал хугацаатай хорих ялаар сольж болох талаарх зохицуулалтыг шинээр оруулна.

д/ Эрх хасах, хязгаарлах ялыг гэмт хэрэг үйлдсэн хүний нийтийн албанд сонгогдох, томилогдох, тодорхой төрлийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг бүрмөсөн хасах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хязгаарлах, эрх эзэмших эрхийг хүчингүй болгох, тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх;

Шүүхийн практикт ихэвчлэн тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг хасахаас өөр байдлаар хэрэглэж байгаагүй юм.

е/ Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, хөрөнгө, орлогыг хураах ялыг Эрүүгийн хуульд заасан нэмэгдэл ялын төрлөөс хэлбэрийн хувьд ялгаагүй эд зүйл, хөрөнгө, орлогыг шударгаар олж авсан хүнд хууль бус хэлцлийн улмаас учирсан хохирлыг буруутай хүний хувьд ноогдох, хуулиар хориглоогүй хөрөнгө, орлогоос албадан гаргуулж хохирлыг нөхөн төлүүлэхээр тусгана.

11. Дагаж мөрдөж буй Эрүүгийн хуульд эмнэлгийн чанартай хянан харгалзах арга хэмжээ, хүмүүжлийн чанартай хянан харгалзах арга хэмжээ гэсэн 2 институтыг оруулсан боловч хүмүүжлийн чанартай арга хэмжээ нь хууль хэрэгжиж эхэлснээс өдийг хүртэл бүрэн утгаараа хэрэгжээгүй, сургалт хүмүүжлийн тусгай байгууллага огт ажиллаагүй байгааг судлан үзэж хүүхдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага хатуу, хуульд зааснаас хөнгөн ял оногдуулах боломжгүй болсон гэж үзэж болно.

#### Хуулийн төсөлд хянан харгалзах арга хэмжээг дараах байдлаар тусгана:

а/ тэнсэж, хянан харгалзах арга хэмжээ нь гадаадын ихэнх орны гэмт хэргийн тухай хуульд parole, probation гэх зэргээр нэрлэдэг хорих ялыг биечлэн эдлүүлэхгүйгээр хянан харгалздаг албадлагын арга хэмжээ байна. Энэ нь хэлбэрийн хувьд тодорхой хугацаанд дахин гэмт хэрэг үйлдэхгүй, засарч хүмүүжих талаар амлалт өгч, хууль сахиулах байгууллагын хяналтад байх хэлбэрээр хэрэгжинэ. Үүнтэй холбоотойгоор хорих байгууллагад хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэх нэгж, алба байгуулагдана.

б/ хүмүүжүүлж хянан харгалзах арга хэмжээ нь хүүхдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, үйлдсэн гэмт хэргийн шинж, учруулсан хохирлоо сайн дураараа төлсөн байдлыг харгалзан үзэж хорих ял оногдуулахааргүй бол шүүхээс дөрвөн жил хүртэл хугацаагаар хүмүүжүүлж хянан харгалзах арга хэмжээг хэрэглэнэ.

в/ эмчилж хянан харгалзах арга хэмжээ нь Эрүүгийн хуулийн зохицуулалтаас зарчмын ялгаагүй боловч гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан, ял эдэлж байх үедээ сэтгэцийн өвчнөөр өвдсөн хоёр тохиолдолд ялыг хэрхэн эдлүүлэх асуудлыг нарийвчлан зааж өгсөн.

12. Ялыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг Эрүүгийн хуулийн тусгай ангид тусгайлан заагаагүй зүйл, хэсэгт хэрэглэх талаар тусгаж өгсөн бөгөөд энэ нь гэмт хэргийн зүйлчлэл, оногдуулах ял шийтгэлд бодитой нөлөөлөх шинжтэй тул аливаа гэмт хэргийг шийдвэрлэхэд ерөнхий ангийн зүйл, хэсгийн үр нөлөөг дээшлүүлэх ач холбогдолтой гэж үзэж хуулийн төсөлд тусгана. Тухайлбал, шүүх ял оногдуулахдаа хуульд заагаагүй өөр хөнгөрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзэж болох, хэрэв тусгай ангийн холбогдох зүйлд хүндрүүлэх нөхцөл байдлыг гэмт хэргийн шинж болгон заасан тохиолдолд ял оногдуулахад харгалзан үзэхгүй байх Эрүүгийн хуулийн уламжлалт зохицуулалтыг авч үлдэнэ.

13. Хүүхдэд хүлээлгэх ялын төрлийг хуулийн төсөлд тусгай бүлгээр зохицуулах бөгөөд “насанд хүрээгүй этгээд” гэсэн нэршлээс зайлсхийж, “хүүхэд” гэж гэмт хэрэг үйлдэх үедээ 18 насанд хүрээгүй хүнийг ойлгохоор томъёолсон. Ял шийтгэл хүлээлгэх насны хязгаарыг 14 наснаас байхаар хуулийн төсөлд тусгасан бөгөөд бусад орны Гэмт хэргийн тухай хуульд заасан

ял шийтгэл оногдуулах насны хязгаарын шалгуурыг харгалзан үзсэн. Энэ нь 14 наснаас дээш гэмт хэрэг үйлдсэн хүүхэд бүрт ял оногдуулах зорилгогүй бөгөөд хүүхдийн хүмүүжил нас бие, сэтгэхүйн онцлогт тохирсон ял шийтгэл оногдуулах тусгай бүлэгтэй харилцан уялдаатай байх талаар хуулийн төсөлд тусгана. Эрүүгийн хуульд зааснаас үзэхэд 18 насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн гэж тодорхой заасан боловч шүүхийн практикт ял оногдуулах үед насанд хүрсэн гэдгээр эрх зүйн байдлыг дордуулан хэрэглэж, насанд хүрсэн хүний нэгэн адил ял оногдуулдаг байдлыг анхаарч, энэ нь олон улсын наад захын стандарт жишиг, дүрмүүдтэй нийцэхгүй байгаа тул цаашид зөвхөн гэмт хэрэг үйлдэх үедээ 21 нас хүрсэн хүний зарим онцлогийг харгалзан хүүхдэд оногдуулах журмыг хэрэглэж болох талаар хуулийн төсөлд тусгана.

14. Хэд хэдэн гэмт хэрэгт болон хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах заалтыг нэгтгэж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ялтан, шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулах, нэг гэмт хэргийг шийдвэрлэхгүйгээр нөгөө хэргийг шийдвэрлэх боломжгүй байдалд хүргэдэг шалтгааныг арилгах боломжтой байдлаар хуулийн төсөлд тусгана. Шүүхийн практикт тулгамдаж буй асуудлыг судлан үзвэл хуулийн дээрх заалтаас шалтгаалж хэргийн шийдвэрлэлт удаашрах, "хэргээ задлах", "хэрэг наймаалцах" зэрэг сөрөг үзэгдэл гарч байна. Хуулийн төсөлд шинээр оруулах заалтын агуулга нь хэрэг бүрт оногдуулсан ялыг нэмэх замаар жинхэнэ эдлэх ялын хэмжээг тогтоох, ингэхдээ хуульд заасан дээд хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, хэргийг тусгаарлан шийдвэрлэх боломжтой талаар хуулийн төсөлд тусгана.

15. Хэрэг хариуцах чадваргүй байдал гэдгийг тодорхой болгох үүднээс бусад улс орны туршлага, Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдлын талаар холбогдох байгууллагуудын саналыг үндэслэн дээрх ойлголтыг хуулийн төсөлд тусгасан. Тухайлбал, Хэрэг хариуцах чадвар бүхий сэтгэцийн зовиуртай, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага, шүүх ял оногдуулахдаа хэрэг хариуцах чадвар нь үгүйсгэгдээгүй сэтгэцийн зовиурыг харгалзан үзэх ба түүнийг эмнэлгийн чанартай хянан харгалзах арга хэмжээ ногдуулах үндэслэл болгож болохоор хуулийн төсөлд тусгана.

16. Эрүүгийн хуулийн Ерөнхий ангид ялын бодлогоор онц хүнд, хүнд, хүндэвтэр, хөнгөн гэж дөрөв эрэмбэлэн заасан ангилал нь "хохирлын хэмжээ" буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр дүйцүүлэн тооцсон "бага бус", "үлэмж", "их", "онц их" гэсэн хэмжээнээс шалтгаалж өөрчлөгддөг. Энэ нь Эрүүгийн хуулийн тусгай ангид нэрлэн заасан нийт гэмт хэргийн 80 орчим хувь материаллаг бүрэлдэхүүнтэй, хохирлын хэмжээнээс хамаарч эдгээр гэмт хэргийн ангилал өөрчлөгддөг. Хуулийн төсөлд материаллаг шинж, босго тогтоосон хэмжигдэхүүнээс зайлсхийж, гэмт үйлдлийг шууд тоочих замаар хууль зүйн техник ашиглаж, ял шийтгэл оногдуулахдаа гэмт хэргийг ангилахгүйгээр гэмт хэрэг үйлдсэн хүний гэм буруу, учруулсан хохирлын шинжийг харгалзан үзэх талаарх зохицуулалтыг оруулна.

Шүүхээс энэ хуулийн тусгай ангид хорихоос өөр төрлийн ялыг сонгон оногдуулах өргөн боломжтой, хорих ялын дээд болон доод хэмжээг сунгаж, харьцангуй уян хатан байдлаар хуулийн төсөлд тусгасан. Ингэснээр гэмт хэргийн ангилал, шүүхээс оногдуулах ял хоорондоо уялдаагүй, хатуу хязгаарын хүрээнд гэм буруугийн шинжид тохирохгүй ял оногдуулдаг гэсэн шүүмжлэл багасч, шударгаар хэргийг шийдвэрлэхэд дөхөм болно гэж үзэж байна.

17. Гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийн гэм буруутай болохыг хүлээн зөвшөөрч, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлөх, хор уршгийг арилгах хүсэлтээ илэрхийлсэн бол шүүх үйлдсэн гэмт хэргийн шинж, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, хор уршгийг харгалзан ялын тодорхой хэсгийг оногдуулах, эсхүл ял оногдуулахгүйгээр хянан харгалзах арга хэмжээ хэрэглэх эсхүл ял шийтгэлээс чөлөөлөх, энэ журмаар ял шийтгэл оногдуулахдаа энэ хуулийн тусгай ангид заасан тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын доод хэмжээнээс доогуур ял оногдуулж болохоор тусгана.

18. Түүнчлэн хуулийн нэр томъёо, давхардал, хоёрдмол утга бүхий зүйл, заалтыг өөрчлөх, "ба", "буюу", "бөгөөд", "эсвэл" гэсэн хоёрдмол агуулга бүхий хууль зүйн техникийг ашиглахаас татгалзаж, санаатай эсвэл болгоомжгүй гэмт хэргийн субъектив талыг тодорхой заах, хуулийн бичилтийг дахиж сайтар өөрчлөн найруулахад анхаарна.

## **2/ Эрүүгийн хуулийн Тусгай ангид хийх өөрчлөлтийн талаар:**

Шинээр гэмт хэрэгт тооцох, эс тооцох буюу эрүүжүүлэх, эрүүгүйжүүлэх үйлдлийг тусгах, Гэмт хэргийн загвар хуульд заасан боломжтой зарим гэмт хэргийн томъёоллыг харгалзан үзнэ. Мөн Хууль санаачлах эрх бүхий субъект, тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан



авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой зүйл, заалтыг НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид заасантай нийцүүлэн гэмт хэргийн шинжийг тодорхой тусгаж өгнө.

Гэмт хэргийн төрлийг шинээр бүлэглэн тус хуулийн Ерөнхий ангид заасан хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийтийн эрх ашгийг хангах бодлогыг нэн тэргүүнд баримтлах талаар хуулийн төсөлд тусгана. Тухайлбал, хуулийн төслийн Тусгай анги нь “Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг” гэсэн бүлгээс эхлэх ба хүн төрөлхтөний эсрэг гэмт хэргийн бүлгийг Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд нийцүүлж, Гэмт хэргийн загвар хуульд заасан нэр, томъёо, хууль зүйн техникийг ашиглана.

Хүний эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн бүлгийг дахин судалж, юуны урьд хүний бие махбодь, сэтгэл санаа, өмч хөрөнгийн эсрэг идэвхитэй халдлага хийсэн, хохирол учруулсан үйлдлийг тусгахаар оруулсан бөгөөд үүний дараа бусад эрх, эрх чөлөө тухайлбал, захидал, харилцаа, улстөрийн эрх, эрх чөлөөг зөрчиж хохирол учруулсан үйлдлүүдийг эрэмбэлэх замаар гэмт хэрэгт тооцож хуулийн төсөлд тусгана.

Шинэ тутам үйлдэгдэж буй гэмт хэрэг, тухайлбал, мэдээллийн аюулгүй байдал, түүнд халдсан зарим гэмт хэргийг ахин шинээр томъёолох, авлига, албан тушаалын гэмт хэргийг тодорхой зааж, шан харамж авах гэх мэт зарим гэмт хэргийн бүрэлдэхүүнийг өөрчилж, энэ бүлэгт нэгтгэнэ. Түүнчлэн, соёлын өвтэй холбоотой түүх соёлын дурсгалт зүйл, археологи, геологи, палентологийн үнэт олдвор, хосгүй үнэт зүйлийг хамгаалах талаар төрөөс баримталж буй бодлогод нийцүүлж “Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг” гэсэн бүлгийг шинээр оруулна.

Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг гэсэн бүлгийг шинээр оруулсан бөгөөд хүүхдийн эрхийн эсрэг үйлддэг хүчирхийллийн ялын бодлогыг чангатгах, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч хүүхдийг хайхрахгүй орхих, хүүхдийг шийтгэснээс хор уршиг учирсан тохиолдолд ял шийтгэл оногдуулах талаар төсөлд тусгана.

Практикт шийдвэрлэхэд байнга бэрхшээл учруулж байдаг хулгай, дээрэм, булаалт, танхай, залилан мэхлэх, завших, үрэгдүүлэх, хүнийг санаатай алах, хөнгөн, хүндээр гэмтээх зэрэг өдөр тутам гарч буй гэмт хэрэг, хуулийн байгууллагын үйл ажиллагаа, ажлын ачаалалд нөлөөлж байдаг гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг хоёрдмол утгагүй, нарийвчлан, илүү тодорхой байдлаар хуулийн төсөлд тусгана.

Хуулийн төсөл боловсруулахдаа гэмт хэргийг зүйлчлэхэд хүндрэл учрахгүй байхад анхаарч ижил төрлийн харилцааг хамгаалсан, гэмт хэрэгт тооцож, ял оногдуулахаар заасан хэмжээний давхардлыг арилгана.

Түүнчлэн эдийн засгийн эсрэг гэмт хэрэг гэсэн шинэ бүлгийг орчин үеийн нийгмийн харилцааны онцлогийг харгалзан оруулж байгаа бөгөөд үүнд зах зээл дэх давамгайл байдлаа хууль бусаар ашиглах, зах зээлийн үнэ хөөрөгдөх, зохиомлоор, эсхүл зориуд дампуурах, хууль бусаар зээл төлөхөөс зайлсхийх, банк, санхүүгийн үйл ажиллагаа хууль бусаар эрхлэх, аж ахуйн үйл ажиллагааны нууцад халдах, хууль бусаар дампууруулах, хууль бусаар нийгмийн халамж үйлчилгээ, даатгал авах зэрэг шинэ гэмт хэргийг тусгана.

Мөн хуулийг Улсын Дээд шүүхийн тогтоолоор тайлбарлаж, төсөөтэй хэрэглэдэг байдлыг эцэс болгож, зөвхөн хуулиар тайлбарладаг байх эсхүл хуулийн зүйл, заалт, хэсгийн доор хууль зүйн техник ашиглан бичих замаар хуулийн нэр томъёог тайлбарлан хэрэглэх боломжийг хуулийн төсөлд тусгана.

#### Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

- Гэмт хэргийн тухай хуулийн төсөл батлагдаж, мөрдөгдсөнөөр хорих ял эдэлж буй ялтнуудын тоо багасна.
- Хуулийн төсөлтэй холбоотой нэмэлт зардлыг тусгайлан тооцож гаргах бөгөөд тухайлбал, хорих ял оногдуулахгүйгээр бусад эрх чөлөө хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх ял болон тэнсэж хянан харгалзах, хүүхдэд хүлээлгэх албадлагын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг тухайлан тооцно.
- Гэмт хэргийн тухай хуулийн төсөл батлагдсаны дараа багавтар хэмжээгээр бусдын эд хөрөнгийг хулгайлах, булаах, залилан мэхэлж авах гэмт хэрэг зэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх зардлыг шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудын төсөв, зохион байгуулалтын хүрээнд шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.
- Хуулийн төсөлд тусгагдсан ял, хянан харгалзах арга хэмжээг хэрэгжүүлэх институтын бүтэц, нэгжийг шинээр зохион байгуулна.

Дөрөв. Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах хүчингүй болгох хуулийн талаар

Гэмт хэргийн тухай хууль шинээр боловсруулж байгаатай холбогдуулан Зөрчлийн хууль /Захиргааны хариуцлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга/, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай болон бусад холбогдох хуулиудад зарчмын шинжтэй томоохон өөрчлөлт оруулна. Түүнчлэн Гэмт хэргийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг боловсруулна.

## **Б. Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал<sup>38</sup>**

Монгол Улсад гэмт явдалтай тэмцэх харилцааг зохицуулж ирсэн Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль хоорондоо уялдаатай явж ирсэн. Гэмт явдалтай тэмцэх бодлогын шинэтгэл хийгдэж байгаатай уялдуулан Захиргааны хариуцлагын тухай хууль ч шинэчлэгдэх зайлшгүй шаардлага урган гарсан.

### Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1992 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Улсын Их Хурлаас “Зөрчлийн тухай” Монгол Улсын хуулийг баталж, мөн оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн одоог хүртэл хүчин төгөлдөр мөрдөж байгаа бөгөөд энэ хугацаанд уг хуульд нийтдээ 30 удаа нэмэлт, өөрчлөлт орсон боловч зарчмын шинжтэй шинэчлэлт хийгдээгүй байна. Энэ хугацаанд улс орны нийгэм, эдийн засаг, хэв журмын нөхцөл байдал, иргэдийн амьжиргааны түвшин ихээхэн өөрчлөгдсөн, мөн шинээр олон хууль тогтоомж батлагдан гарсан байна.

Монгол Улсын Их Хурлын 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Зөрчлийн тухай хуулийг шинэчлэн найруулахаар тусгасны дагуу Зөрчлийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэл бэрхшээл, үр нөлөөний талаар судалгаа хийж уг хуулийг шинэчлэх дараахь шаардлага байна гэж үзэж байна:

1. Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 410 гаруй хууль байгаагаас зөрчлийн хэм хэмжээ тогтоосон зүйл заалт бүхий 196 хууль байна. Эдгээр хуулийн 14 хуульд нь хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ гэсэн ерөнхий байдлаар, 41 хуульд нь Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр иш татсан байдлаар зохицуулж, бусад хуульд зөрчлийн зөрчлийг бүрэлдэхүүнээр нь тодорхойлж заасан байна. Хууль тогтоомжийн эдгээр зохицуулалт нь Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийн бүрэлдэхүүнтэй зөрчилдсөн, давхардсан нь цөөнгүй байгаа бөгөөд үүнийг цаашид цэгцлэх, нэг мөр болгох шаардлага зүй ёсоор гарч байна.

2. Зөрчлийн тухай хуульд зөрчил хүлээлгэх эрх бүхий 11 этгээдийг заасан боловч зөрчлийн хэм хэмжээ тогтоосон бусад хуулиудад зөрчил хүлээлгэх эрх бүхий этгээдийг зөвхөн улсын байцаагч, шүүгч байхаар тусгасан нь зөрчил хүлээлгэх эрх бүхий этгээдийн зөрчил хянан шийдвэрлэх харъяаллыг давхардуулж зөрчил хүлээлгэх эрх бүхий субъектийн хүрээг тодорхой бус болгож байна.

Зөрчил хүлээлгэх эрх бүхий улсын байцаагч нь хуулиар тусгайлан улсын байцаагчийн эрх олгогдсон этгээд байдаг бол шүүгчийн хувьд зөрчлийн зөрчлийг дагнан шийдвэрлэдэг шүүх, шүүгч байдаггүйгээс сум, дүүргийн эрүүгийн хэргийн шүүгч нар ийм төрлийн зөрчлийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг. Энэ нь шүүх эрх мэдлийн байгууллагад ихээхэн ачаалал үүсгэдэг байна. Тухайлбал, анхан шатны шүүхээс 2009 онд улсын хэмжээнд нийт 12688 хүнд зөрчлийн шийтгэл ногдуулсны 682 хүнд торгох, 12006 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулсан байна. Мөн анхан шатны журмаар шүүгч, улсын байцаагчаас хянан шийдвэрлэсэн 191 зөрчлийн зөрчлийг зөрчил гаргасан этгээд, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч буюу өмгөөлөгчийн гаргасан гомдлоор аймаг, нийслэлийн шүүх давж заалдах журмаар хянасан гэсэн статистик тоо гарчээ.

Иймд зөрчил хянан шийдвэрлэх харъяаллын давхардлыг арилгаж, тодорхой болгох, зарим субъектийг зөрчил хүлээлгэх субъектийн тооноос хасах шаардлагатай байна.

3. Зөрчлийн тухай хуульд торгох, тусгайлан олгосон эрх хасах, хууль бусаар олсон орлого, эд зүйл буюу зөрчил гаргахад ашигласан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, байрыг хураах, баривчлах гэсэн 4 төрлийн шийтгэлийг заасан байдаг.

Зөрчлийн зөрчилд баривчлах шийтгэл ногдуулдаг эрх зүйн зохицуулалттай улс орнуудын хувьд зөрчлийн баривчлах шийтгэл, эрүүгийн баривчлах ял 2 нь зөвхөн хугацаагаараа ялгагддаг. Харин Герман, Австри, Швейцари зэрэг Европын холбооны улс орнууд зөрчлийн зөрчил нь ялимгүй зөрчил байдаг учраас хүний эрх чөлөөг хязгаарласан баривчлах шийтгэлийг ногдуулдаггүй бөгөөд дэлхийн ихэнх улсууд баривчлах шийтгэлийг зөрчлийн шийтгэлийн төрөлд хамруулахаас аль болох зайлсхийж, зөрчлийн зөрчилд торгох шийтгэлийг түлхүү хэрэглэдэг байна.

Зөрчлийн шийтгэл нь зөвхөн тухайн зохицуулалтыг амьдралд хэрэгжүүлэх зорилготой бөгөөд зөрчил гаргасан этгээдийг яллах, цээрлүүлэх зорилгыг агуулдаггүй учир хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах шийтгэлийг хүлээлгэх шаардлагагүй гэж судлаачид үздэг.

Мөн торгох шийтгэлийн хэмжээг 1992 онд 100-250000 төгрөгөөр тогтоож, одоо хүртэл энэхүү хэмжээгээр шийтгэлийг ногдуулж байна. Торгуулийн хэмжээг ийнхүү мөнгөн дүнгээр шууд илэрхийлсэн нь цаг хугацаа, нийгэм, эдийн засгийн өсөлт, мөнгөний ханшны өөрчлөлтөөс шалтгаалан хэт бага болж, шийтгэлийн зорилго, мөн чанар, нөлөөллийн шинж чанар, ач холбогдол алдагдаж байна.

Иймд бусад орны жишиг, чиг хандлагад нийцүүлэн зөрчлийн шийтгэлийн төрлийг шинэчлэн, шийтгэлийн хэмжээг оновчтой тогтоох шаардлагатай байна.

4.Зөрчлийн зөрчил нь эрүүгийн гэмт хэргээс нийгмийн аюулын шинж чанар, хир хэмжээгээрээ ялгагддаг боловч Зөрчлийн тухай хуульд нийт 51 төрлийн зөрчлийн зөрчлийг бүрэлдэхүүнээр нь тодорхойлон заасны 18 төрлийн зөрчил нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй давхардсан байдлаар тусгагдсан нь эрүүгийн хариуцлагаас зайлсхийх, ял завших боломжийг бүрдүүлж байна. Тухайлбал, Гадаадын иргэн харьяалалгүй хүн Монгол Улсад оршин суух, дамжин өнгөрөх, зорчих журам зөрчих /Зөрчлийн тухай хуулийн 28 дугаар зүйл, Эрүүгийн хуулийн 240 дүгээр зүйл/, Битүүмжилсэн эд зүйлийг дур мэдэн зарцуулах / Зөрчлийн тухай хуулийн 33 дугаар зүйл, Эрүүгийн хуулийн 244 дүгээр зүйл/, Албан дайчилгаанаас зайлсхийх / Зөрчлийн тухай хуулийн 45 дугаар зүйл/, Төрийн дайчилгаанаас зайлсхийх /Эрүүгийн хуулийн 239 дүгээр зүйл/ зэргийг дурдаж болно.

Иймд зөрчлийн ойлголтыг шинэчлэн томъёолж, Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиудад давхардсан байгаа гэмт хэрэг, зөрчлийн зөрчлийг нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээгээр нь ялгаж зөрчлийг бүрэлдэхүүний хувьд тодорхой зааж өгөх шаардлагатай байна.

5.Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Зөрчлийн тухай хуулиар зөрчлийн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааг нарийвчлан журамлаагүй, мөн зөрчил хүлээлгэх эрх бүхий этгээдийн ихэнх нь хуульч биш өөр мэргэжлийн субъект байдагтай холбоотойгоор зөрчлийг хянан шийдвэрлэх явцад алдаа гаргах, хүний эрх, эрх чөлөөг зөрчих явдал гардаг.

Мөн зөрчлийн эрүүгийн гэмт хэргээс ялгагдах нэг ялгаа нь зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа эрүүгийн гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанаас илүү хялбаршуулсан журамтай байдаг. Тухайлбал, Герман, Австри зэрэг орнуудад зөрчлийн зөрчлийг анхан шатны журмаар зөрчлийн байгууллага, албан тушаалтан шийдвэрлэдэг бөгөөд шүүгч зөвхөн давж заалдах журмаар зөрчлийн зөрчлийг шийдвэрлэх ажиллагаанд оролцдог. Өөрөөр хэлбэл, зөрчлийн зөрчлийг анхан шатны журмаар шийдвэрлэхэд шүүгчийг оролцуулах нь зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх боломжгүй болгодог байна.

Иймд зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааг нарийвчлан тусгаж, илүү хурдан, чирэгдэл багатай аргаар хялбаршуулан шийдвэрлэдэг болох чиглэлээр шинэчлэх шаардлага байна.

Хоёр. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Зөрчлийн тухай хуулийг шинэчлэн найруулж, бусад хуулиудад заасан зөрчлийн зөрчлийг энэ хуульд нэгтгэн төрөлжүүлж хуулийн төслийг Ерөнхий болон Тусгай ангид бүлэглэн дор дурдсан зарчмын шинжтэй өөрчлөлтийг тусган боловсруулна.

Нэг. Ерөнхий ангийн хүрээнд

1.Зөрчлийн шийтгэлийн төрлийн талаар

Зөрчлийн баривчлах шийтгэлийг шууд зөрчлийн байгууллагаас ногдуулах боломжгүй бөгөөд заавал шүүгчийг татан оролцуулж, зөрчлийн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааг хялбаршуулсан журмаар явуулах боломжгүй болдог. Иймд баривчлах шийтгэлийг зөрчлийн зөрчил гаргасан этгээдэд ногдуулах шийтгэлийн төрлөөс хасахаар тусгана.

Түүнчлэн хууль бусаар олсон орлого, эд зүйл, зөрчил гаргахад ашигласан тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, байрыг хурааж улсын орлого болгох, устгах журмыг Засгийн газар батлах эрхийг тус хуулиар олгоно. Энэ нь хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан

авахыг хориглосон Монгол Улсын Үндсэн хуулийн зарчмыг алдагдуулахгүй байх эрх зүйн үндэс болно.

## 2. Зөрчлийн шийтгэлийн хэмжээний талаар

Торгох шийтгэлийн хэмжээг өнөөгийн түвшинд нийцүүлэн шинэчлэн тогтооно.

## 3. Хариуцлага хүлээлгэх эрх бүхий этгээдийн талаар

Одоогоор зөрчил хүлээлгэх эрх бүхий 11 этгээд хууль тогтоомжоор тодорхойлогдсон байгаа бөгөөд тэдгээрийн ихэнх нь харьяалал давхардсан хэргийг шийдвэрлэдэг. Иймд уг давхардлыг аль болох багасгах, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид шүүгч, улсын байцаагчийг давхардуулан хуульчилсан байгааг цэгцлэх, шүүх эрх мэдлийн байгууллагад үүсч буй ачааллыг багасгах зорилгоор шүүгчийг зөрчил хүлээлгэх эрх бүхий этгээдээс хасахаар тусгана. Харин зөрчил хүлээлгэх эрх бүхий этгээдээс зөрчлийн шийтгэл ногдуулсан шийдвэрийг зөрчил гаргасан этгээд, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч буюу өмгөөлөгч гомдол гаргасан тохиолдолд давж заалдах журмаар шүүгч шийдвэрлэдэг байхаар тусгана.

Мөн Зөрчлийн хуульд сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргыг зөрчил хүлээлгэх эрх бүхий этгээдэд хамруулсан боловч Засаг даргын харьяалан шийдвэрлэдэг зөрчил харьцангуй цөөн, зөрчлийн хэм хэмжээ тогтоосон 177 хуулийн 10 орчим хуульд л Засаг дарга зөрчлийн шийтгэл ногдуулахаар хуульчилсан байна. Иймд улс төрийн албан тушаалтан болох сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргыг зөрчил хүлээлгэх эрх бүхий субъектээс хасна.

## 4. Зөрчил хүлээлгэх харьяаллын талаар

Зөрчлийн шийтгэлийн төрөл, хэмжээ, хариуцлага хүлээлгэх эрх бүхий этгээдийн хүрээнд өөрчлөлт орохтой холбогдуулан зөрчлийн зөрчлийг хянан шийдвэрлэх харьяаллыг дахин хянаж, тодорхой болгоно.

## 5. Зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааны талаар

Зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааг тусгайлан бүлэг болгож аль болох хүний эрх, эрх чөлөөг хангах, чирэгдэл бага үүсгэх байдлаар нарийвчлан зохицуулна.

Зөрчлийн зөрчлийг хянан шийдвэрлэх эрх бүхий этгээдүүд нь өөрсдийн эрх хэмжээ үйлчлэх хүрээ, нутаг дэвсгэрт гарсан зөрчлийг хянан шалгаж, зөрчлийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан, ялимгүйн учир хор уршигт хүрээгүй зөрчлийг сануулах арга хэмжээ аван тэмдэглэл үйлдэн хаах, зөрчил хүлээлгэх шаардлагатай зөрчилд нотлох баримтыг бүрдүүлэн эрх хэмжээний хүрээнд хамаарах бол шийтгэл хүлээлгэх, эс хамаарах бол холбогдох эрх бүхий этгээдэд шилжүүлэх арга хэмжээ авахаар тусгана.

Хоёр. Тусгай ангийн хүрээнд

### 1. Тусгай ангид заах зөрчлүүдийг бүлэглэх

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудад заагдсан зөрчлийн хэм хэмжээ тогтоосон зохицуулалтыг энэ хуулийн тусгай ангид нэгтгэн төрөлжүүлж, зөрчлүүдийг хамгаалж буй ашиг сонирхол, нийгмийн харилцааны ойролцоо төрлөөр нь бүлэглэн хувааж хууль хэрэглэгчид болон иргэдэд ойлгомжтой болгох арга хэмжээ авна.

### 2. Зөрчлийг тодорхойлсон гипотезийг дахин хянаж, шаардлагатай өөрчлөлтүүдийг тусгах

Зөрчил хүлээлгэх хууль зүйн үндэслэлийг тодорхойлсон гипотезийг дахин хянаж шаардлагатай өөрчлөлтүүдийг тусгана. Энэ нь нийгмийн амьдралд хариуцлага хүлээлгэвэл зохих зөрчлүүд гардаг ч хуульд гипотези нь тусгагдаагүйгээс шалтгаалан шийтгэл хүлээдэггүй байдлыг арилгах, өөрөөр хэлбэл хариуцлага хүлээлгэх шаардлагатай зарим үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд шинээр тооцох эрх зүйн үндэс болно.

### 3. Зөрчлийн зөрчилд торгох шийтгэлийг түлхүү хэрэглэх

Зөрчлийн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль ёсыг хангах байдлыг дээшлүүлэх үүднээс зөрчилд торгох шийтгэлийг түлхүү хэрэглэх явдлыг чухалчилна. Торгуулийн хэмжээг мөнгөн дүнгээр шууд илэрхийлэх нь цаг үеийн аясад нөлөөллийн шинж чанараа алддаг байдлыг харгалзан төрөөс шинэчлэн тогтоож байдаг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар дараахь үр дагавар гарна гэж тооцоолж байна:

1. Зөрчлийг хянан шийдвэрлэх тогтолцоо сайжирч, хүлээлгэх шийтгэлээс хамааран хэргийн харьяалал тодорхой болж улмаар хэргийг хангалттай үндэслэл, нотлох баримттайгаар шийдвэрлэх шударга тогтолцоо улам бүрдэх, шийтгэлийн үр нөлөө дээшлэх эрх зүйн үндэс бүрдэнэ.

2.Зөрчлийн бүх зөрчлийг нэг хуульд төрөлжүүлэн хуульчилснаар зөрчлийн бүрэлдэхүүнийг болон мөнгөн торгуулийн хэмжээг өөр өөр байдлаар заасан зохицуулалтууд нэг мөр болж, зөвхөн энэ хуульд заасан үйлдлүүдийг зөрчлийн зөрчил гэж үзнэ.

3.Зөрчил хүлээлгэх эрх бүхий этгээдээс хянан шийдвэрлэх зөрчлийн харъяалал тодорхой болж, шүүх эрх мэдлийн байгууллагын ачаалал багасна.

4.Мөнгөн торгуулийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан шинэчлэн тогтоосноор торгох шийтгэлийн үр нөлөө дээшилнэ.

5.Зөрчлийн зөрчил, эрүүгийн гэмт хэргийн давхардал арилна.

Уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон үнэт цаасны шаардлага хангасан торгуулийн хуудас хэвлүүлэх асуудлаар нэмэлт хөрөнгө шаардагдана. Энэ асуудлыг шийдвэрлэх, уг хуудсыг хэвлүүлэхэд шаардагдах хөрөнгийг бүрдүүлэхэд дэмжлэг болох үүднээс торгуулийн шийтгэлийн доод хязгаарыг бодит өртгийг шингээсэн үнийн дүнгээс багагүй /жишээ нь тухайн торгуулийн хуудсыг хэвлүүлэх зардлаас багагүй/ байдлаар тогтоох чиг барина.

Дөрөв. Хуулийн төсөл нь бусад хуультай хэрхэн уялдаж уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Энэхүү шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэх бөгөөд батлан гарахтай холбогдуулан зөрчил тооцохоор заасан бусад хууль тогтоомж нэг бүрт нэмэлт, өөрчлөлт оруулна.

#### IV. ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГАА

нийгмийн хөгжлийн олон үе шатуудад хууль зүйн салбар тэр дундаа хууль сахиулах үйл ажиллагаа эрх зүйн нэгдсэн зохицуулалтгүй явж ирснийг бид мэдэх билээ. Үндсэндээ эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа, эсхүл захиргааны зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа гэсэн ойлголт эрүүгийн процессын эрх зүй болон захиргааны процессын эрх зүйд хамаарч, үндсэн хуульд заасан иргэний эрхийг хамгаалах, хүний халдашгүй эрхийг хязгаарлах, үндэслэл бүхий сэжгийг шалгаж, төрийн нэрийн өмнөөс хуулийг хэлбэрэлтгүй сахин биелүүлэх ажиллагаа олон салбарын хууль тогтоомжид өөр өөрөөр тусч ирсэн.

2001 онд ХЭҮК байгуулагдаж эрүүдэн шүүлт байгаа эсэх талаар олон улсын шинжээч Манфред Новакийн хийсэн судалгаагаар эрүү шүүлтийн хэлбэрээс гадна гэм буруу нь нотлогдоогүй, хугацаагүй хоригдож байгаа олон хүн байгааг илрүүлж, гэмт хэрэг хүлээлгэх арга болсон тухай иш баримттай дурджээ. Тухайн үеийн хууль хяналтын байгууллагын зөвлөгөөн дээр энэ алдаа дутагдлын талаар хүчтэй шүүмжлэл явагдаж, урьдчилан хорих байр, хорих ангид тураалаар нас барсан хоригдлын тоо дунджаар жилдээ 120-д хүрч байсан нь бодит үнэн юм.<sup>39</sup>

Хуулийн байгууллагын шинэчлэлд ийм амь бөхтэй арга барил, газар авсан хандлага өөрчлөгдөхгүй явсаар ирсэн хожим энэ үр дагаварт хүргэжээ. Өөрөөр хэлбэл Монгол Улсад хууль сахиулах үйл ажиллагааны нэгдсэн стандарт, түүнийг тогтоосон эрх зүйн хэм хэмжээ байхгүйгээс эрүүгийн тагнуул, мөрдөн байцаах арга барилд тулгуурлаж үйл ажиллагаа явуулдаг хууль сахиулах байгууллагууд даруй 70 гаруй жил ажиллаж байна.<sup>40</sup>

Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн нэрээс аваад үзэхэд хууль сахиулагчдад ямар “стериотип” үүсгэж, хандлага төрүүлж байгаа нь тодорхой байна. Эрүүдэж, байцааж шийтгэх тухай хууль гэсэн нэртэй. Уг нь гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нь хууль сахиулах үйл ажиллагааны хуультай хослон олон оронд хэрэглэгдэж байна. Хуулийн нэр, зүйл заалт, үзэл баримтлалаас гадна тогтсон уламжлалт хандлагаас хууль сахиулах байгууллагын алба хаагчид ангижраагүй байгаа учраас хүн хэргээ хүлээсэн л бол шийдвэрлэхчигэж болно гэж үздэг үзэл байгаа талаар ярьж хэлж бичиж байгаа нь ийм түүхэн уламжлалтай юм.

Хууль сахиулах үйл ажиллагаа, гэмт хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанаас ялгаагүй учраас үндсэндээ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль болон татвар, гааль, мэргэжлийн хяналт, байгаль орчны багц хууль тогтоомжоор зохицуулж иржээ.

Одоогийн бидний мэдэх онолын ойлголтод “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа гэдэг” нь ЭБШЭЗ-н хэм хэмжээгээр зохицуулагдаж улмаар хэрэг бүртгэх мөрдөн байцаах байгууллага болон прокурор шүүхээс хэрэгжүүлдэг өөр хоорондоо уялдаа холбоо бүхий олон талт цогц үйл ажиллагаа юм.<sup>41</sup> Монгол Улсын нутаг дэвсгэр дээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь гэмт хэрэг хаана үйлддэгдсэнийг үл харгалзан бүх нөхцөлд энэ хуулийн дагуу явагдах бөгөөд Эрүүгийн Байцаан шийтгэх ажиллагааг явуулахдаа тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байгаа ЭБШХ-ийг баримтална.<sup>42</sup> Эндээс үзэхэд Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг гагцхүү ЭБШХ-иар зохицуулна. Иймд тухайн хуулийг төсөөтэй хэрэглэдэггүй Монгол Улсын Эрүүгийн хуультай адилтган үздэг.<sup>43</sup>

ЭБША-нд Үндсэн хуулийг удирдлага болгохын зэрэгцээ Эрүүгийн Хууль, Прокурорын Байгууллагын Тухай Хууль, Шүүхийн Тухай Хууль, Цагдаагийн Байгууллагын Тухай Хуулийг хэрэглэж болохоор заасан байдаг.<sup>44</sup> МУ-ын одоо хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн байцаан шийтгэх хууль нь 2002 оны 01 сарын 10-ны өдөр батлагдан гарсан бөгөөд нийт 11 хэсэг 48 бүлэг 414 зүйлтэй. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын талаар хуульд заасан асуудлыг дурьдахын өмнө түүний тухай товч ойлголтыг тодорхойлолтуудыг авч үзэх нь чухал юм. Тухайлбал, мөрдөн байцаалтын ажиллагаа нь мөрдөлт, байцаалт гэсэн бие даасан үйлдлүүдийн нийлбэр. Хэрэгт ач холбогдол бүхий баримт, сэлт мэдээллийг цуглуулахын тул хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас явуулж буй эрүүгийн байцаан шийтгэх тодорхой ажиллагаа.

Энэ нь үзлэг, нэгжлэг хийх, хураан авах, туршилт явуулах, шинжилгээ хийх гэх зэргээс гадна сэжигтэн, яллагдагч, гэрч, хохирогч болон бусад оролцогчдын мэдүүлгээс бүрдэнэ.

Мөрдөн байцаалтын ажиллагаа нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт гэсэн үндсэн хоёр хэлбэртэй. Хэргийн газарт үзлэг хийхээс бусад эрүүгийн байцаан шийтгэх тодорхой ажиллагаануудыг зөвхөн эрүүгийн хэрэг үүсгэсний дараа явуулна. Байцаалт явуулах эрх бүхий этгээдүүдийг ЭБШХ-д тов тодорхой заасан. Түүнчлэн байцаалт явуулах журам ч чанд хуульчлагдсан байдаг. Байцаалтын үр дүн нь мэдүүлгээр хэлбэршдэг.

ЭБШХ-аар тогтоосон журмын дагуу гэмт явдал, түүний нөхцөл байдал, оролцогчдын тухай болон эрүүгийн хэрэгт ач холбогдол бүхий бусад асуудлыг тодруулах зорилгоор байцаагчдаас мэдээ, мэдээлэл олж авах, бэхжүүлэхэд чиглэсэн эрүүгийн байцаан шийтгэх тодорхой ажиллагааг байцаах гэнэ.

- Мөрдөн мөшгих гэдэг нь мөрдөн байцаалтыг хариуцан явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас сэжигтэн, яллагдагчийг гэмт хэрэг өдүүлсэн гэм буруутай болохыг илчлэн илрүүлж байгаа ажиллагаа юм.
- Байцаалтыг амжилттай явуулахын тулд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч ямар арга барил, хэрэгслээр ямар мэдээлэл олж авах гэж байгаагаа сайн ойлгосон байх хэрэгтэй. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн тодруулах гэж буй тэрхүү цогц асуудлыг байцаалтын зүйл гэнэ.

**Хэрэг бүртгэлт** /анг-inquest, inquiry/. МУ-ын мөрдөн байцаалтын нэг хэлбэр бөгөөд МУ-ын Эрүүгийн Байцаан Шийтгэх хуульд заасны дагуу /28-р зүйлд заасан/ хөнгөн, хүндэвтэр хэрэгт явуулна. Түүнчлэн захиргааны зөрчилд хэрэг бүртгэлтийн ажиллагаа бас хийдэг.

Манай улсын хувьд 14, 30 хоногт явуулах онцлогтой мөрдөн байцаалтын бие даасан ажиллагаа юм.<sup>45</sup> Өмнөх ЭБШХ-ийн ойлголтоор хэрэг бүртгэлийн ажиллагаа гэж Хэрэг бүртгэх Байгууллагаас байж болзошгүй гэмт этгээдийг олж тогтоох, гэмт хэргийн ул мөрийг хамгаалах, бэхжүүлэх зорилгоор явуулах мөрдөн байцаалтын ажиллагаа гэж тодорхойлж байсан байна. Шинэ ЭБШХ-ийн үзэл баримтлалын дагуу хэрэг бүртгэлт гэдэг нь хэрэг бүртгэгчээр хөнгөн хүндэвтэр хэрэгт үйлдсэн нь хангалттай нотлогдлож байвал түүнийг яллагдагчаар татаж ял сонсгон байцаах ажиллагаа юм. Хэрэг бүртгэлтийг зөвхөн хэрэг бүртгэгч явуулах ба уг эрхийг Хилийн Цэргийн алба ба Цагдаагийн Байгууллагаас олгоно.<sup>46</sup>

**Мөрдөн байцаалт** /анг-investigation/. Хэрэгт ач холбогдол бүхий баримт сэлт, мэдээллийг цуглуулахын тулд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас явуулж буй эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа юм. Энэ нь үзлэг нэгжлэг, туршилт, таньж олуулах ажиллагаа, эд хөрөнгө хураах, битүүмжлэх, шинжилгээ хийлгэхээс гадна гэр хохирогч сэжигтэн, яллагдагчийг байцаах мэдүүлэг авахаас бүрдэнэ.

Мөрдөн байцаалтын ажиллагаа нь хэрэг бүртгэлт мөрддөн байцаалт гэсэн хэлбэртэй ба хэргийн газрын үзлэг хийхээс бусдыг зөвхөн эрүүгийн хэрэг үүсгэсний дараа явуулна. Мөрдөн байцаалтын ажиллагааг ЭБШХ-д заасны дагуу чанд баримтлан явуулна гэж үзсэн<sup>47</sup> байхад “Мөрдөн байцаалт гэдэг нь мөрдөн байцаагчаас хүнд онц хүнд гэмт хэргийн эрүүгийн байцаан шийтгэх тодорхой ажиллагааг явуулж улмаар тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож байвал түүнийг яллагдагчаар татах, ял сонсгох ажиллагаа юм.

а/ Хэрэв нэг буюу хэсэг бүлэг этгээд хэд хэдэн газар гэмт хэрэг үйлдсэн байвал хамгийн сүүлд хэрэг гарсан газар

б/ Гэмт хэрэг хэд хэдэн газар орон нутагт гарсан бол хэргийг Мөрдөн Байцаах Газрын тухайн асуудал эрхэлсэн хэлтэс мөрдөн байцаалт явуулна.

в/ нэг буюу хэд хэдэн бүлэг этгээд хөнгөн буюу хүнд гэмт хэрэг үйлдсэн байвал үүнийг хүндэд багтаан мөрдөн байцаалт явуулна гэжээ.<sup>48</sup>

#### **4.1. Мөрдөн байцаах албаны талаар**

##### Мөрдөн байцаах албаны чиг үүрэг

Мөрдөн байцаах байгууллагын бүх үйл ажиллагаа шинжлэх ухааны үндэстэй, хууль ёсыг хэлбэрэлтгүй сахих үндсэн дээр явагдана. Мөрдөн байцаалтын арга тактикийг улам

боловсронгуй болгож мөрдөн байцаалтын ажиллагааг хуулийн дагуу түргэн шуурхай, чанартай явуулж, гэмт хэрэг бүрийг бүрэн дүүрэн илрүүлж, гархад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг судлан тогтоох, арилгах арга хэмжээ авахад мөрдөн байцаах байгууллага ажлаа бүрэн чиглүүлэх үүрэгтэй. Мөрдөн байцаах үйл ажиллагаа нь гадны нөлөөнд үл автагдах, шудрага ёсыг дээдэлж, хуульд шуурхай ажиллагааг хэвшүүлэх зарчимд үндэслэгдэнэ.

Мөрдөн байцаах байгууллагын үйл ажиллагаа нь тус улсын шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх хүрээнд явагдана. Мөрдөн байцаах байгууллага дараах эрх үүрэгтэй.

1. ЭБШ хуулиар харъяалуулсан эрүүгийн бүх гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулах
2. Мөрдөн байцаах ажиллагаанд хуулийн заалтыг хангуулах
3. Мөрдөн байцаах ажиллагааны үр дүнг үндэслэн прокурорт шилжүүлэх
4. Хуульд заасан үндэслэл журмын дагуу хэрэгсэхгүй болгох
5. Мөрдөн байцаагчийн үйл ажиллагаа шийдвэрийн талаарх байгууллага аж ахуйн нэгж, иргэдээс ирсэн гомдлыг хянан шийдвэрлэх
6. Хуулийг биелүүлэх, гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар эрх бүхий албан тушаалтанд санал тавих буюу гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгахыг шаардаж
7. Төр, засаг олон нийтийн болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй харилцан холбоотой ажиллах, тэдний хүч туслалцаанд түшиглэх
8. Гэмт хэрэг түүнийг үйлдсэн этгээдийг илрүүлэхэд хэрэг бүртгэх эрэн сурвалжлах байгууллагатай нягт хамтран ажиллах
9. Гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг эрэн сурвалжлах талаар гүйцэтгэх байгууллагад тодорхой асуудлаар хандаж тэдний туслалцааг авах
10. Шаардлагатай тохиолдолд иргэний үнэмлэх, бусад баримт бичгийг шалгах, хүний бие эд зүйлд үзлэг хийх, албан байгууллага болон иргэний орон сууцанд нэвтрэн орох, мөрдөн байцаалтанд ач холбондол бүхий ямар ч материалыг холбогдох байгууллага, хүмүүсээс үнэ төлбөргүй шаардан авах
11. Хуульд тусгайлан тогтоосон журам нөхцлийн дагуу чухал гэж үзсэн газар, байр, бусад зүйлд үзлэг, нэгжлэг, хийх, нотлох баримт, гэмт хэргийн багаж эд юмыг хураан авах, байцаалт явуулах, шинжээч томилох, туршилт хийх, мөрдөн байцаах ажилд иргэн, байгууллага, олон нийтийн төлөөлөгчийг оролцуулах, албадан саатуулах цагдан хорихоос бусад таслан сэргийлэх арга хэмжээний төрлийг хэрэглэх
12. Мөрдөн байцаах байгууллагын ажилтан хуульд заасан журмын дагуу галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх зэрэг болно.

Мөрдөн байцаах байгууллагын ажилтан албан хэрэг гүйцэтгэх үедээ Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 26-р зүйлд заасан эрхийг нэгэн адил эдлэх зэрэг болно. Мөрдөн байцаагч нь ЭБШ хуулийн 28-р зүйлийн 2-т заасан эрх эдлэж үүрэг хүлээнэ. Хэрэг бүртгэгч мөрдөн байцаагчаас тодорхой хэргийг шалгах явцад ЭБШ хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд гаргасан тогтоолыг аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан заавал биелүүлнэ.

#### Орчин үеийн Мөрдөх алба /2002 оноос 2012 он хүртэл/

Монгол Улсын эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан Мөрдөн байцаах алба нь онц хүнд, хүнд гэмт хэрэг болон тусгайлан харъяалуулсан хүндэвтэр хэрэгт мөрдөн байцаалт явуулахаар болж, ЦЕГ-ын даргын 2002 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 297 тоот тушаалаар тус газрын орон тоо зохион байгуулалтыг өөрчлөн баталжээ.

Уг тушаалаар Улсын ерөнхий прокурорын дэргэд мөрдөн байцаах алба байгуулах болсонтой холбогдуулан Мөрдөн байцаах газрын харъяанд ажиллаж байсан шүүх, прокурор, цагдаагийн ажилтнуудаас үйлдсэн гэмт хэргийг мөрдөж байсан хэлтсийг орон тоо төсвийн хамт Улсын ерөнхий прокурорын мэдэлд, дүүргүүдийн Мөрдөн байцаах тасгуудыг Нийслэлийн цагдаагийн газрын мэдэлд орон тоо төсвийн хамт шилжүүлэн УМБГ-ын бүтцийг дараах байдлаар тогтоосон байна.

Улсын мөрдөн байцаах газар нь Удирдлага зохион байгуулалт хяналт шалгалтын хэлтэс, Зохион байгуулалттай хэрэг мөрдөх хэлтэс, Хэрэг илрүүлэх эрэн сурвалжлах хэлтэс, Авлигал, эдийн засгийн гэмт хэрэг мөрдөх хэлтэс, Онц хүнд гэмт хэрэг мөрдөх хэлтэс гэсэн зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж, орон нутаг болон дүүргүүдийн цагдаагийн газар, хэлтсүүдийн мөрдөн байцаах тасаг нь тухайн цагдаагийн газар, хэлтсийн бүтцэд шилжин,



Мөрдөн байцаах газар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу мэргэжлийн удирдлагаар ханган ажиллах чиг үүрэгтэй болсон байна.

Монгол Улсын Засгийн газрын 1992 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 101 тоот тогтоолоор батлагдсан ЦЕГ-ын Улсын мөрдөн байцаах газрын бүтэц, орон тоонд 1995 он болон 2002 онуудад хууль эрх зүйн шинэчлэл, нийгмийн тогтолцооноос хамааралтай өөрчлөлтүүд орж байсан тул ЦЕГ-ын даргын 2003 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 115 тоот тушаалаар УМБГ-ын бүтэц, орон тоог дараах байдлаар тогтоожээ.<sup>49</sup>

УМБГ-ын даргын 2003 оны 03 тоот тушаалаар Мөрдөн байцаах албаны алба хаагчдын "ажлын байрны тодорхойлолт"-ыг, 2003 оны 63 тоот тушаалаар "ЭБША-нд прокурор, мөрдөн байцаах албаны дарга нарын гаргаж буй шийдвэрийг зөвхөн бичгийн хэлбэрээр хүлээн авч хэргийн материалд хийж байх журам"-ыг, 2003 оны 18 тоот тушаалаар "Мөрдөн байцаах хэлтэс, тасгийн дарга, нэгжийн ажил дүгнэх аргачлал"-ыг шинэчлэн баталсан зэрэг олон зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүрч ажилласан байна.

Мөрдөн байцаах газар 2003 онд явагдсан ЦЕГ-ын даргын нэрэмжит шалгалтад амжилттай бэлтгэн байгууллагаараа 4.85 үнэлгээтэй / хангалттай/ дүгнэгджээ.

УИХ-аас батлан гаргасан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЦЕГ-ын даргын 2005 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 21 тоот тушаалаар албан тушаал, зохион байгуулалттай гэмт хэрэг мөрдөх хэлтсийг шинээр байгуулж, мөрдөх болсон бөгөөд тус хэлтэс нь авлигал, эдийн засгийн гэмт хэргүүдийн судалгааг төв орон нутгуудаас гаргуулан, дүгнэлт хийн ажиллаж, энэ төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлт, үр дүнгийн талаар Прокурорын байгууллагатай хамтарсан зөвлөгөөн хийж, шийдвэрлэлтийг дээшлүүлэх арга хэмжээ авсан байна.

Тус хэлтэс нь 2005 онд авлигал, албан тушаал, аж ахуйн 85 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 53 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр, 22 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар прокурорт шилжүүлж, эдгээрхэргүүдээсүлсын төсөвт 1500.0 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 900.0 сая төгрөгийн хөрөнгийг битүүмжлэн хамгаалах ажиллагаа хийсэн байна.

2004-2006 онуудад "Хадгаламж зээлийн хоршоо"-ны нэрээр иргэдээс онц их хэмжээний мөнгөн хадгаламжийг үндэслэлгүй өндөр хүү амлан залилан мэхлэх замаар авч ашиглах гэмт хэргүүд олноор үйлдэгдсэн тул тухайн үеийн шаардлагаар ЦЕГ-ын даргын 2006 оны 265 тоот тушаалаар УМБГ-ын бүтэц, орон тоог шинэчлэн баталж, "Хадгаламж зээлийн хоршоо"-дын хэргийг шалгах Эдийн засгийн гэмт хэрэг мөрдөх хэлтсийг 50 алба хаагчийн орон тоотойгоор байгуулж, УМБГ нь Тамгын хэлтэс, Үнэлгээ, хяналт шалгалтын хэлтэс, Онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэрэг мөрдөх хэлтэс, Эрэн сурвалжлах, хулгайн гэмт хэрэг мөрдөх хэлтэс, Хүнд гэмт хэрэг мөрдөх хэлтэс, Албан тушаалын гэмт хэрэг мөрдөх хэлтэс, Зам тээврийн гэмт хэрэг мөрдөх хэлтэс, Эдийн засгийн гэмт хэрэг мөрдөх хэлтэс гэсэн бүтэцтэйгээр ажиллах болов.

2005 онд нэг мөрдөн байцаагч дунджаар 45.4 хэрэг мөрдөн шалгаж, 37.5 хэрэгшийдвэрлэсэнээс 16.7 хэргийгяллахдүгнэлтүйлдүүлэхсаналтай прокурорт хүргүүлсэн байна.<sup>50</sup>

2007 оны 9 дүгээр сард эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт орж, "хүндэвтэр" гэмт хэргийн харъяаллыг тогтоосноор хэрэг бүртгэх албанаас мөн ангилалд хамаарах хэргүүд шилжин ирж нийт хэргийн тоо өсснөөс гадна, шийдвэрлэсэн хэргийн тоо өмнөх жилүүдийнхтэй харьцуулахад буурсан байна. 2008 онд мөрдөн байцаах албаны хэмжээнд нийт 25503 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, мөрдсөн хэргийн 75,7 хувийг шийдвэрлэсэн нь урьд оныхтой харьцуулахад 11,1 хувиар буурсан байв.

Энэ үед хулгайлах гэмт хэргийн 95% нь хүндэвтэр гэмт хэргийн ангилалд хамрагдаж байсан тул хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, халуун мөрөөр нь шуурхай илрүүлэхзорилгоор нийслэлийн цагдаагийн мөрдөн байцаах тасгуудын дэргэд "хулгайн гэмт хэрэг мөрдөх хэсэг" байгуулан ажиллуулжээ.

ЦЕГ-аас Мөрдөн байцаах албаны төв, орон нутагт ажиллаж байгаа мөрдөн байцаагч нарын ажлын ачаалал, орон тооны нөхөн хангалтын талаар 2008 оны эхний улирлын байдлаар судалгаа хийж, хөдөө орон нутагт орон тоо дутуу байгаатай холбогдуулан нөхөн хангалт хийхээр үүрэг өгчээ. Энэхүү үүрэгтэй холбогдуулан "Мөрдөн байцаагч"-ийн сонгон

шалгаруулалтыг нээлттэй зарлаж нийт 160 эрх зүйн дээд<sup>51</sup> боловсролтой иргэдийг бүртгэн, боловсон хүчний зааварт заагдсан шалгуур үзүүлэлтүүдээр 22 иргэнийг сонгон шалгаруулж Цагдаагийн академитай хамтран 45 хоногийн цагдаагийн анхан шатны дамжаа, 45 хоногийн мөрдөн байцаагчийн сургалтад тус тус хамруулан амжилттай төгссөн 21 алба хаагчийг орон тооны дутагдалтай байгаа орон нутгийн нэгжүүдэд мөрдөн байцаагч-дадлагажих ажилтнаар 6 сарын хугацаатай томилжээ.

2008 онд нийт 355 мөрдөн байцаагч ажилласан ба нэг мөрдөн байцаагч дунджаар 69 хэрэг мөрдөж, 49 хэрэг шийдвэрлэсэн байна.<sup>52</sup>

2009 онд Мөрдөн байцаах газрын бүтцэд өөрчлөлт орж УМБГ-ын харъяа байсан Зам тээврийн гэмт хэрэг мөрдөх хэлтэс нь Замын цагдаагийн газрын Эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах хэлтэс болж өөрчлөгдөж, УМБГ нь Тамгын хэлтэс, Үнэлгээ, хяналт шалгалтын хэлтэс, Онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэрэг мөрдөх хэлтэс, Эрэн сурвалжлах, хулгайн гэмт хэрэг мөрдөх хэлтэс, Хүнд гэмт хэрэг мөрдөх хэлтэс, Эдийн засгийн гэмт хэрэг мөрдөх хэлтэс гэсэн бүтэцтэйгээр ажиллаж байжээ.

2010 оны байдлаар нэг мөрдөн байцаагч 60.5 өргөдөл гомдол шалгаж шийдвэрлэн, 42.3 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 16.3 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлж, 33.4 хэрэг шийдвэрлэж, ажиллагааны явцад 6.6 хэрэг илрүүлж, эзэнгүй түдгэлзүүлсэн хэргээс 5.6 хэргийг нөхөн илрүүлсэн улсын дундаж үзүүлэлттэй байна. Мөрдөн байцаах албанаас дэвшүүлсэн хүрэх түвшингийн шалгуур үзүүлэлтийг мөрдөн байцаах 42 нэгжээс 10 нэгж 100 хувь ханган биелүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 3 нэгжээр буюу 7.2 хувиар өссөн байна.<sup>53</sup>

#### **4.2. Хэрэг бүртгэх албаны талаар**

Засгийн газрын 2002 оны 189 дүгээр тогтоолыг үндэслэн ЦЕГ-ын даргын 2002 оны 361 дүгээр тушаалаар **Хэрэг бүртгэх газрыг** Тамга, Татвар, Гааль, Цэрэг, Байгаль орчин Галын хэрэг бүртгэх хэлтэс, тасагтай байхаар бүтэц, орон тоог шинэчлэн баталж, мөн даргын 2002 оны 417 дугаар тушаалаар аймаг, дүүргийн цагдаагийн газар, хэлтсийн хэрэг бүртгэх хэсгийг тасаг болгон өөрчлөн зохион байгуулсан байна.

Засгийн газрын 2003 оны 11 дүгээр тогтоолыг үндэслэн Төрийн өмчийн хорооны даргын 2003 оны 77 дугаар тушаалаар Төрийн өмчийн зарим байрыг мөн оны 04 дүгээр сарын 20-ны дотор багтаан холбогдох хууль журмын дагуу хүлээлцэх ажлыг зохион байгуулах, барилга, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, инженерийн шугам сүлжээний хэвийн ажиллагааг барилга хүлээлцэх баримт бичигт тусгах, төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн хөдөлгөөнийг зохих журмын дагуу гүйцэтгэхийг Төрийн өмчийн байрны ашиглалт, зохицуулалтын албаны даргад хариуцуулан шийдвэрлэжээ.

ЦЕГ-ын Хэрэг бүртгэх алба байгуулагдсан нь цаг үеэ олсон чухал арга хэмжээ байлаа, Энэ албыг байгуулсны ач холбогдол нь:

1. Зэвсэгт хүчний жанжин штабаас 25, Хил хамгаалах ерөнхий газраас 5, Гал түймэртэй тэмцэх газраас 26, Гаалийн ерөнхий газраас 14, Татварын ерөнхий газраас 13 хэрэг бүртгэгчийн 83 орон тоог цалингийн сан, ашиглаж буй авто машин, техник хэрэгслийн хамт Цагдаагийн байгууллагад нэгтгэн төвлөрүүлснээр улсын хэмжээнд зөвхөн цагдаагийн байгууллага хэрэг бүртгэх ажиллагааг дагнан явуулж тэднийг нэгдсэн удирдлагаар хангах боломж бүрдсэн.

2. Хэрэг бүртгэлтийн ажиллагааг 6 /ЦЕГ, ЗХЖШ, ХХЕГ, ГТТГ, ГЕГ, ТЕГ/газар явуулж тус тусдаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гомдол мэдээлэл хүлээн авч шалгахдаа иргэдийг хууль зүйн үндэслэл муутай асуудлаар хорьж, саатуулж тэдэнд ихээхэн хүндрэл учруулдаг явдал таслан зогсоогдож, эмх журамтай болсноор хүний эрх, эрх чөлөөг хангах чухал алхам болов.

3. Аймаг сумын нутагт ихэвчлэн үйлдэгддэг, хүндэвтэр ангилалд хамаарах танхайрах, хүндрүүлэх нөхцөл байдалтай хулгайлах, ялангуяа малын хулгайн гэмт хэргийг хэсгийн төлөөлөгч шалгах эрх зүйн боломж нээгдсэн үр дүнтэй ажил болсон.<sup>54</sup> ЦЕГ-ын даргын 2010 оны 108 дугаар тушаалаар Хэрэг бүртгэх газрын бүтэц, зохион байгуулалтанд өөрчлөлт оруулж

Хэрэг бүртгэх хэлтэс болгон үйл ажиллагааг нь хяналт шалгалтын чиг үүрэгтэйгээр ажиллуулжээ.

Үндсэн хуулийн 56 зүйлд “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж...” гэж заасны дагуу Хэрэг бүртгэх алба Монгол Улсын цагдаагийн байгууллагын бүтцэд байгуулагдан, үйл ажиллагаа явуулснаас хойш даруй 10 жилийн нүүр үзжээ.

УИХ-аас 2002 онд баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах Ерөнхий газар, Гал түймэртэй тэмцэх газар, Гаалийн Ерөнхий газар, Татварын Ерөнхий газрын хэрэг бүртгэх албадыг нэгтгэн зохион байгуулж хэрэг бүртгэх газрыг байгуулсан юм. Үүнээс өмнө буюу 1946 оноос эхтэй хэрэг бүртгэх алба нь дээр дурдсан байгууллагын харъяанд, хуульд тусгайлан заасан гэмт хэрэгт хэрэг бүртгэлийн үйл ажиллагаа явуулж, улмаар мөрдөн байцаах албанд шилжүүлж шийдвэрлэж байв.

2002 онд хэрэг бүртгэх албадыг цагдаагийн байгууллагад татан төвлөрүүлж, хуульд заасан хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэгт хэрэгт хэрэг бүртгэлт явуулах харъяаллыг тусгаснаар 2002-2003 онд галын хэрэг бүртгэгч, татварын хэрэг бүртгэгч, цэргийн хэрэг бүртгэгч, гаалийн хэрэг бүртгэгч гэсэн албан тушаал эрхэлж байсан алба хаагчдын нийт 83 хүний орон тоог, техник, хэрэгслийн хамт цагдаагийн байгууллагад шилжүүлж, Хэрэг бүртгэх алба, орон нутагт хэрэг бүртгэх тасаг байгуулах нүсэр ажил явагдсан.

ЭБШХ–д заасан заалтыг хангах зайлшгүй шаардлага нь хэрэг бүртгэх албыг тусгайлан байгуулах явдал байсан гэдгийг хуулийн байгууллагын удирдах албан тушаалтнуудаас өгүүлдэг.

2002 оноос хойш ЭБШХ–д олон удаа нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотойгоор, ялангуяа хэргийн харъяаллыг өөрчилж, зөвхөн хөнгөн хэрэг хэрэг шалгах болсон зэргээр энэ албаны бүтэц, зохион байгуулалт олон удаа өөрчлөгдөж байв.

1. Гэмт хэргийн ангилал: 2003 оноос хойш Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлд зааснаар хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэсэн ангиллаар статистикийн мэдээллийг гаргасан бөгөөд энэ хугацаанд үйлдэгдсэн гэмт хэргийн 34.9 хувийг хөнгөн, 49.2 хувийг хүндэвтэр, 13.7 хувийг хүнд, 2.1 хувийг онц хүнд гэмт хэрэг тус тус эзэлж байна. Энэ нь Хэрэг бүртгэх албаны харъяалан шалгах хэрэг нийт гэмт хэргийн 84 хувийг эзэлж байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл байнга гардаг нийтлэг гэмт хэргийн дийлэнх хувийг хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг эзэлж, ажлын ачааллыг нэмэгдүүлж байгаагаас шалтгаалан хэрэг бүртгэлтэд байсан хүндэвтэр гэмт хэргийг шалгах чиглэлийг Мөрдөн байцаах албанд шилжүүлсэн байна.

Эрүүгийн хуульд хэрэглэсэн гэмт хэргийн ангилал практикт ямар байдлаар илэрч байгааг шүүхийн доорхи статистик мэдээнээс харж болно. Хүндэвтэр гэмт хэргийн төрөлд хамаарах гэмт хэрэг шүүхээр таслан шийдвэрлэгдсэн нийт хэргийн 50-62 хувийг эзэлж байгаа бөгөөд хөнгөн гэмт хэргээс даруй 3 дахин их хэмжээтэй байна.

| Шүүхээр таслан шийдвэрлэгдсэн хэрэгийн тооноос | 2002  | 2003  | 2004  | 2005  | 2006  | 2007  | 2008  | 2009  |
|--|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|
| Онц хүнд                                       | 5,0%  | 5,0%  | 7,5%  | 8,4%  | 9,4%  | 8,4%  | 6,6%  | 6,2%  |
| Хүнд   | 15,9% | 15,8% | 17,0% | 16,6% | 23,2% | 22,5% | 19,7% | 20,3% |
| Хүндэвтэр                                      | 64,0% | 64,0% | 62,4% | 56,4% | 50,0% | 52,2% | 58,5% | 58,3% |
| Хөнгөн   | 15,1% | 15,2% | 13,1% | 18,6% | 17,4% | 16,9% | 15,2% | 15,2% |

Ийнхүү Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн ангилалт, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан хэрэг шалгах харъяалал нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны хооронд хэргээ шидэлцэх, хугацаа алдах улмаар гэмт хэргийн илрүүлэлтэд сөргөөр нөлөөлж ирснийг тэмдэглүүштэй юм. 2002 оноос мөрдөн байцаах, алба, хэрэг бүртгэх албаны хооронд эрүүгийн 10 мянга орчим хавтас хэрэг 3-4 удаа шилжсэн байдаг.

#### 4.3. Гүйцэтгэх ажлын талаар:

Гүйцэтгэх ажлын тухай хууль нь 1997 онд батлагдан гарч хэрэгжиж эхэлсэнээс хойш даруй 16 жил өнгөрч, цаашид явагдаж эрх зүйн шинэтгэлийн хүрээнд бусад хууль тогтоомжтой уялдуулах, агуулга зарчмын хувьд зайлшгүй өөрчлөх хэрэгтэй талаар эрдэмтэн, судлаачдаас санал дэвшүүлж, үзэл бодлоо илэрхийлсээр байна.

##### Гүйцэтгэх ажил гэсэн нэр томъёоны тухайд:

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 2 дугаар зүйлд “Үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас ердийн ба тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглан явуулж байгаа мэдээ, мэдээлэл, баримт бичиг, нотолгоо эрж олох, цуглуулах, шалгах, шалгах үйл ажиллагааг **гүйцэтгэх ажил** гэнэ.

Мөн хуулийн 6.2-д “**эрэн сурвалжлах ажил**” гэж тагнуулын байгууллага, цагдаа, хорих ял эдлүүлэх байгууллагад Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад хууль тогтоомжоор харьяалуулсан эрүүгийн хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох чиглэлээр хийх нууц ажиллагааг хэлнэ.

Мөн хуулийн 9.1-д “ Дараах байгууллагууд дор дурдсан зорилгоор **гүйцэтгэх ажил явуулах** эрхтэй” гээд тагнуулын байгууллага, цэргийн тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр биелүүлэх газрын гүйцэтгэх алба гэж дурьдсан.

Тагнуулын байгууллагын тухай хуулийн 4.1-д “Тагнуулын байгууллага гэж Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг **тагнуулын арга, замаар** хангах зорилго бүхий байгууллагуудын тогтолцоог хэлнэ.”

Тагнуулын байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-т “Монгол Улсын тагнуулын байгууллагын тогтолцоо нь Тагнуулын ерөнхий газар, цэргийн тагнуулын байгууллага, хилийн тагнуулын алба, тэдгээрийн салбар, нэгжээс бүрдэнэ.” хэмээн заасан хоорондоо агуулгын зөрүүтэй байна.

Хуулиудын дээрх заалтуудаас үзэхэд давхардсан нэг нь нөгөөгөө үгүйсгэсэн санаа гарч ирж байна. Өөрөөр хэлбэл уг чанартаа нэг л ажлыг хэлээд байгаа мөртлөө ямар түвшинд очихоороо “гүйцэтгэх ажил”, ямар утгаар хэрэглэгдэхээрээ “эрэн сурвалжлах ажил”, юунд хүрэхээрээ “тагнуулын ажил” болдгийг ойлгоход бэрх болсон байна. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн нэр томъёог оновчтой болгох бодит хэрэгцээ байсаар байна /Гүйцэтгэх ажил гэдгийг нууц ажил, тагнуулын ажил, халхавчтай ажил, халхавчтай ажиллагаа гэдэг/

Цагдаагийн байгууллагын бүх алба, тухайлбал хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, замын цагдаа, хэв журмын албад нь гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг эрэн сурвалжилж, олж тогтоох үүрэгтэй байдаг. Гүйцэтгэх ажлын тухай хуульд эрэн сурвалжлах ажлыг тодорхойлсноор бол тэдгээр нь бүгдээрээ нууц ажиллагаа буюу гүйцэтгэх ажил явуулах ёстой болж байна. Эрэн сурвалжлах ажил нь нууц ажиллагаа биш юм. Эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйлийн талаарх мэдээлэл хэдий чинээ их түгээсэн байна төдий чинээ уг ажил шуурхай явагдаж байна.

#### 4.4. Шүүхийн шинжилгээний албаны талаар:

УИХ-ын 2009 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаар "Шүүхийн Шинжилгээний тухай" хуулийг баталж, 2010 оны 1 дүгээр сарын 22-ны өдрөөс мөрдөж байна.

Энэ хуулиар шүүхийн шинжилгээний зарчим, шинжилгээ хийх үндэслэл, нийтлэг журам, шинжээчийн эрх үүрэг, зарим төрлийн шинжилгээ хийх онцлог, байгууллагын тогтолцоо, алба хаагчдын эрх зүйн байдлыг нарийвчлан тогтоож, тус байгууллагын бие даасан хараат бус байдлыг хуульчилан тогтоосон чухал ач холбогдолтой арга хэмжээ болсоноос гадна байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох үндэс суурь боллоо.

Шүүхийн шинжилгээний тухай хууль батлагдсантай уялдан хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулдаг Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Захиргаа, Иргэний хэргийг шүүхэд хянан хэлэлцэх тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай зэрэг хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулсан юм.

Шүүхийн шинжилгээний байгууллагын үндсэн чиг үүргийн үйл ажиллагааны 2007-2011 оны статистикийн мэдээллээс үзэхэд криминалистикийн чиглэлээр, Шүүх эмнэлэгийн чиглэлээр, эдийн засгийн чиглэлээр шинжилгээнүүдийг хийжээ.

Криминалистикийн чиглэлээр 2011 онд 13548 шинжилгээ хийсэн нь 2007 оныхоос 88.0 хувиар өссөн, түүнчлэн шинжилгээний 35.5 хувийг гарын мөрний, 20.2 хувийг биологийн шинжилгээний эзэлж байна. Жилд дунджаар 9153 шинжилгээ хийдэг байна.

| Үзүүлэлт                               | 2007        | 2008        | 2009        | 2010        | 2011         | Бүгд  | Дундаж | Эзлэх хувь |
|--|-------------|-------------|-------------|-------------|--------------|-------|--------|------------|
| <b>Криминалистикийн шинжилгээ-нийт</b> | <b>7206</b> | <b>8333</b> | <b>7889</b> | <b>8790</b> | <b>13548</b> | 45766 | 9153   |            |
| Гарын мөр                              | 3417        | 1913        | 3384        | 3684        | 3829         | 16227 | 3245   | 35,5       |
| Биологи                                | 1038        | 873         | 1235        | 1672        | 4438         | 9256  | 1851   | 20,2       |
| Хими                                   | 655         | 913         | 687         | 840         | 2809         | 5904  | 1181   | 12,9       |
| Мөр судлал                             | 643         | 1541        | 627         | 714         | 789          | 4314  | 863    | 9,4        |
| Бичиг судлал, гарын үсэг               | 730         | 914         | 700         | 850         | 770          | 3964  | 793    | 8,7        |
| Бичиг техник                           | 317         | 773         | 484         | 558         | 296          | 2428  | 486    | 5,3        |
| Галт зэвсэг                            | 188         | 205         | 424         | 161         | 268          | 1246  | 249    | 2,7        |
| Физик                                  | 153         | 173         | 206         | 149         | 194          | 875   | 175    | 1,9        |
| Дүр зураг                              | 65          | 121         | 142         | 162         | 155          | 645   | 129    | 1,4        |

Шүүх эмнэлэгийн чиглэлээр жилд дунджаар 10919 шинжилгээ хийсэн бөгөөд үүний 52.9 хувь нь биологийн шинжилгээний эзэлж байна. Харин амьд хүнд гэмтлийн зэрэг тогтоолгох үзлэг 2011 онд 23183, хавтаст хэргийн материалыг магадлан шинжлэх шинжилгээ 1073, нас барагчийн цогцсыг магадлах шинжлэх шинжилгээ 3767 хийсэн ба эдгээр шинжилгээнүүдийн тоо 2007 оноос эрс нэмэгджээ.

| Үзүүлэлт   | 2007         | 2008         | 2009         | 2010         | 2011         | Бүгд  | Дундаж | Эзлэх хувь |
|--|--------------|--------------|--------------|--------------|--------------|-------|--------|------------|
| <b>Шүүх эмнэлэгийн шинжилгээ-нийт</b>              | <b>11091</b> | <b>10256</b> | <b>11072</b> | <b>14108</b> | <b>8066</b>  | 54593 | 10919  |            |
| Хими   | 2519         | 2194         | 2989         | 3648         | 2203         | 13553 | 2711   | 24,8       |
| Биологи  | 6788         | 6697         | 5809         | 7757         | 1841         | 28892 | 5778   | 52,9       |
| Гистологи  | 1784         | 1365         | 2274         | 2703         | 4022         | 12148 | 2430   | 22,3       |
| <b>Амьд хүнд гэмтлийн зэрэг тогтоох үзлэг</b>      | <b>12735</b> | <b>13475</b> | <b>20746</b> | <b>20835</b> | <b>23183</b> | 90974 | 18195  |            |
| <b>Хавтаст хэргийн материалыг магадлан шинжлэх</b> | <b>612</b>   | <b>604</b>   | <b>953</b>   | <b>944</b>   | <b>1073</b>  | 4186  | 837    |            |

|   |      |      |      |      |      |       |      |
|---|------|------|------|------|------|-------|------|
| <b>Нас барагчийн цогцсыг магадлан шинжлэх</b> | 1964 | 1443 | 2811 | 3479 | 3767 | 13464 | 2693 |
|---|------|------|------|------|------|-------|------|

Эдийн засгийн чиглэлээр 2007-2001 онд 626 хэргийн холбогдогчтой 596 зөрчил, дутагдлын шалтгааныг тогтоохоор шинжилгээ хийжээ. Жилд дунджаар 125 холбогдогчтой 119 зөрчил, дутагдлын шалтгааныг тогтоох шинжилгээ хийдэг байна.

| Үзүүлэлт                     | 2007       | 2008      | 2009       | 2010       | 2011       | Бүгд | Дундаж |
|------------------------------|------------|-----------|------------|------------|------------|------|--------|
| Хэргийн холбогдогч           | <b>129</b> | <b>92</b> | <b>121</b> | <b>143</b> | <b>141</b> | 626  | 125    |
| Тогтоогдсон зөрчил, дутагдал | 106        | 85        | 121        | 143        | 141        | 596  | 119    |

Дээрх нөхцөл байдлаас шалтгаалан шүүхийн шинжилгээний үйл ажиллагааг зохицуулж буй дүрэм, журам, заавруудыг хуульд нийцүүлэн шинэчлэх шаардлагын дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар Алба хаагчдын сахилгын дүрэм, Шинжилгээний объектыг шүүхийн шинжилгээний байгууллагад хүргүүлэх, хадгалах, шилжүүлэх, устгах журам, Криминалистикийн шинжилгээ хийх журам, Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтныг аттестатчилах журам, Гарын хээний нэгдсэн сангийн журам, Хэн болох нь тогтоогдоогүй, хариуцах эзэнгүй хүний цогцосны мэдээллийн нэгдсэн сангийн журам, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам, Гэмтлийн зэрэг тогтоох журам, Задлан шинжилгээ хийх журам, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар Эдийн засгийн шинжилгээ хийх журам зэргийг батлуулан мөрдөж эхлээд байна.

#### **4.5. Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр Цагдаагийн байгууллагын зохион байгуулалт, бүтэц**

1996 он хүртэл ЦЕГ-т Эрүүгийн цагдаагийн алба, өндөржүүлсэн бэлтгэлтэй тусгай тасаг, криминалистикийн шинжилгээний төв, дүн шинжилгээ мэдээллийн төв, урьдчилан цагдан хорих төв, холбооны алба байгуулагдан ажиллаж байсан.

2000 онд Эрүүгийн цагдаагийн алба, криминалистикийн шинжилгээний төв, дүн шинжилгээ мэдээллийн төв, цагдан хорих төв, холбооны хэлтэс болсон.

2002 онд Эрүүгийн цагдаагийн алба, шинжилгээний хүрээлэн, урьдчилан цагдан хорих төв, мэдээлэл судалгааны төв, холбооны хэлтэс болжээ.

Мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалтад нийцүүлж 6 хэлтэстэй байсныг 4 хэлтэстэй болгон өөрчлөн Эрүүгийн нөхцөл байдлыг харгалзан Эрүүгийн цагдаагийн газрын онц хүнд гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийг өргөжүүлж, эрэн сурвалжлах хэлтэс, ажлын шаардлагаар малын хулгайтай тэмцэх, хар тамхи мансуурал, садар самуунтай тэмцэх нэгжүүдийг шинээр байгуулав.

Авлигатай хийх тэмцлийг тодорхой чиглэлээр явуулахын тулд Авлига, эдийн засгийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст авилга, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх, татвараас зайлсхийх орлогоо нуун дарагдуулах гэмт хэрэгтэй тэмцэх тасгуудыг бий болгов. Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийг Эрүүгийн цагдаагийн газрын бүтцээс гарган Нийслэлийн цагдаагийн газарт шинээр байгуулав.

“Мөрдөн байцаах албаны орон тоо, төсвийн тухай” Засгийн газрын 2002 оны 179 дүгээр тогтоолыг үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2002 оны 343 дугаар тушаалаар Мөрдөн байцаах газраас нийт 28 орон тоог Монгол Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албанд шилжүүлж, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн 24 цагдан хорих, 2 албадан саатуулах байрыг тэдгээрт ажиллаж байгаа алба хаагчийн орон тоо, цалингийн сангийн хамт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүлээлгэн өгсөн байна.

2002 оноос Хэрэг бүртгэлтийн үйл ажиллагаа цагдаагийн байгууллагад төвлөрч байгаатай холбогдуулан Зэвсэгт хүчний жанжин штабаас 25, Хил хамгаалах ерөнхий газраас 5, Гал түймэртэй тэмцэх газраас 26, Улсын гаалийн ерөнхий газраас 14, үндэсний татварын ерөнхий

газраас 13 хэрэг бүртгэгчийн орон тоог цалингийн сан, ашиглаж байгаа автомашин, холбогдох техник хэрэгслийн хамт Цагдаагийн ерөнхий газарт шилжүүлжээ.

Хэрэг бүртгэх байгууллагууд цагдаагийн байгууллагад төвлөрсөнтэй холбогдуулан Хэрэг бүртгэх албыг Бодлого зохицуулалтын хэлтэс, Бүх цэрэг, Татвар, Гаалийн хэрэг бүртгэх 3 тасаг, Галын хэрэг бүртгэх хэсэгтэй байхаар шинээр зохион байгуулжээ.<sup>55</sup>

Нийслэл Улаанбаатар хот, 21 аймагт Засаг даргын дэргэдэх цагдаагийн газар, хэлтэс, 330 сум, 120 хороодод цагдаагийн хэсгийн төлөөлөгч, байцаагч, хэсэг, тасаг, хэлтэс ажиллаж байна.

“Цагдаагийн байгууллагын мэдээллийн автоматжуулсан сүлжээ байгуулах төсөл”, “Цагдаагийн байгууллагын хэсгийн төлөөлөгч болон цагдаа нарын тогтвортой үйл ажиллагааг хангах дэд хөтөлбөр”, “Эрүүгийн цагдаагийн албаны гүйцэтгэх ажлыг сайжруулах дэд хөтөлбөр”, “Цагдаагийн байгууллагын алба хаагчдыг бэлтгэх, давтан сургах, дадлагажуулах дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлсэн нь үр дүнтэй ажил болсон байна.”<sup>56</sup>

Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн 29 дүгээр заалтад тусгасан зорилтын дагуу Цагдаагийн байгууллагын тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, бусад хууль тогтоомж, төслийн хүрээнд тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ирсэн боловч гэмт хэргийн өсөлт, цагдаагийн албан хаагчдын ажлын ачаалал, гэмт хэрэг үйлдэхэд ашиглагдаж буй техник хэрэгсэл, технологийн дэвшил, шинэ тутам үүсэн бий болж буй гэмт хэрэгтэй тэмцэхэд цагдаагийн байгууллагад өндөр ур чадвартай албан хаагч, хүчин чадал сайтай техник, хэрэгсэл шаардлагатай байна.

2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн Монгол Улсын прокурорын байгууллагын тухай хуулийн дагуу Ерөнхий прокурорын дэргэдэх Прокурорын мөрдөн байцаах алба зохион байгуулагдаж, 2002 оны 9 дүгээр сарын 11-ний өдрөөс ЭБШ хуулиар тусгайлан харъяалсан / тусгай субъектын үйлдсэн / гэмт хэргийн тухай гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргүүдийг хүлээн авч шалгах, мөрдөн байцаалт явуулах үндсэн үүргээ хуулийн хүрээнд хэрэгжүүлж эхэлжээ.

Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн дэг журмыг хамгаалах үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх хамгийн их эрсдэл дагуулж болох талтайг харгалзан цагдаагийн алба хаагчид, түүнчлэн шүүгч, прокурор, мөрдөн байцаагчийн үйлдсэн гэмт хэрэг, хууль зөрчсөн ажиллагааг тухайлан мэргэшсэн мөрдөн байцаах байгууллага хараат бусаар мөрдөн шалгах хэрэгцээ шаардлагыг үндэслэн тус албыг байгуулжээ.

Эрүүгийн хуульд заасан хөнгөн, хүндэвтэр хэрэгт явуулах байцаан шийтгэх ажиллагааг хэрэг бүртгэлт, хүнд, онц хүнд гэмт хэрэгт явуулах ажиллагааг мөрдөн байцаалт гэсэн ойлголтод хамааруулж, Эрүүгийн хуульд заасан хөнгөн, хүндэвтэр хэргүүдийг хэрэг бүртгэлтээс шүүхэд шилжүүлэх, хүнд, онц хүнд хэргүүдийн хувьд хэрэг бүртгэлтийн шатнаас мөрдөн байцаалтын шатанд шилжүүлж байхаар тусгажээ. Үүнтэй улдаж хэрэг бүртгэлтийг хөнгөн, хүндэвтэр хэргийн хувьд тусгай, бие даасан ажиллагаа гэж үзэж хэрэг бүртгэгч нь мөрдөн байцаагчтай адил байцаан шийтгэх ажиллагаа явуулах, тухайлбал мөрдөн байцаалт явуулахгүйгээр шүүхэд шилжүүлэх хэрэгт яллагдагчаар татах эрхтэй байхаар заажээ.

Шинэчлэн найруулж 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн Эрүүгийн байцаан шийтгэх хууль нь дотоод, гадаадын эрдэмтэн судлаачдын дүгнэснээр хэргийн бодит үнэнийг тогтоох, талуудын байцаан шийтгэх ажиллагаанд оролцох үүргийн бодит-практик тэнцвэрт байдлыг хангаж, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг эрх зүйт төрийн үзэлд тохируулж олон улсын жишигт нийцсэн хууль болжээ. Үүний сацуу, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь мэтгэлцэх зарчмын зарим нэгэн элементийг агуулсан боловч мөрдөн шалгах зарчмын дийлэнх хэсгийг нэгэн адил тусгасан холимог шинжтэй байгаа зэргийг тэд анхааруулж, өөр хоорондоо зөрчилдөж байгаа зарим заалтыг өөрчлөх талаар санал дэвшүүлсэн байна.<sup>57</sup>

- УИХ-ын 2002 оны 47-р тогтоол, Засгийн газрын 2002 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 179 дүгээр тогтоолын дагуу Монгол Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба байгуулсан;
- УИХ-ын 2006 онд баталсан “Авлигын эсрэг хууль”-ийн дагуу Авлигатай тэмцэх газрын бүтцэд “Мөрдөн шалгах хэлтэс” байгуулагдсан ажээ.

Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаах алба сүүлийн 5 жилийн байдлаар эрүүгийн 53337 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 28203 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэх, 16652 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай, нийт 44855 хэргийг шийдвэрлүүлэхээр прокурорт шилжүүлсэн. Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нийт хэргийн 90.2 хувийг нь хуулийн анхны хугацаанд, шалгасан нийт хэргийнхээ 84.1 хувийг эцэслэн шийдвэрлүүлэхээр прокурорт шилжүүлжээ.

Бүртгэгдэх үедээ эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 22548 хэргээс 15657 буюу 69.4 хувийг нь халуун мөрөөр нь илрүүлж, ЭБШХуулийн 205 дугаар зүйлийн 205.1.1-д заасан яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй үндэслэлээр түдгэлзүүлсэн хэргээс 10679 хэргийг нөхөн илрүүлжээ.

Дээрх хугацаанд иргэд байгууллагаас ирүүлсэн 124482 гомдол мэдээллийг хүлээн авч шалган, 59506-д нь эрүүгийн хэрэг үүсгэх, 45977-г нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, 9437-г харъяаллын дагуу шилжүүлэх саналтай, 7737-г нь эрүүгийн хэрэгт нэгтгэн шалгажээ.

Мөрдөн байцаалтын явцад гэмт хэргийн улмаас бусдад учирсан нийт 276 тэрбум 840 сая төгрөгийн хохирлоос 78 тэрбум 121,8 сая төгрөгийг нь нөхөн төлүүлж, 152 тэрбум 354 сая төгрөгийн эд хөрөнгийг иргэний нэхэмжлэлийг хангах зорилгоор битүүмжлэн хамгаалж, хохирлыг нөхөн төлүүлэх баталгааг хангасан байна. Гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн байдлыг авч үзвэл 2007 онд шалгасан гомдол мэдээллийн 97,3 хувийг, 2008 онд 90,5 хувийг, 2009 онд 99,2 хувийг, 2010 онд 99,1 хувийг, 2011 оны эхний 8 сарын байдлаар 97,9 хувийг шийдвэрлүүлэхээр прокурорт шилжүүлээд байна.

Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаах албанд бүртгэгдсэн гэмт хэргийг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл гэмт хэргийн гаралт буурсан боловч гэмт хэргийн бүтэц, шинж чанар өөрчлөгдөж, үйлдлийн арга нь нарийсч, бүлэг зохион байгуулалттай хэлбэрт шилжиж байна. Энэ нь сүүлийн үед гарч байгаа гэр бүлээр нь болон олон хүнийг нэг дор санаатай алах, бага насны охидыг хүчирхийлж, амь насыг нь хохироох зэрэг онц ноцтой гэмт хэргүүдээс иргэд олон нийтэд мэдрэгдэж байгаа.

Мөн үндэстэн дамнасан гэмт хэрэг түүний дотор хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисын хууль бус худалдаа, хэрэглээ, тээвэрлэлттэй холбоотой хэргүүд дотоод гадаадад гарч, бусдын бие махбодод гэмтэл учруулж танхайрах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих, хүн худалдаалах хэргүүд өсч цаашид нэмэгдэх хандлагатай байна.

Уул уурхай, ашигт малтмалын салбарын хөгжил нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах болсоноор эдийн засаг хөрөнгө оруулалтыг дагасан гадаад, дотоодын гэмт бүлэглэлийн зүгээс банк санхүү, хөрөнгийн зах зээл, татварын хууль бус ажиллагаа, мөнгө угаах гэмт хэргүүд үйлдэгдэж болзошгүйг анхааралдаа авч ажиллах шаардлага тулгарсан.

Өнөөгийн нийгэмд гарч байгаа шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн байцаах ажлын үр дүнг дээшлүүлэх зорилгоор тус газрын бүтцэд Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг мөрдөх, Зохион байгуулалттай гэмт хэрэг мөрдөх хэлтсүүдийг орон тоонд нь зохицуулан шинээр байгуулж, дүүргүүдийн ажлын ачааллыг харгалзан мөрдөн байцаах 2 тасагтай болгон ажиллуулж байна.

Үүний зэрэгцээ мөрдөн байцаалтын чанар, үр дүнг дээшлүүлэх зорилгоор албаны хэмжээнд хүрэх түвшингийн үзүүлэлтээ жил бүр тодорхойлж, нэг мөрдөн байцаагчийн шийдвэрлэх мөрдөн байцаалтын хэргийн тоо, гомдол мэдээллийн түвшинг тодорхойлж, олныг хамарсан онц их хэмжээний хохиролтой, ээдрээ төвөгтэй, зохион байгуулалттай үйлдсэн хэргүүдийг шуурхай илрүүлж шалгахын тулд мөрдөн байцаалтын ажлын хэсгүүдийг томилж, зохион байгуулалтын арга хэмжээг авч ирлээ.

Мөрдөн байцаалтын ажиллагаа, иргэдэд үйлчилэх үйлчилгээг шуурхай болгох, гэмт хэрэг түүнийг үйлдсэн этгээдийг халуун мөрөөр нь илрүүлж, шалгахад дан ганц байцаалтын арга хэрэглэн мөрдөн байцаагчийн ур чадварт найдах нь нийгмийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцэхгүй байгааг анхаарч шинжлэх ухаан техникийн дэвшил, шинэ техник технологийг цаг алдалгүй нэвтрүүлэх нь нэн тэргүүний хэрэгцээ, шаардлага болоод байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Цагдаагийн байгууллагын мэдээллийн орчинг илүү боловсронгуй болгох зайлшгүй хэрэгцээ, шаардлага байна. Гэмт хэргийн илрүүлэлт нь цаг хугацаатай уралдаж явагддаг ажил. Гэмт хэргийн талаарх мэдээллийг дамжуулах хурдыг сайжруулах, нөгөө талаар Прокурор, Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Татвар, Гааль, Хил хамгаалах, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Монголбанк, Авто тээврийн газар зэрэг байгууллагуудтай нэгдсэн сүлжээнд холбогдон



мэдээлэл авах техникийн нөхцөлийг бүрдүүлж, мэдээллийн нэгдсэн санг өргөн цар хүрээтэй ашиглах хэрэгтэй.

#### **4.6. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны шинэтгэлийн үзэл баримтлал**

##### **А. Гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн үзэл баримтлал<sup>58</sup>**

###### Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Шинэчлэн найруулсан Эрүүгийн байцаан шийтгэх хууль 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдаж, 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс даган мөрдөгдсөн. Өнгөрсөн хугацаанд энэхүү хуулийн хэрэгжилтийн төлөв байдлын талаар төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн, судлаачдын зүгээс хийсэн судалгааны ажил болон хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээр гаргасан санал, дүгнэлтээс үзэхэд: Эрүүгийн байцаан шийтгэх хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон уг хуулийн шинэчилсэн найруулга нь мэтгэлзэх зарчмын хэрэгжилтийг сонгодог утгаар нь хангахад чиглэсэн шүүн таслах ажиллагаа болон яллах, өмгөөлөх чиг үүргийг тунхаглалын чанартайгаар “бие даалгаснаас” бусдаар өмнөх тогтолцоо – нийгмийн үед бий болсон үндсэн хэв загварыг бүрэн өөрчлөн шинэчлээгүй өнөөдрийг хүрсэн гэж үзэж болохоор байна.

Орчин цагийн нийтлэг чиг хандлагыг тодорхойлсон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны суурь зарчмуудыг хэрэгжүүлэхийн тулд гэмт хэрэгтэй тэмцэх, түүнийг илрүүлэх, гэмт этгээдийг олж тогтоох, түүнд шударга ял шийтгэл оногдуулахад чиглэсэн тогтолцоо болон байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын чиг үүргийн хуваарилалтыг өөрчлөх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Уг хуулийн зохицуулалтыг цаашид улам боловсронгуй болгох шаардлагыг харгалзан Улсын Их Хурлын 2009 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл” - ийн 96 – д “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг шуурхай явуулахын тулд байцаан шийтгэх ажиллагаа явуулах байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэргийн тоог нэмэгдүүлэх” талаар заасан юм.

Гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэсэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь улс орон бүрт өөр өөрийн онцлогт тохирсон эрх зүйн тогтолцооны уламжлалын хүрээнд бүрэлдэн бий болсон байдаг хэдий ч онолын болон практик хэрэглээний хүрээнд Эх газрын буюу Ром – Германы, Нийтийн эрх зүй буюу Англосаксоны гэсэн бүлүүдэд хуваагдан хөгжиж ирсэн билээ.

Монгол Улсын хувьд орчин цагийн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь Эх газрын эрх зүйн тогтолцооны бүлд хамаарах Зөвлөлт маягийн загварыг өөрийн онцлогт тохируулан үндсэндээ хуулан хөгжиж ирсэн.

Нийгмийн хөгжлийн өнөөгийн түвшинд эрх зүйн тогтолцооны энэ хоёр бүл харилцан тус тусын давуу байдлыг хуваалцан, орхих зүйлээ орхин зэрэгцэн хөгжиж ирсэн. Хөгжлийн энэ шатанд эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжоо цаашид боловсронгуй болгон хөгжүүлэх үзэл баримтлалаа тууштай тогтоох хэрэгцээ бий болжээ.

Иймээс Улсын Их Хурлын 2012 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-т:

- шүүхэд мөрдөн байцаалтын шатны шүүгчийн бүтцийг бий болгож, хүний эрхийн баталгааг дээшлүүлэх,
- прокурорын байгууллагын хүний эрхийн болон гүйцэтгэх ажлын хяналт, процессын маргаан шийдвэрлэх чиг үүргийг шүүхэд шилжүүлэх,
- шүүхээс гадуур хүний эрхийг хязгаарлаж, эрүүгийн хэргийг байцаан шалгадаг тогтолцоог халж, шүүхийн хяналтын дор эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоох”-оор заасан.

Иймээс шаардлагатай өөрчлөлтийн цар хүрээнд тохируулан дээрх асуудлыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна. Хуулийн төсөл боловсруулахад урьд нь хийгдэж байсан холбогдох хуулийн төсөл болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хэрэгжилтийн төлөв байдлын талаар

гарсан судалгааны бүтээлүүдийг харгалзан үзнэ. Мөн зөрчлийн дараахь улс орнуудад зориулсан НҮБ-аас гаргасан Эрүүгийн процессын загвар хууль болон Япон, Солонгос, АНУ-ын эрүүгийн процессын хуулийг тус тус судалж үзнэ. Хуулийн төсөл боловсруулахад Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцийн заалт, НҮБ-аас ирүүлсэн зөвлөмжүүдийг анхаарч нийцүүлнэ.

### Хоёр. Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хуулийн төслийн ерөнхий бүтэц

Дараахь чиглэлээр Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд оруулах суурь өөрчлөлтийг харгалзан үзэж мөн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл буюу Гэмт хэргийн тухай хуулийн төсөлтэй уялдуулан хуулийн төслийн нэрийг Гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль хэмээн өөрчилнө.

2. Гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг Гэмт хэргийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал, ялын төрөл, хэмжээ, нэр томъёонд нийцүүлж боловсруулна.

3. Хэрэг үүсгэхээс өмнө гэмт хэргийн тухай гомдол мэдээллийг шалган баримтжуулж, хэрэг үүсгэх эсэх тухай асуудлыг шийдэх үе шатыг хууль сахиулах үйл ажиллагаа гэсэн зохицуулалтад хамруулан тусад нь хуульчлах, үүнтэй уялдан гэмт хэргийн ангиллаас нь шалтгаалан хэрэг бүртгэлтийн болон мөрдөн байцаалтын гэж ангилан зохицуулсан зохицуулалтыг шинэчилнэ.

4. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын чиг үүргийг өөрчлөн прокурор хэрэг үүсгэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял сонсгох асуудлыг бие даан шийдвэрлэх зохицуулалтыг тусгана.

5. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь эрх тэгш бүхий яллах, өмгөөлөх талын мэтгэлцээний үндсэн дээр явагдах зарчим бүрэн хэрэгжих нөхцөл бүрдүүлэх өөрчлөлт оруулна. Өмгөөлөгчийн явуулах үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлж, оролцоог өргөжүүлнэ.

6. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шүүх, шүүгчийн бүрэн эрхийг шинэчлэн найруулж баталсан Шүүхийн багц хуультай уялдуулна. Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх зарчмын дагуу прокурорт байсан зарим эрх хэмжээг шүүхэд шилжүүлнэ. Үүний дагуу шүүхэд шүүн таслах ажиллагааны өмнөх шатан дахь шүүхийн оролцооны асуудлыг шийдвэрлэнэ.

7. Прокуророос эцэслэн яллах дүгнэлт үйлдэн ирүүлсэн хэргийг талуудын саналыг үл харгалзан дахин мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт шүүхээс буцаадаг зохицуулалтыг хална.

8. Үйлдсэн гэмт хэрэгтээ гэмшиж байгаа, учруулсан хохирлоо барагдуулсан, хэргийн талаар ямар нэг маргаан гараагүй, зохих нотлох баримт хангагдсан, яллагдагч өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд шүүх хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэж болохоор тусгана. Ингэснээр шүүхийн ачаалал тодорхой хэмжээгээр хөнгөрч, шүүхийн үйлчилгээний зардал багасна гэж тооцож байна.

9. Хэргийг шүүн таслах ажиллагаа буюу шүүх хурал нь хэд хэдэн бэлтгэл ажиллагаа, хуралдаанаас бүрдэж болох ба бэлтгэл ажиллагааны явцад зохих зөвшөөрөл өгөх шүүх хуралдааны явц болон шүүх хуралдааныг эхлэх, шүүхийн хэлэлцүүлэг хийх ажиллагааг илүү нарийвчлан зохицуулна.

10. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу шүүн таслах ажиллагаанд иргэдийн төлөөлөгчийн оролцоо болон иргэдийн төлөөлөгчийг татгалзан гаргах үндэслэлийг тусгана.

11. Хуулийн төсөлд таслан сэргийлэх арга хэмжээний төрлийг цөөрүүлнэ. Аль болохоор цагдан хорих арга хэмжээг хэрэглэхгүй байх үүднээс эрх хязгаарлах албадлагын арга хэмжээний төрлийг нэмэгдүүлнэ.

12. Өөрийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч болох яллагдагч, хохирогч болон гэрчийн эрхийг хамгаалахад ахиц гаргах өөрчлөлт тусгаж, олон улсын хэм хэмжээнд нийцүүлнэ.

13. Насанд хүрээгүй этгээдтэй холбоотой зохицуулалтыг тухайлан авч үзэж, тэдний эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн нэмэлт өөрчлөлт тусгана.

14. Цаазаар авах ялтай холбогдсон зохицуулалтыг хална.

15. Хуульд оновчгүй хэрэглэсэн нэр томъёог залруулж, хоёрдмол утга илэрхийлсэн болон давхардсан утга бүхий зүйл, заалтыг тодруулж өөрчилнө. Гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн бүтэц процесс дарааллаараа эрэмбэлэгдэнэ.

16. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарим бүлэг, зүйл, хэсгийг энэхүү үзэл баримтлалын дагуу тус тус хүчингүй болгож, өөрчилж, нэмэлт оруулна.

17. Хуулийн төсөлд шинээр нэмж оруулсан нэр томъёог тайлбарлана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм эдийн засгийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд бодит үнэнийг тогтоохын тулд асуудлыг тал бүрээс нь нягтлан түргэн шуурхай шийдвэрлэх зохицуулалт бий болно.

Гэмт хэргийн тухай хуулийн төсөл батлагдан гарсны дараа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий хүмүүсийн ажлын чиг үүрэгт болон байгууллагын үйл ажиллагаанд зохион байгуулалтын өөрчлөлт орно.

Гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал, шүүх хуралдааны зардал /бэлтгэл ажиллагаа, хуралдаан явуулах/, хүний нөөцийн болон материал, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн зардал одоо байгаагаас нэмэгдэнэ гэж тооцоолж байна. Хууль батлагдсаны дараа хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын үнэлгээг мэргэжлийн хүмүүс бүхий ажлын хэсгээр тусгайлан хийлгэнэ.

Дөрөв. Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Энэхүү хуулийн төсөл нь эрүүгийн чиглэлийн багц хуулийн төсөл боловсруулах хүрээнд хийгдэж байгаа тул бусад хуулийн төсөлтэй тухайлбал Гэмт хэргийн тухай хуулийн төсөл, Хууль сахиулах үйл ажиллагааны тухай, Мөрдөх албаны тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай зэрэг хуулийн төсөлтэй тус тус уялдана. Гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлтэй уялдуулан Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай, Прокурорын байгууллагын тухай зэрэг хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулна.

## V. ХУУЛЬ ЗҮЙН САЛБАРЫН ХУУЛЬ САХИУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЭТГЭЛ

### 5.1. Хууль зүйн салбарын хууль сахиулах үйл ажиллагааны шинэтгэл

ЭБШХ-ийн хэрэгжилтийн төлөв байдлын талаархи санал, уг хуулийг хэрэглэж, хэрэгжүүлж буй байдлаас харахад ЭБШХ нь байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдын чиг үүргийн хяналт, хариуцлагыг зөв хуваарилах, байцаан шийтгэх ажиллагааны хүнд суртлыг багасгах, түргэн шуурхай болгох, байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрхийг хангах баталгааг сайжруулж, бодитой болгоход чиглэгдсэн, олон улсын болон бусад орнуудын эрх зүйн жишиг хандлагад тулгуурлах, хэрэгтэй гэж дүгнэжээ.

Судалгааны үр дүнд хууль тогтоомжийг боловсронгуй болгох буюу төгөлдөржүүлэх саналыг төрөлжүүлэн авч үзэхэд 29.8% нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын, ялангуяа гэмт хэрэгт холбогдсон, гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн, мөн гэрч, хохирогчийн эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн санал, 24.5% нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчдээс уг ажиллагааг явуулахтай холбоотой, 12.2% нь нотлох баримт олж, цуглуулах, мэтгэлцэх боломж, эрхийг хангахад чиглэсэн, 10.5% нь эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт этгээдийг шилжүүлэн өгөх ажиллагаатай холбоотой, 7% нь таслан сэргийлэх арга хэмжээг авах ажиллагааны явцад хүний эрхийг зөрчихгүй байх баталгааг хангахад чиглэсэн, 5.2% нь ЭБША-ны явцад гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нэхэмжлэлийг шийдвэрлэхтэй холбоотой, 3.5% нь ЭБШХ үйлчлэх хэмжээ хязгаарыг өргөтгөхөд чиглэсэн саналтай байна.

Судалгааны явцад ЭБША дахь хэргийг зөвхөн байцаалтаар нотолж буй байдлыг үндсэнд өөрчилж, байцаалтаас бусад нотолгоогоор хэргийг нотлох эрх зүйн орчныг бий болгох, эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх тогтолцоо, журмыг боловсронгуй болгох талаар нилээд санал иржээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг бүхлээр нь шинэчлэх нийгмийн хэрэгцээ, шаардлага байна хэмээн энэ салбарын эрдэмтэн судлаачид, практик алба хаагчид, хуулийн байгууллагын удирдлагаас дүгнэжээ.<sup>59</sup>

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын<sup>60</sup> “Эрх зүйн шинэтгэл 2007-2021” гэсэн 7.1 дэх хэсгийн 1 дэх стратегийн зорилтод “Дэлхийн улс орнуудын эрх зүйн тогтолцооны үнэт зүйл, эрх зүйн соёл, шинэ дэвшилтэт, түгээмэл ач холбогдол бүхий зохицуулалтын аргыг судалж нэвтрүүлэх”-ээр заасан байна.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг олон улсын стандартад нийцсэн, шинэ түвшинд гаргах зорилгоор хийгдэж буй зарим ажлууд хоорондоо уялдаа холбоогүйгээс хүлээгдэж, төсөөлөгдөж буй шинэчлэлүүд бүрэн тусах нь эргэлзээтэй, үйл явц удаашралтай байгаа нь тулгамдсан асуудал болоод байна. Хэдий тийм ч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг шинэлэг үзэл баримтлалаар өөрчлөх зүй ёсны шаардлага байгааг бүх талд хүлээн зөвшөөрч, Монгол Улсын УИХ, Засгийн газар, Ерөнхийлөгчөөс гаргасан дээрхи бодлогын баримт бичгүүд нь эгзэгтэй мөчид “нэг цэгт” төвлөрч байгаа нь сайшаалтай байна.

#### **1. Засгийн газрын бодлого:**

Хууль зүйн яамнаас Засгийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 5 дугаар бүлэгт туссан “Эрх чөлөөт Монгол хүн” гэсэн хэсэгт багтсан ажлын 90 гаруй хувийг шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллага, харьяа агентлагуудтай хийх хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Нийгмийн хөгжлийн олон үе шатуудад хууль зүйн салбар тэр дундаа хууль сахиулах үйл ажиллагаа эрх зүйн нэгдсэн зохицуулалтгүй явж ирснийг бид мэдэх билээ. Үндсэндээ эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа, эсхүл захиргааны зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа гэсэн ойлголт эрүүгийн процессын эрх зүй болон захиргааны процессын эрх зүйд хамаарч, үндсэн хуульд заасан иргэний эрхийг хамгаалах, хүний халдашгүй эрхийг хязгаарлах, үндэслэл бүхий сэжгийг шалгаж, төрийн нэрийн өмнөөс хуулийг хэлбэрэлтгүй сахин биелүүлэх ажиллагаа олон салбарын хууль тогтоомжид өөр өөрөөр тусч ирсэн.

#### **2. Онолын шийдэл:**

Эрх зүйн процессын хувьд Ром германы эрх зүйн тогтолцоотой орнуудад төр нь (“ардчилсан журмаар сонгогдсон хууль тогтоогчийн хувьд”) эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг тогтоох гол төв гэж үздэг. Төр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг удирдан чиглүүлдэг ба үүнийгээ шударга бөгөөд хараат бусаар хийнэ гэж найддаг байна. Харин нийтийн эрх зүйн тогтолцоотой газарт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэргийг хянан шийдвэрлэх төрийн чадавхид эргэлздэг бөгөөд ингэснээрээ маргалдагч талуудын хооронд хараат бус шүүгчид гол найдвар хүлээдэг байна.<sup>61</sup>

Ром германы эрх зүйн тогтолцоон дахь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны дээрх ерөнхий зарчмаас үүдэн дор дурьдсан тогтолцоо буй болжээ. Эх газрын эрүүгийн эрх зүйн бодит байдлыг судлаад үзэхэд төвд тэмүүлэх хүч үйлчилдэг, цагдаа, прокурор, шүүх эрх мэдлийн тогтолцоог төвлөрүүлэх замаар шийдвэр гаргах ажлыг хэрэгжүүлдэг, дээд шатны байгууллагаас доод шатандаа тушаасан хөшүүн систем салбар дотроо буй болгосон (тухайлбал шүүх эрх мэдлийн тогтолцоо дотроо) болон салбар хооронд (хууль тогтоогчоос шүүхийн эрх мэдэл шалтгаалах); тодорхой тогтоосон дүрэм, журам, албан ёсны баримт бичиг, тайланг илүү үзэх “эрүүгийн эрх зүйн ноён нурууг бүрдүүлсэн, дээд удирдлага хянахад шаардлагатай хавтаст хэрэгтэй байх”; албан тушаалтнууд түүний дотор шүүгчдийг сонгон шалгаруулах, сургах, албан тушаалд дэвшүүлэх тогтолцоогоор бэхжсэн хүнд сургалтын арга барил, сэтгэн бодох хязгаарлагдмал хэв маяг зэрэг болно.”<sup>62</sup>

### 3. Бодлогын шинэтгэл:

Хууль зүйн салбарт эрүүгийн хариуцлагын тогтолцооны шинэтгэл буюу “**criminal justice reform**” хийгдэж байгаатай холбогдуулан хууль тогтоомжийн төдийгүй дэд бүтцийн бодлогыг салбарын яамнаас шинээр тодорхойлж байна. Бидний мэдэх Эрүүгийн хууль тогтоомж гэсэн ойлголт нь илүү өргөн болж материаллаг болон процессын хуулиудыг бүхэлд нь хамарч, хэргийг хурдан шуурхай шийдвэрлэх, оролцогчдын аюулгүй байдлыг хангасан, шударга ёсыг тогтооход чиглэж буй.

Монгол Улсад хууль сахиулах чиг үүргийг олон салбарын мэргэжлийн байгууллага хэрэгжүүлдэг боловч өнөөг хүртэл төрөлжсөн хуульгүй явж ирлээ.

Хууль сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмыг гэмт хэрэг болон зөрчлийг шалган шийдвэрлэх салбар эрх зүйн хүрээнд төдийгүй байгууллагын хэм хэмжээ тогтоосон салбарын хуулиудаар зохицуулж байгаа нь эрх зүйн хийдэл, цоорхой, давхардлыг бий болгож, улмаар хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхагдахгүй байх Үндсэн хуулийн зохицуулалтыг гажуудуулах нөхцөл болж байна.

Иймд үндэслэл бүхий сэжиг, гэмт хэрэг, зөрчлийг бүртгэх, мөрдөн шалгах эрх бүхий цагдаа, мөрдөх болон хилийн алба, татвар, гааль зэрэг хууль сахиулах байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, ашиг ашиг сонирхлын зөрчил, авлигалаас ангид нэгдсэн зарчим, журмаар хэрэгжих эрх зүйн баталгааг бүрдүүлэх шаардлагад үндэслэн Хууль сахиулах үйл ажиллагааны тухай бие даасан хуулийн төслийг боловсруулж байна.

Гэмт хэрэг илрүүлэх хойшлуулгүй ажиллагаа, иргэний өмч хөрөнгийг битүүмжлэх, хураан авах, нэгжих, үзлэг хийх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах буюу нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, гүйцэтгэх ажил, нийгмийн хэв журам сахиулах, нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанууд “**хууль сахиулах үйл ажиллагаа**” гэсэн ойлголтод багтаж хууль сахиулагчийн эрх зүйн байдлыг тусгайлсан хуулиар тогтооно. Ингэснээр хүний халдашгүй эрхийг хязгаарлах, өмч хөрөнгөд халдах ажиллагаа нэг стандартаар хэрэгжих юм. Хууль сахиулагчид хамаарах

Гэмт хэргийг мөрдөх, зөрчлийг шалгах, нийгмийн хэв журам сахиулах, аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж буй субъект болох ял эдлүүлэх, хил хамгаалах, онцгой байдал, харьяатын албаны алба хаагчийн эрх зүйн байдлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Монгол Улсын Хилийн тухай, Гамшгаас хамгаалах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай зэрэг тухайн салбарын хуулиар зохицуулж байгаа бөгөөд эдгээр алба хаагчдын эрх, үүрэг, ажиллах нөхцөл, баталгаа нь давхардсан, зохицуулалт нь хангалтгүй байна.

Түүнчлэн Улсын Их Хурлаас 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу зохион байгуулалттай, нууц далд

аргаар үйлдэгддэг гэмт хэргийг мөрдөн шалгах “мөрдөх алба”, шүүхийн шат дахь гэрч, хохирогч, шүүгчийн аюулгүй байдлыг хамгаалах чиг үүрэгтэй “маршалын алба” зэрэг байгууллагууд шинээр байгуулагдах бөгөөд эдгээр албаны алба хаагчийн эрх зүйн байдлыг мөн нэгдсэн байдлаар зохицуулах, албан хаагчийн хариуцлага, ёс зүйн болон сахилгын дүрмийг олон улсын стандарт, зөвлөмжид нийцүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах зарчмын шинэлэг зохицуулалт бий болгох, албан хаагчийн үйл ажиллагаа байгууллагаас бус хуулиас илүү хамааралтай байх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.


Иймд дээрх хууль зүйн болон практик шаардлагыг үндэслэн Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулж байна. Энэ хуулийн төслөөр хууль сахиулагч буюу цагдаа, мөрдөх, маршал, ял эдлүүлэх, хил хамгаалах, онцгой байдал, харьяатын албаны алба хаагчийн эрх зүйн байдал, үүргээ гүйцэтгэх нөхцөл, ажиллах баталгааг хангахтай холбогдсон харилцааг зохицуулж, гааль, татвар, мэргэжлийн хяналтын улсын байцаагч нь энэ хуулийн үйлчлэлд хамаарах этгээд байхаар тусгана.

Ийнхүү хууль сахиулах үйл ажиллагаа нэг стандартад орсноор эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд байдаг цагдан хорих, хөтөлж байцаах, нэр хүндийг нь гутаан доромжилж харьцах зэрэг эрүү шүүлтийн амь бөхтэй оршсоор байгаа хэлбэрүүдийг хязгаарлах боломжтой болж байгаа юм. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд байгаа олон ажиллагаа, үндэслэл журмууд хууль сахиулах ажиллагаанд хамаарч байгаатай холбоотойгоор Гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл боловсруулагдаж байна. Энэ хуулийн төсөлд хүнийг гэмт хэрэгт сэрдэж, баривчилсан үеэс эхлэн зөвшөөрлийг шүүгч цагдан хорих, бусад эрхийг хязгаарлах бүхий л ажиллагааг хүний эрхийг хангаж байгаа эсэхийг харгалзаж, зөвшөөрөл олгодог байхаар тусгахаар судлан боловсруулж байна.

## 5.2. Хууль сахиулах байгууллагуудын дэд бүтэц, шинэтгэлийн үндсэн чиглэл

Хууль сахиулах байгууллагыг цэргийн юмуу цэрэгжсэн байгууллага гэж ойлгоод батлан хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллагатайгаа нийлүүлээд хүчний байгууллага гэж нэрлэдэг байсан. Энэ нь иргэнд аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг бууруулсан шинжтэй байсан. Иймд иргэнд үйлчилдэг байгууллагыг цэргийн байгууллагаас ялгах шаардлага зайлшгүй байсан. Үүнийг халах зорилгоор Монгол Улсад өмнө нь хийгдэж байсан шинэтгэлүүд гэвэл нийтийн захиргааны байгууллагын институтыг оруулж ирж байсан.

Гэвч энэ нь зөвхөн захиргааны байгууллагуудыг хамарснаар хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллагын иргэнд үйлчлэх чиг үүргийг тодорхой хэмжээнд гаргаж ирсэн боловч цэрэгжсэн байгууллага гэсэн ойлголтоос нь салгаж чадаагүй. Иймд хууль сахиулах байгууллагыг цэрэгжсэн байгууллага цэргийн байгууллага гэсэн стасусыг арилгаж хууль сахиулах байгууллага гэдгийг тодотгох шаардлагатай.



Ийм ялгаа байгааг олж харахад манай улсад бий болсон хэд хэдэн кэйс буюу хэрэг явдал нөлөөлсөн байдаг. Тухайлбал, 7 сарын 1-ний хэрэг явдлын дараагаар цагдаагийн удирдлагыг уг үйл явдлын улмаас хүний амь нас үрэгдсэн явдалд гэм буруутай эсэхийг шүүхээр шийдвэрлэх үед өмнө нь бид бол цэрэгжсэн байгууллага учраас тушаалаар хөдөлдөг гэсэн ойлголттой байсан боловч яг шүүхээр хэрэг шийдвэрлэх явцад бид иргэнд үйлчилдэг байгууллага болохоор цэргийн гэмт хэргээр зүйлчлэгдэхгүй гэж маргаж байсан.

Учир нь цагдаагийн байгууллага нь хууль сахиулах үйл ажиллагааг явуулахдаа иргэн лүүгээ хандсан зорлиго нь илүү тодорхой харагдаж байдаг хууль сахиулах чиг үүрэгтэй байгууллага болохоос цэргийн байгууллага биш гэсэн гаргалгааг гаргаж ирсэн. Гэхдээ цагдаагийн байгууллага бол цэргийн байгууллага биш боловч захиргааны байгууллага бас биш юм. Иймд ямар байгууллага байх ёстой вэ гэдэг асуудал хөндөгдсөн. Иймд бид цэргийн болон

иргэний байгууллагын дунд “Хууль сахиулах байгууллага” гэсэн шинэ статус байх ёстой гэж үзсэний үндсэн дээр энэхүү шинэчлэлийг хийх шаардлагатай болсон.



**Шинэтгэлийн үндсэн чиглэл:** Хууль сахиулах үйл ажиллагааны шинэтгэл дараах үндсэн чиглэлээр шинэчлэл хийх шаардлагатай юм байна гэж үзсэн юм.

#### 5.2.1. Цагдаагийн байгууллагад хийгдэх шинэтгэлийн чиглэл

Хууль зүйн салбарт “шударга ёсыг хамгаалах тогтолцооны шинэтгэл явагдаж байгаатай холбогдуулан хууль тогтоомжийн төдийгүй инфра дэд бүтцийн бодлогыг салбарын яамнаас шинээр тодорхойллоо. Нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах эрх бүхий цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, ашиг ашиг сонирхлын зөрчил, авилгаас ангид нэгдсэн зарчим, журмаар хэрэгжих эрх зүйн баталгааг бүрдүүлэх шаардлагад үндэслэн Цагдаагийн байгууллагын тухай хууль болон Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүдийг боловсруулж байна.

1993 оны 12 дугаар сарын 02-ны өдөр УИХ-аас баталсан Цагдаагийн байгууллагын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 20-иод жилийн хугацаанд тус улсын эдийн засаг, нийгмийн бүх талын харилцаанд ихээхэн өөрчлөлт орж, энэхүү өөрчлөлтийн явцад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах ажиллагааг уг хуулиар шуурхай, үр дүнтэй зохицуулах боломжгүй болжээ.<sup>63</sup>

Дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлагуудыг үндэслэн, олон улсын туршлагыг өөрийн орны онцлогт нийцүүлэн, цагдаагийн байгууллагын харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг харьцуулан дүгнэж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хариуцлагатай байдлыг хангах, цагдаагийн байгууллагыг удирдах, хяналт тавих эрх бүхий субъектын чиг үүрэг, бүрэн эрхийг зааглан тодорхой болгох, иргэний хяналт, иргэн болон цагдаагийн байгууллага харилцан бие биедээ тусалж, хамтран ажиллах эрх зүйн үндсийг бий болгох, цагдаагийн алба хаагчийн үүргээ гүйцэтгэх нөхцөл баталгааг дээшлүүлэх, мөн цэрэгжсэн зохион байгуулалт, хүчирхийлсэн арга барилаас хууль сахиулах, иргэнд үйлчлэх чиг үүргийг нь тодорхой зохицуулахад анхаарч байна.

#### Цагдаагийн байгууллагын шинэчлэлийн шаардлага:

Дэлхийн улс орнуудын практикаас харахад хууль сахиулах үйл ажиллагаа нь нэлээн өргөн хүрээг хамарсан ойлголт бөгөөд үүний нийт иргэдэд шууд мэдрэгдэх хууль сахиулах, аюулгүй байдлын хосолсон шинжтэй үйлчилгээг цагдаагийн байгууллага гүйцэтгэдэг. Гэхдээ хууль сахиулах байгууллагууд нь өөрийн зорилго чиг үүрэгээс хамаараад янз бүр байдаг.

Тухайлбал, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хоёрны нэг нь иргэнд үйлчилдэг захиргааны байгууллагын шинжтэй нөгөө хэсэг нь хууль сахиулах чиг үүргийг гүйцэтгэх шинжтэй байдаг.

Иймд хууль сахиулах байгууллага нь иргэнд үйлчлэх үүргээ биелүүлэх үе шат нь хаанаа байгааг, хууль сахиулах тохиолдол нь хаанаа байгааг илүү тодорхой болгох шаардлагатай. дэлхийн улс орнуудын Цагдаагийн байгууллагын туршлагаас үзэхэд үндсэн гурван чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд нэгт, гэмт хэрэгтэй тэмцэх, хоёрт, хэв журмыг хамгаалах, гуравт олон нийтийн аюулгүй байдлыг хангах гэсэн гурван чиг үүрэг байдаг байна. Нийгмийн хэв журмыг хамгаалах, гэмт хэргийн талаарх өргөдөл гомдлыг шийдвэрлэх үедээ иргэнд үйлчилдэг байна. Гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх болон таслан зогсоох, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах буюу нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэхээс сэргийлэх таслан зогсоох хязгаарлах үед хууль сахиулах чиг үүргээ биелүүлдэг байгууллага байна. Эдгээр чиг үүргийг илүү тодорхой болгохоор цагдаагийн байгууллагын тухай хуулийн шинэчилсэн төсөлд оруулж өгсөн.

### **Цагдаагийн байгууллагын тухай хууль шинэчлэн батлагдсанаар гарах эерэг үр дагавар**

1. Цагдаагийн байгууллагын тогтолцоо боловсронгуй болж, зарим албадын чиг үүргийн давхардал арилна. Тухайлбал, Эрүүгийн цагдаа, мөрдөн байцаах газар, нийгмийн хэв журам хамгаалах газар гэсэн босоо удирдлага бүхий албадын заримыг орон нутгийн эрх мэдлийн түвшинд шилжүүлнэ. Ингэснээр тухайн орон нутгийн захиргааны байгууллага цагдаагийн байгууллагаар дамжуулан нутаг дэвсгэрийн хэмжэээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах бодлогыг тодорхойлж үр ашигтай, ухаалаг тогтолцоо бий болох юм. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн журам сахиулах үндсэн чиг үүргийг тодорхой болгож, Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг байсан 6 дүүргийн цагдаагийн хэлтсийг 12 болон өөрчилж, цаашдаа 100,000 мянган хүн амд нэг цагдаагийн хэлтэс ногдох стандартай байхаар шинэтгэлийн ажлуудыг хийж эхэлсэн байна.

2. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах ажлыг ялган зааглаж өгсөнөөр цагдаагийн алба хаагчийн гүйцэтгэх чиг үүргийн давхардал арилж, нэгж, анхан шатны цагдаагийн алба хаагчид оногдох ачаалал жигд, тэнцвэртэй болно. Алба хаагчийг хуульд заасан цагаар ажиллуулах, өөр чиг үүргийг хавсран гүйцэтгэж үйлчилгээний чанар буурдаг, ажлын байранд стресс үүсэх, эрх зөрчигдөх зэрэг нөхцөл багасна.

3. Үндэсний болон нутаг дэвсгэрийн хэмжээнд цагдаагийн байгууллагын ажлыг үнэлэх дүгнэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах, үйл ажиллагаа явуулахад иргэдийг оролцуулдаг тогтолцоо бүрдэнэ. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт туссан гол гол ажлууд тухайлбал, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нэгж байгуулах, хэв журмын чиг үүргийг орон нутгийн эрх мэдлийн түвшинд шилжүүлэх зэрэг заалтыг хэрэгжүүлэхэд зарим төсөв, үйл ажиллагаа явагдана. Нутаг дэвсгэрийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн талаар баримтлах бодлого, чиглэл өөрчлөгдөж байгаа. Тухайлбал, тухайн нутаг дэвсгэрт урьдчилан сэргийлэх бодлого боловсруулахад иргэдийн төлөөлөл оролцуулж, нээлттэй хэлэлцүүлэн тухайн онд хийгдэх ажлыг төлөвлөх зэргээр иргэн төвтэй үйл ажиллагаа явуулахад чиглүүлнэ. Ингэснээр цагдаад өгөх иргэдийн үнэлгээ өсч, тус байгууллага, иргэдийн хамтын ажиллагаа бэхжиж, иргэдэд хүрэх үйлчилгээ чанаржина.

**4. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажлын чанар, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирна.** Үндэслэл бүхий сэжиг, гэмт хэрэг, зөрчлийг бүртгэх, хянах, мөрдөн шалгах эрх бүхий цагдаа, мөрдөх болон хилийн алба, татвар, гааль зэрэг хууль сахиулах байгууллага, шүүх эрх мэдлийн байгууллага болох прокурор шүүхийн байгууллагатай хамтран ажиллах эрх зүйн үндэс илүү нарийн, тодорхой болж байгаа юм.

**5. Цагдаагийн алба хаагч мэргэжлийн болон албаны ур чадвараа ил тодоор үнэлүүлэн тушаал ахих, тухайн албан тушаалыг илтгэсэн цол хэрэглэх, албан үүргээ гүйцэтгэж байх үедээ болон цагдаагийн албанаас тэтгэвэрт гарахдаа эдийн засаг, нийгмийн боломжит нөхцлөөр хангагдан ажиллна.** Ингэснээр цагдаагийн алба хаагчийн үүргээ гүйцэтгэх нөхцөл баталгаа, цалин хөлс, урамшил сайжирна;

**6. Цагдаагийн байгууллагын холбоо хяналтын нэгдсэн сүлжээг орчин үеийн мэдээллийн технологи, ололт амжилтад тулгуурлан хөгжүүлнэ.** Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ухаалаг цахимжсан, аюулгүй байдал, албаны нууцлалыг хангасан



**ухаалаг дэд бүтэц, тоног төхөөрөмжтэйгээр үйл ажиллагаа явуулна. Тухайлбал цагдаагийн байгууллагад алба хаагчийг бэлтгэх үе шатлал бүхий сургууль, судалгааны байгууллага, лаборатори, гэмт хэргийн цахим мэдээллийн тогтолцоо, сан бүрдэн үйл ажиллагаа явуулна.**

7. Цагдаагийн алба хаагч шуурхай үйл ажиллагаа явуулах үедээ эдлэх эрх, гүйцэтгэх үүргийг тодорхой болгож, тээврийн хэрэгслийг дайчлах, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тусгай дуут дохио ашиглах зэрэг эрх, үүргийн баталгааг тэнцвэртэй олгоно.

8. Алба хаагчийн хувцас, агсамжийг өөрчлөнө. Өнөөгийн байдлаар цагдаагийн албан хаагч нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх зэвсэг хэрэгслийн хангалт муу, чанар эдэлгээгүй байгаагаас гадна албаны үүргээ гүйцэтгэхэд хүндрэлтэй, ажил мэргэжлийн онцлог, аюулгүй байдлыг хангахгүй байгааг харгалзан үүрэг гүйцэтгэх үедээ гав, бороохой, цахилгаан гүйдлээр цохигч, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, холбооны хэрэгсэл, гар чийдэн, дүрс, дуу бичлэгийн хэрэгсэл зэрэг иж бүрдэл бүхий агсамжаар хангагдаж, биед эвтэй, хууль сахиулагчийн ажлын наад захын стандарт шаардлагыг хангасан хувцас, хэрэгслээр хангагдах боломж бүрдэнэ.

### **5.2.2. Мөрдөх алба буюу гэмт хэрэгтэй тэмцэх шинэтгэл хийх шаардлага**

Мөрдөх алба нь цагдаагийн байгууллага шиг гурван чиг үүрэг байхгүй зөвхөн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийнх нь тодорхой хэсгийг хэрэгжүүлдэг байгууллага. Ийнхүү гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн тодорхой хэсгийг шинэчлэх шаардлага нь нууц далд аргаар үйлдэгддэг, олон хохирогч бүхий, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд цагдаагийн байгууллагын үндсэн арга хэрэгсэл, хүч тохирохгүй байдаг. Мөн цагдаагийн байгууллагын мөрдөн шалгах арга ажиллагаа буюу аливаа үйлдлийг гэмт хэргийн шинжтэй болохыг нотлох арга ажиллагаа нь зарим ноцтой үндэстэн дамнасан зохион байгуулалттай хэрэгт хүчин мөхөсддөг.

Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй хийх тэмцэл нь иргэдийн өргөдөл, гомдолд үндэслэж шалгадаг боловч нөгөө талаасаа иргэдийн өргөдөлд хариу өгөх, иргэдийн өргөдлийг шийдвэрлэх зорлиготой байдаг. Иймд цагдаагийн байгууллагын хууль сахиулах үйл ажиллагаа нь иргэдээс шууд хамааралтай байна. Ийм иргэдийн өргөдөл гомдлоор шалгаж байдаг гэмт хэрэг нь нийт гэмт хэргийн 90 хувийг эзэлж байдаг тул түүнээс хэрхэн яаж урьдчилан сэргийлэх гэх мэт асуудал нь цагдаагийн байгууллагын хууль сахиулах ажиллагаа байна.

Харин мөрдөх албаны хууль сахиулах ажиллагаа нь нууц далд арга хэлбэрээр үйлдэгддэг, үндэстэн дамнасан зохион байгуулалттай, шууд хохирогч байхгүй тул мэдээлэл, судалгаан дээр үндэслэдэг, урьдчилан тагнах арга ажиллагаагаар сэргийлж таслан зогсоодог, нотлох баримтыг цуглуулах буюу бий болох газар нутаг нь нэг хууль тогтоомжийн системд хамаардаггүй, олон улсын нутаг дэвсгэрт үйлдэгдэж байдаг терроризм, цагаан захтны буюу албан тушаалын, хүний наймаа, хар тамхи мансууруулах бодис наймаалах гэх мэт гэмт хэргийг шалгадаг байна.

Мөрдөх алба бол цэвэр хууль сахиулах байгууллага юм. Иргэнд үйлчлэх хэсэг нь маш бага буюу тухайн мөрдөх албаны үйл ажиллагаатай холбоотой гомдол санал гаргаад явах тохиолдолд иргэнд үйлчилдэг байна. Иймд мөрдөх алба нь гэмт хэргийг илрүүлэх, нотлох тусгай арга хэрэгсэл их хэрэглэдэг, эрсдэлтэй үйл ажиллагаа явуулдаг учир нь галт зэвсэг хэрэглэх эртэй байна гэх мэтийн байдлаараа цагдаагийн байгууллагаас ялгаатай байна. Мөн зохион байгуулалттай гэмт хэргийн гэрч хохирогчийг хамгаалах шаардлага цаашдаа зайлшгүй гарч ирнэ. Мөн энэ төрлийн гэмт хэргийг үйлдэж байгаа этгээдүүд нь мөрдөлтийн үйл явцад садаа болох, нөлөөлөх, таслан зогсоохыг оролдох зэрэг нөхцөл байдал үргэлж гарч байдаг тэр нь хор аюултай байдлаар илэрдэг тул хууль сахиулах чиг үүргийн энэ хэсгийг дангаараа хариуцсан бие даасан байгууллага байх хэрэгтэй гэж үзсэн.

### **5.2.3. Маршалын алба байгуулах буюу шүүхийн тасралтгүй үйл ажиллагааг хангах гэрч хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах талаар хийх шинэтгэл хийх шаардлага**

Хууль сахиулах чиг үүргийн бас нэг томоохон хэсгийг шүүхийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах байдаг. Энэ дотроо бас шүүхийн үйл ажиллагааг хэвийн явуулах үүднээс гэрч хохирогчийг хамгаалах ялтанг ял эдлүүлэх байгууллагад хүргэх, шүүхэд авчирах, шүүхийн байрыг хамгаалах гэх мэт чиг үүрэг нь бие даасан байгууллагатай байж шүүхийн тасралтгүй үйл ажиллагаа хэвийн явагддаг. Мэдээж шүүхийн үйл ажиллагааг хэвийн явуулах бусад нөхцлүүд байдаг. Тухайлбал, шүүхийн байрны зохион байгуулалт, төсөв санхүү гэх мэт

нөхцлүүд байдаг боловч тэр нь иргэний буюу захиргааны чиг үүрэгт хамаарах тул хууль сахиулах шинжгүй байна.

Харин шүүхийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлага нөхцөлийг бүрдүүлэхэд хууль сахиулагч оролцох тохиолдолыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байгууллага нь “Маршалын алба” байна. Шүүн таслах ажиллагааг аюулгүй явуулах нөхцөлийг хангаагүй нөхцөлд шүүх хурал хэвийн явахгүй бөгөөд үүний улмаас иргэд шударга шүүхээр шүүлгэх эрх нь зөрчигдөхөд хүрдэг. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд шүүгч шүүхийн аюулгүй байдлыг хангана, шаардлагатай гэвэл улсын яллагчын аюулгүй байдлыг хангаж, гэрч хохирогчийг хамгаалж, яллагдагчийг хуяглан хүргэх, шүүхээс оргон зайлсан ялтанг эрэн сурвалжилах чиг үүргийг гүйцэтгэнэ. Шүүгдэгч, ялтанг хуяглан хүргэх, оргон зайлсан шүүгдэгч ялтанг эрэн сурвалжлах ажиллагаа нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай ажил үүргийн хувьд давхцаж болно.

Гэхдээ маршалын алба нь дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхдээ шүүхийн хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүрэгтэйгээ уялдуулна. Хорихоос оргон зайлсан гэмт хэрэгтнүүдийн бодит заналхийлэл нь ихэнх тохиолдолд хэрэг, маргааныг гэрчилсэн гэрч, хохирогчид, хэргийг шүүсэн шүүгч, яллагчид чиглэсэн байдаг тул энэ чиг үүргийн хүрээнд оргон зайлсан этгээдийг эрэн сурвалжлахад оролцоно. Мөн шүүхийн шатанд буюу хэрэг хянан шийдвэрлэх шатанд оргон зайлсан этгээдүүд нь шүүхийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулж байгаа бол мөн энэхүү чиг үүргийнхээ хүрээнд эрэн сурвалжилж болно.

Зөвхөн оргон зайлах ч биш тухайн ялтан нь ял эдэлж байхад нь маршалын чиг үүргийг хамаарч болно. Өөрөөр хэлбэл хорихоос ялтанг суллагдсан тохиолдолд тухайн хэргийн хохирогч, гэрчид энэ тухай мэдэгдэж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авах зорилгын үүднээс цагдаагийн байгууллага, мөрдөх алба, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд нь уг ялтаны статусын өөрчлөлтийг маршалын албанд мэдэгдэх үүрэгтэй байдаг.

Шүүхээр хэргээ шийдвэрүүлж буй яллагдагч шүүх хуралд ирэхгүй бол шүүх хурлын хэвийн үйл ажиллагаанд саад учруулдаг. Иймд цагдан хоригдож байгаа газраас нь шүүх хурал болох газар авчирах, буцааж хүргэх, гадуур байгаа этгээдүүдийг ирэхгүй тохиолдолд албадан авчирах гэх мэт чиг үүрэг орно.

Маршалын алба нь захиргаанб болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэний хэргийн оролцогчид бүрэн байж хэргийг шийдвэрлэхээр хуульд заасан тохиолдолд тухайн хэргийн оролцогчидоос ирэхгүй байх, шаардлагатай нотлох баримтыг гаргаж өгөхгүй байх зэрэг тохиолдолд оролцох боломжтой байж болно.

#### **5.2.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны шинэтгэл хийх шаардлага**

Маршалын албанд дээрх чиг үүргүүдийг шилжүүлснээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ялтанд хорих ял эдлүүлэх, хорихоос өөр төрлийн ялыг хэрэгжүүлэх, гэмт хэрэгт шалгагдаж байгаа этгээдийг цагдан хорих гэх мэт чиг үүргүүд үлдэж байгаа бөгөөд үүнийг тодорхой стандартад оруулж зохицуулах шаардлагатай. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын иргэний шийдвэр гүйцэтгэх болон ял эдлүүлэх, нийгэмшүүлэх, хорихоос өөр төрлийн ялыг хэрэгжүүлэх үүднээс хууль тогтоомжийн болон үйл ажиллагааны томоохон шинэтгэл хийхээр төлөвлөн ажиллаж байна.

#### **5.2.5. Хил хамгаалах байгууллагын эрх зүйн шинэтгэл хийх шаардлага**

Хил хамгаалах байгууллага нь хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, хилийн дэглэм сахих, хил хамгаалах гэсэн чиг үндсэн гурван үүрэгтэй үүний эхний хоёр нь хууль сахиулах чиг үүрэгт хамаарах бөгөөд үлдсэн нь батлан хамгаалах чиг үүрэгт хамаарна. Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх албаны шинэтгэлтэй уялдуулан хилийн шалган нэвтрүүлэх албаны чиг үүргийг өөрчилнө.

#### **5.2.6. Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх албаны шинэтгэл хийх шаардлага**

Энэ байгууллага нь хууль сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх боловч иргэнд үйлчилгээ үзүүлдэг. Хилийн шалган нэвтрүүлэх үйлчилгээний хэлбэртэй хууль сахиулах шинжтэй байна, Виз олгох, хянах мөн үйлчилгээний хэлбэртэй хууль сахиулах шинжтэй, Иргэний харьяалалын асуудал мөн үйлчилгээний хэлбэртэй хууль сахиулах шинжтэй байна. Энэ байгууллагын чиг үүргийн хүрээнд хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэргүүд илэрч байдаг онцлогтой учраас хууль сахиулах чиглэлээр зарим үйл ажиллагаагаа явуулдаг байх юм. Түүнчлэн татвар гааль гэх мэт байгууллагууд нь иргэний шинж нь давамгалсан мөн хууль

сахиулах чиг үүрэгт хамаарагдана. Энэхүү шинэчлэлээр татвар гаалийн гэх мэт байгууллагад ажиллаж байгаа улсын байцаагчийн хууль сахиулах шинжтэй үйлдлийг хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулахаар оруулж байгаа. Тухайлбал, торгох, тодорхой эд зүйлийг хураах гэх мэт шийдвэрийг гаргахдаа хууль сахиулах чиг үүргээ хэрэгжүүлж байгаа тул хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуульд хамаарагдна.

#### **5.2.7. Онцгой байдалын албаны шинэтгэл хийх шаардлага**

Онцгой байдлын албаны иргэдийг аврах гэх мэт үйл ажиллагаа нь иргэний чиг үүрэгт хамрагдах боловч тодорхой тохиолдолд нотлох баримтыг хадгалах, бусды эд хөрөнгийг хураах, дайчлах гэх мэт тохиолдлуудад хууль сахиулагчийн статустай болно. Эдгээр байгууллага дээр нэмэгдээд Хууль сахиулахын их сургууль мөн хууль сахиулах байгууллагад хамаарагдна. Өөрөөр хэлбэл хууль сахиулах боловсон хүчин бэлтгэх, бэлтгэж байгаа боловсон хүчин нь онцгой тохиолдолд хууль сахиулах зарим үйл ажиллагаанд оролцох тохиолдол байж болно. Мөн багш нар нь хууль сахиулагчид хамаарахаар байна.

## VI. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ<sup>64</sup>

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо нь одоогийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Ерөнхий газар нь дотроо иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх газар, эрүүгийн хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх газар, харьяа хорих байгууллага /25 хорих/, аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба /25 алба, 3 хэсэг/-наас тус тус бүрдэж байна.

2002 оноос хойшхи хугацаанд ШШГЕГ-ын бүтэц, зохион байгуулалтыг 5 удаа шинэчлэн зохион байгуулж, ХЗДХ-ийн сайдын 2002 оны 204, 2007 оны 98, 2009 оны 32, 2010 оны 93, 2012 оны А/10 дугаар тушаалаар тус тус батлуулсан бөгөөд сайдын тушаалыг үндэслэн ШШГЕГ-ын даргын тушаалаар шинэчилсэн бүтэц, зохион байгуулалтын дагуу төв аппаратын зохих албан тушаал, зэрэглэлд шилжүүлэн өнөөдрийн байдлаар төв аппаратад 113 алба хаагч ажиллахаас 103 албан хаагчийг томилжээ.

Судалгааны явцад алба хаагчдаас авсан санал асуулгын дүнг нэгтгэн үзвэл: ШШГБ-ын одоогийн тогтолцоог хэрхэн дүгнэж байгаа талаарх санал асуулгын дүнгээр 46.7% нь “одоогийн тогтолцоо болж байна гэхдээ сайжруулах шаардлагатай”, 28.9% нь “одоогийн тогтолцоог өөрчлөх шаардлагатай”, 10.5% нь “өөрчлөх шаардлагагүй”, 10.5% нь “хэлж мэдэхгүй байна” гэжээ. Нийтлэг хандлагыг харвал дийлэнх нь одоо байгаа тогтолцоог өөрчилж сайжруулах шаардлагатай гэж үзсэн байна. График 1-ийг үзнэ үү.

**График 1.**




**Хүснэгт 1.**

| Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын одоогийн тогтолцоог Та хэрхэн дүгнэх вэ? |  |         |      |
|---|--|---------|------|
|   |  | Тоололт | Хувь |
| 1   | Өөрчлөх шаардлагагүй   | 25      | 10.5 |
| 2   | Одоогийн тогтолцоо болж байна гэхдээ сайжруулах шаардлагатай | 111     | 46.7 |
| 3   | Одоогийн тогтолцоог өөрчлөх шаардлагатай                     | 68      | 28.9 |
| 4   | Хэлж мэдэхгүй байна  | 33      | 13.9 |
| 5   | Нийт   | 237     | 100  |

Хорих ялыг гүйцэтгэх Тогтоол гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, төрөл, дэглэмийн ялгааг хуульчилсан өнөөгийн байдлыг хэрхэн дүгнэсэн талаарх санал асуулгын дүнгээр 41.5% нь “одоогийн тогтолцоо болж байна, гэхдээ сайжруулах шаардлагатай”, 36% нь “одоогийн тогтолцоог өөрчлөх шаардлагатай”, 15% нь “одоогийн тогтолцоо болж байна, өөрчлөх шаардлагагүй”, 7.5% нь “хэлж мэдэхгүй” гэж хариулжээ. Судалгаанд оролцогчдын нийтлэг хандлага “өөрчилж сайжруулах шаардлагатай” гэж хариулжээ. График 2-ыг үзнэ үү.

## График 2.



| Хорих ялыг гүйцэтгэх Тогтоол гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, төрөл, дэглэмийн ялгааг хуульчилсан өнөөгийн байдлыг Та хэрхэн дүгнэх вэ? |   |         |      |
|--|---|---------|------|
|  |   | Тоололт | Хувь |
| 1  | Одоогийн тогтолцоо болж байна өөрчлөх шаардлагагүй            | 36      | 15   |
| 2  | Одоогийн тогтолцоо болж байна, гэхдээ сайжруулах шаардлагатай | 99      | 41.5 |
| 3  | Одоогийн тогтолцоог өөрчлөх шаардлагатай                      | 86      | 36   |
| 4  | Хэлж мэдэхгүй байна.  | 18      | 7.5  |
| 5  | Нийт  | 239     | 100  |

## Хүснэгт 2.

Улсын хэмжээнд төвлөрсөн цөөн хорих ял эдлүүлэх байгууллагатай болох нь гэсэн асуулганд 46.6% нь “зөв бодлого, дэмжиж байна”, 22.7% нь “хуульд заасан ялын биелэлтийг хангах зарчимд харшилна”, 18.5% нь “буруу бодлого, дэмжихгүй байна”, 12.2% нь “хэлж мэдэхгүй байна” гэжээ. Үүнээс харахад Улсын хэмжээнд төвлөрсөн цөөн хорих ял эдлүүлэх байгууллагатай болохыг дэмжиж, одоо байгаа тогтолцоог сайжруулах шаардлагатай гэсэн хандлага давамгайлжээ. График 3-ыг үзнэ үү.

## График 3.



## Хүснэгт 3.

| Улсын хэмжээнд төвлөрсөн цөөн хорих ял эдлүүлэх байгууллагатай болох нь? |  |         |      |
|--|--|---------|------|
|  |  | Тоололт | Хувь |
| 1  | Зөв бодлого, дэмжиж байна  | 111     | 46.6 |
| 2  | Хорих байгууллага нь зарим хөдөлмөр-хүмүүжлийн боловсрол, эрүүл мэндийн байгууллага болдог онцлогтой тул хуульд заасан ялын биелэлтийг хангах зарчимд харшилна | 54      | 22.7 |
| 3  | Буруу бодлого, дэмжихгүй байна   | 44      | 18.5 |
| 4  | Хэлж мэдэхгүй байна.   | 29      | 12.2 |
| 5  | Нийт   | 238     | 100  |

**Албадан ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх:**

2002-2012 оны байдлаар албадан ажил хийлгэх ял шийтгүүлсэн 1124257 цагийн 4106 ялтанд холбогдох ял эдлүүлэх ажиллагааг зохион байгуулж, 4072 ялтны шийтгэх тогтоолд заасан ялыг /цаг/ бүрэн эдлүүлж, өнөөдрийн байдлаар 6926 цагийн 34 ялтны ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавин ажиллаж, ялын бодит биелэлт 94.0 хувьтай байна.

Албадан ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагааг аймаг, нийслэлийн Засаг даргатай ялтныг ажлын байраар хангах гэрээг шийдвэр гүйцэтгэх алба, ажил олгогчтой шийдвэр гүйцэтгэгч тус тус гэрээ байгуулан 2002-2012 оны байдлаар нийт 4106 ялтныг ажлын байраар хангуулж, ял эдлэх ажиллагаанд хяналт тавин ажиллажээ. 2002-2012 оны байдлаар албадан ажил хийлгэх ял эдлэлтийг биелэлтийг харьцуулахад: 2006-2007 онд 0.6, 2007-2008 онд 3.0, 2009-2010 онд 1.1 хувиар тус тус буурсан, 2002-2003 онд 16.6, 2003-2004 онд 3.5, 2004-2005 онд 8.6, 2005-2006 онд 3.6, 2008-2009 онд 3.6, 2011-2012 онд 0.4 хувиар тус тус өссөн үзүүлэлтэй байна.

**Шүүхийн зарим төрлийн шийдвэрийг бусад байгууллагаас гүйцэтгэх үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, энэ талаар нэгдсэн тоо бүртгэл хөтөлж, хяналт тавих:**

ШГГ-аас хийсэн ажил, авсан арга хэмжээ, үр дүн тодорхойгүй, танилцуулга, тайланд энэ талаар бичээгүй байгааг анхаарч дээрх заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй.

**Хорих ял эдэлж буй төлбөр төлөгчийн** биелүүлбэл зохих **1305** гүйцэтгэх баримт бичгийн **1963671,1** мянган төгрөгийн төлбөрөөс **467** гүйцэтгэх баримт бичгийн **548207,2** мянган төгрөгийн төлбөрийг бодитой биелүүлсэн, **838** гүйцэтгэх баримт бичгийн **1415463,9** мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаад тус газар дүгнэлт хийж эдгээр 4 төрлийн гүйцэтгэх баримт бичиг, мөнгөн төлбөрийг барагдуулах талаар санаачилгатай, Санхүү, аж ахуйн газар болон, ялтныг ажлын тогтмол байраар хангаж байгаа хорих ангийн удирдлагуудтай нягт хамтран ажиллах шаардлагатай байна.

Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд төвлөрсөн хорих анги 25, үүнээс гяндан нэг, онцгой дэглэмтэй хорих анги нэг, чанга дэглэмтэй хорих анги 11, жирийн дэглэмтэй хорих анги 11, Баривчлах ял эдлүүлэх анги 1, баривчлах ял эдлүүлэх байр 13, Цагдан хорих анги 1, баривчлах цагдан хорих байр 25, цагдан хорих хэсэг 2, Гадаадын иргэдийг албадан саатуулах байр нэг ажиллаж хуульд заасан чиг үүргийг тус тус хэрэгжүүлэн ажиллаж ШШГЕГ, ТГГ-аас зохион байгуулалт, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж байна.

Прокурорын байгууллагын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу улс, нийслэл, дүүргийн прокурорын байгууллагаас ШШГЕГ-ын харъяа хорих болон баривчлах, цагдан хорих байранд гарсан гэмт хэрэг, зөрчил, хорих байрны ахуй нөхцөл, хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж, хууль зөрчсөн ажиллагааг засуулах, арилгах, дахин давтан гаргуулахгүй байх, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцуулж, хорих байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор хугацаатай шаардлагыг өгч, биелэлтэд хяналт тавьж ажиллаж иржээ.

Прокурорын байгууллагаас 2012 онд хийсэн шалгалт, түүний мөрөөр өгсөн шаардлагыг нийтэд нь судлан үзвэл ШШГЕГ-ын харъяа хорих анги, эмнэлэг, эмч нарын үйл ажиллагаанд шууд холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажил хангалтгүй байна. Хууль хэрэгжиж эхэлсэн хойших хугацаанд Тогтоол гүйцэтгэх ажлын чиглэлээр ХЗДХС-ын 2002 оны 25 дугаар тушаалаар “Шүүхээр ял шийтгүүлсэн хүмүүсийн тухай мэдээллийг хүргүүлэх журам”, 2002 оны 270 дугаар тушаалаар “Сахилгын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл журам”, 2002 оны 275 дугаар тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2002 оны хамтарсан 313/316 дугаар тушаалаар “Ялаас чөлөөлөх өвчний жагсаалт, хүнд өвчтэй ялтанд эмнэлгийн бусад байгууллагын тусалцаа үзүүлэх журам” зэрэг 10 гаруй, ШШГЕГ-ын даргын 2008 оны А/115 дугаар тушаалаар “Ялтныг мэргэжлийн түр сургалтад хамруулах, шалгалт авах, мэргэжлийн чадамжийн гэрчилгээ олгох журам”, 2009 оны А/11 дүгээр тушаалаар “Чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гяндангийн болон цагдан хорих төвийн гадна хамгаалалтыг зохион байгуулах журам”, 2009 оны А/12 дугаар тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шуурхай удирдлагын бүлгийн ажиллах журам”, зэрэг ШШГЕГ-ын даргын


баталсан 15 тушаал шийдвэрийг батлуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

**Баривчлах болон хорих ялыг албадан эдлүүлэх:**

Баривчлах болон хорих ялыг албадан эдлүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллажээ. Үүнд: 2002 оноос 2012 оны 10 дугаар сарын байдлаар баривчлах ял эдэлж байсан 1869, хорих ялтай 66228 ялтныг холбогдох хууль журам, тогтоосон цагийн хуваарь, зохих дэглэмийн дагуу хорих ялыг албадан эдлүүлж, иргэн, нийгэмд учруулсан хохирол, төлбөрийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллажээ.

Төлбөртэй нийт 2834 ялтан 91.237.922.2 мянган төгрөгний төлбөр төлөхөөс 490 ялтан 4.425.166.8 мянган төгрөгийн төлбөр төлсөн, 2344 ялтны 86.812.755.4 мянган төгрөгний төлбөр төлөгдөөгүй байна. “Ялтны хөдөлмөр хийсэн хөлс”-ийг ялтан нэг бүрт олгох, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, иргэн, нийгэмд учруулсан хохирол, төлбөрийг барагдуулах чиглэлээр судалгаа хийж, тодорхой ажлыг үр дүнтэй зохион байгуулан ажиллахаар төлөвлөж байна. 2002 оноос 2012 оны эхний 10 дугаар сарын байдлаар хорих болон баривчлах ял эдэлж байсан ялтны судалгааг график 1-ээс үзнэ үү.


**График 1.**



2002 онд оргосон 73 ялтнаас 68 ялтныг, 2003 онд оргосон 68 ялтнаас 56 ялтныг, 2004 онд оргосон 49 ялтнаас 26 ялтныг, 2005 онд оргосон 40 ялтнаас 30 ялтныг, 2006 онд оргосон 35 ялтнаас 31 ялтныг, 2007 онд оргосон 18 ялтнаас 16 ялтныг, 2008 онд оргосон 10, 2009 онд оргосон 14, 2010 онд оргосон 10, 2011 онд оргосон 12, 2012 онд оргосон 15 ялтныг эрэн сурвалжлах ажиллагааг шуурхай үр дүнтэй явуулж олж баривчилж албадан ял эдлүүлсэн байна.

Эхний 5 жилд оргох гэмт хэрэг үйлдсэн ялтны тоог сүүлийн 5 жил 10 сарын байдалтай харьцуулахад 186-аар буюу 70.2 хувиар буурсан үзүүлэлт гарч байна. Урьд онд оргоод баригдаагүй ялтан 2002 онд 14, 2003 онд 19, 2004 онд 35, 2005 онд 29, 2006 онд 30, 2007 онд 24, 2008 онд 21, 2009 онд 17, 2010 онд 16, 2011 онд 10 байсан бол 2012 оны 10 сарын байдлаар 4 ялтан байна. График 2-ыг үзнэ үү.

**График 2.**



ШШГЕГ-ын харьяа Баривчлах 431 дүгээр анги ЗГ-ын 2002 оны 155 дугаар тогтоол, ШШГЕГ-ын даргын 2002 оны А/93 тоот тушаалаар 16 нэгж орон тоотой байгуулагдаж 10 жилийн хугацаанд Эрүүгийн хуульд 51 дүгээр зүйлд заасан "Баривчлах ял"-ыг биечлэн эдлүүлэх, хүмүүжлийн нөлөөлөл үзүүлэх, улмаар дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, ялын зорилгыг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн явуулж, Улаанбаатар хотын дүүргүүд, Төв, Дорноговь, Говьсүмбэр аймгийн баривчлах ялтай этгээдийн ял/1-6 хүртэл сар/-ыг эдлүүлж байна.

2012 онд 39 нэгж орон тоотой 259,062,0 сая төгрөгний төсөвтэй батлагдсанаас 38 албан хаагч 90-110 ялтны дунд удирдлага зохион байгуулалт, харуул хамгаалалт, санхүү аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Эрүүгийн хуулийн 51 дүгээр зүйлд "... гэмтхэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой дэглэм бүхий байранд ганцаарчлан байлгахыг баривчлах ял" гэж заасан нь баривчлах ялын онцлогийг заажээ. Мөн ШШГЕГ-ын даргын 2009 оны А/48 дугаар тушаар баталсан "Баривчлах ял эдлүүлэх байрны дотоод журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1-д "баривчлах ял эдлүүлэх байранд ялтныг ганцаарчлан байрлуулна" гэж заалтын биелэлттэй танилцахад одоогийн байдлаар тус ангид ганцаарчлан хорих 6 өрөө байгаа нь журамд заасан ялтныг ганцаарчлан хорих нөхцөлийг хангахгүй байна.<sup>65</sup>


*Баривчлах 431 дүгээр ангийн дарга, дэд хурандаа Ч.Энхбаатартай хийсэн ярилцлагаас: Ялтныг ганцаарчлан хорих заалттай. Үүнийг хангах 6 өрөө байгаа бөгөөд ямар ялтныг ганцаарчлан байлгах вэ гэдэг асуудлыг үүсдэг. Нөгөө талаас ганцаарчлан хорих нь хүмүүжлийн нөлөөлөл үзүүлэхээсээ илүү улам "жожиг" болох зэргээр сэтгэл зүйд нь сөргөөр нөлөөлж болзошгүй байдаг. Мөн баривчлах ялтай этгээд хөдөлмөр эрхэлдэггүйтэй уялдаж элдэв хэл ам их гардаг. Дулааны улиралд ангийн гадна тохижилтын ажилд ялтнуудыг дайчилдаг.*

Баривчлах ялтай этгээдээр хөдөлмөр эрхлүүлэх заалт байдаггүй бөгөөд ШШГЕГ-ын даргын 2009 оны А/48 дугаар тушаалаар баталсан "Баривчлах ял эдлүүлэх байрны дотоод журмын 10.1-д "баривчлах, ял эдлүүлэх байрны цэвэрлэгээ, үйлчилгээ, тохижилтын ажилд ялтныг түр хугацаагаар ажиллуулж болно" гэсэн заалтыг мөрдөж байна.

Энэ ангид хоригдож буй ялтнуудаас авсан судалгаагаар 80.2% нь ял эдлэх хугацаанд ажил хөдөлмөр эрхлэх хүсэлтэй, 15.4% нь хөдөлмөр эрхлэх хүсэлгүй гэж хариулжээ. График 4-ийг үзнэ үү.



График 4.



Үүнээс үзвэл баривчлах ял эдэлж буй этгээдийг ажил хөдөлмөр хийлгэх шаардлага байна.

**Гэмт хэрэг үйлдсэний улмаас иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирол, төлбөрийг ялтны хөдөлмөрийн хөлснөөс суутгаж хохирогчид шилжүүлэх:**

ШШГЕГ-ын даргын 2010 оны А/92 тоот тушаалаар баталсан “Ялтны хөдөлмөрийн норм норматив тогтоох болон цалин хөлс тодорхойлох журам”-ын дагуу 2010 оноос эхлэн ялтны хөдөлмөрийн хөлсийг шинэчлэн бодож, гэмт хэрэг үйлдсэний улмаас иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирол, төлбөрийг ялтны хөдөлмөрийн хөлснөөс суутгаж хохирогчид шилжүүлж ажиллаж ирсэн. Үүнд: 2005-2009 онд 1753 ялтны 1,384,6 мянган төгрөг, **2010** онд 316 ялтны 476,3 сая төгрөг, 2011 онд 457 ялтны 799,8 сая төгрөг, **2012** онд 413 ялтны 429,9 сая төгрөгийн төлбөр бүрэн төлөгдөж баталгаажилт хийгджээ.

Хорих ялтны тоо өсөж өнөөгийн хүчин надлаар тэдэнд хяналтыг бүрэн тавьж чадахгүй байгаа нөхцөлд хорих ангиуд ялтны тоог цөөлөх талаар “санаачлагатай” ажиллаж эхэлсний илрэл нь ялтныг хугацаанаас нь өмнө тэнсэн суллах санал, тодорхойлолтыг гар татахгүй гаргаж, шүүхэд шилжүүлдэг болсон байна. Сүүлийн 3 жилийн байдлаар жилд дунджаар 2245 ялтныг шүүхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллаж шийдвэрлэжээ.

Хорих ял эдэлж байгаа ялтныг ажлын байраар хангаж, хөдөлмөр хийлгэх нөхцөлийг бий болгох нь шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлын нэг болоод байна. Хуульд зааснаар ялтныг гэмт хэрэг үйлдсэний улмаас иргэд, байгууллагад учруулсан хохирлыг ажил хийлгэж олсон орлогоос нөхөн төлүүлэх учиртай. Нийт хорих ялтны 40-60 хувь нь хөдөлмөр хийж байгаа гэх хэдий ч үнэн хэрэгтээ бусад аж ахуй нэгжид хөдөлмөр хөлсний бага үнэлгээтэй буюу эсхүл хорих ангийн өөрийн бүсэд ажил хийж байгаа ялтнуудыг хамруулсан байна.

2005 оны байдлаар 3464 ялтны 7.8 тэрбум төгрөгийн хохирол нөхөн төлөгдөхөөс 273 ялтны 635000 төгрөгийн буюу нийт төлбөрийн 8.1 хувь төлөгдсөн нь маш бага үзүүлэлт юм.

Шалтгааныг судлахад улсын хэмжээнд жилд дунджаар 12000 ял эдэлж байгаагийн ердөө 50 хувь буюу 6500 ялтны ял эдлүүлэхэд хүрэлцэх хэмжээний мөнгийг төрөөс санхүүжүүлж байгаагаас ялтны хөдөлмөрийн хөлсний орлогын зонхилох хувийг хорих ангиудын үйл ажиллагаанд зарцуулж ирсэн байна. Байдал ийм байхад ялтны хөдөлмөр хөлсний орлогоос иргэд, байгууллагад учруулсан хохирлыг төлүүлэх ажиллагаа ямар түвшинд байх нь ойлгомжтой юм.

Хорих ялын хэрэгжилтийн явцад тулгамдсан хүндрэл бэрхшээл, тулгамдсан олон асуудлыг нэг мөр болгох талаар хууль хяналтын байгууллагууд дорвитой ажил зохиож, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал, төслийг боловсруулж бэлэн болгосон ч Улсын их хурал, Засгийн газар одоог хүртэл шуурхай хэлэлцэж, шийдвэрлэхгүй хойш тавьж байгаа нь эцсийн дүнд төрийн ялын бодлого алдагдаж хууль зөрчих зохисгүй хандлагыг газар авахуулахад тодорхой байдлаар нөлөөлж байна.<sup>66</sup>

### 6.1. Ялын хэрэгжилт

Монголд ял шийтгэлийн хэрэгжилтийн тоон үзүүлэлт сайн боловч чанар, үр дүнгийн хувьд анхаарах асуудал байсаар байгаа билээ. Ял. шийтгэлийн гүйцэтгэлийг хангах нөхцөл, хорих, цагдан хорих, баривчлах ял эдлүүлж буй нөхцөл, байрыг сайжруулан дэлхийн жишигт нийцүүлэх шаардлага тулгарч байна.

Ялтны эрхийг зөрчдөг. эрүүл ахуй. ариун цэврийн шаардлага хангахгүй нөхцөлд ял эдлүүлдэг явдал ч хэвээр байсаар байна. Ялтныг цээрлүүлэх болон нийгэмшүүлэх эрх зүйн

орчин тогтоогүй, ялтныг ямар арга хэрэгслээр цээрлүүлэх, нийгэмд хууль дүрмийг мөрдөж амьдрах чадвартай болгож бэлтгэх талаар стандарт, дүрэм, журам, арга зүй байхгүй байна.

Одоогийн дагаж мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд хорих ял эдлүүлэх дэглэм нь зөвхөн эргэлт, уулзалтын тоо, хүлээн авах болон илгээх захидал илгээмж, утсаар ярих эрхээр хязгаарлагдаж байна. Харин жирийн чанга, онцгой дэглэмтэй хорих анги болон гянданд ял эдлүүлэхэд ямар нөхцөл, дэглэмийн ялгаа байх нь хуульчлагдаагүй байна.

Шийтгэх тогтоолыг биелүүлэх хутацаа өнгөрсөн гэх үндэслэлээр торгох ялыг биелүүлэхгүй ял завшуулах, албадан ажил хийлгэх, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ялын хувьд ч ял завших явдал түгээмэл байна. Монгол Улсын Эрүүгийн хуулийн ялын бодлого, ялангуяа хорих ялын бодлого ха-туу чанга гэсэн шүүмжлэл дагуулдаг. Орчин үеийн иргэншсэн, эдийн засаг, зах зээл хөгжсөн нийгэмд хорих ялын бодлогыг дахин авч үзэх, хорихоос өөр төрлийн ялын бодлого барих нь нийгэмд ач холбогдолтой байдаг.

Салбар хуралдаанаас дээрх тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлохын зэрэгцээ хорих ангийн үйл ажиллагааны стандартыг бий болгох, мөрдүүлэх, ялтны эрхийг хамгаалах, хорихоос суллагдсан этгээдийг нийгэмшүүлэх, ялын мэдээллийн сан, хяналт, мониторингийн асуудлыг хөндөн ярилцаж, санал зөвлөмж гаргалаа.<sup>67</sup>

## **6.2. Хорихоос өөр төрлийн ялын үр нөлөөг дээшлүүлэх**

### ***а/ Торгох ялын талаар:***

Монгол Улсын хэмжээнд 2011 оны 3 дугаар сарын 29-ны байдлаар гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь тогтоогдсон 187 хүнд 1 221 217 900 (нэг тэрбум хоёр зуун хорин нэг сая хоёр зуун арван долоо мянга есөн зуу) төгрөгийн торгох ялыг шүүхээс оногдуулаад байна.

Гэтэл энэ ялын дөнгөж 14.4 хувь буюу 85 328 200 төгрөгийн торгох ял биелэгдэж, үлдсэн 1 135 889 700 төгрөгийн торгох ял биелэгдээгүй байна. Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх хэсэгт заасан хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн боловч гурван жил өнгөрсөн бол ялтны үндсэн ба нэмэгдэл ялыг эдлүүлж болохгүй, мөн хуулийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсэгт заасан торгох ялаас зөвхөн ноцтойгоор зайлсхийсэн бол хорих ялаар сольж болох тухай зохицуулалтууд нь ялтанд ял завших үндэс суурийг бий болгож болзошгүй байна.

Дээрх заалтууд нь Эрүүгийн хуулийн 9 дүгээр зүйлд заасан "Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх" болон хууль дээдлэх шударга ёсны зарчмыг алдагдуулж шүүх эрх мэдлийн нэр хүндэд сөргөөр нөлөөлж иргэдийн дунд "Торгох ялыг биелүүлэхгүй байж болно, торгуулийг бага багаар төлж 3 жилийн хугацааг нь дуусгаад ялаас чөлөөлөгдөнө" гэх сөрөг хандлага тогтоож байна. Түүнчлэн торгох ялыг биелүүлэх боломжгүй, амьдралын хүнд нөхцөлтэй, орлогогүй хүмүүст оногдуулснаас биелэгдэхгүй байгааг ч үгүйсгэхгүй байна.

Ялтан шүүхээс оногдуулсан торгох ялыг тогтоосон хугацаанд бүрэн төлж барагдуулах ёстой бөгөөд торгуулийг бага хэмжээгээр төлсөн, торгууль төлөхгүйгээр хууль сахиулагчийн дуудсан цагт ирсэн зэрэг нь ял эдэлж байгаа хэрэг биш бөгөөд төрийн албадлагын арга хэмжээ болох торгох ялыг ялтны хүсэл сонирхолд захирагдалгүй нэг мөр хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзнэ.

Торгох ялын хэрэгжилтийн өнөөгийн байдал, ийм төрлийн ял эддэхээс зайлсхийсэн этгээдэд хариуцлага хүлээлгэдэг бусад орны жишгийг харгалзан "торгуулийг бүрэн төлж барагдуулаагүй бол" торгох ялаас зайлсхийсэнд тооцож хорих ялаар сольдог, шүүхийн шийдвэр гарцаагүй хэрэгждэг байх ёстой гэж дүгнэж байна.

Иймд торгох ялаар шийтгүүлсэн этгээд оногдуулсан ялыг биелүүлэхгүй ял завшиж, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмыг алдагдуулж байгааг таслан зогсоох зорилгоор "торгох ялыг биелүүлээгүй тохиолдолд шүүх үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээнд тохируулан баривчлах, хорих ялаар солих" гэсэн нэмэлт, өөрчлөлтийг Эрүүгийн хуульд тусгах.

### ***б/Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялын талаар:***

Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ялын талаарх мэдээллийн нэгдсэн сан байхгүй учраас улсын хэмжээнд хичнээн ялтан энэхүү нэмэгдэл ялаар шийтгүүлсэн тоо, баримт гаргах, нэг мөр хяналт тавих боломжгүй байна.

Иймд дээрх ялаар шийтгүүлсэн ялтанд тавих хяналтыг боловсронгуй болгож, мэдээллийн нэгдсэн сантай болгох шаардлагатай байх тул шүүхээс оногдуулсан<sup>68</sup>тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ялын биелэлтийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд бүрэн хариуцуулж, энэ төрлийн ялын биелэлтийг хангах, хяналт тавих нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх.

#### **в/Албадан ажил хийлгэх ялын талаар**

Улсын хэмжээнд 2011 оны байдлаар шүүхээс 136 хүн 40681 цагийн албадан ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн бөгөөд үүнээс 82 ялтны ял буюу 60.3 хувь нь биелэгджээ. Энэхүү ял бүрэн хэрэгжиж биелэгдэхгүй байгаа нь ШШГТХуулийн 96 дугаар зүйлийн 96.4 дэх хэсэгт заасан" Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ялтныг албадан ажил хийлгэх, ажил олгох, ажлын байраар хангах үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй" гэсэн хуулийн заалтын хэрэгжилт хангалтгүй байгаатай холбоотой байна. Иймд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар дээрх Үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын асуудлыг хуульд тусгах, түүнд тавих хяналтыг сайжруулах.

### **6.3. Баривчлах ялын үр нөлөөг дээшлүүлэх талаар:**

Гэмт хэрэг үйддсэн этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой дэглэм бүхий байранд ганцаарчлан байлгах тухай Эрүүгийн хуульд заасан шаардлагад нийцүүлэн баривчлах ял эддүүлэх байр байгуулах үүргээ Засгийн газар биелүүлэхгүй 10 дахь жилийнхээ нүүрийг үзэх гэж байна. Үүний улмаас баривчлах ялаар шийтгэгдсэн 4-1 Оялтан хамт байрлаж гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс удаан хугацаанд тусгаарлаж шоронгийн хэв маягт дасгахгүй, бие биедээ сөргөөр нөлөөлж зан төлөвийг нь эвдэхгүйгээр цээрлүүлэх ялын бодлого алдагдаж байна.

Өөрөөр хэлбэл баривчлах ял хуульд заасан нөхцөл журмын дагуу хэрэгжихгүй байгаа шалтгаан нь санхүүгийн асуудалтай шууд холбоотой байна. Иймд Эрүүгийн хуулийн агуулгад нийцсэн баривчлах ял эдлүүлэх байр байгуулахад шаардлагатай санхүүжилтийг нэн даруй хийж, тухайн ялыг эдлүүлэх орчин, нөхцөл, дэглэм, бусад ставдартыг боловсруулж мөрдөх.

### **6.4. Хорих ялын үр нөлөөг дээшлүүлэх талаар:**

Өнгөрсөн хугацаанд хорих ял эддүүлэх ангиудад гарсан ялтан "шалтгаангүй" нас бардаг, тураалд ордог, хүнд өвчин тусдаг явдал үндсэндээ арилж тодорхой хэмжээгээр ахиц гарсан боловч ялтны эрхийг ноцтой зөрчдөг, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангахгүй нөхцөлд ял эдлүүлдэг явдал хэвээр байсаар байна.

Хамгийн ноцтой асуудал нь ялтныг цээрлүүлэх болон нийгэмшүүлэх эрх зүйн орчин тогтоогүй энэ талаар нэгдсэн ставдарт, дүрэм, журам , арга зүй боловсруулагдаагүй байна. Иймд хорих ялын үр нөлөөг дээшлүүлэх үүднээс

- Хорих ялыг жирийн, чанга, онцгой дэглэм болон гянданд эдлүүлж буй өнөөгийн тогтолцоог дэлхий нийтийн жишигт нийцүүлэн нээлттэй, хаалттай хорих ангийн тогтолцоонд нэн даруй шилжүүлэх;

- Хорих ялын цээрлүүлэх агуулгыг шинэчилж, хорих байгууллагад мөрдөх дэгжурам,хориг, хязгаар, албадлагын арга хэрэгслээс гадуур хуулиар зөвшөөрөөгүй арга зам болон аливаа хэлбэрээр ялтны эрх чөлөөнд хууль бусаар халдах явдлыг таслан зогсоож, хорих байгууллагад явагдах бүх төрлийн үйл ажиллагааг стандартчилах;

- Хорих ял эдлүүлэх ажиллагааг олон улсын эрх зүйн баримт бичигтэй нийцүүлэн боловсронгуй болгож, ял эдлүүлэх нөхцөл, дэглэмийн стандартыг баталж мөрдүүлэх

- Хорих ангид хяналтын үр нөлөөтэй, хэмнэлттэй систем, тухайлбал, хяналтын ажлын шаарддага бүрэн хангахуйц телекамерийн хяналтыг бүрэн нэвтрүүлэх;

- Хорих байгууллагад ялтны эрх чөлөөнд халдсан үйлдлийг эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт тооцох, өөрөөр хэлбэл, "шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын албан хаагч хууль бус шаардлага тавин эрүүл шүүлт тулгасан" үйлдэлд эрүүгийн хариуцдага хүлээлгэдэг болох;

- Хорих ялын үр нөлөөг дээшлүүлэхтэй уялдуулан ялтныг нийгэмшүүлэхэд тавих хяналт, хэрэгжүүлэх арга замыг стандартчилах<sup>69</sup>

- Тогтоол гүйцэтгэх байгууллагын тогтолцоог улсын хэмжээнд төвлөрсөн цөөн хорих байгууллагатай болохыг зөв бодлого гэж үзэн дэмжсэн нь Шинэчлэлийн Засгийн газрын

баримталж буй бодлогыг ерөнхийд нь дэмжиж байгааг илтгэж байна. Гэхдээ ялын биелэлтийг хангах зарчим буюу ял эдэлж буй этгээдийн онцлог, дэглэмийн ялгааг онцгой анхаарах ёстой гэж санал асуулгад тусгажээ.

- ШШГТХ хэрэгжээд 10 гаруй жил өнгөрч зохицуулж байсан нийгмийн харилцаанд ихээхэн өөрчлөлт гарсантай уялдуулж энэ хуультай нийцүүлэн гаргасан тушаал, шийдвэр, заавар, журмыг шинэчлэх шаардлагатайн дээр шинэчлэн найруулсан хуулийн төслийг системийн хэмжээнд ажиллаж байгаа нийт албан хаагчдад хүргүүлж, хэлэлцүүлэг зохион байгуулах.

- Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулгад баривчлах ялыг өөрчилж ялын өөр төрлийг шинээр болон шинэчлэн томъёолсонтой санал нэгтэй байна. Хорих ангийн төрөл дэглэмийг нээлттэй болон хаалттай тогтолцоонд шилжүүлэх тухай заалтыг Эрүүгийн хуулийн болон ШШГТХ-ийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах.


## 6.5. Хорихоос суллагдсан хүмүүст чиглэсэн бодлого, нөхцөл байдал

**Нөхцөл байдал.** Монгол Улсад сүүлийн 10 жилийн дунджаар жилд 7272хүн хорих ял эдэлдэг. Практик алба хаагчдийн хийсэн судалгааны дүнгээс<sup>70</sup> үзэхэд жилдээ хорих байгууллагаар дамжиж байгаа хүмүүсийн тоо 12000 байдаг.<sup>71</sup>

/Prison Brief for Mongolia<sup>72</sup>/

|  |   |
|--|---|
| <i>Шоронд байгаа хүний тоо<br/>/цагдан хоригдож байгааг<br/>орсон/</i>   | <b>7,265</b><br>2010 оны байдлаар   |
| <i>Ял эдэлж байгаа хоригдлын<br/>дундаж тоо<br/>(100.000 хүн тутамд)</i> | <b>269</b><br>/2.7 сая хүн амтай/ дэлхийд 216 улсаас 44-т<br>жагсаж байна.  |
| <i>Эмэгтэй хоригдол<br/>(нийт хоригдлын дунд эзлэх<br/>хувийн жин/</i>   | <b>6.2%</b>   |
| <i>Хүүхэд<br/>(нийт хоригдлын дунд эзлэх<br/>хувийн жин/</i>             | <b>1.0%</b><br>(18 наснаас доош)  |
| <i>Хорих газар</i>   | <b>62</b><br>(25 хорих ял эдлүүлэх газар, 26 цагдан хорих төв,<br>11 баривчлах байр)  |
| <i>Хорих ял эдэлсэн байдал</i>   | 1993 - <b>6,085- (270)</b><br>1996- <b>6,070- (265)</b><br>1999 <b>6,414- (271)</b><br>2002 <b>7,256 -(296)</b><br>2005 <b>6,998- (274)</b><br>2008 <b>7,570- (287)</b> |

2000-2010 онд Улсын хэмжээнд нийт 40119 хүн шоронгоос суллагдсан байна. Энэ нь жилд дунджаар 3647 хүн шоронгоос суллагдсан байна гэсэн үг.




2000-2010 онд урьд ял шийтгэгдсэн 19000 хүн дахин гэмт хэрэг үйлджээ.<sup>73</sup> Энэ ньсүүлийн арван жмийн дунджаар шоронгоос суллагдсан хүмүүсийн 47% нь ахин гэмт хэрэг үйлдэж хуулийн байгууллагад шалгагдсаныг харуулж байна.

Цагдаагийн байгууллагаас тавьж байгаа захиргааны хяналт нь сард нэг удаа дуудаж, бүртгэх хэлбэртэй байгаа ба цагдаагийн байгууллагын хэсгийн төлөөлөгч, байцаагчаас ч тэр, хяналтад байгаа хүмүүсээс ч энэ арга хэмжээ үр дүнд хүрэхгүй байгааг ярьж байна.<sup>74</sup> Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй, шоронгоос суллагдагсадад тавих хараа хяналт дутсан гэж үзээд хяналтыг хүчтэй болгож тэдэнд чиглэсэн бодитой туслалцаа, дэмжлэг үзүүлдэггүй.

Өршөөл үзүүлэх тухай хуулиар хорихоос суллагдаад харих мөнгөгүйн улмаас дахин хулгай хийсэн нэгэн залуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярихдаа *"Би тэгээд харих мөнгөөгүй яах байсан юм. Ахиад тэнд чинь очъё"* гэсэн.

Булган аймгийн Тэшиг суманд гэртээ үлдсэн охиныг хүчиндэн, улмаар амь насыг хөнөөн, нууранд хаясан хэргийг Өршөөл үзүүлэх тухай хуулиар суллагдсан 20 настай Т гэгч үйлджээ. Тулга нь 2002 онд хулгайн хэргээр шоронд ял эдлээд суллагдсаны дараагаар дээрмийн хэрэг хэрэг үйлдэж мөн л хорих ял шийтгүүлсэн байна. Энэхүү ялаа эдэлж байхдаа 2009 он Өршөөл үзүүлэх тухай хуульд хамрагдан суллагдсан хойноо дээрхи аймшигт хэргийг үйлджээ. Гэмт хэргийн үйлдлийн арга нь улам хүч хэрэглэсэн, хэрцгий шинжтэй болж байгаа нь илэрхий байна.



Хорих байгууллагад ял эдэлж байгаа хүмүүсээс суллагдаж гарсны дараа учрах бэрхшээлүүдийн талаар судлахад<sup>75</sup> ялтнуудын ихэнхи нь "хэн нэгэнтэй үл ойлголцох байдал бий болно, ажил олдохгүй байх, гэр бүл, нийгэм намайг хүлээж авахгүй" гэсэн

айдастай байдаг ба нийгэмд хэвийн ажиллаж амьдрахад нь төрийн бодлого, олон нийтийн чиг хандлага түлхүү үйлчилж, гадуурхагдах, ажилд орж чадахгүй байх, улмаар давтан гэмт хэрэг үйлдэх зам руу орж байна.

#### Дахин гэмт хэрэг үйлдэж байгаа шалтгаан:

Хорих газарт ял эдэлж байгаа хүмүүсийн 50.4% нь хоёр ба түүнээс дээш удаа хорих ял шийтгүүлж байсан рецидив, тэдний 37.2 % нь хүч хэрэглэсэн болон шунахай сэдэлттэй гэмт хэрэг үйлдсэн<sup>76</sup> байна. УПЕГ-ийн Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт хэлтсийн хяналтын прокуроруудтай хийсэн ярилцлагаас үзэхэд 3-20 удаагийн давтан гэмт хэрэг үйлдсэн хүмүүс ял эдэлдэг байна.

- Ажил олдохгүй, олдсон ч ажиллах боломжгүй
- Санхүүгийн эх үүсвэргүй, мөнгөөгүйн улмаас өмчийн эсрэг гэмт хэрэг гол төлөв үйлддэг. Энэ хулгайн гэмт хэргийн 30 хувь нь давтан үйлдэж байгаагаас харагдаж байна.
- Бэлгийн болон гэр бүлийн асуудлаа шийдвэрлэж хэн нэгэнтэй харилцаа тогтоож, нийгмийн бусад гишүүдийн дунд орж чадахгүй байх
- Асуудлыг хүчээр шийдвэрлэх хандлага
- Архидан согтуурах, мансуурах дон

Хорих байгууллагын нийгмийн ажилтнуудтай хийсэн ярилцлагаас:

*“Шоронд байдаг гал хам, эсвэл янз бүрийн бүлэг нь элдэв хүчирхийлэл, гэмт хэрэг үйлдэх арга, зан араншинг бусаддаа халдаадаг. Өнөөдөр хүн шоронд тэр байтугай хэдхэн хоног урьдчилан хоригдоод гэмт хэрэгт суралцаад гардаг нь үнэн. Нийгмийн ажилтан нь өөрөө үүнийг засч залруулах үүрэгтэй ч бодид байдал дээр ажлын стресс хүчтэй ордог. Үүнээс шалтгаалан хоригдогсодтой зүй бус харьцах асуудал гардаг. Үнэндээ шоронд байгаа хүмүүсийн ихэнхи нь муу хүмүүс буюу бидний ярьдагаар яадгаа алдсан гэмт хэрэгтнүүдбиш байдаг ч эелдэг зөөлөн харьцахаараа давардаг”* гэж байлаа.

Хүүхдийн хорихын талаар судалгаа хийсэн нэгэн ажилтны судалгааны дүнгээс үзэхэд хүүхдийн урьдчилан хорих анги, шоронд “судар солилцох” гэсэн ойлголт байдаг бөгөөд ихэнхи нь үйлдсэн гэмт хэргээ ярьж, нөгөөдөө хэрэг худалдах процессийг хэлдэг юм байна.

Хүүхдийн хорих ч бай насанд хүрэгчдийн хорих ч бай шоронгоос суллагдсан хүмүүсийг орон нутагт нь хүргэх талаар хуулийн заалт байдаг ч замын унааны мөнгө гэж багахан хэсгийг өгдөг. Суллагдаж очоод “гэмт хэрэгтэн” гэсэн бичигдээгүй пайз зүүж амьдардаг. Судалгаа явуулсан аймгуудад шоронгоос суллагдсан хүмүүсийн нэг нь ч ажилд ороогүй байв.

#### Иргэдийн санаа бодол:

“Хүнийг шоронд суулгаснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайн зохион байгуулах нь илүү үр дүнтэй байдаг гэсэн саналыг юу гэж үзэж байна вэ?” гэсэн асуулгаас үзэхэд шоронд хүмүүсийг байлгаж цээрлүүлэх нь үр дүнтэй, шоронд л хийчихвэл болно гэсэн хандлага тал хувьд нь байхад энэ нь буруу санал нийлэхгүй байгаа нь 35 орчим хувийг эзэлж байна.

#### Ял шалгах хуудас:

Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2008 оны А/113, 547, 494 тоот захирамж, тушаалаар батлагдсан “Шүүхээр ял шийтгэгдсэн хүмүүсийн тоо бүртгэлийг хөтлөх, лавлагаа олгох заавар”-ын 23-д зааснаар эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хянан шалгах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад тухайн гэмт хэрэгт холбогдсон этгээдийн хувийн байдал, эрүүгийн хариуцлагын хэр хэмжээ, шинж чанарт нөлөөлөх нөхцөлүүдийг бодитой тогтоох зорилгоор Мэдээлэл, судалгааны төвөөс ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудсаар лавлагаа авдаг. Гэтэл төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад ажил, сургууль, уралдаант шалгалтад орох иргэнээс бүх тохиолдолд ял шийтгэлийн тухай лавлагааг гаргуулж авдаг болсон<sup>77</sup> нь ял шийтгүүлсэн хүн нийгэмд ажил хийх ямар ч боломжгүй байдалд хүрч, ялгаварлан гадуурхагдахад хүргэж байна. Иймд энэ асуудлыг төрийн түвшинд авч үзэх, тогтолцоог өөрчлөх, ял шийтгэгдсэн тодорхойлолт авах шаардлага, шалгуурыг тодорхой болгох, цөөлөх шаардлага байна.

Эрүүгийн гэмт хэрэг нь санаатай болон болгоомжгүйгээр үйлдэж, ял шийтгүүлсэн хүмүүсийг бүх насаар нь гэмт хэрэгтэн, ял шийтгэгдэж явсан бүтэлгүй этгээд, эрүүгийн элемент гэж үзэх үнэлэмж нь хүний эрхийн зарчимд нийцэхгүй юм.

#### Хорих ялын өртөг:

Нэг жилд нэг ялтанд хорих ял эдлүүлэхэд дунджаар 815859 төгрөг улсын төсвөөс зарцуулагддаг бөгөөд ялтнуудад хорих байгууллагын нийт төсвийн 67 хувийг зориулагддаг.<sup>78</sup> Сүүлийн 3 жилийн дунджаар 7272 хоригдол ял эдэлж байна хэмээн үзэх юм бол зөвхөн хорих үйл ажиллагаанд 1 жилд 5 тэрбум 932 926 648 төгрөг төсвөөс зарцуулж байна. Үүний чамгүй хувийг давтан гэмт хэрэг үйлдсэн ялтнуудад зарцуулдаг.

#### Хүүхдийн асуудлыг тусгайлан авч үзэх нь

Хорих байгууллагаас суллагдсан хүүхдийн асуудлыг тусгайд нь авч үзэх шаардлагатай хэмээн үзлээ. 2006, 2009 онуудад батлагдан гарсан “Өршөөл үзүүлэх тухай” хуулиар хорих 411, 407 дугаар ангиас суллагдсан хүүхдүүд ахин гэмт хэрэг үйлдэж шоронд орсон, эсвэл насанд хүрсэн хүмүүсийн хорих ангид дэглэм өгсөж хоригддог<sup>79</sup>, 50-70 хувь нь суллагдсанаас хойш 3 жилийн дотор дахин гэмт хэрэг үйлдсэн байна.

Хүүхдээс давтан гэмт хэрэг үйлдэж байгаа шалтгаан, нөхцөлийг судлан үзэхэд:

- 1) Хорихоос суллагдаад очих газаргүй, орон гэргүй,
- 2) Эцэг, эх нь өрхийн орлого байхгүй, амьдралын баталгаажих түвшингээс доогуур амьдралтай,
- 3) Ажил, сургуульд орох гэхэд иргэний бичиг баримтгүй, сургууль завсардсан, мэргэжил, боловсролгүй. Өөрөөр хэлбэл тэднийг нийгмийн зүгээс хүлээн авах бэлтгэл хангагдаагүй, нийгмийн хүрээлэл нь зөвөөр хүлээж авахгүй байгаа<sup>80</sup> нь дахин гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлдөг.

Иймээс шоронгоос /уг нь хүүхдэд хорих ял ногдуулах нь хамгийн эцсийн арга хэмжээ байх ёстой/ суллагдсан хүүхдэд амьдрах орчин бэлтгэх, түр хугацаанд байршуулах зэрэг онцгой арга хэмжээг авах хэрэгтэй юм.

Манай улсын хувьд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүмүүст нийгмээс тусгаарлахгүйгээр оногдуулж буй хүмүүжүүлэх үр нөлөө бүхий бусад орнуудыг бодвол харьцангуй бага. Энэ нь хүүхдээс үйлдсэн зөрчил, хэргийг тусгайлан шийдвэрлэх процедур<sup>81</sup> манай улсад байхгүй байгаатай холбоотой. Хүүхдийн хувьд нөхөн сэргээх эрх зүйн хандлагыг алхам алхамаар төлөвшүүлж эхлэх нь зүйтэй бөгөөд тэр тусмаа насанд хүрээгүй этгээдэд үйлдсэн гэмт хэргийн шинж чанараас нь хамааран хэрэгтэнд тодорхой биечилсэн хориг хэрэглэлгүйгээр хянан харгалзах /пробац/ албадлага хэрэглэх хандлагыг төлөвшүүлэх хэрэгтэй байдаг.

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, тогтоомжоос хүнийг шоронгоос суллах<sup>82, 83, 84, 85, 86, 87, 88</sup> эрх зүйн зохицуулалтыг судалж үзэхэд нийгмийн зүгээс дэмжлэг үзүүлэх, нөхөн сэргээх үйл ажиллагааны хэлбэр огт тусгагдаагүй, эдгээр хүмүүсийг нийгэмшүүлэхэд нь туслалцаа, дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчин, үр нөлөөтэй бодлого, тогтолцоо аль аль нь бий болж бүрдээгүй байна.

Цагдаагийн байгууллагын тухай болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиудад хорих байгууллагад байгаа болон суллагдсан хүмүүст тавих хяналтын талаар зааж, тусгаж өгсөн боловч энэ олон байгууллагын хуулиар заасан чиг үүргийн давхардал нь бэрхшээл учруулж байна. Хуулийн байгууллагын үйл ажиллагаа тухайлбал шүүхийн цагдаа, прокурорын байгууллагын хуулиар заасан дээрхи ажиллагаанд иргэд шүүмжлэлтэй ханддаг. Суллагдсан хүмүүст дарамт учруулдаг, алдсан дээр нь дахин

түлхдэг, тэднийг нийгэмд хэвийн ажиллаж амьдрахад нь саад учруулж байгаа тухай захиргааны хяналтад байгаа судалгаанд хамрагдсан зарим хүмүүсээс саналаа илэрхийлж байв.

Гэмт хэргийг байхгүй болгоно гэдэг нь аль ч нийгэмд боломжгүй зүйл бөгөөд харин үүнийг ямар хэмжээнд барьж байх вэ гэдэг төрийн бодлогоос хамаардаг. Давтан гэмт хэрэг үйлдсэн хүмүүст зарцуулж байгаа төсвийг багасгах, онц ноцтой гэмт хэрэг үйлдэхээс нь өмнө урьдчилан сэргийлэх ажлыг одоо үйлчилж байгаа хууль тогтоомжоор шийдвэрлэх боломжгүй. Цаашид шоронгоос суллагдсан хүмүүст дэмжлэг туслалцаа үзүүлэх эрх зүйн орчин бий болгох шаардлагатай илэрхий байна.

## **VII. ХОХИРОГЧ, ГЭРЧИЙН ЭРХИЙН ХАМГААЛАЛ**

Монгол Улсын хууль тогтоомжид гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн байдал олон улсын стандартад зарим талаар ойртож очсон боловч хохирогчийн зарим эрхийг хэрэгжүүлэх механизм, зохион байгуулалт, эдийн засгийн баталгаа, бааз суурь байхгүйн улмаас хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэн хэвээр байна. Үүний улмаас гэмт хэргийн хохирогч нь нийгмийн халамж тусламж авах эрх болон хохирогчийн аюулгүй байдлаа хамгаалуулах эрх нь хангагдахгүй байгаагаас гадна төрөөс нөхөн төлбөр авах, нөхөн олговор олгох асуудал олон улсын жишгээс хоцорчээ.

Хохирогчийн нотлох, зөрчигдсэн эрхээ нөхөн сэргээлгэх эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд туслах шинжтэй үүрэг болон хувирсан нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцох түүний эрхийн агуулга зөрчигдөхөд хүргэж байна.

Эрүүгийн хэргийг илрүүлэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтын болон шүүн таслах шатанд оролцсон гэрч, хохирогч, бусад оролцогчийн аюулгүй байдлыг хамгаалах эрх зүйн зохицуулалт, хамгаалалт дутагдсанаас хуулийн зарим байгууллагууд өөрсдийн үзэмж, дотоод журмаар шийдэх, түүнчлэн хохирогчийг олон дахин явуулах, хүлээлгэх, залхаах, хүнд суртал гаргах, шат дамжлага ихтэй, хохирогчийг хэргээ өөрөө нотлохыгшаарддаг зэрэг бэрхшээл, дутагдал байна. Хохирогчдод наад захын тусламж үйлчилгээг зөвхөн хөтөлбөрийн хүрээнд төрийн бус байгууллагаас үзүүлж байна.

Иймээс хохирогчийн өргөдөл гомдлыг түргэн шуурхай авч үзэж шийдвэрлэх, хохирогчийн бие махбод, эд хөрөнгө, сэтгэл санааны хор хохирлыг арилгах, хохирогчийн аюулгүй байдлыг хангах улмаар хохирогчид нийгэм сэтгэл зүй, нийтийн халамж, хамгаалал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх цогц механизм хэрэгтэй байна.

Энэхүү салбар хуралдаанаар үр дүнд гэмт хэргийн гэрч, хохирогчийн эрх зүйн байдал гэмт хэргийн улмаас учирсан хохиролд нөхөн төлбөр олгох, гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах талаар холбогдох хууль тогтоомжид тодорхой өөрчлөлт, хохирогчид төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх тогтолцоо, хохирол барагдуулах сан хэрхэн, яаж байгуулах арга замын талаар хэлэлцэж, хохирогч, гэрчийн эрх зүйн хамгаалал, аюулгүй байдлыг хангах, хохирлыг барагдуулах сан, хохирогчийн эрүүл мэнд, сэтгэл зүйн зэрэг шаардлагатай туслалцаа үзүүлэх механизм зэрэг асуудлыг хөндөн тодорхой санал зөвлөмж гаргалаа.

Хохирогч гэрчийн эрх зүйн статус, хохирогч гэрчид үзүүлэх тусламж үйлчилгээний хэлбэр, тогтолцоо, хохирогч гэрчийн аюулгүй байдлыг хангах хэрэгцээ шаардлага, хохирлын үнэлгээ, ялангуяа сэтгэл санааны хохирол, түүнийг барагдуулах оролдлого хийж байгаа практикаас, төрийн бус байгууллагаас хохирогч, гэрчид хуулийн болон бусад тусламж дэмжлэг үзүүлж байхад гардаг хүндрэл бэрхшээлүүдийн тухай үндсэн оролцогчдоос мэдээлэл өгч тодорхой санал гаргаж байлаа. Гарсан саналыг доор байдлаар ангилж байна. Үүнд:

- Гэрч хохирогчийг хамгаалах тогтолцоо алга, тэдэнд зөвхөн хэдэн ТББ-ууд үйлчилгээ үзүүлж байна. Иймд албан тогтолцоотой болъё.
- Прокурор, цагдаагийн байгууллагад гэрч, хохирогчийг хамгаалах тусгай албатай болох
- Хохирогчид хохирчихоод дээрээс нь хуулийн туслалцаа авах гэхээр төлбөр төлөх шаардлагатай болж байна. Тэд ихэнх тохиолдолд төлбөрийн чадваргүй байдаг. Гэтэл тэд үндсэн хуулиар эрхээ хамгаалуулах эрхтэй байдаг. Иймээс төлбөргүй хуулийн туслалцаа үзүүлдэг болгох хэрэгтэй гэсэн санал гарч байна
- Үүнтэй уялдуулаад орон нутагт хохирогч, гэрчийг хамгаалах өмгөөлөгчдийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай
- Хохирогч, гэрчид үзүүлэх үйлчилгээг сайжруулах хэрэгтэй, үүний хөрөнгө, санхүүжилтийг шийдвэрлэх хэрэгтэй



- Тэдэнд мөн шүүхэд төлөөлүүлэх, өөрийгөө төлөөлөх эрх зүйн мэдээлэл хангалтгүй байна. Ийм мэдээллээр хангадаг байх хэрэгтэй
- Одоогийн практикт тэднийг зөвхөн мэдүүлэг өгөхөд л ашиглаж байна. Гэтэл тэдний аюулгүй байдлыг хангах асуудал огт орхигджээ. Аюулгүй байдлыг хангах зайлшгүй хэрэгцээ байна. Байцаан шийтгэх ажиллагаанд тэднээр худал мэдүүлэг өгүүлэх, өгсөн мэдүүлгийг өөрчлөх, байцаан шийтгэх ажиллагаа хэт удаашран залхаах зэрэг асуудал гардаг үүнийг зогсоох хэрэгтэй байна.
- Хохирогчид янз бүрийн дарамт, заналхийллээс болж мэдүүлгээс буцах, худлаа мэдээлэл өгч хэрэгтэн болох ч тохиолдол гарч байна. Ийм хохирогч, гэрчийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, аюулгүй байдлыг хангах, хохирлыг барагдуулах санхүүжилтийг зохицуулсан тусгай хуультай болох санал гарсан.
- Энэ хуульд хохирлын асуудлыг маш тодорхой заах хэрэгтэй. Хохирлыг эхний ээлжинд төрөөс гаргаж шийдвэрлэж байх
- Хохирогчийн хохирлыг бодитой үнэлдэг болох, хуулийн байгууллагууд хохирогчийн бодит хохирлыг гаргадаг болох шаардлага байна.
- Бие эрхтний хохирол гэж хуулиар заадаг энэ нь зөвхөн бие эрхтэн гэмтэл авсан тохиолдлыг л хамарч байна. Гэтэл эрүүл мэндэд учирсан хохирлыг хамрахгүй байна. Үүнийг хамардаг болгох
- Сэтгэл санааны хохирлын үнэлгээ хийх аргачлалыг тогтоох. нэвтрүүлэх, нөхөн төлүүлдэг болгох хэрэгтэй байна.
- Эрүү, иргэний хуулийн хооронд байгаа зөрчлийг арилгах хэрэгтэй байна.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, шүүхийн хамтын ажиллагааг сайжруулж шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлдэг болох
- Мөрдөн байцаагч нарыг хохирогчийн эрхийг хамгаалахад илүү анхаарч ажиллах хэрэгтэй. Үүний тулд хуульчлах асуудал хэрэгтэй. Тухайлбал хохирогчийг өмгөөлөгчтэй мэдүүлэг авах гэж хуульчлах, Мөн хохирогчид үзүүлэх үйлчилгээ, ялангуяа аюулгүй байдлыг хангах асуудлыг хийж болно. Харин зардал, санхүүжилтийг шийдэх
- Гэрч, хохирогчийн эрхийг хамгаалах асуудал ХЭХҮндэсний хөтөлбөрт тусгагдсан байдаг. Энэ хөтөлбөрийн заалтыг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг сайжруулах хэрэгтэй.
- Хөөн хэлэлцэх хугацаа дууссантай холбоотой иргэд хохирдог. Үүнийг болиулах шаардлагатай
- Эрүүгийн байцаан шийтгэх хуулиас хохирогчийг ялгаж заагласан заалтыг хасах
- Хохирогчийг тогтоох асуудлыг боловсронгуй болгох
- ЗГ-ын сангийн тухай хуульд хохирогчийн эрхийг хамгаалах сан байгуулах. Хохирогчийг хамгаалах сангийн асуудал өмгөөллийн тухай хуульд орсныг болиулах
- Хохирлын үнэлгээтэй холбогдуулаад Монгол хүний үнэ цэнийг тогтоон хэрэглэх санал ч гарч байлаа.<sup>89</sup>

Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн тавдугаар бүлэгт “гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх”-ээр тус тус заасан.

Түүнчлэн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2003 оны 58/4 дугаар тогтоолоор баталсан Авилгалын эсрэг конвенци, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2000 оны 55/25 дугаар тогтоолоор баталсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц болон бусад олон улсын гэрээ, конвенцид “Оролцогч улс бүр энэхүү конвенцид тогтоосон гэмт хэргийн талаар мэдүүлэг өгч буй гэрч ба шинжээч, мөн зохих тохиолдолд тэдний хамаатан садан олон бусад ойрын хүнийг өс хонзон, буюу айлган сүрдүүлгээс хамгаалахаар заах талаар зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нийцүүлэн, боломжийн хэмжээнд авна. Оролцогч улс бүр энэхүү конвенцид хамаарах гэмт хэрэг, ялангуяа өшөө авах буюу заналхийллээс хохирогчийг хамгаалах болон түүнд туслалцаа үзүүлэх зохих арга хэмжээ авна” гэж тус тус үүрэг хүлээжээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 40/34 дугаар тогтоолоор 1985 онд “Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдлийн улмаас хохирсон хохирогчийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмын тухай” тунхаглалыг батлан гаргасан нь олон улсын хэмжээнд хохирогчийн эрхийн талаар гаргасан үндсэн баримт бичиг болсон байна. Уг

тунхаглалын 6 дугаар зүйлд “гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлын нэн тохиромжтой нөхцөлөөр хангах, мөн заналхийлэл буй тохиолдолд гэрчийг хамгаалах”-ыг улсуудад уриалсан байна.

Гэрч, хохирогч нь эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангахад гол үүрэг гүйцэтгэдэг субъектүүд бөгөөд судалгаанаас үзэхэд тэдний аюулгүй байдал хамгаалалтгүй байна. Гэрч, хохирогчийг сүрдүүлэх, дарамтлах, хуурч мэхлэх, мөнгө өгөх, гуйх, ятгах, заналхийлэх зэрэг хэлбэрээр нөлөөлөх явдал гарсаар байгаа бөгөөд үүний үр дагавар нь мэдүүлэг өгөхгүй байх, эсхүл худал мэдүүлэг өгөх, сэтгэлзүйн хувьд хэвийн байдлаа алдах, амиа хорлох оролдлого хийх, амиа хорлох зэрэг үйлдэл болж буйг судлаачид тэмдэглэсэн байна.<sup>90</sup>

Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж буй этгээдүүд гэрч, хохирогчийг хамгаалах зохицуулалт, тогтолцоо бааз суурь байхгүй гэсэн шалтгаанаар гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааг хийдэггүй болох нь судалгаагаар тогтоогдсон байна. Харин амь нас, эрүүл мэндэд нь аюул заналхийлэл тулгарсан хүүхэд, эмэгтэйчүүдийг Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг Хүйсийн тэгш эрхийн төв гэсэн төрийн бус байгууллагууд хамгаалах зарим арга хэмжээ авч хэрэгжүүлдэг.

Бусад улсын эрх зүйн зохицуулалтын чиг хандлагыг судлан үзвэл гэрч, хохирогчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх зорилгоор эрх зүйн бие даасан зохицуулалтыг бий болгож, үүний үр дүнд хохирогч, гэрчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх нэгдсэн тогтолцоо бүрэлдсэн байна. Дээрхи хууль зүйн болон практик шаардлагуудыг үндэслэн Гэрч, хохирогчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх тухай хуулийн төсөл боловсруулж байна.

Хууль зүйн салбарт эрүүгийн хариуцлагын тогтолцооны шинэтгэл буюу “criminal justice reform” хийгдэж байгаатай холбогдуулан хууль тогтоомжийн төдийгүй дэд бүтцийн бодлогыг салбарын яамнаас шинээр тодорхойлж байна. Бидний мэдэх Эрүүгийн хууль тогтоомж гэсэн ойлголт нь илүү өргөн болж материаллаг болон процессын хуулиудыг бүхэлд хамарч, хэргийг хурдан шуурхай шийдвэрлэх, оролцогчдын аюулгүй байдлыг хангасан, шударга ёсыг тогтооход чиглэж буй.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тодорхой заалтуудаар хэрэг хянан шийдвэрлэхэд ажиллагаанд “татагдан ордог” бусад оролцогчид хамаарах **гэрч**, өөрийн болон төлөөлүүлэгчийн эрх ашгийг хамгаалан оролцогч болох **хохирогчийн** халдашгүй эрхийг хамгаалж чадахгүй байгааг бид мэдэх билээ. Энэ талаар хийгдсэн хэд хэдэн судалгааны дүнгээс үзвэл эрх зүйн орчноос гадна, төсөв санхүү, дэд бүтэц, хуулийн байгууллагын уялдаа холбоо, ажил дүгнэх үзүүлэлт зэргээс шалтгаалсан олон хүчин зүйл байгааг төвөггүй харж болохоор байна.

Эрүүгийн хариуцлагын тогтолцоонд хамаарах дээрх хууль тогтоомжийг батлан гаргаснаар гэрч, хохирогчийг хамгаалах үр ашигтай, уян хатан бүтэц бий болгох урьдчилсан төсөөлөлтэй ажиллаж байна. Энэ хүрээнд дараах эрх зүйн үндсийг хуулиар тодорхойлно. Үүнд:

1. Цагдаагийн мөрдөх албанд хамаарах гэрч хохирогчийг хамгаалах тогтолцоо: Түгээмэл гарч, цагдаагийн байгууллагаас бүртгэн шалгадаг 24 мянга гаруй хэргийн дийлэнхи хувийг иргэдийн бие махбодийн болон өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хэргүүд эзэлдэг. Иймээс орон нутгийн хэмжээнд түгээмэл төрлийн гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах, хууль сахиулах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад сэжигтэн яллагдагчийн хууль бус нөлөөллөөс хамгаалах арга хэмжээг тусгах;
2. Мөрдөх албанд хамаарах гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо: Авлига, албан тушаал, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн гэрч, хохирогчийг олон улсын болон дотоодын түвшинд хамтран ажиллах, хамгаалах, туслалцаа үзүүлэх шинэ хэлбэрийг тогтоож, төсөв, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх;
3. Маршалын буюу шүүхийн шатанд гэрч хохирогчийг хамгаалах тогтолцоо: Шүүхийн шатанд гэрч хохирогчийг хамгаалах, тусгаарлах байранд байлгах, эрэн сурвалжлах, шүүх хуралдааны явцад аюулгүй байдлыг хангах гэсэн гурван хэсгээс гадна энэ хуулийг хэрэгжүүлэх зөвлөмж, аргачилсан заавар боловсруулагдана.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн төсөлд уг хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараахь байдлаар тусгана. Үүнд:

**Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны төрөл/ type/**

Хуулийн төсөлд хамгаалалтын төрөл тус бүрийг тусгах. Тухайлбал, хувийн хамгаалалт, орон байрны хамгаалалт, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл олгох, холбоо харилцааны болон дохиоллын системн хэрэгслүүдийг олгох, утасны дугаар болон автомашины дугаарыг өөрчлөх, тодорхой хугацаанд аюулгүй газар байлгах, оршин суугаа газрыг өөрчлөн нүүлгэх, баримт бичгийг өөрчлөх, гадна төрхийг өөрчлөх гэх мэт. Уг хамгаалах аргын төрлийг тусгахдаа олон улсын нийтлэг жишгийг харгалзан тус улсад хэрэгжүүлж чадахуйц аргыг сонгохыг эрхэмлэнэ.

**Гэрч, хохирогчийг хамгаалах журам /procedure/**

Энэ хэсэгт гэрч, хохирогчийг хамгаалалтад авах нөхцөл, хүсэлт гаргах, мэдээлэл цуглуулах, шийдвэр гаргах, хамгаалах болон хамгаалалтад хамрагдах этгээдийн хүлээх үүрэг, эдлэх эрх зэргийг тусгана. Түүнчлэн хамгаалалт дуусгавар болох нөхцөлүүдийг заана. Гэмт хэргийн гэрч, хохирогчид хүртээлтэй байх зарчмыг баримтлан уг журмыг тусгана.

**Гэрч, хохирогчид туслалцаа үзүүлэх /rehabilitation/**

Туслалцааны хэсэгт хохирогч, гэрчид сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн талаар мэдээлэл хүргэх, эрх зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл заслын болон бусад үйлчилгээ үзүүлэх зэрэг асуудлыг тусгаж, энэ чиглэлээр ажиллах төрийн болон төрийн бус байгууллагын эрх зүйн үндсийг тодорхой болгоно. Түүнчлэн төрийн бус байгууллагад төрөөс үзүүлэх дэмжлэгийг мөн тусгана.

**Хариуцлага /responsibility/**

Энэ хэсэгт гэрч, хохирогчийг хамгаалах хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх захиргааны хариуцлагыг тусгана. Түүнчлэн уг хуулийг дагаж гарах хуулийн төсөлд гэрч, хохирогчид нөлөөлөх, заналхийлэх үйлдлийг гэмт хэрэгт тооцож, хамгаалах арга ажиллагааны гол цөм болох нууц хадгалахыг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгана. Энэ нь шинээр боловсруулж буй Эрүүгийн хууль, Зөрчлийн хуулиудад ялгамжтай тусна.

Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдоос гэрч, хохирогчид нөлөөлөх, ойртохыг хориглох таслан сэргийлэх арга хэмжээ ба Эрүүгийн хуулийн эрх чөлөө хязгаарлах ялын төрлүүд хоорондоо уялдаа холбоотой зохицуулалт хийх боломжийг судалж байна.

Гэрч, хохирогчоор хязгаарлагдахгүй бас нэг асуудал бол шинжээч эмч, мэргэжилтний аюулгүй байдлыг хангах асуудал бөгөөд үүнийг орхигдуулахгүй байхад анхаарна. Мэргэжилтэн, шинжээч эмчийг байцаахдаа биеийн байцаалтыг тэмдэглэж, бусад оролцогчидод хувийн байдлын талаар мэдээлэл авах бололцоо олгож байгааг өөр байдлаар шийдвэрлэх хэрэгтэй.

Түүнчлэн шүүхийн шийдвэр нээлттэй, ил тод байх үйл ажиллагаанд хүрээнд хуулийн байгууллагын нэгдсэн цахим дэд бүтэц бий болгож энэ цаг үед оролцогчдын мэдээллийг нууцлах асуудлыг орхигдуулахгүй байх нь зүйтэй гэж үзэж байна.